



**ХАЛХЫН ШОРОНГИЙН**  
*Альд түрх*

**WIII**

Халхын шоронгийн амьд түүх VIII  
Зохиолч: Б.Шидбүтэх

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Өршөөлийн зарлигаар өөдөлж дэвжсэн хулгайч

Манай Эрүүгийн байцаан шийтгэх хууль аль соц нийгмийн үеэс эхлээд л халаасны хулгайч нарыг өөгшүүлж ирсэн түүхтэй. Хүний халаас суйлсан этгээд гурван жилээс илүү ял сонсдоггүй. Олон удаагийн нахиур, рецедив, эрүүгийн элемент байлаа ч халаасны хулгайн үйлдэл дээр гурван жилийн хорих ялаас хэтэрдэггүй тул халаасны хулгайч нар гурван жилийг “Ялын дээд хэмжээ” хэмээн нэрийджээ. Бусдаас хоосон түрийвч булаасан, дээрэмдсэн этгээд шүүхээр ороод доод тал нь долоон жилийн хорих ял авч, зарим нь уг ялаа чанга дэглэмтэй хорих ангид эдлэхээр шийтгүүлж байхад 10 сая төгрөг хулгайлсан халаасны хулгайч шүүхийн өмнө гурван жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлэх, мөн нийт ялынхаа тавин хувийг эдэлсэн тохиолдолд хугацаанаасаа өмнө суллагдах эрхтэй болдог ажээ. Нэг ёсондоо тэд энэрэнгүй бөгөөд эвтэйхэн хуулиар шийтгүүлдэг гэж хэлж болно. Тэгээд аливаа нэг өршөөлийн хууль, тэгш тоо тохиосон ойн баяруудаар хамгийн түрүүнд халаасны хулгайч нар суллагдах жишээтэй. Ямар сайндаа л бусдын халаас суйлж амьдардаг “Онин” Буядаа гэгч этгээд зургаахан жилийн дотор гурван ч удаа төрийн өршөөл, зарлиг гэдгээр эдлэх ёстой ялнаасаа нэг мөсөн мултарсан байгаа юм. Тэрбээр анх 1999 онд Улсын их дэлгүүрт хүний халаас суйлж байгаад үйлдэл дээрээ баригджээ. Гэвч тэр мөрдөн байцаагчид мэдүүлэг өгөхдөө хэргээ хүлээхгүй гүрийжээ. Үйлдэл дээрээ улаймцайм баригдсан мөртлөө л “Би тэр хүний халаасыг суйлаагүй. Өмдний нь халааснаас мөнгө цухуйгаад хариугүй унах гэж байхад нь туслах санаатай мөнгийг нь авч өгсөн юм. Гэтэл тэр хүн намайг буруугаар ойлгоод шууд цагдаад бариад өгчихсөн. Би тэгж хүний халаас суйлдаг арчаагаа алдсан этгээд биш. Надад тийм совесть байхгүй” гэх зэргээр мэлзжээ. Гэвч төдөлгүй түүнтэй цуг халаас суйлдаг, тодруулж хэлбэл хамжигчаар ажилладаг “Цэхэр” Батаа, “Солир” Гансүх гэгч этгээдүүд баригдсанаар “Онин” Буядаа өмнө нь бусдын халаас суйлж байсан нь нотлогджээ. Мөрдөн байцаагч тэднээс “Та нарыг хараад байхад нүд чинь цэхэр биш, солир биш, онин биш юм. Тэгсэн мөртлөө өөрсдийгөө яахаараа цэхэр, солир, онин гээд нэрлэчихсэн юм бэ” гэж асуухад “Энэ бол халаасны хулгайч нарын бие биенээ таних нууц пароль. Бид чинь бөөн хүмүүсийн дунд бие биенээ бараг харахгүй шүү дээ. Цэхэр нь халаас суйлж байхад солир нь хүмүүсийг шахаж өгөөд, онин нь суйлсан мөнгийг авч бултах жишээтэй. Хүмүүсийн дунд бид нэрээ дуудалцахгүйн тулд “Цэхэр ээ, наана чинь авшиг очиж байна, Солир оо, авшиг шахаад өг” гэж харьцдаг. Авшиг гэдэг нь халаасандаа мөнгөтэй хүнийг хэлж байгаа юм. Авшиггүй бол бид нар юугаараа амьдрах билээ дээ” хэмээжээ. “Онин” Буядаа анхныхаа хэрэгт нэг жил зургаан сарын хорих ялыг жирийн дэглэмд эдлэхээр болжээ. Гэтэл тэр “Би анх удаа хэрэг үйлдсэн шүү дээ. Надад шүүх арай дэндүү хатуу хандаж байна. Би зургаан сарын ял эдлэх ёстой” хэмээн заргалдаж улмаар Нийслэлийн шүүхэд давж заалдсан байна. Мөрдөнгийн умгар өрөөнд давааны хариугаа хүлээж нэг сар гаруй хэвтсэн Буядаагийн чихэнд чимэгтэй нэг зүйл ойроос сонсогдох болжээ. Тэр нь юу гэвэл “Анх удаа ял эдэлж байгаа хоригдлуудад “Зууны өршөөлийн зарлиг” гээч юм тусах гэнэ” гэсэн яриа байлаа. Нээрээ ч 1999 оны сүүлчээр “Зууны манлай дуучин”, “Зууны манлай бөх”, “Зууны манлай улс төрч” гэх мэтийн цол гуншин бий болж, үүний хажуугаар шорон гяндангуудад “Зууны өршөөлийн зарлиг” гээч юм цуурайтаж эхэлжээ. Төдөлгүй мөрдөнд хоригдож байгаа хулгайч нарын үг үнэн болох нь батлагдсан бөгөөд “Онин” Буядааг “Ганц худаг”-аас дамжин руу ачигдахын урд өдөр “Зууны өршөөлийн зарлиг” гарч, мөнхүү өршөөл түүнд туссанаар нэг жил, зургаан сарын ял сонссон Буядаа нарны амьдрал руу суга үсрэх нь тэр. Гэвч төрийн өршөөл үзсэн Буядаа засрах нь бүү

хэл “Ганц худаг”-ийн мөрдөнд архаг хулгайч нараас сурсан эрдмээ баяжуулан хавь орчныхоо хүмүүсийн халаас, цүнхийг ухаж гарчээ. Ингэх болгондоо тэрбээр “Зууны өршөөл гарсан 2000 онд баярлалаа” гэж наминчилдаг болж. Тэгээд олон хавар нэгэндээ гэгчээр 2001 оны 11-р сарын нэг өдөр Гуравдугаар хорооллын “Номин” их дэлгүүрт хүний халаас суйлж байгаад баригджээ. Энэ удаад тэрбээр “Би тэр хүний халааснаас унах гэж байсан мөнгийг авч өгөх гэж байсан юм” гэж хэлж зүрхэлсэнгүй. Өмнө нь халаасны хулгайн хэрэгт холбогдоод өршөөлөөр суллагдсан түүний үгэнд мөрдөн байцаагч нар итгэнэ гэж юу байхав. “Онин” Буядаа ч өөрийн хувь заяатайгаа эвлэрээд “Тиймээ, би энэ хүний халаасыг суйлсан. Нэгэнт л баригдчихсан юм чинь одоо ер яах ч билээ дээ” хэмээн аргагүй л архагшиж яваа хулгайчийн дүр эсгэжээ. Тэгээд дахиад л нөгөө шүүгч дээрээ тавиад орох нь тэр. Шүүгч энэ удаа түүний хэргийг сайтар судлаад гурван жилийн хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр болжээ. Мөн хулгайн зүйл анги болох Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 123-р зүйлийн хоёрт зааснаар “Нийт ялынхаа гуравны хоёрыг биеэр эдэлсэн тохиолдолд суллагдана” гэсэн журмыг хасч гурван жилийг нь яс эдлүүлэхээр болжээ. Энэ удаад “Онин” Буядаад өөрийгөө гэм буруугүй гээд давж заалдах совесть байсангүй. Тэрбээр Зүүнхараагийн хорих ангид ял эдэлж байгаад 2002 оны 4-р сард дэглэм буурч жирийн дэглэмтэй хорих ангид шилжин иржээ. Энэ үед цоожтой саванд байгаа хоригдолууд “Эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдчихлээ. Тун удахгүй Эрүүгийн хуулийн тэгшитгэл гэгч болох гэнэ. Ихэнх нь хулгай хийсэн хулгаруудад тусах юм байна. Төр яахаараа энэ муу хулгайч нарыг дандаа өршөөдөг байна аа” гэх зэргээр хоорондоо ярилцдаг болж. “Онин” Буядаа үүнд нэг их үнэмшиж, итгэсэнгүй. Гэхдээ түүний сэтгэлд “Хана хүртэл сонсдог гэдэг дээ. Арай би суллагдах юм биш биз” гэсэн бодол эргэлдэх болжээ. Нээрээ ч төдөлгүй хоригдолуудын ярьсан яриа нотлогдож 2002 оны 9-р сарын нэгнээс Эрүүгийн хуулийн тэгшитгэл гээч нь болж олон арван ялтаныг баярлуулах нь тэр. Зөвхөн Мөнгөнморьтын хорих ангиас гэхэд л гуч гаруй малын хулгайч хугацаанаасаа өмнө суллагджээ. Тэр ч байтугай онц ноцтой гэмт хэрэгтэнүүд ялынхаа 80 хувийг эдэлсэн тохиолдолд магадлангаар суллагдах, мөн таван жилээс доош ялтай хоригдолууд ялынхаа тавин хувийг эдэлсэн тохиолдолд магадлангаар суллагдах аятайхан завшаан тохиожээ. Халаасны хулгайч “Онин” Буядаа ч шинэ эрүүгийн хууль хэрэгжсэний буянаар хугацаанаасаа хоёр жилийн өмнө суллагджээ. Тиймээс тэр “Би их азтай цаг үед төрсөн хулгайч. Эхний удаад намайг зууны өршөөл аварсан. Энэ удаад Эрүүгийн хуулийн шинэчлэл аварлаа. Ямар гоё вэ. Дараагийн удаад намайг бас л нэг шинэчлэл аварч таарна” гэж өөрийгөө хөөргөдөөд дахиад л бусдын халаасыг суйлж эхэлжээ. “Заамал дүнзэн нарсанд суугаад засарна гэвэл гонжийн жоо” гэдэг үг бий. Буядаагийн хувьд гэвэл “Засгийн өршөөл тусаад байхад засарна гэвэл гонжийн жоо” гэгч нь болжээ. Халаасны хулгайгаар чамгүй мэргэжсэн Буядаа цагдаа нарт баригдалгүйгээр хичнээн хүний халаас суйлсаныг бүү мэд. Ямартай ч нэг жил зургаан сарын дараа үйлдэл дээрээ баригдсан Буядаа мөрдөн байцаагчид “Би арай ч өдөр болгон хүний халаас суйлж байгаагүй. Гэхдээ огт гараа эвхээд суугаад байсан гэж хэлэх совесть надад бас байхгүй. Чухам хэдэн сарын хэдний өдөр, ямар хүний халаасыг суйлсанаа ёстой санахгүй байна. Би ямар иргэний бүртгэл мэдээллийн товчоо биш дээ” гэж хэнэг ч үгүй мэдээлжээ. Түүнийг өмнө нь хоёр ч удаа таслан шийдвэрлэсэн шүүгч энэ удаад бүр гайхаж орхижээ. Гэхдээ дахин давтан хэрэг үйлдсэнд нь бус хугацаанаасаа өмнө шоронгоос суллагдсанд нь гайхсан байна. Шүүгч түүнээс “Чи чинь өдийд шоронд сууж байх ёстой биш бил үү” гэхэд “Онин” Буядаа “Та чинь ямар сонин юм асуудаг хүн бэ. Эрүүгийн хууль шинэчлэгдээд, хулгайч нар өршөөгдсөнийг та дуулаагүй хэрэг үү” гэж амыг нь таглажээ. Энэ удаад шүүгч түүнд нөгөө л халаасны хулгайчийн “Дээд хэмжээ” болох

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 145-р зүйлийн хоёроор зүйлчлэн гурван жилийн хорих ял оноосон байна. Түүнийг шоронд очсон хойно хулгарууд ахиад л “Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн зарлигаар баахан хоригдол суллагдах гэнэ. Анхны хэрэгтэй, мөн хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдээд таван жил хүртэл хорих ял эдэлж байгаа хүмүүс шууд л ногоон гэрлээр гарах гэнэ” гээд л хорих ангиар нэг шуугиж гарчээ. Рецедив хулгайч Буядаа энэ үгийг сонсоод хөх инээд нь хүрч “Би ёстой нэг гайхамшигтай цаг үед амьдарч байгаа гайхалтай хулгайч юмаа” гээд бас л өөрийгөө болон засаг төрийнхөө өршөөл зарлигийг магтаж гарсан байна. Нээрээ ч төдөлгүй мань эр 2000 гаруй хоригдолын хамт “Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн өршөөл”-д хамрагдаж нарны амьдралд баясгалантайгаар хөл тавьсан байна. Түүнийг “Өршөөлийн зарлигаар өөдөлж дэвжсэн хулгайч” гэвэл зохилтой. Гэхдээ тэр өршөөлийн зарлигаар оюун сэтгэхүйгээ зөв чигт нь чиглүүлж өөдөлж дэвжих биш буруу чигт нь хөгжүүлж халаасын хулгайн чиглэлээр өөдөлж дэвжжээ. Одоо тэр чухам хаана манаргаж яваа нь тодорхой бус. Үнэндээ нэг талаас алдаж, эндсэн аавын хүүхдүүдийг төр өршөөгөөд байгаа юм шиг боловч нөгөө талаас энэхүү харалган өршөөлийн зарлигаар “Онин” Буядаа мэтийн засаршгүй этгээдүүд ял завшаад байх шиг. Уг нь олон жилийн ялтай, анхлан биеэрээ ял эдэлж байгаа хоригдолууд “Тулгар төр-800 жилийн ой”-гоор өөрсдийн ялаасаа 5-10 хувь хасчих болов уу гэж төрдөө битүүхэн найдвар тавьж суусан гэдэг юм. Санамсаргүйгээр хүний амь хөнөөгөөд хар залуугаараа шоронд орсон залуугийн данайсан 25 жилийн ялнаас ганц хоёрхон жилийг хасч болмоор. Ингэлээ гээд тэр хүн шоронгоос суллагдаад гараад ирэхгүй шүү дээ. Онц ноцтой хэрэг гэдэг нэрийн дор зарим хүнийг олон жилээр шийтгэж цээрлүүлдэг. Гэтэл байнга хулгай хийдэг халаасчдын толгойг өршөөл, зарлиг гээч юм цаг ямагт илээд байхыг яана. Өнгөрөгч зун Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өршөөлийн зарлиг гаргаж баахан ялтаныг хугацаанаас нь өмнө сулласан. Үүнд “Онин” Буядаа мэтийн олон арван засаршгүй хулгайч суллагдсан. Харин хүний амь хөнөөсөн ялтануудаас ганц жил ч хасагдаагүй. Судалгаанаас үзэхэд хүн амины хэргээр ял эдэлж байгаа нийт хоригдолуудын 80 хувь нь хохирогчийн буруутай үйлдлээс болж хүний амь бусниулсан байдаг. Мөн хүн амины хэрэг үйлдсэн хүмүүсийн 90 гаруй хувь нь анх удаа хэрэг үйлдсэн гэсэн судалгаа бий. Эрүүгийн хуучин хуулиар ялын дээд хэмжээ 15 жил байсан бол одоо мөрдөгдөж байгаа эрүүгийн хуулиар ялын дээд хэмжээ нь 25 жилийн хорих ял болчихсон. Гэтэл ялын дээд хэмжээг 10 жилээр нэмсэн гээд онц ноцтой, хүн амины хэрэг багасах бус харин ч ихэссээр байгаа билээ.

## Нарны сайхан амьдралыг нарсны амьдралаар солиод насаараа хохирох нь олонтаа

1960-аад оноос хойшхи халхын шоронгийн түүхэнд “Ака” Төмөрбаатар, “Колони” Төмөрбаатар, “Квадрат” Төмөрбаатар, “Балиус” Төмөрбаатар, “Бацаан” Төмөрбаатар, “Хоовон” Төмөрбаатар гэх мэтийн дор бүрнээ өөрийн гэсэн дуулиан шуугиантай олон Төмөрбаатар төрөн гарсан байдаг. Эднээс “Ака”, “Колони”, “Квадрат”, “Балиус”, “Бацаан” нар сонин хэвлэлд бичигдэж байсан. Харин “Хоовон” Төмөрбаатарын талаар тэр бүр дурсагдаж байсангүй. “Нохой” Арвижихт хутгалуулж нас барсан Авдрантын гяндангийн атаман явсан “Бүдүүн” Нармандахын дотны найз “Хоовон” буюу Хорлоогийн Төмөрбаатар халхын шоронд 36 жил ял эдлээд 2000 оны үед суллагджээ. Өчнөөн жил шоронд гүрийтлээ суусан хүнд амьдрал гэж юу байхав. Тэр дундаа 36 жил шоронд суусан Төмөрбаатарт үнэндээ сайхан амьдрах боломж байсангүй. Ямар сайндаа л тэрбээр шоронгоос суллагдсаныхаа дараа “Намайг цааш нь харуулаад өгөөч” гэж төр засгаас хүсч байсан удаатай. “Яршиг зүгээр нохой шиг амьд явсанаас үхсэн минь дээр. Хятад Гаанжуур гээд надтай хамт шоронд байсан нэг хүнийг дөнгөж шоронгоос гарангуут л машинаар дайраад алчихсан. Надад бол ийм арга хэрэглэж болно. Заримдаа би өөрөө өөртөө хэт гутардаг. Сүхбаатарын хөшөөнөөс боогоод үхчихмээр санагддаг. Зүгээр нэг амиа хорлосноос ийм маягаар үхчихвэл арай утгатай. Үнэнийг хэлэхэд би өлсч байна, цангаж байна. Орох орон, оочих аяга алга. Ерөөсөө л нэг ганцаардмал байдалтай, таньдаг ганц хоёр айлынхаа тогоог хараад л даанч хэцүү байна. Болж өгвөл хулгай хийхгүй, дахин шоронгийн хаалга татахгүй юмсан гэж хичээх юм. Даанч өнөөгийн нийгэмд над шиг хүн амьдрах нөхцөл алга” гэж халагласан удаатай. Хорлоогийн Төмөрбаатар 1959 онд “Болдоггүй хүүхдүүд”-ийн тоонд орж хөдөлмөр сургуульд явсанаас хойш өөд нар харсангүй. Ер нь захиргаадалтын үеийн хүүхдийн колони гэдэг чинь гэмт хэрэгтэн бэлтгэх дамжаа байсан бололтой. Дэггүй хүүхдүүд хүүхдийн колонид очоод гэнэн цайлган сэтгэлээр алдаж онох нь даанч их байж. Хоорондоо зодоон нүдээн хийж бие биенээ дарамтална. Янз бүрийн болох бүтэхгүй юм руу бүгдээрээ дарвицгаана. Хүмүүжүүлэх гэж аваачаад харин ч бүр зан төрхийг нь эвдэж араатан болгодог. Ийм байдлаар маш олон хүнийг эвдэж шоронгийн тав болгоод хөгширсөн хойно нь суллаж хань ижил, үр хүүхэдгүй, амьдралгүй болгодог байлаа. “Хоовон” Төмөрбаатар 57 насандаа шоронгоос суллагдсан бөгөөд түүнд нарснаас наранд гарч явсан удаа хэд бий аж. Тэр үедээ 117 төгрөгийн хэрэгт холбогдож Октябрийн районы шүүхээр орж энүүхний төлөө дөрвөн жилийн ял авсан байгаа юм. Түүний нэг найз нь хоёр гурав хоног Төмөрбаатараар архи даалгаж уусан мөртлөө өөрөө ганц ч шил архи авсангүй. Тиймээс Төмөрбаатарын уур хүрч хармаанаас нь түрийвчтэй мөнгийг нь авч нэг шил архи аваад уучихаж. Төдөлгүй нөгөө нөхрийн авгай нь мөнгөө нэхээд ирэхэд “Май, энийгээ ав” гээд түрийвчтэй мөнгийг нь нүүр лүү нь шидтэл нүүрийг нь жаахан халцалчихсан юм байх. Тэгээд л хүний гоо сайхан сэвтээсэн, бусдын эд хөрөнгөнд халдсан гэдгээр дөрвөн жилийн ял аваад Мааньтын чангад очжээ. Даанч харамсмаар. Бас нэг удаа наранд гарч ирээд ажил төрөл ч олдохгүй, ёстой л хог дээр гарчээ. Шоронд ял эдэлсэн болохоор албан газрууд ажилд авна гэж байхгүй. Тиймээс тэр аргагүйн эрхэнд хүний хармаа суйлж 400 төгрөг аваад онцгой дэглэмийн шоронд очсон байгаа юм. Энэ мөнгөө эргүүлээд төлчихсөн байна. 400 төгрөгийн төлөө хүнийг ингэж олон жил шоронд тарчлаахын зэрэгцээ онц аюултай рецедивист гэмт хэрэгтнээр цоллож нэгэн насны хувь заяагаар нь тоглож орхижээ. Эдүгээ 400 төгрөг битгий хэл, дөрвөн сая, цаашлаад 400 сая төгрөг идчихээд шоронд орохгүй аргалаад яваад байгаа өчнөөн хүн байж л байна. Хүмүүжүүлэх гэж байгаа

шорон гянданд нь хүмүүжих ямар ч үндэс байхгүй. Харин ч бүр улам муу юм сургаад хүн чанарын хэлтэрхий ч үгүй болгоно гээч. Ер нь төр засаг өөрийнхөө дайсныг өөрөө бэлдэж байгаа юм. Харин Хорлоогийн Төмөрбаатарын хувьд гэвэл 36 жил ял эдлээд гарч ирэхдээ ааш авир, зан суртахуун нь огтхон ч эвдэрсэнгүй. Тэрбээр “Би 36 жил шоронд огт зүгээр суугаагүй. Наранд байгаа хүн найман цаг ажилладаг бол би арван цагийн хөдөлмөрийг 36 жилийн турш хийлээ. Улс нийгэмд би сохор зоосны ч хохирол учруулаагүй. Надаар 36 жил үнэгүй ажил хийлгэчихээд өнөөдөр намайг нохойн гөлөг шиг наранд гаргаад хаячихлаа. Үгүй ядаад иргэний паспорт өгчихөж болно. Насны эцэст ингэж л хохирдог юм байна. Ямар сайндаа л үхэх тухай бодож байх билээ дээ. Надад ганц охин байсан, хүнд алуулчихсан. Хандаа гэдэг ганц охин маань Дандар гэдэг залуутай сууж “Таван шар”-д амьдарч байсан. Тэгтэл Дандар нь архины халуунаар агсам тавиад маслын хутгаар гэдэс рүү нь дүрээд алчихсан. Охин маань тэр үедээ жирэмсэн байсаныг хэлэх үү. Оршуулах үед нь би шоронд байсан. Нөхөр нь хоёр хүний аминд халдсан хэргээр онцгой шоронд очоод бие нь муудаад үхчихсэн сураг дуулдсан. Уг нь охин минь амьд мэнд байсан бол мах цусны минь тасархай байлаа. Одоо надад үр удам юу ч алга. Шоронд би атаман явсан гэж худлаа хэлэхгүй. Гэхдээ би 36 жил болохдоо бусдад дээрэлхүүлж явсангүй. Ямар ч гэсэн өөрийнхөө амийг тээгээд мужаан, сийлбэрчин хийгээд энэ олон жилийг өнгөрөөлөө. Зан суртахууны хувьд би энэ олон жил харин ч эвдрээгүй гарч ирлээ. Энэ бол асар их тэвчээр юм шүү. Нарны сайхан амьдралыг хоолоо идэж байсан ч бодно, шөнө унтаж байсан ч зүүдэлнэ. Ээ дээ, залуучууд минь. Нарны сайхан амьдралыг нарсны амьдралаар сольсон хүн насаараа хохирдог болохыг “Хоовон” Төмөрбаатар миний амьдрал гэрчилнэ” гэж билээ.

## Орос, Монгол хоёр улсын хоригдол солилцооны шугамаар Улаан-Үдийн чанга дэглэмтэй шоронгоос мултарчээ

Гучин насыг шүргэж буй Түмэнхүүгийн Наранбаатар залуу зандан насныхаа 15 жилийг шоронд өнгөрөөсөн болохоор түүнд баяр баясгалантайгаар эргэн дурсах зүйл хомс байлаа. Хүүхэд ахуй насны дуртгал нь ч олигтой бууж өгсөнгүй. Хүний амьдралын хавар гэгддэг залуу насны тэр л үеүд нь хар зам татуулан өнгөрчээ. Харин сүүлийн хоёр жилд эх нутгаа, ээж, дүүгээ урьд өмнө нь хэзээ ч санаж мөрөөдөж яваагүйгээр их санажээ. Тэрбээр одоогоос хоёр жилийн өмнө Мааньтын хорих ангиас суллагдаад гэртээ хэдхэн сар болов уу, үгүй юу гадаад руу явмаар санагджээ. Тэгээд шоронд хамт ял эдэлж байсан хоёр нөхрийнхөө хамт иргэнийхээ паспортанд хавсралт хийлгэж аваад хойд хөршийг зорьсон байна. Ингэж явахдаа Сэлэнгийн хэдэн залуутай нийлж Наушк, Улаан-Үд, Эрхүүгээр ёстой нэг жуулчлах шиг болжээ. Өөрийн санаснаар Улаан-Үд хот орчмоор хоёр долоо хоног тэнүүчлээд, тэндээсээ Эрхүү рүү хөдлөх болж гурван нөхрийнхөө хамт галт тэргэнд суужээ. Энэ удаа ачаа тээш ч гэсэнгүй. Замдаа уухаар үүргэвчиндээ хэдэн шил архи хийгээд л болчих нь тэр. Гэвч тэд зорьсон газраа эсэн мэнд хүрч чадсангүй. Галт тэргэнд ууж согтууран улмаар хоорондоо муудалцан зодолджээ. Тэгээд нэг л мэдэхэд нэгнийхээ амийг хороосон байж. Энэ хэрэгт Түмэнхүүгийн Наранбаатар идэвхийлэн оролцсон тул хүн амины хэргийн гол хэрэгтэн болж хувирчээ. Төдөлгүй тэрбээр харийн нутагт ОХУ-ын Эрүүгийн хуулиар шийтгэгдэж 12 жилийн хорих ялыг чанга дэглэмтэй колонид эдлэхээр болжээ. Ийнхүү Монголын нэгэн залуу Оросын шоронгийн хаалгыг татах нь тэр. Угийн сургууль соёлоор яваагүй түүнд бүх зүйл хүнд байв. Хэл мэдэхгүйн зовлон, ганцаардахын зовлон, ээж, дүү нараа санахын зовлонг амсч эхэлжээ. Оросын шорон ахуй хангалт, үйлчилгээ сайн хэдий ч яагаад ч юм нутагтаа очиж ялаа эдлэхсэн гэсэн бодол цаг үргэлж толгойд нь эргэлдэнэ. Эндхийн бүх юм нэг л нүсэр. 6000 хоригдолтой тус колони Улаан-Үдийн нутаг дэвсгэрт байрлах агаад эрхлэх ажил нь олон төрөл. Барилга барьж хоёрдогч түүхий эдээр элдэв бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Бас машины релей угсарна. Автомашин засварын хоршоолол ч ажиллана. Мебелийн цехэд нь гал тогооны гоёмсог мебель үйлдвэрлэнэ. Наранбаатар мебелийн цехэд хуваарилагджээ. Эндхийн шоронгоос оргох ямар ч арга байхгүй аж. Харуул хамгаалалт гэдэг нь бөх бат хэрэм л гэсэн үг. Жаахан л зөрчил гаргавал хатуу шийтгэнэ. Гадаадынхан голдуу байдаг шорон нь Москвагаас холгүй Мордов гэдэг газар байдаг гэж хүмүүс ярилцана. Наранбаатар Улаан-Үдийн шоронд орсон өдрөөсөө эхлээд хоёр жилийн турш өргөдөл бичжээ. Тэр нь ердөө эх нутгийнхаа хорих лагерьт шилжихийг хүссэн өргөдөл байлаа. Улаан-Үд нь Монголтой хил залгаа мөртлөө тэндхийн шоронд Наранбаатараас өөр ганц ч монгол хүн байсангүй. Оросын бусад хотуудад гэмт хэрэг үйлдээд ял авсан монгол хүмүүс ихэвчлэн олон улсын тодотголтой Мордовын шорон руу ачигддаг ажээ. Наранбаатар Улаан-Үдийн шоронд байх гурван жилийн хугацаандаа нутаг усныхаа талаар өчүүхэн ч мэдээ сонссонгүй. Сурсан зүйл гэвэл оросоор ойр зуур ярьдаг болжээ. Тэгж байтал нэг өдөр хорих ангийн нэг хошууч “Чамайг удахгүй нутгийн чинь шорон руу шилжүүлж магадгүй. Манай нэг ялтан танай шоронд байгаа юм. Чи нэг ёсондоо хоригдол солилцооны ажиллагаанд орчихлоо” гэж дуулгажээ. Үүнийг сонсоод Наранбаатар маш их баярласан байна. Хүний нутагт, тэр тусмаа харийн нутгийн шоронд ганцаараа байна гэдэг яг л тамд орсонтой адил байж. Ингээд нэг л өдөр Орос, Монгол хоёр улсын хоригдол солилцооны шугамаар эх нутаг руугаа ачигджээ. Наранбаатар тухайн үед “Намайг эх нутагтаа хөл тавихад тус дөхөм болсон



ямар гээчийн орос хоригдол байгаа бол. Түүнтэй ядаж нүүр нүүрээ харалцах юмсан” гэж бодож байжээ. Гэтэл яг түүний хүссэнээр Наушк дээр орос, монгол хоёр хоригдолыг албан ёсоор солилцсон бөгөөд Наранбаатар хууз сахал бүхий өндөр шар орос залууг тэвэрч аваад өөрийн мэдэлгүй үнсч орхисон гэдэг. Цаад орос нь ч баярлаж байгаа нь илт байж. Ер нь аливаа хүний төрсөн нутаг гэдэг юугаар ч сольшгүй үнэт эрдэнэ байдаг бололтой. Улаан-Үдийн чанга дэглэмтэй шоронд гурван жил тарчилсан Наранбаатар өмнө нь бодоогүйгээ бодож, санаагүйгээ санаж “Төрсөн газар нутаг гэдэг чинь хамгаас үнэтэй зүйл юм. Урьд нь би үүнийг ойлгодоггүй ухаардаггүй байж. Архинаас л болж хамаг амьдралаа үрэн таран хийлээ дээ” гээд уртаар шүүрс алдан суужээ.

## Үүдэн шүднүүдээ бахиар суга татуулаад хохирох байтал харин ч бүр завшсан байна

Энд өгүүлэх Нордовын Төгсбаатар шоронд очоод дээд доод үүдэн дөрөв, нийлээд найман шүдээ суга татуулжээ. Энэхүү хачирхалтай явдлыг өгүүлэхээс өмнө түүнийг нарны амьдралд хэрхэн манаргаж явсан тухай өгүүлье. 23 настай Төгсөөг нүдэндээ нулимс цийлэгнүүлээд халхын шорон руу ачигдахад ойр дотны нь олон хүн өрөвджээ. Гэвч тэр төрсөн эх, ах дүү нараа асар ихээр гомдоосон нүгэлтэн байв. Тэрбээр анх өөрийн төрсөн ах Төгсбатыгаа мал болтлоо согтон унтаж байхад гэрийх нь түлхүүрийг сэм авч хувилуулж авсанаар хулгайн замдаа шуударчээ. Тэгээд ах эгч хоёрыгоо эзгүй хойгуур хувилсан түлхүүрийнхээ тусламжтайгаар өнгөт телевизор, систем хөгжим зэргийг хулгайлж аваад бараан зах дээр хямдхан зарж мөнгөөр нь хэд хоног тансаглажээ. Ах Төгсбат нь хулгайд алдагдсан эд зүйлээ цагдаад тэмдэглүүлсэн болоод л өнгөрсөн байна. Гэтэл энэ явдлаас хоёр сарын дараа Төгсбатын гэрээс наймааных нь ашиг орлого болох 300 мянган төгрөг алдагджээ. Бас л гайхшаа бараад цагдаад хандсан байна. Хаалганы цоож цуурга бүтэн, цонх тагт нь түгжээтэй байхад долоон давхарт хулгай орсон нь нэн сонин. Төгсбат энэ тухай ээждээ хэлэхэд “Та нар мөнгө төгрөгөө ажил дээрээ орхисон юм биш үү. Энд тэндээ сайн үз” хэмээжээ. Гэвч хэн нэгэн хүн гэрийн нь түлхүүрийг хувилж аваад хулгай хийгээд байгааг Төгсбат гадарласан болохоор эхийнхээ үгийг тоосонгүй. Харин хулгайчийг хэрхэн яаж, барих аргыг боловсруулжээ. Тэгээд хэдэн өдрийн турш байрныхаа гаднаас тандалт явуулсан байна. Өглөө ажилдаа явж байгаа дүр эсгээд машинаа асаагаад хөдөлсөнөө төдөлгүй байрныхаа гадаа сэмхэн ирж алсаас тандах жишээтэй. Нэг өдөр тэрбээр байрныхаа гадаа машин дотроосоо тандалт хийж байгаад жолоогоо дэрлээд нам унтаж орхижээ. Оройн зургаан цагийн үед сэрээд хартал том өрөөний нь гэрэл цэлсхийтэл асчихсан байж. Төгсбат эхнэрээ ирсэн юм болов уу гэж бодоод түүн рүү утасдтал “Би одоо л гэр лүүгээ явж байна” хэмээжээ. Тиймээс Төгсбат шууд цагдаа дуудсан байна. Ойролцоо явсан хөдөлгөөнт эргүүлийн машин нэг их удалгүй давхиад ирж. Төгсбат хулгайчийг үйлдэл дээр нь барихаар баахан цагдаа дагуулаад долоон давхраад өгсчээ. Тэгээд хаалгаа түлхүүрдэж онгойлгоод дотогш ортол төрсөн дүү Төгсбаатар нь зочны өрөөнийх нь том хивсийг хуулаад зогсч байх нь тэр. Ахыгаа болон төрийн цагдааг орж ирэхийг хараад Төгсбаатарын царай зэвхий даагаад л явчихаж. Төгсбатад үнэндээ хэлэх үг олдсонгүй. Дэмий л дүүгээ нам цохиж унагаад “Энэ миний төрсөн дүү. Би өөрөө учрыг нь олъё” гэж хэлээд хөдөлгөөнт эргүүлийнхэнийг явуулжээ. Тэрбээр Төгсбаатарыг татаж босгоод нүүр нүд рүү нь хэд сайн цохиж өгөөд “Өмнө нь чи бас телевизор, хөгжим, 300 мянган төгрөг хулгайлаа биз. Тэгээ биз дээ чи” гэж зандрахад цаадах нь “Ах аа, би авсан нь үнэн. Одоо би танайхаас дахиж хулгай хийхгүй” гэж уйлан дуулжээ. Төгсбат түүнийг чирч гулдран дагуулж гараад машиндаа суулган авч давхисаар ээж дээрээ авчирсан байна. “За нөгөө манай гэрийг удаа дараа тоносон айхтар хулгайч чинь энэ байна” гэхэд ээж нь Төгсбаатарыг загнахын оронд харин ч бүр өмөөрөөд “Миний муу хүүгийн нүд амыг ийм болгочихдоо яахав дээ. Нэг муу телевизор, хөгжим зэргийг төрсөн ахаасаа хулгайлж аваа л биз. Юун сүртэй юм бэ. Ямар танихгүй айл ухчихсан биш. Зулай зулайгаа гишгэж төрсөн дүүгээ ингэж зодохдоо яадаг юм бэ. Тэр муу телевизорыг чинь би төлөөд өгчихнө” гэх зэргээр ухаангүй аашилжээ. Ингэснээр Төгсбаатарыг улам давруулж орхисон байна. Тэрбээр ах дүү, хамаатан садныханаа тонож дуусаад “Даварсаар даварсаар Дагвын оронд” гэгчээр дээрэм, булаалтын хэрэг өдүүлж эхэлжээ. Тэр ч байтугай нэг удаа төрсөн эгчийгээ танилгүй булган малгайг нь шүүрч аваад зугтсан байгаа юм. Лифт зогссон хойно

шатаар уухилан өгсч явсан эгчийнхээ малгайг хэнэг ч гүй шүүрээд доош зугтсан бөгөөд эгч нь орцны жижүүрээс “Сая нэг дээрэмчин малгай шүүрээд зугтчихлаа. Харав уу” гэхэд цаадах нь “Юун дээрэмчин байх билээ. Чиний дүү Төгсбаатар л сая гартаа нэг юм бариад гараад гүйчихлээ шүү дээ” гэсэн гэдэг. Төдөлгүй Төгсбаатарыг гэмгүй царайлаад гэртээ орж ирэхэд эгч нь “Чи байтлаасаа миний малгайг шүүрдэг болох нь ээ. Арай дэндэж байгаа юм биш үү. Алив тэр малгай аваад ир” гэхэд “Юун малгай, би мэдэхгүй” гэж тас гүрийжээ. Нэгжиж үзвэл халааснаас нь хоёр мянган төгрөг, хугас шил архи гарч ирсэн байна. Гэвч нэгэнт түүнийг үйлдэл дээр нь гардаж чадаагүй болохоор энэ асуудал тэгсхийгээд өнгөрчээ. Харин хоёр хоногийн дараа ойролцоох дэлгүүрийн авгай Төгсбаатарын эгчийн саарал булган малгайг духдуулчихсан явж байгаад Төгсбаатарын ээжтэй тааралдчихжээ. Ээж нь бас л хүүгээ өмгөөлж хамгаалах маягаар худалдагч авгайд хандаж “За чи наад малгайгаа хамаагүй өмсч болохгүй шүү. Өчигдөр манай хүү эгчийнхээ малгайг шүүрээд чамд зарсан болж таарлаа. Энэ тухай эгч нь мэдэх юм бол бөөн хэрүүл болно. Чи ер нь манай хүүд хэдэн төгрөг өгсөн юм бэ. Би тэр мөнгийг чинь нэг дахин ихэсгээд өгье. Харин наад малгайгаа яг одоо надад өг” гэхэд цаадах нь ч дуртайяа зөвшөөрсөн байна. Төгсбаатар эгчийнхээ булган малгайг худалдагч авгайд нэг шил архи, хоёр мянган төгрөгөөр өгсөн бөгөөд ээж нь худалдагч авгайд арван мянган төгрөг өгч байж охиныхоо булган малгайг олж авчээ. Тэгэхдээ Төгсбаатарын талаар ганц ч үг ганхийлгүйгээр “Чиний булган малгайг би цагдаагийн хэсэгт тэмдэглүүлчихсэн юм. Өчигдөр нэг хулгайчийг цагдаагийнхан барьсан байна. Тэр хулгайч чиний малгайг шүүрчихсэн юм байна шүү дээ. Гэтэл орцны жижүүр та хоёр хүүг маань хилс хэрэгт гүтгэж л байдаг. Одоо дүүгээсээ уучлал гуй” гэж маанагтжээ. Эх хүн төрсөн үрдээ хайртай байж болно. Гэхдээ ингэж хайрлах нь утгагүй юм. Хүүгээ хайрлах биш харин ч бүр хохироож, давраулж, өөгшүүлж байгаа хэрэг. Үүний оронд “Чи ямар муухай хулгайч хүүхэд вэ. Дахиад чамайг хулгай хийсэн байвал мөчийг чинь хуга цохино шүү” гэж зандраад алгадаад авах ёстой байлаа. Эцэг нь аль эрт бурхан болж, ээж нь бусдаас өмөөрсөөр байгаад Төгсбаатарыг буруу эрхлүүлж, бухын хүзүүнээс хатуу зан суртахуунтай, хулгайч сэтгэхүйтэй болгож орхижээ. Сүүлдээ Төгсбаатар шоронгоос суллагдсан хэдэн хулгайч залуугийн хамт албан газруудыг тонодог болсон байна. Бүр албан газрын үүдэнд ачааны машин тулгаж зогсоогоод, манаачийг нь суудал дээр нь хүлж орхиод л эд хогшилыг нь ачдаг болжээ. Тэгэхдээ бас зүгээр байхгүй. Эсэргүүцсэн манаачийн эрүү амыг хуга цохиж таашаал авдаг байж. Гэвч тэрбээр олон хавар нэгэндээ гэгчээр 2005 оны дөрөвдүгээр сарын нэг бүүдгэр шөнө гурван хулгайчийн хамт үйлдэл дээрээ баригджээ. Төгсбаатар хувь хүн, албан байгууллагуудад олон арван сая төгрөгийн хохирол учруулахаас гадна тав зургаан манаачийг зодож гэмтээсэн хэргээр байцаагджээ. Энэ хэрэгтээ 13 жилийн ял авсан байна. Гэвч тэр шоронд очоод “Ногоон” Андрууш хэмээх овгор ялтаны банди болж үйлээ үзжээ. Ингэснээр төдөлгүй дээд доод үүдэн найман шүдээ суга татуулсан байгаа юм. Учир нь Андрууш түүнд заримдаа бэлэг эрхтэнээ хөхүүлэх боловч шүд нь бэлэг эрхтэнийг нь нухаад зовоодог байж л дээ. Тиймээс тэр нэг өдөр “Чи наранд байхдаа тав зургаан манаачийн эрүүг хуга цохьсон гээ биз дээ. Яасан их хүн хохироодог хулгайч вэ. Одоо чи гэмгүй хүнийг хохироосныхоо горьг амсах болж дээ. Гэхдээ би чиний эрүүг хуга цохихгүй. Харин бэлэг эрхтэнийг маань нухаж зовоогоод байдаг шүднүүдийг чинь суга татна” гээд юу юуны туханд хүрэлгүй дээд доод найман шүдийг нь бахиар суга татаж орхисон байгаа юм. Одоо яая гэхэв. Гэмгүй хүнийг хохироож тарчлаасан хүн өөрөө хэзээ нэгэн цагт үйлийнхээ үрийг эдэлдэг ёсон бий. Энэ цагаас эхлээд “Шүдгүй” Төгсбаатар хэмээх банди шоронгийн шуумаруудын бэлэг эрхтэнийг бувалзтал хөхөж “од” болсон гэдэг. Үүнийхээ хүчинд тэрбээр хүнд хүчир ажил хийхгүй, овгоруудаар тэжээлгээд л

хэвгэж байдаг болж. Хоригдолууд түүнээс “Чи үүдэн шүднүүдээ суга татуулаад хохирсон уу, завшсан уу” гэж асуухад “Юуны чинь хохирох. Харин ч бүр завшсан. Та нарыг харж байхад би ажилд гарахгүй, амттан шимтэнээр дайлуулаад сайхан л байгаа биз дээ. Шүдээ суга татуулсанаар надад шоронд хоолоо олж идэх сайхан боломж бүрдсэн юм даа. Тэгтэл та нарыг хийх гэж яаж зовж байна. Харин би бол ганц хоёр атаманы эрхтэнийг хөхөөд л ажлаа хийчихэж байна шүү дээ. Ертөнцөд ийм амархан ажил байхгүй” гэж томордог болсон аж.

## “Онгоон” Хасчулууны өдүүлсэн олхиогүй хэрэг

Соц нийгмийн үед хугацаат цэргийн албан хаагчид харьцааны зөрчлөөс болж янз бүрийн гэмт хэрэг үйлдэж, зарим нь үүрдийн тахир дутуу болж, амь насаа алдсан хэрэг нэлээд гарч байсан нь нууц биш. Гэвч иймэрхүү хэргийг төрийн зүгээс учиргүй нууцалдаг байсан юм. Тухайлбал 1980-аад оны дунд үед хуучин цэргүүдэд дэглүүлж залхсан нэгэн шинэ цэрэг хоёр түрүүчээ АКА буугаар шүршиж алаад, нэг байлдагчийг барьцаалан зугтсаныг тухайн үед олон түмэнд мэдээлэлгүй нам дарж орхижээ. Тэр үед Зүүнбаянгийн цэргийн анги салбарууд байрлалаасаа 10 гаруй км-т орших зэвсэгийн агуулахын харуулд долоо хоногийн хугацаатай ээлжлэн гардаг байж. Нэг удаагийн харуулд түрүүч Гантайхүү харуулын даргаар, бага дарга Батноров манаа халагчаар, гурван шинэ цэрэг цагийн манаачаар томилогдсон байна. Гурван шинэ цэргийн нэг болох байлдагч Загдсүрэн хүний арга эвийг олчихдог гайгүй сэргэлэн нэгэн байсан тул хоёр бага даргынхаа ивээлд багтан тогооч хийж, гэдэс цатгалан эрх дураараа жаалдаг байж. Харин Хасчулуун, Мягмарсүрэн хоёр нь тулаа манаанд ээлжлэн гараад зогсохгүй ихэнхдээ л ходоод дундуур, нойр дутуу, зүгээр ч үгүй хоёр түрүүчийнхээ гарын загатнааг үе үе гаргаж үйл тамаа үздэг байж. Гэхдээ байлдагч Хасчулуун нэлээд хор шартай, өөрт нь байнга л пээдэлздэг Гантайхүү, Батноров хоёрыг үзэн ядахаас гадна тэдний эрх хав Загдсүрэнд ихэд агаархдаг, ямар сайндаа л “Энэ муу бага дарга нарыг халагдаад явахад Загдсүрэн чамайг цустай чинь хутгана даа” гэж шазуур зуух жишээтэй. Харин Мягмарсүрэн нь номхон нь дэндсэн ноолгор цэрэг болохоор бага дарга нартаа яаж ч зодуулж нүдүүлж байсан элдэв юм санана гэж байхгүй. Хасчулуун нэг өдөр түүнд хандаж “Хоёулаа энэ муусайнуудад ингэж дээрэлхүүлж байхаар хот руу оргоё” гэхэд жаахан пайнагдуу цаадах нь “Өө, яршиг. Аав загнана” гэсэн гэдэг. Хар нялхаасаа эхлээд л хойд эцгийнхээ дарамтанд өсч торнисон Мягмарсүрэн үнэхээр зүрхээ авахуулчихсан, бага дарга нар нь дарамталж байсан ч ингэх л ёстой гэж боддог цөлх нэгэн байж. Тэр ч байтугай муу муудаа дээрэлхүү, муна нь гадсандаа дээрэлхүү гэгчээр Хасчулуун хүртэл түүнийг дээрэлхэж, зарим үед өөрийнхөө оронд харуул манаанд гаргаад хэдэн цагаар зогсоочихдог байж. Цаадах нь өлсч ядарч, даарч хөрч байсан ч зогсч л байдаг, ёстой л нөгөө Чингиз Айтматовын “Зуунаас ч урт өдөр” зохиолд гардаг толгойгоо ширлүүл-чихсэн “Манкурт боол” шиг хөдөлгөөнгүй нэгэн байсан бололтой. Нэг орой харуулд гарч байгаад түрүүч Гантайхүү байлдагч Хасчулууныг шалихгүй зүйлээс болж хоёр шанаадсан нь өмнөх хорсол занал дээр нь тос нэмж орхижээ. Манаанд гарч байсан Хасчулуун постоо түр орхиод харуулын байрны үүдэнд ирээд хаалгаар нь сэм шагайвал түрүүч Гантайхүү, бага дарга Батноров, байлдагч Загдсүрэн гурав өөх тос халгисан цуйван идээд сууж байжээ. Үүнийг хараад өлсгөлөн Хасчулууны уур улам дүрэлзээд иржээ. Гэсэн ч тэр шууд яваад орчихсонгүй. Хэсэг байж байгаад хаалгаар сэм шагайвал хоёр бага дарга бод идсэн боохой шиг идсэн хоолондоо цохиулаад орон дээр тэрий хадан дугжирцгааж, харин байлдагч Загдсүрэн гал тогооны өрөөнд амандаа дуу аялсан шиг аяга таваг угаагаад зогсч байсан байна. Уур нь хүрч уушиг нь сагсайсан Хасчулуун гадаа харуулд зогсоо Мягмарсүрэндээ хандаж “Ер нь энэ муусайнуудад хэдий болтол ингэж дарлуулах юм бэ. Чи бид хоёрт юун төлөө буу, сум байгаа билээ. Хоёулаа эд нарыг нухчих уу” гэхэд цаадах нь “Өө, үгүй үгүй. Аав загнана” хэмээн өмнөх шигээ пайнагтжээ. Тэгтэл Хасчулуун түүнийг алгадаж авсанаа “Чи ч ёстой бусдад дээрэлхүүлж байхдаа таарсан новш юмаа. Дуугүй л миний хий гэснийг хий” гээд под сумканаас нь жаран сумтай магазиныг нь авч буундаа сумлаад түүнийг дагуулан дотогш оржээ. Байнга л гарынхаа чилээг гаргаж байдаг хоёр

нусгай цэрэг нь буу, сум агсчихсан “Босоцгоо” гэж сүртэй зандрахыг хараад хоёр түрүүч “Муусайн шинэковууд яаж даварч байна аа. Ална шүү” гээд өндийхөд Хасчулуун “Хэн нь хэнийгээ алах бол доо” гээд шууд л автомат буугаар шүршиж орхижээ. Хажууд нь зогсоо Мягмарсүрэн айснаасаа болоод өмдөндөө шээс алдчихаж. Энэ үед буун дуу сонсоод сандарч тэвдсэн Загдсүрэн гүйн орж ирэхэд хайрлаж хамгаалдаг хоёр түрүүч нь аль хэдийнэ амь тавьчихсан бөөн цусан дунд хэвтэж байх нь тэр. Царай нь цонхийж цайсан Хасчулуун “Чи юуг нь хараа вэ. Хоёр новш л үхсэн байна даг. Чи энэ хоёр шигээ энд үхэх үү, эсвэл бид хоёртой цуг явах уу” гэж тулгаж асуухад айснаасаа болоод цөс нь хагарах шахсан Загдсүрэн тэдэнтэй хамт явахаар дуугүй л толгой дохин зөвшөөрчээ. Ингээд Хасчулуун нэг ёсондоо Мягмарсүрэн, Загдсүрэн хоёрыг хүчээр барьцаалаад харуул-ынхаа байрыг тэр чигт нь орхиод зүүн хойд зүгийг барин оджээ. Учир нь Хасчулуун нь Сүхбаатар аймгийн харъяат бөгөөд амьхандаа нутгаа бараадаж байгаа нь энэ. Хасчулуун нөгөө хоёроо дагуулан таамгаар нутгаа зүглэн нэг хоног яваад жижиг горхин дээр ирж, харуулынхаа байрнаас авч гарсан хүнснээсээ идээд хэсэг амарчээ. Тэрбээр Загдсүрэнг зугтаж мэднэ гээд хажуунаасаа алхам ч холдуулахгүй явсан бөгөөд 24 цагийн турш унтаагүй болохоор аргайгүй л үүрэглээд эхэлсэн байна. Гэхдээ тэр бас хөөрхөн муу санаа гаргажээ. Загдсүрэнгээс сэрэм-жилж байгаа нь тэр гээд сумтай магазинаа буунаас нь салгаж аваад өвөртөө хийхдээ “Чи муу бас сумтай магазин авах санаатай юу. Чадахгүй юм чинь. Чамайг өвөр лүү тэмтрэх л юм бол би сэрээд автоматаар шүршиж орхино шүү” гэж заналхийлжээ. Тэгээд Загдсүрэн, Мягмарсүрэн хоёрыг хажуудаа аваад нам унтаад өгч. Харин энэ хооронд Загдсүрэн түүнээс илүү муу санаатай, сэргэлэн болох нь ойлгогджээ. Тэрбээр унтсан хүн болж худлаа баахан хурхирч байгаад сэмхэн босч Хасчулууны бууны буцаах пүршийг аваад харанхуй жалга уруудан алга болж өгчээ. Буцаах пүршгүй буу яаж ч буудах билээ дээ. Үүнийг цөлх ухаантай Хасчулуун ухаарсангүй. Загдсүрэн харахнуй жалганаас гараад зам дагуу гүйж явтал аз болж нэг машин таарсан бөгөөд жолоочид бүх учрыг тайлбарлаад цэргийн анги дээрээ хүргүүлж дарга нараа түргэн авахуулсан байна. Хоёр түрүүчийг амь насаа алдаад бүтэн 24 цаг болж байхад дарга нар нь огт мэдээгүй, тэднийг харуул манааны үүрэг гүйцэтгэж байгаа гэж итгээд л сууж байсан байгаа юм. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчээр цэргийн анги түгшүүрийн дохиогоор жигдэрч, офицеруудын зэвсэг-лэсэн групп Хасчулуун, Мягмарсүрэн хоёрын байгаа газар луу яаравчлан хөдөлжээ. Хасчулуун үүр хаяарч байх үед “Байлдагч Хасчулуун босоод гараа өргө” гэсэн чимээнээр сэрээд өврөө тэмтчин магизинтай сумаа гаргаж автомат буундаа угсраад “Хохь чинь шүү. Ойртсоныг чинь шүршинэ шүү” гэж хашгирчээ. Гэтэл өөдөөс нь “Байлдагч та шүршиж болно. Тэгээд шүршээч дээ” гэж даапаалах нь тэр. Хоёр хүн алж цагаандаа гарчихаад байгаа Хасчулуун ч элдэв юм бодож саналгүйгээр гохоо даржээ. Гэвч буцаах пүршгүй буу нь түүний санасан үйлдлийг гүйцэтгэсэнгүй. Ингэж тэр баригдсан бөгөөд өс хонзонгийн сэдэлтээр хоёр бага даргаа хөнөөсөн тэрбээр цаазаар авахуулаагүй нь хачирхалтай. Хоёр бага дарга нь өөрсдөө түмэн буруутай байсан болохоор арга ч үгүй юм. Энэ хэрэгтээ Хасчулуун хорин жилийн ял авч, харин бусдыг алах гээд буу, сум болж явахад эсэргүүцэл үзүүлэлгүй хүлцэнгүйгээр дэм тус болсон Мягмарсүрэн долоон жилийн ял авчээ. Хожим сонсохнээ халхын шоронд “Онгоон” Хасчулуун гэсэн нэр дуулдах болсон бөгөөд тэрбээр хоёр хүний аминд хүрсэн зүрх зоригтой, юу ч хийхээс буцдаггүй гэх мэтийн шалтгаанаар халхын шоронд бас нэр алдраа дуурсгаад авсан байгаа юм.

## **Нэгэн цагт харгис хянагч байсан бумтогоо ялтануудын авран хамгаалагч болохоор шийджээ**

Нийгмийн уур амьсгал, амьдралын нөхцөл байдлаас болж зарим хүний үзэл бодол 360 градус болж өөрчлөгдөх юм даа. Соц нийгмийн үед “Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи” мөн гэх зэргээр чангаар хашгирч явсан час улаан коммунист 1990 оны ардчилсан хувьсгалын дуулианаар гэв гэнэт л үзэл бодлоосоо урваад лам, зурхайч болж байсан нь олонтаа. Хүн үзэл бодлоосоо бага зэрэг урваж болно л доо. Гэхдээ шашныг үзэн яддаг байсан час улаан коммунист хүн алга эргүүлэхийн хооронд лам, зурхайч болж 360 градус өөрчлөгдөх нь арай л дэндсэн хэрэг. Ийм туйлбаргүй хүнд сүсэгтэн олон итгэнэ гэж юу байхав даа. Гэсэн ч гэнэн итгэмтгий монголчууд итгэж бишрээд л байсан юм даа. Тэгэхээр хамгийн гол аюул нь гэнэн итгэмтгий монголчуудад л байгаа юм. Энэ тухай юунд өгүүлэв гэвэл 1990-ээд оны үед сэжигтэн, ялтануудыг үзэн яддаг, аймшигтайгаар залхаан цээрлүүлдэг байсан Бумтогоо хэмээх хянагч эдүгээ тэтгэвэртээ гарчихсан, эргээд мөнөөх үзэн яддаг ялтанууддаа жигтэйхэн хайртай болчихсон, тэдний эрх ашгийг хамгаалах нэрийдлээр эвсэл холбоо байгуулах гээд цохиж явна. Мань эр хоригдолуудад хайртай болчихсондоо ингэж яваа юм биш юмсанж. Сүүлийн жилүүдэд хүний эрх, эрх чөлөө гэдэг утгаар хоригдолуудад гадаад дотоодын буяны байгууллагууд тусламж дэмжлэг нэлээд үзүүлдэг болсон, мөн элдэв шашны байгууллагууд энд тэндхийн хорих ангиудад тусламжийн гараа сунгах нь их болсон бөгөөд энэ бүхнийг гардан хэрэгжүүлэхийн тулд хоригдолуудын эрх ашгийг хамгаалдаг ямар нэгэн холбоо байх ёстой болоод байгаа юмсанж. Энэ асуудал одоогоос хэдэн жилийн өмнөөс л яригдаж эхэлсэн билээ. Ямар сайндаа л Түвдэндорж аваргын хүү Дагвачимэд хэмээх “сайн эр” хоригдолуудын эрх ашгийг хамгаалдаг холбоо байгуулна гэж олон жилийн турш ярьж явсаар түүнийгээ ч байгуулсан юмгүй өөрөө гэмт хэрэгт холбогдоод шоронгийн хаалга татчихаад байгаа. Харин эдүгээ энэ асуудлыг нэгэн цагт хянагч байсан Бумтогоо хэмээх эр шүүрээд авчээ. Гэвч 1990-ээд оны үед түүний гар дээр “тэлчилж” байсан олон арван хүн Бумтогоог хоригдолуудын сайн сайханы төлөө явах хүн хэрхэвч биш гэж үзэж байна. Тэр ердөө л хоригдолуудын нэрийг ашиглаж эсэн бусын төсөл бичээд гадаад дотоодын буяны байгууллагуудаас мөнгө цохихоор санаархаж буй бололтой. 1990-ээд оны үед Монголын шоронгуудад аймшигтай өлсгөлөн болж олон зуун хоригдол нас барсаныг тухайн үеийн хүмүүс сайн санаж байгаа. Дээр өгүүлсэн Бумтогоо тухайн үед өлсгөлөн ялтануудыг жинхэнэ чангалж явсан хүний нэг бөгөөд тэрбээр ялтануудыг өлсгөлөнгөөр үхэж үрэгдэж байх үед ямархан үзэл бодол агуулж явсан нь хэвлэлийн хуудсанд хүртэл мөнхөрч үлджээ. Тухайлбал:

**-Хоригдол олноороо турж үхэж байна. Үүнийг зогсоох арга байна уу?**

-За ямар ч байсан ойрын хоёр гурван жилдээ л байхгүйг дотор нь ажиллаж байгаа бид бол сайн мэдэж байна. Энэ өлсгөлөн тураал чинь зөвхөн шоронд бий болчихоод байгаа юм биш. Эрх чөлөөгөө хасуулсан ялтанууд байтугай эрх чөлөөтэй бид өлөн зэлмэн амьдарч байна шүү дээ. Цагдаа турж байна, цэргүүд бүр турж үхэж байхад нийгмийн хог шаар болж, эх орондоо, ард олондоо хор хүргэсэн “дайснууд” тайван цатгалан амьдрах ёс суртахууны гавьяа байхгүй. Гэтэл тэдний үхэлд хянагч биднийг буруутгаад байгаа. Яг үнэнийг хэлэхэд өч төчнөөн хүн хохироож, сэтгэл санаагаар нь тамлаад энд ирсэн ялтанууд бол үхэж байхдаа таарсан хулгайч нар шүү дээ.

-Тэгэхдээ үхэж байхдаа таарснууд нь үхэхгүй, тэдний оронд ядруу зөнгөөр улс нь үхэж байгаа шүү дээ.

-Аль нь ч ялгаагүй, хулгайч л бол хулгайч. Алийг нь ч өрөвдөх хэрэггүй.

-Хүний эрхэнд байгаа улс хэцүү л дээ.

-Хүн чинь хэзээд хүнийхээ л эрхэнд явдаг. Хуяг, харгалзагч нар чинь хулгайч, дээрэмчид биш. Манай ард түмний л нэг хэсэг, та бидний хэнд маань ч оногдож болох алба, үүрэг. Бид өөрийн дотоод ном дүрмийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулж харьцдаг цэх шударга ажилтанууд. Шорон гэдэг чинь хүний мөсгүй улсын цуглуулга болохоор ялтанууд бие биенээ дээрэлхэж бах нь ханадаг, сэтгэлийн тамиргүй араатанууд.

**-Цөмөөрөө биш байх л даа?**

-За ялгаагүй дээ. Тэдэн дотор нэг их сайн хүн ч байхгүй шүү дээ. Анх удаагийн хэрэгтнүүд л эхний нэг хоёр жилдээ гайгүй байдаг юм. Тэгээд л яваандаа хүн биш араатан болж хувирдаг юм даа.

Энэ бол Бумтогоогийн ерээд оны үзэл бодол. Түүний үгэнд “Яваандаа хүн биш араатан болж хувирдаг” гэх ноцтой үг байна. Энэ бол ялтануудыг харгалзаж хүмүүжүүлэх үүрэг бүхий засангийн ажилтаны амнаас гарах үг хэрхэвч биш баймаар. Ялтануудыг араатан болгохгүй, харин хүн болж хүмүүжүүлэхийн тулд л засангийн ажилтануудыг засаг төр цалинжуулдаг бус уу. За энэ ч дүүрсэн хэрэг. Харин 1990-ээд оны үед ялтануудыг ингэж үзэн ядаж явсан хүн эдүгээ тэдэнд дэндүү хайртай болчихсон эрх ашгийг нь хамгаална энэ тэр гээд ханхалзаж яваа нь нэг тиймэрхүү. Уг нь тэрбээр үнэхээр л бусдын төлөө дайчин шударга тэмцэж чаддаг юм бол ерээд оны тэр их өлсгөлөн, үхэл зовлонгийн үед үгээ хэлж байхгүй яав даа. Гэтэл тэр эдүгээ өнгөрсөн борооны хойноос цув нөмрөөд л гүйж явна. Нөмөрсөн цув нь ихээхэн сүржинийг яана. Тухайлбал тэрбээр дөнгөж байгуулагдах гээд дуншиж буй “Хоригдолуудын эрх ашгийг хамгаалах холбоо”-ныхоо зүгээс дэвшүүлж тавьсан нэг заалтандаа “Хоригдолд ээлжийн амралт олгох ёстой” гэж дөвчигнөжээ. Мань эр хорих ял эдлүүлэх байгууллагын өнөөгийн хуулийг үндсээр нь өөрчлөх ёстой гэж үзээд өөрөө нэг хуулийн төсөлөрхүү юм боловсруулсан байгаа юм. Түүндээ хоригдолын эрхтэй холбогдсон дараах асуудлыг хөндсөн байна.

-Зөрчил дутагдал гаргасан хоригдлын ажлын хоногийг хасах тухай заалтыг үндсээр нь өөрчилж ажлын хоног хасахгүй байхыг хүсч байна. Яагаад гэвэл зөрчил дутагдал гаргасан хоригдол сахилгад суугаад үйлдсэн гэм нүглээ цагааруулдаг. Үүн дээр ажлынх нь хоногоос хасах бол буруу. Тэд бидний л ижил хүн.

-Эргэлт уулзалтад зөвшөөрөгдсөн хүмүүсийн тоонд хадам эцэг, эхийг нь оруулах ёстой. Хэдий хоригдол ч гэлээ тэдэнд бусдыг энэрч хайрлах нинжин сэтгэл байдаг юм.

-Хоригдол ял эдэлж байхдаа улсад зөндөө ажил хийдэг. Тэр ажилласан хугацааг нь улсад хөдөлмөрлөсөнд тооцох ёстой. Хоригдолууд тэнгэр заяатай монгол хүн болж төрсөний хувьд хэзээ нэгэн цагт шоронгоос гараад улс эх орондоо сайн үйл бүтээх нь тодорхой. Мөн



шоронгоос суллагдсан хоригдолуудыг угтаж аваад ажил төрөлтэй, амьдралтай болгодог тусгай байгууллага үгүйлэгдэж байна. Ийм байгууллага байхгүйгээс ажил, мэргэжилгүй, орон гэргүй, ах дүүсгүй хоригдолууд шоронгоос суллагдаад хийх ажилгүй хэсэг гиюүрч байгаад л дахиад хулгай, дээрэм хийгээд шоронд орж байна. Тэднийг засч залруулж авах нь бид бүхний үүрэг.

-Хоригдолд ээлжийн амралт олгох ёстой. Хүн амины хэргээс бусад хөнгөн ялтай, найдвартай хоригдолуудыг жилд арав юмуу хорь хоног албан ёсоор амрааж, аав ээж, амраг садан, үр хүүхэдтэй нь уулзуулж байх нь зүйтэй. Тэд бол бидний л адил уйлдаг дуулдаг, хэн нэгнийг санаж сарвайдаг жирийн л нэг бодгаль.

-Манай шоронгуудад хоригдолуудыг хайр найргүй залхаадаг, зодож нүддэг харгалзагч олон бий. Шаардлагатай бол би үүнийг баримтаар дэлгэж чадна. Засангийн ажилтанууд албан үүрэг биелүүлэх үедээ хоригдолуудад хууль бусаар ямарваа нэгэн дарамт үзүүлэх, нэр хүндийг нь гутаах, доромжлох, занал-хийлэх, хүч хэрэглэхийг хатуу хориглох ёстой. Энэ бүхнийг зөрчсөн этгээдэд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой гэх мэтээр санаанд орсоноо бурж гарчээ. Хэн ч ингэж бурж болно л доо. Хамгийн гол нь нэгэн цагт ялтануудын эрх ашгийг ноцтойгоор зөрчиж, харааж зүхэж байсан хүн гэв гэнэт ингэж өөрчлөгдсөн нь гайхалтай. “Шорон гэдэг чинь хүний мөсгүй улсын цуглуулга болохоор ялтанууд бие биенээ дээрэлхэж бах нь ханадаг, сэтгэлийн тамиргүй араатанууд” гэж нэгэн цагт ялтануудыг үзэн ядаж байсан бол эдүгээ тэрбээр “Хэдий хоригдол ч гэлээ тэдэнд бусдыг энэрч хайрлах сэтгэл байдаг юм. Хоригдолд ээлжийн амралт олгох ёстой. Тэд бол бидний л адил уйлдаг дуулдаг, хэн нэгнийг санаж сарвайдаг жирийн л нэг бодгаль” гэх зэргээр дэндүү энэрэнгүй дүр эсгэсэн байхыг яана. Мөн тэрбээр нэгэн цагт хамт ажиллаж байсан засангийн ажилтануудаа хүртэл журамлахаар шийджээ. Одоо бол өөрөө тэнд биш тэтгэвэртээ суучихсан болохоор яаж ч худлаа томорч болно л доо. Мэдээж ялтануудыг зодож нүддэг, залхаан цээрлүүлдэг хөгийн хянагч нар байж л байгаа. Харин эдүгээ Бумтогоо тэдний алдаан дээр дөрөөлж жинхэнэ авран хамгаалагч, ардын баатар болохоор шийдсэн бололтой.

## Хурандаа Л.Санжаасүрэнгийн гэгээн дүрийг Мааньтын хоригдол чулуугаар сийлжээ

Зүүнхараагийн хорих ангийг нэг хэсэг чимээгүй аллагын газар гэдэг байлаа. Энэ нь үнэний ортой. Хүний амь гээч нь хойшоо гардаг байсан гуалингаас дор байсан гэдэг. Наад захын жишээ гэхэд л хөрөө рам дээр гуалин зүсэх гэж байгаад маш олон хоригдол банзанд гэдсээ сүлбүүлж нас баржээ. Үүний хажуугаар өлсгөлөн, тураалаар нас барсан хоригдол гэж тоймгүй. Харин энэ бүхнийг тухайн үед Хорих байгууллагын удирдах газрын даргаар ажиллаж байсан хурандаа Л.Санжаасүрэн өөрчилж чадсан гэдэг билээ. Нэг удаа Эрдэнэбаяр хэмээх ялтан хөрөө рамны банзанд тийрүүлэн унажээ. Тэрбээр маргааш өглөө нь “Гэдэс өвдөөд байна” гээд босч чадахгүй хэвтэж байтал нэг хэрцгий хянагч “Битгий баашлаад бай” гээд ташуурдан босгоод ажилд хөөж гаргажээ. Гэсэн ч тэр хоёр хөл дээрээ тогтож чадалгүй ухаан алдаж унасан байна. Түүнийг хорихын эмнэлэгт авчрахад бүдүүн, нарийн гэдэс нь тасарсан болох нь тогтоогджээ. Яг энэ үед хурандаа Л.Санжаасүрэн Зүүнхараагийн хорих ангид шалгалтаар явж байсан бөгөөд Эрдэнэбаяр түр ухаан орохдоо “Хурандаа та санаа зовох хэрэггүй. Би зүгээр” гэж хэлээд мэс заслын ширээн дээр арай ядан гараад амьсгал хураасан гэдэг. Түүний гэдэс тасраад 24 цаг болчихсон болохоор ингэх нь арга байж уу. Тэсвэр тэвчээртэй мань хоригдолыг харсан хурандаа Л.Санжаасүрэн “Та нарын дунд Павел Корчагин шиг ийм залуу олон бий” гэж хэлээд хоригдолуудыг уйлуулсан гэдэг. Энэ үг одоо болтол хорих ангиудаар яригддаг юмсанж. Хурандаа Санжаасүрэн, генерал Гарамжил хоёр нэг удаа Мааньтын шоронд зориуд очиж нилдээ бөөстсөн хоригдолуудын хувцасыг бензиндэн шатааж байсан удаатай аж. Тухайн үед 6000 гаруй хоригдолын нүд өлсгөлөнгөөр гялалзаж байхад хурандаа Л.Санжаасүрэн олон улсын хорих байгууллага болон буяны байгууллагуудын анхаарлыг Монголын хорих ангиуд руу чиглүүлж чадсан гэдэг билээ. Тэрбээр өөрийн албан хаагчиддаа өндөр шаардлага тавьдаг байсан бөгөөд нэг удаа “Зайсангийн хориход хивгээр хоол хийж өгч байна” гэсэн хоригдолын гомдлын дагуу шууд давхин очиж шуурхай арга хэмжээ авч байжээ. Тэрбээр “Хоригдолуудыг хүн ёсоор үзэж байж нийгэмд хүмүүжүүлж чадна. Тиймээс манай хорих байгууллага боловсролтой, соёлтой, бусдыг хүндэлж чаддаг хуягтай болох ёстой” гэж ярьдаг байжээ. Гэвч түүнийг 1990-ээд оны сүүлчээр гэв гэнэт л ажлаас нь халчихсан. Тэр үед хоригдолууд “Бидний хурандааг ажлаас нь халлаа” гээд бослого гаргах дөхсөн гэдэг. Түүнд хоригдолууд аль хэдийн үнэлэлт дүгнэлтээ өгчихсөн бөгөөд ямар сайндаа л Мааньтын нэг хоригдол гэгээн дүрийг нь чулуугаар сийлсэн гэдэг билээ.

## Нарны амьдралд дасан зохицоогүй учраас үхэн үхтэлээ тортой хашаанд суухаар шийджээ

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын харъяат Наранчимэгийн Болор хэмээх эр 23 жил шоронд суугаад 2006 онд Багануурын хорих ангиас суллагдсан байна. Түүний бага болоод идэр нас тортой хашааны цаана өнгөрсөн болохоор бүхий л ой санамж, сана асэтгэл нь мөрдөнгийн хүйтэн өрөө, түлхүүр харжигнуулсан хянагч, хүйтэн царайтай овгор хулгайч, адууны гэдсээр хийсэн шингэн бантан, харгис хэрцгий явдлуудаар дүүрэн байж. Түүнд сайхан санагдах баярт мөчүүд, хайр дурлал, үр хүүхэд гэж байсангүй. Нэгэн бодлын тэрбээр хүний ёсноос хол хөндий зэрлэг араатаны амьдралаар залуу насаа баржээ. Тиймээс ямар ч үед боломж л гарвал гэмт хэрэг үйлдэх сэтгэлгээ түүнд төлөвшсөн байна. Мань эрийг шоронгоос суллагаад гарч ирэхэд нийгмийн амьдрал тэр чигээрээ өөрчлөгдчихсөн түүнийг тал талаас нь ширтээд байгаа юм шиг санагджээ. Энэ бүхнийг мэдэрсэн Болор яг л том цэнгэлдэх хүрээлэнгийн голд зогсчихоод аль нэг зүгээс гарч ирэх дайсныг хүлээх гладиатор шиг өвдөг нь чичрэх болжээ. Харин тэрбээр ах дүү, хамаатан саднуудынхаа ятгалгаар Балжинням хэмээх дөрвөн хүүхэдтэй эмэгтэйтэй суухаар болжээ. Ингээд хэвийн амьдралд орох анхны алхам нь эхэлсэн байна. Гэвч тэр шоронд сурсан барилаа огт тавьсангүй. Ямар сайндаа л өглөөний зургаан цагт орноосоо үсэрч босоод “Сэрээд сэрээд, сэрсэн бол босоод. Нийгмийн муусайн хог шаарнууд аа, та нарыг жаргаах гэж энд авчраагүй шүү” гэж өөрийн мэдэлгүй хашгирч орхидог болжээ. Нойрмог хүүхдүүд өндийгөөд “Юу гэж хашгичаад байгаа юм бэ” гэхэд мань эр “Юу гэнээ, лаларууд аа” гэж зандраад бурууддаг болж. Ингээд яаж ч оролдсон шорон зангаа тавилгүй буруу харж хоол идэх, явган суух, хүүхдүүдийн дунд яс хаях, ойр зуурхан шургуу хийх мэтээр авирласаар байж. Аажимдаа хүүхдүүдийн дэггүй байдал, эхнэрийн нь энхрийлэл мань эрийн уурыг хүргэдэг болжээ. Өдөр ирэх тусам жирийн хүмүүсийн зовлонтой амьдрал таалагдахаа байсан тул тэрбээр буцаад шорондоо орохыг мөрөөдөх болсон бөгөөд учир нь тэнд түүнийг дулаан наар, бэлэн хоол, царайлаг банди нь хүлээж байгаа болохоор тэр л дээ. Түүнд өдөр ирэх тусам шоронгийн амьдрал нь бодогдоод байхаар нь нэг өдөр хутга ханцуйлж гараад хажуу айлынхаа залууг хутгалаад цагдаад баригдсан гэдэг. Түүнийг хүний нийгэм ч ойлгож чадсангүй, тэр өөрөө ч нарны амьдралд дасан зохицоогүй учраас үхэн үхтэлээ тортой хашаанд суухаар шийдсэн нь энэ байж.

## Шоронд ороод сүрхий гэгээрч хүмүүжсэн Тожоогийн Буяннэмэх ярьж байна

Шоронгоос суллагдсан хүмүүсийг дахин хэрэг түвэгт орооцолдуулахгүйн тулд угтаж аваад ажилтай, амьдралтай болгодог ганц газар нь Монголд үйл ажиллагаа явуулдаг Христийн сүмүүд болж хувирсан нь сайшаалтай. Учир нь төр засаг гээч нь гэмт хэрэгтэнүүдийг шал худлаа өрөвдөж халаглаад өршөөж суллахаас өөр юм мэддэггүй. Өршөөн нигүүлсэж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ тэрхүү өршөөж суллаж байгаа хүмүүсээ ажлын байраар хангаад өгөх ухаан сүйхээ байдаггүй. Гол алдаа нь үүнд л байгаа юм. Тэгээд л мэргэжил боловсролгүй, ажил төрөлгүй, нэг ёсондоо хүний хармаа суйлж, бусдыг дээрэмдэж, айлын орон байр “дэлбэлэх”-ээс өөр гавьяа зүтгэлгүй хүмүүс мөнөөх л сурсан зангаараа хулгай, дээрэм хийгээд буцаад шорондоо орчих жишээтэй. Ардчилал, зах зээл ноёрхсон сүүлийн хориод жилийн хугацаанд иймэрхүү үзэгдэл Монголд түм бумаараа давтагдлаа. Анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбатаас эхлээд л ялтануудыг хайр найргүй өршөөсөөр, үүнийг нь дараачийн ерөнхийлөгчид болох Н.Багабанди, Н.Энхбаяр нар амжилттай үргэлжлүүлээд, эцэст нь Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бараг л халхын шоронг тэр чигт нь суллагч шахсан билээ. Одоо тэр бүр цаазаар авах ялыг устгана гэж яриад байгаа. За яахав, цаазаар авах ялыг үгүй болгож гэмээнэ тэр алуурчин нь наранд гарч ирээд биднийг ямар зовоогоод байх биш, шорондоо л хэвтэж байх юм чинь гэж бодъё. Гэтэл тэр алуурчныг Монгол улс гучин жилийн турш тэжээж тэтгэхээс гадна харгалзаж байгаа дарга, цэргүүдийг нь гучин жилийн турш цалинжуулж, бидний татварын мөнгийг гучин жил шал дэмий юманд урсгах гээд байгаа юм. Тэрнээс биш нэг муу алуурчныг өршөөлөө ч, эс өршөөлөө ч бидэнд огт хамаа алга. Харин үүний оронд шоронгоос суллагдаж байгаа хүмүүстээ л гол анхаарлаа хандуулж, тэднийг дахиад шорон руу нь алдчихгүйн тулд мэргэжил мэдлэгтэй, ажил төрөлтэй болгох нь чухал болчихоод байгаа юм. Харамсалтай нь төр засгийн зүгээс өнгөрсөн хорь орчим жилийн хугацаанд энэ талаар ямар ч ажил зохион байгуулсангүй. Тиймээс орон шорон гээч нь орж л байдаг, гарч л байдаг “Дэн буудал” болж хувирчээ. Яруу найрагч Б.Явуухулан нэгэнтээ,

“Бүрэнхий сансрын цэнхэр нүд

Бүхий л амьтаны үдлэх үд

Ирэх очихын ээлжлэх цэг

Энэ бол дэлхийн бөмбөрцөг” гэж шүлэглэсэн байдаг. Үүн шиг өнөөгийн шорон гяндангууд,

Даамай жаргалыг авсалсан хад

Давган хэрэгтэнүүдийн үдлэх үд

Рецидив ялтануудын цуглардаг орон

Энэ бол Халхын шорон” гэж хэлэгдэх хэмжээнд хүрчихээд байгаа юм. Харин ийм хэмжээнд байлгахгүйн тулд Монголд үйл ажиллагаа явуулдаг Христийн сүмүүд шоронгоос

суллагдаад ажил төрөлгүй гиюүрч яваа хүмүүст тусламжийн гараа сунгадаг болжээ. Гэхдээ шоронгоос суллагдсан болгоныг дэмжиж тэтгэх бололцоо тэр бүр байдаггүй юмсанж. Ямар ч байсан буруу хэрэг хийж шоронд ороод үнэхээр засарсан, сэтгэл санаа нь зохих хэмжээнд гэгээрсэн, үүнийгээ бусдад тайлагнаж чадахуйц авьяастай хүнийг юуны өмнө шашны номлогч буюу “Пастор” болгодог юм байна. Монголчуудын сайн мэдэх “90 саяын” Гансүх хүртэл шоронгоос суллагдмагцаа пастор болчихсон цохиж явахыг бодоход Христийн сүмүүд ихэд нээлттэй байгаагийн шинж. Ингээд шоронд ороод сүрхий хүмүүжсэн гэх Тожоогийн Буяннэмэх хэмээх залуугийн яриаг толилуулъя.

### **-Чи анх ямар хэргээр шоронд орсон юм бэ?**

-Хулгай дээрэм хийж, хүн хутгалсан юм. Ёстой муухай хэрэг. Одоо бодоход сэтгэл эмзэглэдэг юм. Гэхдээ тэрхүү эмзэглэл намайг эргээд гэгээрүүлсэн гэж хэлж болно. Хэрвээ олигтой эмзэглэл төрөөгүй бол мань мэт нь тэгтэлээ гэгээрээ ч билүү, үгүй ч билүү. Хэрвээ би өчүүхэн жижиг хэрэг үйлдээд шоронд орсон бол эмзэглэж гэгээрэх нь байтугай харин ч бүр өөрийгөө хохирчихлоо, хэлмэгдчихлээ гэж өрөвдөж халаглаад улам л тэнэг болох байсан болов уу. Одоогоос арваад жилийн өмнө дэндүү аархуу явж. Хүн амьтан барьж зодоод л, тааралдсан болгондоо агсам согтуу тавиад л их болчимгүй үйлдэл хийж явсан. Тэгээд шоронд очоод л гэнэтхэн ухаажсан даа. Зөвхөн өөрөө ухаажаад зогсохгүй бусдад үлгэр дууриал үзүүлэхийг их хичээсэн. Ямар сайндаа л зодолдож байгаа хоёр хоригдолыг салгаад хооронд нь эвлэрүүлж байхав. Шоронгоос оргох гэж төлөвлөж байсан хоригдолыг хүртэл өөрийн чадах чинээгээр сэнхрүүлээд оргохыг нь болиулж байсан. Тэгээд хоригдолуудад хандаж “Та нар хэн нэгнийг хохироож гомдоож ерөөсөө болохгүй. Хүн хохироож гомдоосон хүн дараа нь өөрөө заавал хохирдог юм. Нэгэн цагт хүн хохироосон та нар одоо өөрсдөө хохироод байж байгаа биз дээ. Тиймээс хүнд аль болох тус болохыг хичээ. Тэгвэл тэр тус нь дараа нь та нарт заавал ирдэг юм” гэж сургамжилдаг байлаа. Миний сургамжийг авах нэг нь авна, авахгүй нэг нь авахгүй. Зарим нэг овилгогүй хоригдол намайг сургамжлаад байхаар “Чи Есүс Христ юмуу. Дандаа олон долоон юм солиорч байх юм. Энэ муу хар саванд хүн хүмүүжинэ гэж юу байсан юм бэ. Ер нь бид нар шиг эрээ цээрээ алдсан хүмүүст тэр хүмүүжил мүүмүүжил чинь ямар хэрэгтэй юм бэ” гэх зэргээр агсардаг байсан. Ийм хүмүүст хичнээн сайхан юм яриад нэмэргүй л дээ. Зарим нэг муу муухай юм муу чигээрээ байх ёстой юм байх. Тэгээд ч энэ орчлонд чинь сайн муу хоёр зэрэгцэн оршиж байдаг бололтой. Тэр ч байтугай хоригдолуудаасаа долоон дор хүмүүжилтэй хянагч нар байдаг гээд бод. Ямар ч боловсрол байхгүй, муухай хараал хэлж, бүхнийг нударгаар зохицуулдаг хянагч нар олон бий. Ийм хүмүүсийн өмнө номхон зогсоод доромжлуулж байхдаа би их гутардаг байсан. Тэгээд би “Очиж очиж энэ муу хоосон толгойтой, ойворгон зантай, дандаа муу муухай бүхнийг хийж явдаг, хоригдолуудтайгаа цуг архи уудаг новшийн хянагчийн өмнө ингэж ч доошоо орох гэж дээ” гэж их бухимддаг байлаа.

### **-Үнэхээр гэгээрч хүмүүжсэн эсэхийг чинь юугаар нотлох вэ? Хэрвээ чамайг хэн нэгэн согтуу эр цохиод авбал яах вэ?**

-Арваад жилийн өмнөхөн бол би шууд л зодолдох байсан байх. Одоо бол үгүй. Чухам яагаад цохиж авав гэдэг учрыг нь юуны өмнө олохыг хичээнэ. Ер нь хэн нэгэнтэй хэрэлдэж зодолдох шаардлага байхгүй гэдгийг би шоронд суусан хэдэн жилд их сайн ухаарсан. Аливаа

асуудлыг эв зүйгээр зохицуулах шиг сайхан юм байхгүй. Манай жолооч нар хотын гудамжинд нэг нэгнээ шүргэчихээд машинаасаа гарч ирээд шууд л хэрэлдэж зодолдох юм. Энэ бол ёстой муухай үзэгдэл. Бие биенээсээ буруу хайгаад л үсчээд байхыг яана. Хэн хэн нь өөрийгөө зөвтгөөд л дайрчихдаг. Үүний оронд учраа ололцох хэрэгтэй байхгүй юу. Тэгээд хэрвээ хэн нэг нь буруутай бол шударгаар хүлээх хэрэгтэй. Гэтэл монголчууд өөрийгөө зөвтгөөд дайсан хайгаад л давхичихдаг. Цаад дайсан болох гээд байгаа хүн ч гэсэн адилхан л амьдрах гэж зүтгэж яваа хүн шүү дээ. Ер нь өөрийгөө зөвтгөж дайсан хайх үзэгдэл манай улсад хавтгайрсан байна. Улс төрчид нь ч ялгаа байхгүй. Бие биенээ гүтгээд л, ямар нэг болж бүтэхгүй юмнаас дайсан хайгаад байдаг.

**-Таныг ийм хүмүүжилтэй болоход чухам юу нөлөөлсөн бэ?**

-Миний өөрийн хүчин чармайлтаас гадна Христийн сургаал их нөлөөлсөн. Христийнхэн шоронгуудаар очиж номлол үйлддэг юм шүү дээ. Гэтэл манай бурханы шашныхан залуучуудыг гэгээрүүлж байгаа юм огт алга. Шашин гэдэг чинь хүмүүсийг гэгээрүүлж хүмүүжүүлэхдээ гол нь байдаг. Христийн шашныхан хүмүүсийг архинаас гаргаж байна. Тэгтэл манай Буддын шашныхан архин далайд живчихээд байгаа монголчуудын тусын тулд ер нь юу хийсэн юм бэ. Үнэн худал нь мэдэгдэхгүй түвд маани мэгзэм уншиж л цаг нөхцөөдөг байх. Үүний оронд залуучуудыг цуглуулаад архи, тамхины эсрэг сурталчилгаа хийж болно шүү дээ. Гэхдээ намайг ингэж хүмүүжлийн замд ороход Христийн сургаал бүх талаар нөлөөлсөн гэж хэлж бас болохгүй л дээ. Шоронгийн диктатур бас нөлөөлсөн. Хэрвээ диктатур байхгүй бол жаргалтай газар хүн хэзээ ч хүмүүжихгүй. Харин ч бүр тэндээ жаргаад байхыг бодно. Ер нь иймэрхүү бодолтой хүмүүс олон байдаг болохоор тэд дахин дахин шоронд ороод байдаг юм.

**-Чи ч яахав ингээд хүмүүжчихдэг байж. Харин чам шиг хүмүүжлийн замд орсон хүн аль хэр олон байдаг вэ?**

-Хүн хүнээсээ л шалтгаална. Нэг хэсэг нь “Дахиж энэ муу хөсрий шоронд хэзээ ч орохгүй” гэж өөртөө зорилго тавиад сайхан хүмүүжээд гарч байна. Зарим нь “Би тэртэй тэргүй өнгөрсөн хүн” гэж тэнэгтээд улам эвдэрдэг. Миний хувьд гэвэл нэг алдсан алдаагаа дахиж давтахгүй гэж их хичээсэн. Тэгээд шоронд байхдаа өглөө болгон тэнгэрт залбирдаг байлаа. Энэ ч утгаараа би жинхэнэ хүмүүжлийг олсон. Зөвхөн хүмүүжээд зогсохгүй ном зохиол уншиж өөрийгөө нэлээд гэгээрүүлсэн. Тийм ч учраас би Христийн сүмийнхэнд энэ байдлаа ойлгуулах хэрэгтэй болчихоод байгаа юм л даа.

## Луйварчин хүүхэнд хамаг байдагаа зальдуулахад “Зуун хувь” гэдэг дуу нөлөөлжээ

1990 оноос хойш ганзагын наймаа хийж нэлээд хөлжсөн Сүрэндэмбэрэл гэгч тавь гаруй насны эр эдүгээ өөрийн тавьтаргүй зангаасаа болж Оюун-Эрдэнэ гэгч завхай бөгөөд зальтай хүүхэнд хамаг байдгаа алдчихаад шүүх сэргийлэхээр гүйж яваа ажээ. Сүрэндэмбэрэлийн эхнэр одоогоос гурван жилийн өмнө нас барсан бөгөөд өнгөрөгч жил тусдаа гарсан хоёр хүү нь эцэгтээ хандаж “Та одоо алийн болгон ганцаараа явах вэ. Цайгаа хувааж уух хүнтэй бол” гэж зөвлөжээ. Гэвч Сүрэндэмбэрэл цайгаа хувааж уух өөрийнхөө үеийн хөгшнийг олж авахын оронд гуч гаруй насны архи хувааж уух хүүхэнтэй танилцсан нь үнэндээ том алдаа болсон байна. Оюун-Эрдэнэ нь 18 нас хүрүүтээ луйврын хэргээр “занималдаж” явсаар 1998 онд 22 насандаа зургаан жилийн ял аваад Луусангийн шоронд морилжээ. Энэхүү ялаа эдэлж байх хугацаандаа хоригдол хүүхнүүдийг залилсан хэргээр гурван жилийн ял нэмүүлээд 2007 онд шоронгоос суллагджээ. Тэрбээр Сүрэндэмбэрэлийн орон байр, мөнгө төгрөг, машин тэргэнд болж л түүнтэй суусан юм санж. Нэг өдөр Сүрэндэмбэрэл найздаа хандаж “Залуухан хүүхэнтэй суух сайхан юмаа. Би залуу насандаа үзээгүй юмаа одоо л үзэж байна. Оюун-Эрдэнэтэй суусанаасаа хойш би ёстой жаргаж байна аа” гэж томорсон байгаа юм. Гэвч мөнөөх залуухан эхнэр Оюун-Эрдэнэ нь түүнийг нэг л өдөр цус харвуулах шахжээ. Учир нь Сүрэндэмбэрэл халуун залуу эхнэртээ зуун хувь итгээд түүнд хамаг түлхүүр, мөнгө төгрөгөө бариулдаг байж. Үүнд мөнөөх “Тоёлын дашинз” киноны “Зуун хувь” гэдэг дуу ч бас нөлөөлсөн юм байх аа. Гайтай тэр өдөр Сүрэндэмбэрэлийн том хүү нь ирж эцгээсээ хэдэн төгрөг аваад явсан нь Оюун-Эрдэний уур хилэнг хөдөлгөж орхижээ. Тэрбээр Сүрэндэмбэрэлд хандаж “Өөрийгөө аваад явчих болсон ажил төрөлтэй хүнд мөнгө төгрөг өглөө” гэж цамнахад түргэн ууртай Сүрэндэмбэрэл өөдөөс нь бас хэдэрлэжээ. Тиймээс настай амрагтаа гомдсон Оюун-Эрдэнэ түүний контейнерийн түлхүүрийг хулгайлж аваад “Нарантуул” захыг зорьжээ. Тэгээд очингуугаа захын муу найркачдыг цуглуулан тус бүрт нь 1000 төгрөг өгөөд контейнерт байсан хамаг барааг нь захын ченжүүдэд хямдхан бөөндөж орхижээ. Таньдаг ченжүүд нь Оюун-Эрдэнээс “Та нар яагаад бараагаа ингэж гэв гэнэт бөөндөхөд хүрэв” гэж асуухад “Дэмбээ бид хоёр Америк явахаар болчихлоо. Тэнд бараг гурван жил болох байх. Боломж олдвол Америкт үүрд амьдарна” гэх зэргээр бүлт үсэрсэн байгаа юм. Сүрэндэмбэрэл залуухан амрагаа шөнөжингөө эрээд адаг сүүлд нь цагдаад ханджээ. Гэвч нэмэр болсонгүй. Харин мань эр уйгагүй хөөцөлдсөний эцэст шартаад муухай царайлчихсан залуухан амрагаа найзындаа шав шалдан, бас ч болоогүй ээ, өөрөөсөө тав зургаан насаар дүү залуу тэвэрчихсэн хэвтэж байхад нь олжээ. Гэхдээ Сүрэндэмбэрэл үүнд нэг их юм санасангүй. Өөрөө залуудаа эсэн бусын хүүхэн эргүүлж явсан болохоор Оюун-Эрдэнийн садар явдлыг уучилсан байна. Гэвч энэ уучлалт өөрт нь улам гай тарьжээ. Уучлагдсан хүүхэн Оюун-Эрдэнэ өвгөнийд буцаж ирсэнээсээ хойш тэс өөр хүн болж хувирсан бөгөөд өвгөний машин тэргийг зальдаж авах ажилд шуударчээ. Тэгээд нэг л өдөр түүний машиныг унаад алга болж өгчээ. Эдүгээ Оюун-Эрдэнэ хаана байгаа нь огт мэдэгдэхгүй байгаа бөгөөд Сүрэндэмбэрэл дэмий л цагдаагийн газар очиж “Нөгөө хүүхнээс чинь сураг байна уу” гэж асуудаг болсон байна. Байцаагч нь түүнд хандаж “Та тэр Оюун-Эрдэнэ гээчийг анхнаас нь сайн судалж байж гэртээ оруулахгүй яасан юм бэ. Цаадах чинь арваад жил ял эдэлсэн аюултай луйварчин хүүхэн байж шүү дээ” гэхэд Сүрэндэмбэрэл “Харин тиймээ. Би түүнийг шоронд ял эдэлж байсаныг нь сая л мэдлээ. Ер нь шоронд ял эдэлж байсан хүний духан дээр нь ямар нэгэн тэмдэг тавьчихаж

баймаар юм. Тэгвэл би юу боллоо гэж луйварчин хүүхэнд хууртагдах билээ дээ” гэж маанагтаж суугаа аж.



## **Халаас хоосон ялтан хүн шоронгоос суллагдаад гэртээ харих замдаа л гэмт хэрэг үйлдчихдэг болж**

Хуулийн байгууллагад олон жил ажиллаад тэтгэвэртээ гарсан Дашцэрэн хэмээх хурандаатай саяхан уулзалдаад ойр зуурын зүйл хөөрөлдөж суутал тэрбээр “1980-аад оны үед манай цагдаагийн газарт шоронгоос суллагдсан хоригдолуудыг угтаж аваад ажилтай болгодог тусгай хэлтэс байдаг байлаа. Би тэр хэлтэсийн даргаар нэг хэсэг ажилласан. Тэр үед энэ тэнүүгээр архидаж гиюүрээд байдаг хүмүүсийг Ерөө рүү явуулж албадан хөдөлмөр хийлгэдэг байсанаас гадна шоронгоос суллагдсан хүмүүсийг заавал ажилтай болгодог, хэрвээ тэдэнд ажил олж өгөлгүй зөнд нь орхих юм бол бид арга хэмжээ авахуулдаг байлаа” гэж ярьсан юм. Ер нь соц нийгмийн үед шоронгоос суллагдсан хүмүүсийг энэ мэтээр нийгэмшүүлдэг байж. Харин өнөө цагт өөр болжээ. Шоронгоос суллагдсан хүмүүсээ олигтойхон нийгэмшүүлж чадахгүй байж бөөн бөөнөөр нь өршөөж суллахыг яана. Дээхэн үеийн хууль цаазын түүхэн эх сурвалжаас үзэхэд гэм хийсэн этгээдийн гэм бурууг ухааруулж, хийсэн хэргийнх нь төлөө хариуцлага хүлээлгэхэд чиглэж байсан байх юм. Ер нь гэмт хэрэг үйлдэж хоригдох ял эдэлсэн хүмүүсийг нийгмийн амьдралд эргэн оруулж давган хэрэгтэн болгохгүй байлгахад бүх нийтийн анхаарал чиглэх ёстой. Гэтэл эдүгээ манай улс энэхүү чухал асуудлыг огт тоохоо байжээ. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хоригдолууд болон хорих ангиас суллагдсан хүмүүсийг нийгмийн амьдралд эргэн ороход нь туслах зорилго бүхий “Алдаж гэнэдэгсдэд туслах Шайдевег нийгэмлэг” хэмээх олон улсын төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулдаг ч чухам ямар ажил зохиож, ямар үр дүнд хүрч байгаа нь тодорхойгүй. За яахав, насанд хүрсэн зарим архаг ялтануудын хувьд гэвэл эвдэрдэгээ эвдрээд, нийгэмшиж цэвэршихээсээ өнгөрсөн гэж бодъё. Харин ямар нэгэн буруу хэрэг хийгээд шоронд орсон бага насны хүүхдийг нийгэмшүүлэх тал дээр түлхүү анхаарах ёстой. Сүүлийн жилүүдэд бага насны хүүхэд гэмт хэрэгт холбогдох нь ихэсч байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн орны хувьд хууль зөрчсөн хүүхдийг зөвхөн гэмт хэрэгтэн гэж үзэхээс илүүтэй эрхийг нь хүндлэх хууль зүйн тусгай хамгаалалт бий болгох талаар ХЗДХЯ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороог загвар байдлаар 2006 оноос нийслэлийн Багануур, Баянгол дүүрэг, Хэнтий аймагт бий болгожээ. Саяхан тус загвар хороодын үйл ажиллагаанд олон улсын шинжээчид үнэлгээ хийгээд насанд хүрээгүй хүүхдэд хорихоос өөр төрлийн олон нийтэд түшиглэсэн арга хэмжээ хэрэглэх, хүүхдийг эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанаас хөндий-рүүлэх боломжтойг онцолжээ. Мөн гэрч болон хохирогч хүүхдүүдийн эрхийг хангах, тэднийг хамгаалах асуудал орхигдож байгаа тухай, хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчмуудыг эрх зүйн шинэтгэл хийх замаар гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, гэрч, хохирогч хүүхдүүдийн асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэх, түүнчлэн хүүхдийг урт хугацаагаар урьдчилан хорих байранд саатуулдаг, хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүүхдийг хорих ялаар шийтгэдэг, тэдэнд үзүүлэх эрх зүйн туслалцаа, үйлчилгээ хангалтгүй, хорих болон урьдчилан хорих байрны нөхцөл байдал муу, ял шийтгэгдсэн болон хорихоос чөлөөлөгдсөн хүүхдийг эргэн нийгэмшүүлэх ажил дутмаг байгаа тухай шүүмжилсэн байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 15-р зүйлд “Хорих ял эдлээд суллагдсан хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно, хорих ял эдэлж суллагдаад байнга оршин

суух газартаа очсоноос хойш гурав хоногийн дотор цагдаагийн байгуул-лагад бүртгүүлэх хэрэгтэй, хорих байгууллага, хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө байнга оршин суух газрын цагдаагийн байгуул-лагад түүний суллагдах тухай мэдэгдэлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ” гэж заажээ. Гэвч энэхүү заалт амьдрал дээр огт хэрэгждэггүй юмсанж. Ялтан хүн хорих газраас суллагдмагцаа л бүхний хараа хяналтаас гарч торноос мултарсан шувуу шиг эрх чөлөөтэй нисчих жишээтэй. Тэгээд ингэж нисч яваад дахиад гэмт хэрэг үйлдээд буцаад шорондоо морилох нь олонтаа. Тухайлбал хүнд гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаад Төв аймгийн Мөнгөнморьтын хорих ангиас суллагдаад Г.Сүхбат гэгч Баянзүрх дүүргийн 9-р хорооны нутагт байдаг өөрийн гэртээ очих замдаа танилтайгаа таарч архи ууж маргалдан улмаар хохирогч А-гийн нүдэнд нь цохиж хараагүй болгон хүнд гэмтэл учруулаад хоёр гараа гавлуулсан байх жишээтэй. Мөн Зайсан дахь хорих 401 дүгээр ангиас хугацаа дуусч суллагдсан В.Мөнхбаттар гэгч сулагдсан өдрөө Хэнтий аймагт байдаг гэртээ очих унаа хайхаар “Нарантуул” зах дээр явж байгаад архи ууж согтууран бусдын эд хөрөнгө хулгайлан үлэмж хэмжээний хохирол учруулжээ. Дээрх хоёр ялтан үгүй ядахнаа гэртээ ороод аяга цай ч ууж амжилгүйгээр буцаад шорон руугаа морилсон нь дэндүү харамсалтай. Ер нь “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони” хэмээх сайхан нэр зүүж явдаг хорих ангиуд ялтануудыг хүмүүжүүлэх тал дээр огтхон ч анхаардаггүй болох нь гэртээ ч орж амжилгүй гэмт хэрэгтэн болсон дээрх хоёр эрийн үйл явдлаас тодорхой харагдаж байгаа юм. Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн 121 дүгээр зүйлд “Ялтаны хийсэн хөдөлмөрийнх нь тоо чанарт тохирсон хөлс олгоно, уг цалин хөлснөөс бүх төрлийн суутгал хийж үлдэх хэсгийг ялтаны нэрийн дансанд төвлөрүүлнэ, төвлөрсөн цалин хөлсний арав хүртэл хувийг ялтан сар тутам хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгоно” хэмээжээ. Мөн хуулийн 130 дугаар зүйлийн “130.0-т суллагдсан хүнд хувийн бичиг баримт, эд зүйл болон суллагдсан тухай албан бичиг олгоно, 130.4-т шаардлагатай бол суллагдаж байгаа ялтанд тухайн улиралын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих ангиас олгож болно” гэж заажээ. Гэвч халаасандаа мөнгөтэй суллагддаг хоригдол тийм ч олон байдаггүй бололтой. Ихэвчлэн халаас хоосон суллагдаад гэртээ харих замдаа л гэмт хэрэг үйлдэх жишээтэй. Тиймээс хорих ангиуд суллагдаж байгаа хүмүүсийнхээ халаасанд үгүй ядахнаа автобус, гуанз, тамхи тарианы мөнгө хийгээд явуулж баймаар юм.

## Жинхэнэ новширдог хулгайч

Насаараа шорон дамжсан Балжирын Далайхүү гэгч эр 2004 онд суллагдаад хамт хоригдож байсан хүмүүсийнхээ ар гэрээр хоног төөрүүлдэг болж. Ингэж явахдаа нэг өдөр “Зурам” Дэмбээ гэгч найзындоо очиж хоносон байна. Дэмбээ нь түүнтэй цуг Зүүнхараагийн шоронд ял эдэлж байсан бөгөөд мань хоёр тухайн үед гал хам энэ тэр болж нэг их сүйд болдоггүй байж. Харин Дэмбээгийн дотны андууд байгаа юм. Би ч Дэмбээг аварч байсан, Дэмбээ ч намайг аварч байсан” гэх зэргээр томорчээ. Тиймээс Дэмбээгийн эхнэр түүнд хоол цай хийж өгч жаахан ч гэсэн хөл алдсан байна. Үүгээр зогсохгүй дэлгүүрээс нэг шил архи авч өгчээ. Дэмбээ, Далайхүү хоёр ч яахав ганц шил юм хувааж уусан шиг шоронгийн дурдатгалаа сэргээжээ. Төдөлгүй Дэмбээ жаахан халчихаад эхнэрээ дуудан гэрээсээ гараад “Чи энэ муу хулгайчид яах гэж хөл алдаад байгаа юм бэ. Бид хоёрын гал хам гэж юу байсан юм. Энэ чинь шоронд байхдаа новшийн хулгайч байсан байхгүй юу. Одоо аягүй бол манайхаас нэг хэсэгтээ л салахгүй дээ” гэхэд цаадах нь “Өө, тийм үү. Би яаж мэдэхэв дээ. Цаадах чинь л өөрөө чамайг аварч байсан энэ тэр гэж яриад байсан даг. Одоо тэгвэл хөөгөөд явуулахгүй юу” гэж уурлажээ. Гэвч архиндаа халсан Дэмбээ Далайхүүг хөөж явуулсангүй. Харин ч бүр учиргүй инээж ханиагаад “Хоёулаа өнөөдөр сайхан ууна аа. Юун төлөө шоронгийн хамууд билээ. Гэхдээ согтчихоод янз бүрийн хэрэг тарьж новшрохгүй шүү” гэхэд цаадах нь “Юу боллоо гэж новсрох билээ дээ. Тэгээд ч тэр гэмт хэрэг гэдэг чинь мань мэтийн өтөлж яваа амьтаныг тоохоо байчихаж. Дандаа л булчин шөрмөс нь чангарсан залуучуудыг л тоодог болсон байна шүү дээ, тэр гэмт хэрэг чинь. Чи бодоод үз. Өнөөгийн шорон хэт залуужаад байна. 20-30 насныхан л шоронг дүүргэдэг болж. Чи бид нар шиг хөгшин хулгайчууд одоо шоронд очлоо гэхэд залуучуудын гарын шүүс болж дуусна. Одоо ерөөсөө хүн шиг л явж хорвоог барахгүй бол болохоо байсан цаг” гэх зэргээр манжилжээ. Ингээд мань хоёр дахиад нэг шил архи цааш нь харуулчихаж. Оройн зургаан цаг гэхэд мань хоёр дор бүрнээ халцгаасан бөгөөд энэ үед Далайхүү Дэмбээд хандаж “Хоёулаа нэг гарчихаад ирэх үү. Танай энэ хавьд “Мурий” Аюурзаных байдаг сурагтай. Цаадах чинь хойтон жил суллагдана. Хоёулаа эхнэртэй нь уулзаж ганц нэг шил юмны мөнгө салгая” гэхэд цаадах нь зөвшөөрсөн байна. Төдөлгүй мань хоёр Аюурзана гэгчийнхийг сурагласаар яваад олж очжээ. Далайхүү эхнэрт нь хандаж “Би өчигдөр суллагдаад гарч ирлээ. Танай Аюурзана сайн байгаа. Би удахгүй дахиад зоон руу явж бичиг баримтаа хөөцөлдөнө. Аюурзана намайг наашаа гарахад “Манайхаар ороод эхнэр хүүхэд маань ямар шуу байгааг нэг мэдээтэхээрэй” гэж захисан юм. Та нар ч яахав гайгүй л аж төрж байгаа юм байна. Харин цаад муу Аюурзана чинь их л хэцүү байгаа шүү. За тэгээд ер нь нарны хүмүүс ямар нарсныхныг ойлгох биш дээ” гэх зэргээр бурж гарчээ. Аюурзанын эхнэр түүний үгэнд итгэж “Та тэгвэл буцаад явахдаа надаас захиа аваад яваарай. Бид нар мөнгө төгрөгөөр тааруухан л байна. Гэхдээ яаж зүгээр байхав” гээд Далайхүүд таван мянган төгрөг өгсөн байна. Далайхүү хүүхдийг нь архинд явуулах гэтэл Аюурзаны эхнэр “Манайд архи ууж болохгүй. Та нар өөр газар очиж архи уу” гэжээ. Тиймээс мань хоёр тэднийхээс гарчээ. Тэднийг гудамжаар гуйвагнан алхаж явтал хүүхэнд сугадуулсан нэг халамцуу эр тааралдсан байна. Далайхүү тэдэн дээр очоод “Алив тамхи байвал өгөөтөх. Уг нь би гуйж авдаггүй гуядаж авдаг хүн л дээ. Яахав та нарыг хүндлээд гуйчихъя” гэхэд халамцуу эр “Чиний тамхийг би бэлддэг юм уу. Аятайхан байгаарай, муу новшоо” гэж агсарчээ. Тэгтэл Далайхүү олон таван үггүй түрийнээсээ хутга

гаргаж ирээд мөнөөх эрийн цээж рүү шууд дүрж орхисон байна. Сугадаж явсан эхнэр нь “Яана аа, нөхрийг маань алчихлаа ш дээ” гэж хашгираад түргэн тусламж дуудахаар цааш гүйжээ. Энэ үед Дэмбээ Далайхүүг сугадаж аваад “Чи яаж байгаа новш вэ. Одоо бушуухан эндээс зайлах хэрэгтэй” гэхэд “Үгүй шүү. Хүн алсан хүн хэзээ нэгэн цагт баригддаг юм. Зугтаж мугтаж шогтохгүй шүү. Аажуухан явж байгаад танайд хүрнэ. Яахав тэгээд Монголын цагдаа намайг олоод очвол тэр л биз” гээд хөдөлж өгсөнгүй. Тиймээс Дэмбээ “Чи ямар тэнэг хулгайч вэ. Хэрэг тарьж новшрохгүй гээд хуцаад байсан биз дээ. Чи хэрэг тарих тарихдаа бүр хүн алчихлаа шүү дээ. За чи надтай хамт яваагүй шүү. Би харилаа. Чи энэ хэргээ өөрөө даагаарай” гээд цааш ум хумгүй хурдалжээ. Тэгтэл Далайхүү хойноос нь гүйж очин ханцуйнаас нь угзраад “Чи муу тэгж ярихгүй шүү. Энэ хэрэгт чи чирэгдэж л таараа. Яагаад гэвэл энэ танай хутга. Би юмыг яаж мэдэхэв гээд шүүгээнээс чинь авчихсан юм” гээд Дэмбээгийн мөнгөн тоногтой хэт хутгыг үзүүлсэн байна. Дэмбээгийн царай хачин болж ирсэнээ “Тэгвэл энэ эд мөрийн баримтыг чинь одоохон устгачихья л даа” гээд хутгыг нь булааж авах гэж тэмцэлджээ. Гэвч Далайхүү нэг л мэдэхэд Дэмбээгийн цээжинд дүрчихсэн байж. Төдөлгүй тэр хавьд цагдаагийнхан ирж мөнөөх хутгалуулсан залуу болон Дэмбээг эмнэлэг рүү авч явжээ. Гэвч нөгөө залуу эмнэлэг рүү явж байхдаа амьсгал хураасан байна. Харин Дэмбээ яаралтай мэс засалд орсоноор амь нас нь аврагджээ. Далайхүү Дэмбээг хутгалсаныхаа дараа хаашаа ч юм бэ зугтаж алга болсон ч маргааш нь л баригджээ. Жинхэнэ новширдог хулгайч хэн бэ гэвэл түүнийг л хэлэх байх. Алуурчин Балжирын Далайхүү нь 1959 онд Говь-Алтай аймагт төрсөн, 14 настайдаа хулгайн хэргээр гурван жилийн ял авч, хүүхдийн хорих ангид очсон боловч ял эдэлж байх хугацаандаа танхайн хэрэг үйлдэж ялаа нэмүүлж байсаар 26 настайдаа суллагджээ. Гэвч наранд ганц жил ч бололгүй хүн амины хэргээр дахин шоронд орсон байна. Энэ эрд хүн алах нь хонь нядлахын дайтай санагддаг бололтой. Шүүгч түүнээс “Чи хүн алахыг хонь нядлахын дайтай боддог хүн юмаа даа” гэж асуухад “Үгүй. Би хонь нядлахыг хүн алахын дайтай боддог болохоос биш хүн алахыг хонь нядлахын дайтай боддог хүн биш. Надаас битгий олон юм асууж шалгаагаад бай. Яршиг би зүгээр шорон руугаа явмаар байна” гэж хариулжээ. Шоронгоос өөр юм бодохоо байсан энэ эрд шүүх цаазаар авах ял оноосон байна.

## **Шоронгоос оргоод Богд ууланд хоёр жил бүгжээ**

*Энд өгүүлэх Цэндийн Тайван гэгч эр 1980-аад оны үед шоронгоос оргоод Богд ууланд хоёр жил гаруй бүгжээ. Ингээд түүний ярианд анхаарлаа хандуулна уу?*

**Э-Шоронгоос оргосон хүмүүс ихэвчлэн хүн амьтан цөөн явдаг ширэнгэн ойг сонгож авдаг. Гэтэл та байнга хүн амьтан хөлхдөг самар жимсний өлгий нутаг Богд уулыг яагаад сонгосон юм бэ?**

-Чоно үүрэндээ өлзийтэй гэх үү дээ. Хэн нэгэнтэй тааралдвал самар түүж яваа хүн гээд итгүүлчихнэ. Харин өвлийн цагт Богд уул нам жим байдаг. Дархан цаазтай болохоор хүмүүс ан хийх, хулгайгаар мод огтлох гэх мэтийн юм байдаггүй нь сайхан. Би зуны цагт их хэмжээний самар түүж голоо зогоодог байлаа. Сүүлдээ Богд уулын ойн цагдаа болох Гочоосүрэн гэдэг өвгөнд үнэн учраа хэлээд дотно танилцаж билээ. Энэ өвгөн намайг оргосон ялтан гэдгийг мэдсэн хэрнээ дээш нь мэдэгдэлгүй бүтэн хоёр жил нуун дарагдуулсан. Би хоол хүнс дуусахаараа өвгөнийхөөс ирээд л хоол хүнс авчихдаг байлаа. Гэтэл 1986 онд өвгөн маань өөд болж би нэг хэсэгтээ л хэцүүдсэн. Тэгээд нэг өдөр түүний хүүд бүх үнэн учраа хэлсэн. “Би аавтай чинь дотно харилцаатай байсан. Аав чинь та нарыг тэжээхийн тулд надаас ангийн арьс, самар жимс авдаг байсаныг чи мэднэ. Гэхдээ чи намайг оргодол босуул гэдгийг мэдэхгүй. Одоо мэдэж ав. Цаашид чи аавынхаа ажлыг үргэлжлүүлэх ёстой” гээд л хүүгээс нь би гуйж гарлаа. Хүү нь зөвшөөрсөн. Тэгтэл тэр хотод байдаг том эгчдээ миний тухай дуулгачихаж л дээ. Эгч нь хотын намын хороонд ажилладаг ихээхэн сэнтэг нэгэн байж. Тэгээд намайг нэг л өдөр цагдаа нараар баривчлуулсан. Хэрэв өвгөн дахиад хэдэн жил амьд байсан бол би нэг хэсэгтээ л баригдахгүй байх байлаа. Тэгээд яахав би Мааньтын шоронд очоод ууланд сурсан эрдмээрээ гайхуулж нэг хэсэг манаргасан.

**-Тухайлбал яаж гайхуулсан гэж?**

-Гайхуулах юм хаанаас мундахав. Хамгийн наад захын жишээ гэхэд л утасны модонд дөрөө хэрэглэлгүй авирч гараад тасарсан утсыг залгачихдаг байлаа. Яг л муур шиг. Ер нь хүн нэг л юмаар дагнан хичээллээд байвал тэр нь гарт орчихдог юм билээ. Шоронгоос оргоод ууланд бүтэн таван жил бүгсэн “Бозлог” Даш гэдэг хүн ууланд байхдаа яг л бозлог шиг өнхөрч сурсан байгаа юм. Тэр ч байтугай ар нуруугаараа хэвтчихээд агаарт хий үсэрдэг байсан.

**-Одоо та утасны модонд дөрөө хэрэглэлгүй авирч чадах уу?**

-Одоо яаж чадах вэ дээ. Хэдэн жилийн өмнө авирах гэж нэг үзсэн. Тэг дунд нь хүрчихээд дээшээ гарч чадаагүй. Аргагүй л хөгширч дээ. Залуу байхад хоол унд сайтай бол ялны ажилд адуу шиг л тачигнадаг байлаа. Ууланд мод цагаалж үзлээ, галт тэргэнд жонш ачиж ч үзлээ. Харин Туул голоор сал урсгаж үзээгүй. Дээхэн үеийн хоригдолууд сал урсгах хүнд ажилд амь бие хайрлалгүй зүтгэдэг байж. Надад бол ууланд мод цагаалахаас жонш ачих л их хүнд байсан. Гар цэврүүтээд улаан нялга болчихно. Сүүлдээ бүр эвэршиж хатуураад яг л мод шиг болчихдог. Нэг ёсондоо модон гартай хоригдолууд жонш ачдаг байлаа. Ийм гараар хүн цохиж унагавал ёстой нам авна биз дээ.

**-Хүн цохиж унагана гэснээс соц нийгмийн үед шоронгоос оргоод ууланд бүгэж байсан хэдэн хоригдол хонь хариулж явсан нэг эмэгтэйг нам цохиж унагаад ууланд авчран арав гаруй жил эдэлж хэрэглэсэн гэдэг яриа байдаг. Энэ тухай та дуулж сонссон уу?**

-Сонссон юм байна. Энэ чинь Төв аймгийн нутагт болсон гэдэг юм. “Хар” Банди тэргүүтэй гурван хоригдол шоронгоос оргоод Төв аймгийн нэг модтой ууланд бүгэж л дээ. Тэгээд Энхнамжил ч билүү нэг бүсгүйг хонь хариулж явтал тэдний нэг нь цохиж унагаад морин дээр дүүрч явсаар бүгэж байсан ууландаа авчирсан гэдэг. Эхнэр хүүхдийн бараа хараагүй тэдэнд эмэгтэй хүн хэрэгтэй л байсан байлгүй. Эдэлж хэрэглэхээс гадна хоол цайгаа хийлгэж, хиртэй хувцасаа баахан угаалгаа биз. Ямар ч байсан арваад жил эдэлсэн гэдэг юм. Сүүлдээ юу болсон юм бүү мэд. “Хар” Банди гэгчийн нэрийг би дуулсанаас цаашгүй. Оргож босоод огт сураггүй болсон аль олон ялтаныг хэлж барахав дээ. “Хар” Бандийг баригдсан гэж би дуулаагүй л юм байна. Гэвч баригдаад би мэдээгүй өнгөрсөн байж болно шүү дээ. Харин Хөвсгөлийн тайгад арван жил бүгсэн “Уулын” Төмөртэй шоронд нэлээд дотно байлаа. Яагаад гэвэл бид хоёр адилхан ууланд бүгэж байсан болохоор амь нэгтэй, адаглаад л ярианы сэдэв таардаг байсан юм. Мөн дээр өгүүлсэн “Бозлог” Даш гэдэг өвгөнтэй нэлээд дотно байсан. Түүнийг зохиолч Сономын Удвал гуай батлан дааж шоронгоос суллаж байлаа. Яагаад гэвэл Даш гуай ууланд байхдаа зохиол оролддог байж л дээ. Тэгээд баригдсаныхаа дараа шоронд ирээд Удвал гуайд захидал бичиж зохиол мохиолоо танилцуулсан юм билээ. Гэхдээ түүний зохиол хэвлэгдээгүй. Зохиол оролддог байсан болохоор нь Удвал гуай үнэлээд харж үзсэн юм байлгүй. Миний хувьд гэвэл тэр зохиол мохиолоос хол хөндий байсан. Тэгээд ч наймдугаар ангийн боловсролтой мань мэтийн хүн юу бичиж гийгүүлэх билээ дээ. Гэхдээ би Богд ууланд хоёр жил бүгэхдээ ямар ч аавын хүүгээс илүү сэргэлэн байж чадсан гэж боддог. Одоо Богд уулыг харах болгонд төрсөн нутаг маань юм шиг санагдаад байдаг юм. Ямар сайндаа л хэдэн жилийн өмнө Монгол даяар хүмүүс овог авч эхлэхэд би “Богд” гэсэн овог авч байлаа. Хүмүүс миний “Богд” овогт Цэндийн Тайван гэдэг паспортыг харчихаад “Та чинь Богд хааны удмын хүн үү” гэж асуудаг юм. Хариуд нь би “Тиймээ” л гэдэг.

**-Соц нийгмийн үед Богд ууланд гурван хүүхэд төөрөөд огт олдоогүй гэдэг. Арай таныг бүгэж байхад энэ явдал болсон юм биш биз?**

-Энэ чинь надаас өмнө болсон явдал байхгүй юу. Хэрэв намайг бүгэж байх үед энэ явдал болсон бол би аягүй бол олоод өгчих байсан байх.

**-Ингэхэд та 1986 онд Богд уулнаас баригдаад хэдэн жилийн ял авсан бэ?**

-Би долоон жилийн ял авсан. Уг нь их олон жилийн ял авах байлаа. Яахав намайг хэнд ч гэм халгүй хоёр жил бүгсэн болохоор гайгүй ял өгсөн. Оргодол босуул гэхээр л хавьтсан ойртсоноо дээрэмдэж, алж хядаад байдаг юм биш шүү дээ. Өмнө нь би хүн амины хэргээр 10 жилийн ял авч ороод хоёр жилийг нь эдлээд оргочихсон юм. Хүн амины хэрэг ч гэж дээ. Бараг л хилс хэрэг үүрчихсэн юм даа. Би чинь Төв аймгийн Эрдэнэсант сумын уугуул. Тэгээд нэг орой кино тарсаны дараа баахан залуус зодолддог юм байна. Би ч тэр зодоонд давхиад орчихсон. Гэтэл нэг залуу толгой руугаа том чулуугаар цохиулаад нас барчихгүй юу. Маргааш нь бөөн мөрдөн байцаалт болж хэсэг залуу шууд над руу бухчихдаг байгаа. Хилс хэрэгт

гүтгэгдэх ямар аюултай, ямар хүнд байдагийг би тэр үед л мэдэрсэн. Яагаад би гүтгэгдэх болсон бэ гэвэл тэнд зодолдож байсан залуусын ихэнх нь дандаа дарга нарын хүүхэд байсан байхгүй юу. Ингээд л ядуу ардын хүү би гэмт хэрэгтэн болчихож билээ.

## Шорон санаатай Т.Оюунбатын үйлдсэн нүгэл хоёр нүдээр нь бүлт үсэрчээ

Энд өгүүлэх Чулууны Энхтамир хэмээх залуу эгчийгээ баярлуулах гэж гэрт нь очсон биш харин ч бүр хүн амины хэрэгтэн болох шахсан байна. Тэрбээр хэрэг гардаг өдөр “Бөмбөгөр” хавьцаа явж байгаад нэг найзтайгаа тааралджээ. Нэлээд халамцуу явсан найз нь түүнийг хармагцаа “Сайн хүн санаагаараа гэгчээр очиж очиж Эркатайгаа тааралдана гэж байх уу. Би чамайг дайल्या” гэснээр мань хоёр “Бөмбөгөр” хавийн нэг бааранд оржээ. Ингээд мань хоёр орой болтол ууж наргисан бөгөөд шөнийн 22 цагийн үед Энхтамир луу эгчийн нь найман настай хүү утасдаж “Ээжийн бие муу байна, та манайд хурдан хүрээд ир” гэж хэлжээ. Эгч Энхтуяа нь тэр үед нөхөр хүүхдийнхээ хамт Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутаны байранд амьдарч байсан бөгөөд Энхтамир тэр даруйдаа таксидаад оюутаны байрны үүдээр ортол байрны жижүүр угтаж аваад “Хүргэн ах чинь эгчийг чинь бөөн цус нөж болгочихсон гаднаас дагуулж ирсэн. Одоо эгч чинь их муу байна” гэж хэлжээ. Энхтамирыг дотогш ороход эгчийн нь уруул ам байдгаараа памбайчихсан байж. Юу болсоныг асуухад хүргэн ах нь “Бид хоёр сая гудамжинд явж байгаад хүмүүст зодуулчихлаа” гэж хэлжээ. Хүргэн ах нь нэлээд согтуу байсан бөгөөд төдөлгүй архи авахаар гадагш гарсан байна. Энхтамир эгчийнхээ духан дээр дарж тавьсан алчуурыг сөхөж үзтэл дух нь сүрхий том шалбарчихсан байж. Гэвч Энхтамир бөх гээч нь унтаж байгаа эгчийгээ сэрээж яасан ийсэнийг нь асуух гэж түвдсэнгүй. Хүргэн ах Оюунбат нь төдөлгүй гаднаас шил архи барьчихсан орж ирээд “Дүү хүү битгий санаа зов. Эгч чинь өглөө гэхэд л сэргээд ирнэ. Харин хоёулаа ойрд уулзсангүй. Ганц шил юм хувааж ууна байгаа” гээд архиа задлаад өмнө нь тавьжээ. Оройжин найзтайгаа архи пиво уугаад чамгүй халчихсан болохоор Энхтамир татгалзсангүй. Тэгээд хүргэн ахынхаа авчирсан архийг дуусгаад мань хоёр дахиад архинд гарсан байна. Гэвч тэд сүүлд авчирсан шил архиа ууж байхдаа хоорондоо сүрхий маргалджээ. Энхтамир хүргэн ахыгаа заамдаж аваад “Та ганц эгчийг минь байнгын дарамтанд байлгахаа болиорой. Өөрөө зодчихоод гудамжинд хүмүүст зодуулчихлаа гэж худлаа яриад байгаа юм даа. Та ямар тэнэг хүн хуурч байгаа юмуу” гэх зэргээр агсарч гарчээ. Ярдаг танхай зантай, өмнө нь орон шоронд ял эдэлж байсан хүргэн ах нь ч бас зүгээр байсангүй. Энхтамирыг заамдаж авмагц Оюунбат яг л өстөн дайсантайгаа тэмцэлдэж байгаа аятай нүд амаа гялалзуулаад, шүдээ хавираад өөдөөс нь цохих гээд дайрчээ. Гэвч тэр залуу хүүхдийн гарын чадлыг хүчирсэнгүй. Энхтамир ч түүнийг нэг сайн хашраахаар шийдээд нүүр, нүд рүү нь хэд сайн балбаад авчээ. Төдөлгүй тэд архиныхаа халуунд дийлдээд зодолдох, ноцолдох хоёрын дунд байсаар хэн хэн нь нам унтацгаасан байна. Харин өглөө болмогц Оюунбатын найман настай хүү “Ээж хөдлөхгүй байна. Түргэн тусламж дуудаарай” гэж хашгирчээ. Энэ чимээнээр Оюунбат, Энхтамир хоёр сэрж босоод Энхтуяагийн байдлыг ажтал нээрээ огт хөдөлгөөнгүй болчихсон, бүр аль хэдийн амьсгал хураагаад хамаг бие нь хөшчихсөн байх нь тэр. Тэгтэл Оюунбат өөрийнхөө хийсэн хэргийг булзааруулахаар Энхтамир луу шорон аргаар дайрч гарчээ. Мань эр Энхтамирыг шууд л заамдаж аваад “За энэ хэрэг чамаас болсон шүү. Чи урьд шөнө намайг барьж авч зодоод, дараа нь эгчийгээ нүдээд байсанаа санаж байна уу. Чи миний энэ нүүр амыг хар. Арай ч дээ, хүргэн ахыгаа ингэж зодохдоо яадаг юм бэ. За би ч яахав, өнгөрч. Эгчийгээ үхтэл нь зодохдоо яадаг юм бэ. Одоохон цагдаа дуудлаа” гэх зэргээр дөвчигнөж гарчээ. Төдөлгүй цагдаа, түргэн тусламж ирж бөөн хэрэг дэгдсэн бөгөөд энэ үед Оюунбат зодуулж бэртсэн хохирогч хүний дүрд хувирч, харин Энхтамир хүн амины, тэр дундаа эгчийгээ хөнөөсөн сэжигтэн болж хувирах нь тэр. Ингээд цагдаа нар башир аргатай, шорон санаатай Оюунбатын гүжир



гүтгэлгэнд итгээд Энхтамирыг “Ганц худаг” руу авч явсан байна. Гэвч сүүлдээ бүх хэргийн учир тайлагдаж шорон санаатай Оюунбатын үйлдсэн нүгэл хоёр нүдээр нь бүлт үсэрчээ. Энэхүү хэргийг Сүхбаатар дүүргийн шүүх авч хэлэлцсэн бөгөөд яллагдагч Т.Оюунбат “Би эхнэрээ хөнөөгөөгүй. Бид хоёр шөнө гудамжинд явж байгаад бусдад зодуулсан. Харанхуй байсан учраас тэдгээр хүмүүсийн царай харагдахгүй байсан. Би эхнэрээ хамгаалах чадваргүй, согтуу байсан. Намайг тэр шөнө Энхтамир зодоогүй юм. Би худлаа хэлсэн юм. Эхнэр бид хоёр тэр шөнө хоёулаа бусдад зодуулсан” гэх мэтээр эцсээ хүртэл гүрийсэн байна. Гэвч яах ч аргагүй үнэнд гүйцэгджээ. Гэрчүүдийн мэдүүлэгээр түүнийг ямар ч шалтгаангүйгээр эхнэрээ онц хэрцгийгээр зодож, амийг нь хөнөөсөнийг нотолжээ. Сүхбаатар дүүргийн наймдугаар хорооны нутаг зэвсгэрт барилга барьж байсан “Нийслэл өргөө” компаний ажилчин Мөнхтулга мэдүүлэхдээ “Манай барилгын ойролцоо нэг эрэгтэй хүн нэг эмэгтэйг учиргүй зодоод байсан. Эмэгтэй нь гараараа толгойгоо дарж суугаад “Амь авраарай” гэж хашгирч байсан. Энэ үед гурван залуу очоод салгах гэтэл эрэгтэй нь “Эр эмийн асуудал та нарт хамаагүй” гээд тэднийг хөөж явуулсан. Тэгээд нөгөө эмэгтэйг дахиад баахан зодож байсанаа чирч гулдарсаар Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутаны байр луу авч орсон. Тэр шөнө эхнэрээ хайр найргүй зодож байсан хүн энэ мөн байна” гэж мэдүүлжээ. Мөн уг барилга дээр ажиллаж байсан Цэдэвсүрэн мөн л ингэж мэдүүлсэн байна. Гэхдээ Мөнхтулга, Цэдэвсүрэн хоёр Оюунбатын хэрцгийг авирлахыг тэсч чадалгүй хөөрхий эмэгтэйг түүний гараас салгаж авахаар явах гэтэл барилгын даамал нь “Ажлаа хий, бусдын явдал та нарт хамаагүй” гэж зандарчээ. Хэрвээ энэ даамал тухайн үед жаахан хүнлэг сэтгэл гаргасан бол Энхтуяагийн амь аврагдах байсан ч юм билүү, хэн мэдлээ. Шүүх эмнэлэгийн дүгнэлтэнд “Тархины орой, бага тархины суурь, уртавтар тархи гэмтэж, хавирга хугарсан. Хөнгөн зэргийн согтолттой” гэж дурджээ. Үүнээс өөр маш олон гэмтэл байгааг бичсэн байна. Үхлийн шалтгааныг тархины цус харвалт гэж оношилжээ. Мөн талийгаачийн биеийг алаг эрэн болтол нь зодсон байж. Т.Оюунбат өмнө нь эхнэрээ удаа дараа зодож байсаныг түүний болон талийгаачийн найз нөхөд шүүхийн байцаалтанд мэдүүлсэн байх бөгөөд энэ бүхэнд Оюунбат “Өмнө нь миний эхнэрээ зоддог байсан энэ хэрэгт ямар хамаатай юм бэ. Хэдийгээр би хааяа гар хүрдэг байсан ч арай ч амьсгал хураах хэмжээнд хүртэл зодож байгаагүй. Харин хэрэг гардаг тэр шөнө үл таних хүмүүс эхнэрт маань жинхэнэ үхлийн цохилт хийсэн. Цохиж байхыг нь би хоёр нүдээрээ харсан” гэх зэргээр өөрийгөө хамгаалах аяджээ. Шүүгч хариуд нь “Үл таних хүмүүс эхнэрт чинь үхлийн цохилт хийсэнийг та мэдэж байсан юм бол яагаад тэр даруйд нь түргэн тусламж дуудаж эмнэлэгт хүргэж өгөөгүй юм бэ” гэж асуухад мань алуурчин “Эхнэр маань өмнө нь надад зодуулчихаад маргааш нь зүгээр л байдаг байдаг байсан болохоор би зүгээр болчих байх гэж бодож байсан юм” гээд өөрийгөө бариад өгчихжээ. Шоронжсон этгээд Т.Оюунбат энэ хэрэгтээ 25 жилийн ял сонссон бөгөөд үүний эхний таван жилийг гянданд, үлдсэн хугацааг нь чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр заажээ. Уг нь улсын яллагч онц хэрцгийгээр хүний амь хөнөөсөн Оюунбатад цаазаар авах ял төлөвлөөд байж. Гэвч Оюунбатын ах дүү нарын зарим нь хууль хяналтын байгууллагад ажилладаг болохоор түүнийг амьд үлдээхийн тулд чамгүй хөөцөлдсөн сурагтай. Тэгээд л өмнө нь аль хэдийн шоронжсон нэг этгээдийг дахиад 25 жил шоронжуулахаар болсон нь энэ бололтой.

## Шорон дотроос өшөө авагч Жүгдэрийн Мягмараас болж хэлмэгдсэн хүмүүс

1982 оны 8-р сарын 26-наас 27-нд шилжих шөнө Эрдэнэт хотын ойролцоо Булган аймгийн Ингэттолгойн сангийн аж ахуйн явуулын агент Дугархорлоо гэгч эр үл мэдэгдэх шалтгаанаар үхсэн байжээ. Чухал хэргийг мөрөн байцаагчид болон нэртэй хуульчид оролцсон шуурхай групп бүх л шалгалт, туршилт, шинжилгээг хийгээд амиа хорлосон хэрэг гэсэн дүгнэлт гаргасан байна. Гэтэл энэ явдлаас хойш гурван жилийн дараа Эрдэнэт хотын хивсний үйлдвэрээс бусадтай бүлэглэн их хэмжээний хивс хулгайлсан хэрэгт есөн жилийн ял шийтгүүлээд Зүүнхараагийн чанга дэглэмтэй колонид ял эдлэхээр очоод байсан Жүгдэрийн Мягмар гэгч жудаггүй эр ямар нэгэн хэрэг илчлээд ял янханаа багасгахын тулд “Би хэдэн жилийн өмнө танил Буджав, Авирмэд, Уранчимэг нартай бүлэглэн агент Дугархорлоог алсан, тэр хэргийг үйлдэж байхыг Цэрэндорж, Чимидбалдирмаа нар харж байсан” гэж мэдүүлжээ. Ингээд хэрэгтэн Ж.Мягмарын “гэрчилсэн” ноцтой гэмт этгээдүүдийг олж мөрдөн шалгах дуулиант ажил эхэлсэн бөгөөд үүнийг Улсын прокурорын туслах, тусгай хяналтын хэлтсийн дарга Л.Отгонбаяр гардан удирджээ. Эцэст нь шүүх Ж.Мягмар, М.Авирмэд, Д.Буджав нарт цаазаар авах ял оноож, Ч.Уранчимэг, Д.Чимэдбалдирмаа, Ц.Маашбат, П.Цэндсүрэн, Д.Чимэддулам, Б.Баянжаргал нарт 1-15 жилийн ял тус тус оноожээ. Гэвч “Дугархорлоогийн хэрэг” гэгч нь ялтан Жүгдэрийн Мягмар, прокурор Отгонбаяр нарын зохион байгуулсан зохиомол хэрэг байсныг сэтгүүлч Ж.Барамсай илчилсэнээр дээрх нэр бүхий хүмүүс аврагдсан билээ. Уг хэрэгт хамгийн гол үүрэг гүйцэтгэсэн Ж.Мягмар болон хилсээр гүтгэгдсэн М.Авирмэд, Д.Буджав нарын тухай өмнө нь сонин хэвлэлд нэлээд бичигдэж байсан. Харин энэ удаад өмнө нь огт хөндөгдөж байгаагүй Ч.Уранчимэг, Д.Чимэдбалдирмаа, Ц.Маашбат, П.Цэндсүрэн, Д.Чимэддулам, Б.Баянжаргал нарын талаар өгүүлье.

### Чүлтэмийн Уранчимэг гэж хэн бэ?

Хүн амины хэргийг зохион байгуулж толгойлсон хэрэгт 15 жилийн хорих ял заагдсан энэ бүсгүй Баянзүрхийн колонид ялаа эдэлжээ. Хялганат хорооны мод боловсруулах үйлдвэрт ажлаа хийж байсан Уранчимэгийг 1985 оны 2-р сарын 16-ны өдөр ахмад цолтой нэг хүн гэнэт баривчилсан байна. Улмаар прокурор Л.Отгонбаяр өрөөндөө дуудаж “Чи хүн алсан. Чамд 15 жилийн чанга ял өглөө” гэхэд бүсгүй гайхан дуу алджээ. Төдөлгүй Ж.Мягмарыг оруулж ирэн нүүрэлдүүлжээ. Хориг-дол Мягмар “Биднийг архи уугаад сууж байхад энэ хүүхэн ирээд “Энд маш их мөнгөтэй агент явж байна. Тэрнийг алаад цөмөөрөө мөнгийг нь авья” гэж хэлээд тэр хүнийг алуулсан. Түүнээс биш би тэр хүнийг алахгүй байсан” гэж мэдүүлжээ. Ж.Мягмарын үгийг батлуулах зорилгоор түүний архи ууж мөрийтэй тоглохдоо орогнож байсан, урьд нь 2-3 удаа ял шийтгүүлсэн, ажил төрөлгүй архинд орсон Тамара гэгчийг авчран Уранчимэгийг таниулах таниулга хийлгэсэн байна. Тамара ч “таньж” гэнэ. Бас Мягмар, Уранчимэг хоёрыг нэг өрөөнд үлдээхэд Мягмар “Урнаа чи залуу хүн, би ч залуу хүн, ингээд хүлээчих, би гарсан хойноо бүх хохиролыг чинь бүрэн төлж өгнө. Чи эмэгтэй хүн. Олон жил суухгүй. Бид нарын амийг л аваад гар. Эмэгтэй хүнээр, чамаар толгойлуулсан гэхээр чи ойлгож байгаа биз дээ. Би гарсан хойноо чамайг харж үзнээ. Гэр орон барьж өгнө” хэмээжээ. 1985 оны 6-р сарын дундуур Уранчимэгийг хоригдож байх үед шөнийн 11, 12 цагийн үед Мягмар гэрт нь очиж эх Бүжинлхамыг нь дуудаж гадаа гаргаад “Уранчимэг надад

ягаан дэвсгэртэй хар цоохор алчуур, шар саатай улаан капрон алчуур хоёрыг өгсөн. Энэ тухай та цагдаа нарт хэлээрэй. Тэгвэл танай охин амархан суллагдаж гарна. Манай ах Цэрэндондог гэдэг хүн танай охиныг мөрдөж байгаа. Ингээд л хэлчихвэл болно. Намайг ирсэнийг хэнд ч хэлж болохгүй шүү” гэж захижээ. Дээр дурьдсан хоёр алчуурыг олоод тавьчихаач гэж Мягмар хоёр дахь удаагаа ирж Бүжинлхамаас гуйжээ. Эрдэнэт хотод байрны хүмүүжүүлэгчийн ажилтай Б.Батцэцэг ярихдаа “Хуучин танил Бүжинлхам гуай нэг өдөр улаан алчуур охинд маань хэрэг болоод байна. Охин минь хэрэг түвэгт орсон” гэхээр нь “Та юу ярьж байнаа, хэргийн учир олдоно. Ингэж явдаг чинь буруу” гэж хэлсэн. Одоо бодоход тэр Мягмар гэдэг хүний захиасыг л биелүүлэх гээд явж байсан бололтой” хэмээжээ. Хорь гаруйхан настай Уранчимэг архагшсан ялтан Мягмарын үгээр ийнхүү хүн алсан ялтан болжээ. Уранчимэгийг хүн алахад удирдсаныхаа шанд агентын мөнгөнөөс 4000 төгрөг өгсөн гэсэн яриа шүүн таслах хурал дээр гэнэт гарч иржээ. Түүнд учир нь огт олдохгүй 6265 төгрөгийн төлбөр тавигдсан бөгөөд үүнийг нь ялтаны ажлын хөлснөөс суутгасан байна. Уранчимэг хожим нь телевизээр “Би мөрдөнд байхдаа амиа хорлоё гэж санаад ханцуйгаараа хоолойгоо боож үзсэн. Гэвч хөгшин эх, хэдэн дүү, хоёр муу бүлтгэр хүүхдээ бодоод үхэж чадахгүй юм билээ. Яагаад ч үхэж болохгүй байсан шүү” гэж нулимсаа цувуулан ярьж байсан билээ.

### **Данзангийн Чимиддулам гэж хэн бэ?**

1980-аад оны үед “Социалист хууль ёс” сэтгүүлийн нэгэн дугаарт “Мэс засалч хуульч” гэсэн гарчигтай найруулалд мэс засалчтай зүйрлүүлж магтуулж байсан прокурор Д.Чимиддулам хэмээх хуульч эмэгтэй мөн л дээр дурьдсан хэрэгт холбогджээ. Түүнийг шоронд хоёр жил гаруй ял эдлэх хугацаанд хань нөхөр нь нас баржээ. Ингээд тэр шоронгоос суллагдмагцаа таван өнчин хүүхдээ тэжээхийн тулд Эрдэнэт хотын 35-р баазад ажилд орсон байна. Прокурорын байгууллагад 20 гаруй жил ажиллаж, төрийн хуулийн заалтыг биелүүлж гэмт этгээдүүдтэй тэмцэж явсан мань эмэгтэй мөнөөх л ялтан Мягмарын гүжир гүтгэлэгээс болж хэлмэгджээ. Мягмар “Чимиддулам прокурорт нэг том хивс хээл хахууль болгож өгсөн” гэж мэдэгдсэнээс болж гэмгүй эмэгтэй хэрэгтний суудалд суужээ. Хуульч эмэгтэйг долоон сарын турш мөрдөн байцааж шоронд хорихдоо хивс авсан гэх ямар ч нотлох баримт олж чадаагүй байна. Тиймээс Чимиддуламын ах дүү, төрөл садан, эр нөхөр, нутаг усныхантай холбоотой хазгай гишгэсэн юу байгааг бүртгэн хайжээ. Эцэст нь тоймтой зүйл олдохгүй болохоор нь албан тушаалын хэргээр шийтгэх болж, прокурор Чимиддуламын шийдвэрлэсэн хэргээс нэгийг сонгосон байгаа юм. Хялганатын худалдаа бэлтгэлийн ангийн тогооч Ц.Дэнсмаа гэгч 90 гаруй мянган төгрөг ашигласан хэрэгт шийтгүүлж, түүнийг прокурор Чимиддулам хянаж ялын төлөвлөгөө баталсан юмсанж. Гэтэл Дэнсмаагийн ажилласан хугацаанд тухайн үед тооцоог нь буруу бодож их хэмжээний мөнгө ашиглах явдлыг илрүүлээгүй асуудалд Хялганатын гурван ня-бо холбогджээ. Үүнийг Ч.Чимиддулам шийдвэрлэжээ. Гэхдээ Сангийн яамнаас шинжээч томилох, тооцоог дахин бодуулах зэрэг хууль зүйн дагуу хийгдэх ёстой бүгдийг хийсний дагуу дахин магадлуулаад Банзрай гэдэг нябогийн үед маш их дутагдал гарч түүнд ял төлөвлөн нөгөө хоёр нябог нь чөлөөлсөн байна. Банзрайг яллан, нөгөө хоёрыг нь чөлөөлсөн нь гарцаагүй нотлох баримтад тулгуурлан зөв хийгдсэн бөгөөд гол буруутан нь Банзрай гэгч болох нь маргаангүй тогтоогджээ. 1984 оны 12-р сарын 15-нд хуурамч шилжүүлэг бичиж дутагдлыг хаасан тооцоог зохих ёсоор нь бодолгүй Дэнсмаагийн амаар шийдэж, түүнийг 93703 төгрөг ашиглахад нь хянан илрүүлээгүй гол буруутан Банзрай нь хуулийн байгууллагын эрх мэдэлтнүүдийн нэгний нь садан байсан

юмсанж. Тиймээс хуульч Чимэддуламыг Банзрай гэгчийг хэлмэгдүүлж, нөгөө хоёр нябог нь хаацайлж үлдсэн хэрэгт унагажээ. “Ийм гайхмаар, огт итгэмээргүй зүйлүүд миний амьдарч, ажиллаж байсан удирдах байгууллагад байсныг өөрчлүүлж, засуулж чадахгүй бол өөрчлөн байгуулалт гэж санахын ч хэрэггүй болов уу. Энэ нь бидний үр хүүхдэд ч сургамж өгөх байх” гэж хожим Чимиддулам өгүүлжээ.

## **Долгорын Чимидбалдирмаа гэж хэн бэ?**

Эрдэнэт хотын хивсний комбинатын ажилчин энэ бүсгүй 1985 оны гуравдугаар сард гэнэт баривчлагджээ. Албадан саатуулах газар олон хоносоны эцэст “хэсэг этгээдүүд бүлэглэн хүн алж байхад харсан мөртлөө нуун дарагдуулж, улмаар гэмт этгээдүүдээс арван мянган төгрөгийн хахууль авч завшсан” гэх үгийг Улсын прокурорын туслах Л.Отгонбаярын амнаас сонсоод маш ихээр гайхаж “Үгүй, ээ. Та хүн андуурчээ” гэж хашгирсан гэдэг. Гэвч прокурор Отгонбаяр “Битгий худлаа хэл. Чи хүн алахыг харсан” гэж тулгажээ. 72 цаг суух ёстой албадан саатуулах газар 432 цаг хоригдсон Чимидбалдирмааг “Ганц худаг”-ийн мөрдөнд шилжүүлэх үед Л.Отгонбаяр “Чи арван мянган төгрөг авсан гээд гарынхаа үсгийг зураад хүлээсэн байхад чамд ямар ч хохирол учрахгүй. Чи энэ мөнгийг төлөхгүй. Ял ч авахгүй. Гарын үсгээ зур” гэж ятгажээ. Гэвч Чимэдбалдирмаа худлаа хэрэгт гарын үсэг зурсангүй. Тэгтэл прокурор Отгонбаяр “Тэгвэл чи шоронд очоод хэвтэж бай” гэж зандарчээ. Чимэдбалдирмаа найман сарын турш мөрдөнд бие, сэтгэлийн зовлон эдэлж суухдаа үнэн олодох байх гэж горьдсоор байжээ. Хэрэг явдал гарах үед тэрбээр Архангай аймгийн Хотонт суманд эцгийнхэндээ байснаа хичнээн хэлэвч хуулийнхан хүлээж авсангүй. 1982 оны 8-р сарын 24-нд тавдугаар баазын жолооч Бадарчтай гарч 25-нд нутагтаа очиж, 28-ны өдөр тэндээсээ эргэсэн байна. Хотонтод байсныг нь хөдөлбөргүй гэрчлэх олон хүний нэг нь 8-р сарын 26-нд тэндхийн 4-р бригадын хоньчин, улсын аварга малчин, АИХ-ын депутат Г.Лхагважав гуай бөгөөд түүнийг зааз хонио Чимидбалдирмаагийн эцэг Долгорт хүлээлгэн өгч байхад Чимидбалдир тоололцож байжээ. Бас 8-р сарын 31-ний оройн суудлын вагоноор Эрдэнэт хотод ирэхэд нь Чимидбалдирмаатай хамт ажилладаг Лхагвадорж, Жамбаа, Алтанцэцэг нар хамт иржээ. Гэтэл эдний хэнтэй нь ч хэрэг мөрдөгчид уулзаагүй байна. Намын гишүүн Д.Лхагвадорж гэгч худлаа мэдүүлэг өгөхөөргүй шударга залуу Чимидбалдирмаатай хамт ирсэнээ яг үнэнээр нь мэдүүлтэл Отгонбаяр мэдүүлгийг нь урж хаяад “Чи үнэнээ хэл, хэлэхгүй бол хорино шүү. Та хоёр эр эмийн холбоотой ч байж магадгүй” хэмээн хэлэх хэлэхгүй үгээр загнаж сүрдүүлж байгаад түүнээс “Хамт ирээгүй. Чимидбалдирмаа худлаа хэлсэн” гэсэн мэдүүлэг авчээ. Сүүлд нь Д.Лхагвадорж худал ташаа мэдүүлэг өгсөнөө шударгаар хүлээж намын гишүүнийхээ хувьд Намын Төв Хороонд өргөдөл бичсэн байна. Ингээд 1986 оны 2-р сарын 13-нд хариу мэдэгдэх хуудас иржээ. Тэр хуудаст “Таны өргөдөлд бичсэн зүйлийг судалж үзлээ. Чимидбалдирмаа нь Мягмар нарыг ноцтой гэмт хэрэг үйлдэх үед хамтран оролцсон болох нь бусад гэрчүүдийн мэдүүлгээр тогтоогдсон байна” гэсэн байж. Хэрэгтэн Ж.Мягмар “Хүн амины хэрэг гарах үед би Чимидбалдирмааг ТМС-ийн сурагчдын нийтийн байрнаас мотоциклиор авчирсан” гэж өчиг өгсөнөөс Чимидбалдирмаа хилс хэрэгт сэрдэгджээ. Хуулийнхан үүнийг шалгасангүй. Жирийн ажилчин бүсгүй Чимидбалдирмааг 210 хоног мөрдөөд эцэст нь ял тулгажээ. Чимидбалдирмаа шоронд ороод тархи толгойны өвчтэй болсон бөгөөд ээж нь охиноо шоронд орсоноос хойш сэтгэл санаагаар шаналан өвчилж, суллагдсанаас нь хойш жил шахам болоод нас баржээ.

## **Пүрэвсүрэнгийн Цэндсүрэн гэж хэн бэ?**

Хуулийн дээд мэргэжилтэй хүмүүс хүртэл дээр дурьдсан хэрэгт холбогджээ. П.Цэндсүрэн тухайн үед Эрдэнэт хотын цагдан сэргийлэх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, ахмад цолтой байжээ. Гэвч прокурор Л.Отгонбаяр “Хүн алсан этгээдээс хээл хахууль авч, ноцтой гэмт хэрэг дарагдуулсан, энэ чинь хөдөлшгүй баримтаар нотлогдсон. Мягмар чамд Хивсний хэрэгт мөрдөгдөж байхдаа хоёр том хивс, хүн амины хэрэгт аргалаарай гэж 10 мянган төгрөг өгсөн байна” гэж тулгажээ. Цэндсүрэн ийнхүү 225 хоног хоригдон мөрдөгдөж, яс арьс болтолоо турж, хоёр хүнээр дамнуулж ял эдлэх колонид хүргэгдсэн байна. Ингээд ялтан Мягмарын хүсэл биелжээ. П.Цэндсүрэн нь Дугархорлоо гэгчийн хэргийг төвөөс ирсэн гавьяат хуульчид болон өөрсдийнхөө нийлсэн 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр урьд нь шалган магадалж тогтоосноос гадна хивсний бүлэг хулгайн хэргийг шалгаж байсан байна. 1983 онд Ж.Мягмар хивсний хэрэгт шийтгэгдээд хүргэгдэх үедээ мөрдөн байцаагч Цэндсүрэнг “Чамайг би заавал хорлоно доо” гэж заналхийлж байжээ. Цэндсүрэнг албан тушаалын хэрэг, машин унаа хувьдаа хэрэглэн олон км газар явсан гэх зэрэгт холбож нэг жил зургаан сарын ялыг чанга дэглэмтэй колонид хорихоор таслан шийдвэрлэжээ. Цэнд-сүрэн шоронд өлсгөлөн зарлаж, хөдөлмөрийн колонид ажил хаяж, өргөдөл, гомдол дээд газар хичнээн бичлээ ч хариу ирдэггүй байж. Тэрбээр 1980-аад оны сүүлчээр “Үнэн” сонинд бичсэн захидалдаа “Бичсэн, ярьсан зүйл худал байх аваас хуулийн хариуцлага хүлээнэ, түүгээр ч барахгүй ял шийтгэлийг нэмэг-дүүлэн оноож болно гэдгийг урьдчилан ухаарч үнэнийг бичсэн гэдгээ дурдъя. 1986 оны 6-р сарын 28-нд хавтаст хэрэгтэйгээ танилцсан үеэс дээд газруудад арвантаа бичиж, хариу хүлээвч хариу өгөхгүй дарагдуулаад байхаар нь үнэний дайчин байлдагч хэвлэл мэдээллийн нөхдийг түшихэд хүрсэн юм” гэж өгүүлжээ.

## **Базгайн Баянжаргал гэж хэн бэ?**

“Зарлан дуудах хуудас №58. 1986 оны 1-р сарын 29-ний өдөр. Эрдэнэт хот дахь цагдан сэргийлэх хэлтэст ахлах төлөөлөгч Баянжаргал таны биеийг Улсын прокурорын туслах ажилтай Л.Отгонбаяр 416 номерийн тасалгаанд 1986 оны 1-р сарын 31-ний өдрийн 09 цагт бэлэн ирсэн байхыг эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155 дугаар зүйлд заасныг удирдлага болгон зарлан мэдэгдэв. Эс ирвэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155 дугаар зүйлд заасан ёсоор албадан ирүүлэх арга хэмжээ авах болно. Улсын прокурорын туслах албан тушаалтай Л.Отгонбаяр” гэсэн бичгийг аваад ахлах төлөөлөгч Баянжаргал “Би чинь одоо ямар хэрэгт холбогдчихдог билээ” гэж учиргүй гайхжээ. Жирийн цагдаагаас эхлэн сэргийлэх, хуулийн байгууллагад 20 гаруй жил ажилласан ахмад цолтой, ахлах төлөөлөгч болтлоо дэвшсэн энэ эр мөнөөх хивсний хэрэгтэй холбоотой Мягмарыг байцааж байсан байна. Нэг ёсондоо хүний ёс жудагаа уландаа гишгэсэн Жүгдэрийн Мягмар түүнээс өш хонзонгоо авч байгаа нь энэ. “Би жолооч Ганбаатарын машин дотор 30 ширхэг хорьтын дэвсгэрт нийт 600 төгрөг байсныг ахлах төлөөлөгч Баянжаргалд өгсөн” гэж Мягмар мэдүүлсэн байж. Тэр ёсоор Баянжаргалыг байцаажээ. “Чамайг хоёр сар харлаа. Мягмар чамд 600 төгрөг өгсөн гэж байгаа. Үүнийг үнэнээр мэдүүлэхгүй бол хохь чинь шүү. Чамайг ухна, хорино” гэж Л.Отгонбаяр түүнийг сүрдүүлээд цагдан хорих тогтоолыг прокурор Д.Даваасүрэнгийн нэрээр бичиж өөрөө батлаад ахлах төлөөлөгч Баянжаргалыг “Ганц худаг” руу илгээжээ. Ингээд түүнийг 82 хоног хорихдоо ёстой л ухааж гарсан байна. Бас л бичиг цаас онгичиж, мэдэх мэдэхгүй зүйл тулган шаардсаар сүүлдээ уг хэргийг шийдэх хүн ч үгүй болж,

Л.Отгонбаяр ч өөрөө хойшоо курст яваад өгчээ. Эрүүл саруул байсан Баянжаргал хөл дээрээ гишгэж ч чадахгүй зүүд зэрэглээ шиг амьтан болоод гарч ирсэн байна. Баянжаргалыг мөрдөнгөөс суллаад дөрвөн сар гэрт нь ажилгүй суулгажээ. Тэгээд 1984 оны өршөөлийн зарлигт оруулж “Хэргийг чинь хэрэгсэхгүй болголоо” гээд УЦСЕГ-т бичиг явуулжээ. Баянжаргал сонинд бичсэн захидалдаа “Би 1986 оны 2-р сараас 1987 оны 4-р сар хүртэл 15 сар буюу нэг жил гурван сар хоригдож эрүүл мэндээрээ хохироод зогсохгүй гар дээрээ ганц ч мөнгөний орлогогүй явж ирсэн. Би сард 950 төгрөгийн цалинтай байсан. Эдийн засгийн хувьд ингэж хохироолоо. Үр хүүхдийг минь хүртэл “Аав чинь шоронд орсон” гэж хүүхэд, багачууд гутааж доромжилсоор өнөөг хүрлээ. Эхнэр хүүхэд маань надаас болж өвчин тусч эмнэлэгт удаан хугацаагаар хэвтсэн. Би огт гэмт хэрэг хийгээгүй болохоор өршөөлийн зарлигт орно гэж байхгүй, гэмт хэрэг хийсэн хүнийг л зарлигт оруулдаг шүү дээ” хэмээжээ. Тэрбээр нам улсын болоод хуулийн дээд байгууллага, дарга, сайд нарт нийтдээ есөн удаа өргөдөл, гомдол бичсэн боловч ганц ч хариу аваагүй байна. Энэ мэтээр Ш.Намхай, Т.Фёдор, Л.Цогоо, Г.Пүрэвжий зэрэг хүмүүс цөм л шорон дотроос өшөө авагч Ж.Мягмар гэгч ялтаны мэдүүлсэнээр хилс хэрэгт холбогдож, мөрдөнд сууж, ял эдэлсэн байгаа юм.

### **Цэрэндоржийн Машбат гэж хэн бэ?**

Эрдэнэт хотын түргэн тусламжийн эмч байх үедээ 1985 оны 3-р сарын 5-нд Улсын прокурорын туслах, тусгай хяналтын хэлтсийн дарга Л.Отгонбаярын гарын үсэгтэй зарлан дуудах бичиг хүлээн авсан Ц.Машбат тэр оройдоо галт тэргээр Улаанбаатар руу гарчээ. Түүнийг хүн алсан этгээдийг хаацайлж эмнэлэгт хэвтүүлсэн хэрэгт тулган байцаажээ. Прокурор Отгонбаяр түүнийг өмнөө суулгаад “Чи Мягмарыг хэдийд эмнэлэгт хэвтүүлсэнээ ярь. Чи архичин, архи тамхи хэрэглэдэг. Муу сайн эмч нарыг би мэдэж байна. Чамайг одоо шоронд хорино” гэж тархи толгойгүй загнахад Машбат үнэхээр цочсон байна. Үүний дараа түүнийг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгуулуудыг удирдах газарт төлөөлөгч Цэрэндондог, Аюушжав нар дамжуулан байцаасаар хэрэгтэн Мягмартай нүүрэлдүүлжээ. Гэмгүй хүнийг гүжирдэж гүтгэхдээ дэндүү гаршсан Мягмар нүүрээ огтхон ч улалзуулалгүйгээр “Би эмнэлэгт хэвтэж байхдаа энэ эмчээр өвчний түүх дахин дахин шинээр нээлгэж байсан” гэж улайм цайм гүтгэжээ. Ингээд эмч Машбат хоригдол Ж.Мягмарыг хүн алах үед нь эмнэлэгт хэвтүүлж байгаад тухайн үед 1200 төгрөг, таван шил архи авч сүүлд нь шинээр өвчний түүх нээж хуйвалдсан ялд унажээ. 40 гаруй хоног улсын прокурорын үүдийг сахиж өдөр болгон байцаалгасны эцэст “Ганц худаг”-т хоригдсон байна. Оюутан байхдаа тархины гэмтэл авч, хожим нь бүдүүн гэдэсний шархлаатай болсон Машбат мөрдөнд хэд хонохдоо хуучин өвчин нь сэдэрч үхлийн даваанд тулжээ. Эцэстээ Машбат нь Мягмарын эмнэлэгт хэвтсэн өвчний түүхийг устгаж шатаасан гэх хэргийн эзэн болж хувирсан бөгөөд иймэрхүү бичиг хуурамчаар үйлдэн байж шоронгоос арай чүү гарчээ. Яагаад ийм хэрэг үйлдэхэд хүрсэн бэ гэж хожим Машбатаас асуухад “Мөрдөнгийн зовлонгоос амьд л гарч байвал юу ч гэж хэлсэн яах вэ гэж бодогддог юм билээ. Амьд л явж байвал үнэн олдох байх гэж бодоод л өөрөө өөртөө хуурамч бичиг үйлдэж билээ” гэсэн байдаг. Түүнийг Мягмараас 1200 төгрөг авсан гэдгийг хүлээлгэхээр Л.Отгонбаяр гадуур сар гаруй байцаахдаа “Хэрэв чамайг 1200 төгрөг авсан гэж хүлээхгүй бол дахиж хориод тулгаж тасална. Хүлээвэл гэрт чинь явуулна” хэмээжээ. Тиймээс шоронг яс махаараа мэдэрсэн Машбат “Би ялтан Мягмараас 1200 төгрөг, таван шил архины хамт авсан” гэж хүлээжээ. Үнэн хэрэгтээ Ж.Мягмар нь хүн амины хэрэг гарахад эмнэлэгт биш шоронд байсан тухай буцаж

булзахааргүй баримт байжээ. Хивсний үйлдвэрийн ажилчин Цамбын Нямсүрэн “Анх би 1982 оны 8-р сарын 26-нд Эрдэнэтийн мөрдөнд цагдан хоригдохоор хүрч ирэхэд Мягмар “Нямсүрэн чи баригдаад ирэв үү” гэж орилж байсан” гэж мэдүүлжээ. Мягмар тэр үед шоронд байсныг тэнд хоригдож байсан Гантулга гэдэг залуу ч бас гэрчилдэг байна. Нөгөө талаар Эрдэнэт хотын урьдчилан хорих байранд 1982 онд цагдан хорьсон хүмүүсийн тогтоолд хавсаргасан материалын баримтад “Ж.Мягмарыг 8-р сарын 31-ний 16 цаг 30 минутад эмч Энхтуяа авч явлаа” гэсэн бичиг байдаг аж. Мөн “9-р сарын 31-ний 21 цаг 50 минутад Мягмарыг эмнэлэгт хэвгүүлэхээр авч явлаа. Сэргийлэгч Энхбаяр” гэсэн гарын үсэгтэй бичиг байдаг аж. Ямартай ч агентын амь нас хохирсон цаг үед Мягмар гэгч гарцаагүй шоронд хоригдож байсан байна. Тэгтэл мань эр “Би энэ хэргийг тийм хүмүүстэй хамт үйлдсэн” гэх зэргээр баахан чулуу хөөлгөжээ. Хэрэг явдал өнгөрснөөс хойш нэгдсэн эмнэлэгийн бүх эмч нараар Машбатын талаар батлан даалт гаргуулах хурал хийлгэжээ. Хурал дээр худал хэрэг хүлээсэн тухайгаа Машбат ярьж, нөхөд нь Машбат яагаад ч ингэхгүй, хуулийн байгууллагад эсэргүүцэл бичье гэсэн санал ч гаргажээ. Ц.Машбат мөрдөнд сууснаас болж архаг өвчин нь улам хүндэрч гурван удаа мэс засал хийлгэсэн байна. “Намайг Мягмарын гүтгэлэгээр ямар ч үндэсгүй 90 хоног мөрдөнд хорьсон. Мөн шоронд хатаана гэж сүрдүүлж байгаад 1200 төгрөг төлүүлсэн. Улаанбаатар руу хоёр удаа дуудагдаж очихдоо замын зардалд гарлага их гарсан. Энэ хохиролыг минь төлүүлж, эмч хүний нэр төрийг маань сэргээж өгөөч” гэж Машбат хожим гомдол мэдүүлжээ.

## “Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэдэг үг Д.Сүхдоржийг насаар нь “алж” орхижээ

“Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэдэг үг Далхаагийн Сүхдоржийг гурвантаа шоронд оруулжээ. Мань эр 1986 онд армид анх очоод карентины шинэ цэрэг байхдаа шаардлага тавьсан нэг бага даргын өөдөөс “Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэж хэлээд АКА бууны бөгсөөр тархи руу нь цохиж хүнд гэмтэл учруулжээ. Зөвхөн ингээд зогссон нь их юм. Учир нь тухайн үед шинэ цэргүүд “Дадлагын гурван сум” гэгчээрээ анх удаа буудлага хийж байсан бөгөөд хэнд ч дээрэлхүүлэхийг хүсдэггүй угийн омголон зантай Сүхдорж өөрт оногдсон гурван сумаараа нэг байтугай гурван бага даргын амийг хөнөөж болох байлаа. Харин тэр АКА бууны бөгсөөр дэлсээд өнгөрсөн нь яамай. Мань эр уг хэрэгтээ дөрвөн жилийн ял аваад шоронд очуугаа “Ингэж шоронгийн хаалга татах байсан юм бол тэр муу онгиороо бага даргын тархийг зад буудчихдаг байж” гээд амаа барьсан гэдэг. Ер нь Сүхдоржийн ах дүү нар бүгдээрээ омголон давилуун улс юмсанж. Түүний ах Сүхбаатар нь энэ зангаасаа болж арав гаруй жил ял эдэлжээ. Сүхдоржийг шоронд очсон хойно ах Сүхбаатар нь эргэж очихдоо “За миний дүү, халхын шоронд зовхи өөдөө явсан хүн хождог юм шүү. Барын сүүл байснаас батганы толгой байсан нь дээр гэдэг сайхан үг байдаг юм. Ээ, дээ миний дүү хулгайч нарт л дээрэлхүүлэв” гэж захижээ. Олон хулгайчийн хулхи нь буудаг байсан Дарьтын хорих ангид очсон Сүхдорж үнэндээ зовхи нь өөдөө байжээ. Түүнийг архаг хулгайч нар хүртэл “Учраа мэдэхгүй яаж ч мэдэх хөлдүү пацаан” гээд оролддоггүй байж. Үүнд тэрбээр ихэд эрэмшиж “Ах нар минь намайг жинхэнэ хатуу гар болгож хүмүүжүүлжээ” гэж боддог болжээ. Тэгээд уйдсандаа нэг хөгшин хулгайчийг өдтөл цаадах нь эхэндээ хөдлөөгүй ч нэг орой түүнийг унтаж байхад нь хутгалж орхисон байгаа юм. Тэрбээр хутгалуулсан тухайгаа хянагч нартаа хэлэлгүй нуусан нь олон хулгайч нарын дунд нэр алдар нь бэхжихэд ихэд тус болжээ. Дөнгөж 21 настай залуу гэхэд 180 см өндөр, 90 гаруй кг жинтэй, хэн ч харсан нүдээр олзломгүй бие хаатай нэгэн байсан нь ч нөлөөлсөн бололтой. Гэвч өөрийн бие хаа, зодоонч зандаа итгэж хэнтэй ч муудалцахад бэлэн байсан түүнийг архаг хулгайч нар дарахаар шийдэж нэг ядарсан нинжад мөнгө өгч мань эрийг өдүүлсэн байна. Өдсөн битгий хэл зүгээр байгаатай нь шөргөөцөлдөхөд бэлэн байсан тэрбээр “Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гээд мөнөөх нинжаг цохиж унагаад дэвсэж гарчээ. Тэгээд мөн л хүн зодож бэртээсэн хэргээр дэглэм дээшилж Зүүнхараагийн чангад очсон байна. Харин энд очоод овоо томоожсон бөгөөд тэрбээр сав л хийвэл “Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэж хашгирч орхидог үгээ хэр барагтай бол хэлэхээ байжээ. Үүний ачаар долоон жилийн дараа буюу 1993 онд шоронгоос суллагджээ. Олон жил шоронд байсан болохоор нарны амьдралд тийм ч сайн дасч өгсөнгүй. Учраа олохгүй ядаж байхад нь эцэг эх хоёр нь доройтож хоногийн хоолоо ч дийлэхгүй шахам болсонд Сүхдорж ихэд бухимдана. Гэхдээ уур бухимдлаа бусдад гаргаж эргээд шоронд орохыг хүсэхгүй байлаа. Эхний хэдэн сар тэрбээр шоронгоос олж авсан мөнгөө идээд дуусчээ. Тэгээд уур нь хүрэхээрээ эцэг эхээ загнаж “Та муу хоёр л намайг ийм новшийн амьдралд татаж оруулсан” гэж зүхдэг болж. Нэг өдөр түүнийг эцэг эх хоёроо яг л дээрх маягаар зүхээд сууж байтал эмэгтэй дүүгийнх нь нөхөр болох шинэхэн хүргэн нь ороод ирж. “Хүргэн хүү хүчтэй, хүзүүний мах амттай” гэгчээр эцэг эхээ загнаж зандраад сууж байсан Сүхдоржийг харуугаа мань хүргэн “Та одоо хэн болчихоод хэнийг зандраад байгаа юм бэ. Таны тэр орон шоронд олон жил болсон чинь



хамаагүй шүү” гэх зэргээр хэгжүүрхжээ. Тэгтэл Сүхдоржийн уур омог гэнэт дүрэлзэж “Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гээд зуухны хажууд байсан галын хайчийг шүүрч аваад хүргэнийхээ тархинд буулгаж орхижээ. Өмнө нь тэр хүн амьтан зодохдоо хүндээр бэртээдэг байсан бол энэ удаад шууд алаад хаячихсан байна. Ингээд хорин жилийн ял авсан бөгөөд эдүгээ түүнд таван жилийн ял дутуу байгаа юмсанж. Сүхдорж нэг үеэ бодвол нас нь хөгшрөхийн хирээр овоо томоожсон төдийгүй “Яасан зэвүүн хулгайч вэ. Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэдэг үгийг тархиныхаа ой санамжаас бүрэн устгаж хаяжээ.

## “Ойлон” Санжаа гэгч эр багшийгаа шоронгоос оргуулаад “Улаан арав”-аар яллагджээ

Хэнтий аймгийн Наран бригадын нутагт Хүүхэн хутагтын хүрээ гэж байсан бөгөөд эдүгээ ердөө дуган сүмийн суурь довжоо л үлджээ. Хүүхэн хутагтын хүрээ нь 15-р жарны харагчин тахиа жил буюу 1873 онд Балжирсамбуу гэдэг хүнийг “Хүүхэн хутагт” хэмээн өргөмжилж ширээт ламаар суулгаснаар анх үүссэн түүхтэй. Энэ цагаас хойш Хүүхэн хутагтын дүрүүдэд Цэвээнлуvsсанданзан, Лувсанжамбалдагва, Лувсанжигмид, Жамъяндамбийбалсан нарын зургаан хутагтыг тодруулан залж байсны хамгийн сүүлчийн Хүүхэн хутагт Жамъяндамбийбалсан нь 19-р зууны үед Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын малчин Цэнднямынд төржээ. Хутагтын хүрээ нь дөчөөд онд хүн ард, өв соёлоо хоморголон устгах их шуурганд дайрагдаж сүйрэх үедээ дөрвөн аймаг, 188 лам, 28 дугантай, тухайн үеийнхээ ханшаар жилд дундажаар 19 мянган төгрөгийн орлоготой томоохон хийд байжээ. Анх Хүүхэн хутагт биелсэн шуламыг дарж хувилсан гэсэн домог бий. Шулам тэртээ хол цагт Өмнөдэлгэр сумын нутаг Мөрөнгийн голын хоёр талд байдаг Сэргэлэн, Бэрх хоёр уулын хооронд хэц татаад, түүнийхээ дотор орсон хүн амьтныг өөрийн болгоно гэж айлгадаг байж. Хүүхэн хутагт түүнийг дарахаар дун бүрээ татаж, ном гүрмээ уншиж явсан бөгөөд засал хийсэн тэр газрыг нь Дунгийн гацаа, Дунгийн бүрд, шуламыг дарсан газрыг нь Удганширээт гэж нэрлэсэн гэдэг. Хүүхэн хутагт гэж нэрлэсэн өөр нэг онцлог нь гэвэл хутагтын дүрд тодорсон зургаан хүн зургуулаа босоо бужгар үстэй байж. Чухам энэ шинжээр нь тодруулдаг байж л дээ. Монгол улсын тамгатай хутагтын нэг Хүүхэн хутагт Жамъяндамбийбалсан нь хүрээний хамгийн тэргүүн том лам төдийгүй хавь ойрдоо ихэд нэр хүндтэй байж. 1930-аад оны үед Хутагт лам Хэнтий аймгийн Дотоод яамны хэлтэсийн ногоон малгайтнуудад баригдаж шоронд оржээ. Тиймээс Хүүхэн хутагтын шавь “Ойлон” Санжаа гэгч ламын сэтгэл санаа ихэд уйтгарлаж “Багш маань бие нь тун чилээрхэж байхдаа баригдаж явсан. Шоронд яаж илаарших билээ. Улам ядарч бараг бурхан шидээрээ нартын өдөр хоногийг өнгөрөөж байж таарна. Тэгэхээр би шавь нь юм бол түүнийг аврах ёстой. Намайг харах юм, хамгаалах сахиус байж таарна. Багшийгаа нутагт нь авчирч төрөл арилжуулах нь шавь ёсны учир тавилан, аз заяаны минь дэнс. Гэвч багшийгаа оргуулаад иржээ гэхэд надад ял нүүрлэнэ. Үнсэнд хаягдсан шалз шиг л болно биз. Гэсэн ч багшийгаа заавал олж авчирна. Багш маань надад буянаа хайрлах байлгүй” гэж шийдээд өвөлжин чөдөрлөж хөл нь улдаж, гэдэс нь цүдийсэн шанхан дэлтэй бор морио эмээллээд Мөрөнгийн голыг уруудаж Хэнтийн төвийг зорин шогшжээ. Тухайн үед хувилгаан хүн битгий хэл хуварга лам нар, энгийн ардууд хүртэл баригдсан бол эргэж ирдэггүй байж. “Ойлон” Санжаа багшийгаа оргуулж авчрахаар явах замдаа “Би гэдэг амьтан Хутагт лам дээр очоод яаж уулзаж чадах вэ дээ. Тэгээд бас лам хүнийг шоронгийн мухраас гаргаж авна гэхэд ёстой л нөгөө “Жанцан тангадын улаан морийг” авна гэдэг үлгэртэй зүйрлэх хэцүү зүйл. Гэхдээ хэрэг явдал хэцүү тусмаа хүн түүнийг хийчихдэг л юм. Усны буйлаар орчихсон хүний хойноос эрэг дээрхи олон хүн яаж ч учраа олохгүй барьц алдаж байхад нэгэн хүн эрэг дээрээс шувт үсрэн усанд цүлхийтэл ороод төдхөн тэр хүнийг үүрээд гараад ирэхийг би харсан. Тэгэхэд түүнийг хөлгүй уснаас аварна гэхэд хүний сэтгэлд багтамгүй санагдаж байсан. Хэний ч санаанд оромгүй зүйлийг хийж бүтээдэгийн нууц нь хүний ухаан, овсгоо хоёрт л байдаг байх” гэх зэргээр бодож явжээ. Багшийгаа гэсэн энэрэнгүй сэтгэл гарган хойно нь ирэх муу хатуу далайлтын өмнө аймшиггүйгээр биеэ барьж өгөх гэж буй мятаршгүй эр “Ойлон” Санжаа нь угаасаа хуульч, заргач хэцүү нэгэн байжээ. Зах залгаа Жаргалтхаан сумын-хан түүний

нутгийнханыг “Оорцог бүрдээ далай гэдэг, Ойлон Санжаагаа хуульч гэдэг” хэмээн шүлэглэж байсан гэдэг. Төдөлгүй “Ойлон” Санжаагийн зорьсон хэрэг бүтсэн бөгөөд нэг харанхуй шөнө Санжаа багшийгаа гяндангаас оргуулан авч гараад мориндоо дүүрэн өдөр нь бүгэж, шөнөд нь сажлуулсаар Хутагтын хүрэн дээр авчирчээ. Хутагт ламыг авч явсан тэр шөнө Чандаган тал руу ороод ирүүт цас хялмайлж нутаг ус нь хүртэл Жамъяндамбийбалсан ламыгаа өрөвдөн хайрлахдаа уйлан хайлан угтах нь энэ үү дээ гэмээр шавьд нь санагдаж нулимс алдруулж явжээ. “Ойлон” Санжааг багшийгаа аваад ирэхэд харамсалтай нь Хутагтын хүрэн дээр хэн ч байсангүй. Гэтэл ч хүүхэн хутагт цаг үеийг сайн мэдэрч байсан болохоор хүрээ хийддээ ирсэндээ сэтгэл нь амарсан бололтой тайван нойрсоод маргааш нь таалал төгссөн гэдэг. Амьсгаа хураахынхаа өмнөхөн шавьдаа баярласнаа илэрхийлж хүзүүн дэх эрдэнийн эрхий авч өгөөд “Дүнчүүр маани уншаарай” гэж захисан байна. Шавь “Ойлон” Санжаа нь удсан ч үгүй баригдаж ёстой л хувь заяа нь хутганы ирэн дээр болж байцаагдахдаа “Би амьд аагаа багтаасан хүнийг авчраагүй, амьдын голтой төдий байхад нь багшийгаа авчирч нутаглуулсан нь миний сүсэг бишрэлийн онгод биз. Багшийгаа би ганцаархнаа Наранчандманы энгэрт оршуулсан. Одоо надад санаа зовох юм байхгүй. Та нар надад ямар ял тулгана өөрсдөө л мэд” гэсэн мэдүүлэг өгчээ. Түүний мөрөөр Дотоод яамны Хэнтий дахь хэлтсээс хүмүүс очиж газар дээр нь малтаад үнэн гэдгийг үзээд буцсан аж. Тиймээс Санжааг “Үнэн үгтэй лам байна” гээд арай ч буудан алах ял оноолгүй тухайн үеийн “Улаан арав” гэдэг ялаар шийтгэж амийг нь хэлтрүүлжээ. Тэрбээр шоронд арван жил ял эдлээд 1950-иад оны үед суллагдсан байна.

## Мунагийн хэрэгт удаа дараа холбогдсон “Муужгай” Цэрэндорж арван жилийн ялтай

*Гурван удаагийн үйлдлээр хорь орчим жил ял эдэлсэн “Муужгай” Цэрэндорж 2006 онд 68 насандаа өөд болохдоо дэрэн доороо нэгэн дурсамж үлдээжээ. Тэрхүү дурсамжийнхаа нэг буланд “Энэхүү дурсамжийг сэтгүүлч Б.Ойдовын “Халхын шоронгийн амьд түүх” номонд оруулах гэсэн боловч амжсангүй. Тиймээс дүү Цэрэнпүрэвтээ захиж үлдээе” гэсэн байв. Саяхан дүү Цэрэнпүрэв нь түүний дурсамжийг надад авчирч өгөхдөө “Уучлаарай. Ах маань амьдралдаа нэг их сайхан зүйл хийж бүтээгээгүй хүн. Гэсэн ч өөрийн гэсэн дурсах юмтай байсан бололтой. Үүнийг та үзээд боломжтой бол сонинд хэвлүүлж өгнө үү” гэсэн юм. Тэрхүү дурсамжиндаа шоронгийн амьдралыг дурсахаасаа илүү уулзаж учирч байсан хүүхнүүдийнхээ тухай өгүүлжээ. Дурсамж ингэж эхэлж байна.*

Архангай аймгийн Хашаат сум. 1958 он. Буурцагийн ам. Зуны дэлгэр цаг байлаа. Найз Төмөрбаатарынхаараа очоод буцаж явтал хонины бэлчээрт 17 орчим насны охин дээшээ хараад тэнгэр ширтээд хэвгэж байв. Яваад очлоо. Янаг амрагийн үг чулуудсан чинь ер тоосон шинжгүй. Тэгэхээр нь шууд дараад авлаа. Ердөө эсэргүүцсэнгүй. Энэ бол миний анхны хийсэн нүгэл. Гэвч би дараа нь ямар ч хүүхнийг сав л хийвэл дарж авах гээд байдаг маш хөгийн зантай болсон байлаа. 1959 оны намар Сангийн аж ахуйд явж байгаад ангийнхаа нэг оюутан охиныг мөн л ийм маягаар дарж авсан. Тэр бас л эсэргүүцээгүй. Тэр цагаас хойш хүүхнүүдийг дарах сонирхолтой болсон гэж хэлж болно. Гэвч энэ нь надад гай авчирсан юм. 1960 оны зуны нэг шөнө нийслэл хотын Дунд голын ойролцоо нэг хүүхнийг шууд дараад авлаа. Тэгтэл тэр маш ихээр эсэргүүцэж орилж чарлаад сүйд болсон. Хэн нэгэн хүн харанхуйд ирж явахыг хараад өмдөө хагас хугас татсан болоод ум хумгүй зугттал тэр хүн хойноос харвасан сум шиг гүйж ирээд бариад авав. Ингээд би Дээд сургуулиа төгсч чадалгүй Эрүүгийн хуулийн 88-ын “Б”-гээр яллагдаж шоронд гурван жил суухаар Дорноговь аймгийн Хажуу-Улааны шоронд очлоо. Тэнд би ус зөөдөг морин тэрэг барьдаг байв. Өглөө хар үүрээр босоод тэр хавийн бүх айлуудаар явж ус түгээнэ. Ингэж явахдаа бас хүүхэн шуухан сонирхоно. Боломж таарвал мөн л хашралгүй дараад авах санаатай. Ер нь миний энэ эрхтэн үү? Ёстой лойдчихсон хог байгаа юм. Эзнийгээ дандаа хэрэгт хийнэ. Өөрөө ард нь ямар ч гэм зэмгүй сугарч үлдэнэ. Гэвч би Хажуу-Улааны шоронд очоод эрхтэнийхээ захиргаанд орохоо байсан. Ер нь заавал хүчин хийх албагүй биз дээ. Гэхдээ хоригдол хүнд сайн дураараа хүүхэн олддоно гэвэл хэцүү. Зөвшөөрөх амьтан байдаггүй. Гэтэл нэг мэдрэлийн согогтой хүүхэн боломжийн юм шиг санагдлаа. Царай зүс гэж авах юмгүй. Тэр хүүхэн айлуудаар хэсч аяга хоол олж иддэг байсан юм. Эцсийн эцэст надад ийм л юм олдож байгаа юм. Түүнийг нэг өдөр морин тэргэн дээрээ суулгаад Хажуу-Улааны шоронгоос урагш байх жалга руу авч орлоо. Юм ярих гэхээр яриа нийлэхгүй. Өөдөөс шал тэнэг юм ярьж эргүүтээд байдаг байсан. Арга ч үгүй юм. Мэдрэлийн согогтой юм чинь. Гэхдээ ямар ч гэсэн манийхаа тачаалыг хангачихдаг л байсан юм даа. Бид хоёр олон удаа жалга руу орсон. За, энэ ч яахав. Арай эрүүл ухаантай юмтай хавьтсанаа бодъё. Дараа нь би Багануурын шорон руу ачигдаж эндхийн нэг хөгшин багш авгайтай нэлээд дотно болж билээ. Зайлуул түүний нөхөр нь өөд болсон тул энгэр зөрүүлэх хүн олдохгүй хэцүү л байсан байх. Надаас бараг хорь гаруй эгч. Энэ хүүхэнтэй би нэг хэсэг үерхсэн. Заримдаа гэрт нь өдрийн цагаар загас наадуулна. Би тэднийд ус өгөх далимаар очно. Энэ үед тэр авгай хичээл заах байснаа түүнийгээ таслаад над руу харайлгадаг байж билээ. Намайг тэр “Амьдралын нар” гэж дууддаг байсан. Харин би

түүнийг “Нарны амьдрал” гэж дууддаг байлаа. Тэгээд л “Нарны амьдрал”, “Амьдралын нар” хоёр өдөр шөнөгүй загас наадуулна. Тэр үеийг одоо бодохоор би уйлчих гээд байдаг. Ер нь миний амьдралын хамгийн гэгээтэй үе тэр л байсан байх. Тэгж байтал би шоронгоос суллагдах боллоо. Хүчин хийж ялаа нэмүүлээгүй нь их юм гэж бодож байлаа. Би шууд явсаар Улаанбаатар хотод ирсэн. “Нарны амьдрал” маань намайг дагаж хот руу явах гээд уйлж унжаад бөөн юм болж билээ. Тэгэхээр нь би “Чамайг удахгүй ирж авна” гэж худлаа хэлээд бултчихсан. Их л хүний мөсгүй зан гаргасан даа. “Нарны амьдрал” маань намайг бүтэн долоон жил хүлээсэн байгаа юм. Энэ явдлаас хойш нэг л мэдэхэд 1965 он гарчихсан байлаа. Энэ хооронд би чухам хэдэн хүүхэнтэй энгэр зөрүүлснээ тоймтой санадаггүй юм. Тухайн үед яруу найрагч Бэгзийн Явуухулангийн шүлгийн дуу ид хүчээ авч байсан цаг. Мөн ч гоё үе байж дээ. Нийтийн бүжгэнд их орно. Сайхан сайхан хүүхнүүд тэр үед л ичээнээсээ гарсан юм даа. Би нэг удаагийн нийтийн бүжгэн дээрээс “Талимаа” Сэлэнгээ гэдэг маш аятайхан хүүхэнтэй танилцлаа. Тэр үед би гурилын үйлдвэрт нормчин хийдэг байсан юм. Ганц бие болохоор цалингаа хүүхэнд л зориулчихна. Архи нэг их уугаад байхгүй. Тэр үед чинь дэг журамтай байсан юм чинь. “Талимаа” Сэлэнгээ бол ёстой янзтай “авалцдаг” хүүхэн байж билээ. Гэвч би түүнийг Хайлаастын агамануудад алдчихсан юм. Толгойн дундуураа трубагаар нэг сайн цохиулж авсан. Дараа нь би Толгойтын Таван шар хавьцаагаас нэг хүүхэнтэй танилцсанаа бүдэг бадаг санадаг юм. Тэр хүүхэн нөхөртэй байсан. Хавар танилцаад зун нь од тоолуулсан юм байна. Ямар ч гэсэн наадам болж байсан. Туул голын хөвөөн дээр түүнтэй усанд орж байсан санагдана. Гэхдээ энэ хүүхэн надад тийм айхтар дурсамж үлдээгээгүй. Тэгсхийгээд л мартагдсан. Бүр хорь гучин жил мартсан. Одоо харин бүдэг бадаг санаж байгаа нь их юм. За, тэгээд дараа нь юу билээ дээ байз. Ер нь л нэг тоймтой юм орж ирэхгүй байх чинь. Аа, тийм. Яармагийн дэнжид Чимгээ ч билүү, Цэцгээ ч билүү нэг хүүхэнтэй учир ургуулсан юм байна шүү. За тэр чинь ямаршуухан хүүхэн байлаа даа. Хүнсний дэлгүүрт худалдагч хийдэг байсан. Тэр үеэс би гайт хар архинд орж эхэлсэн юм даа. Гэхдээ хүүхнүүдийг нохойн гуяар далладаг болсон. Архи уугаад зүрх чангараад тэр. Тэр худалдагч хүүхэн надтай сууна гэж их гуйдаг байлаа. Би ч яахав, сууна гээд л авчирсан архийг нь уугаад байна. Сүүлдээ зайлуул сэтгэл нь харьсан бололтой надаас хөндийрч эхэлсэн. Энэ нь ч надад бараг дээр байлаа. За, ингээд хэдэн он болж байнаа ер нь. Ямар ч гэсэн 1970 оныг сайн санаж байна. Ер нь би их нүгэлтэй хүн. Есөн гудамжны ойролцоо нэг их гоё хүүхэн байдаг байсан. Энэ хүүхэн 1966 оны үерийн усанд төрөл саднаа урсгаад аргагүй л ганцаардсан юм. Би түүнд хань болох санаатай нэлээд зүтгэсэн. Үерт урссан төрөл садныг нь хүртэл шал худлаа өрөвдөж халаглаад л. Одоо бодоход инээдтэй ч юм шиг. Тэр хүүхний нэрийг Одончимэг гэдэг байсан. Бид хоёр нэг жил шахуу хамт амьдарч билээ. Одончимэг бүжиг танцанд их дуртай, их хөнгөмсөг хүүхэн байсан. Надаас янз бүрийн юм шаардаж шахна. Жирийн нэг нормчин би хүссэнийг нь авч өгч чадахгүй байлаа. Ингээд би гологдож эхэлсэн. Сүүлдээ бүр хаягдсан. Анх удаагаа хүнд хаягдаж байгаа нь энэ дээ. Одончимэг сүүлдээ бүр замрах замдаа орж Биокомбинат дахь венгерүүдтэй явалддаг болсон юм даа. Тэгээд “Венгер” Одноо гэдэг хоч хоч авч бүр цагаандаа гарсан. Би түүний сургийг дуулж сонсолгүй олон жил боллоо. Одоо бодвол үхэж үрэгдээ биз дээ, зайлуул. 1972 оноос хойш би авгайтай болох юмсан гэж их боддог боллоо. Ийм сэтгэхүйг надад Одончимэг төрүүлчихсэн байхгүй юу? Гэвч би нэлээд олон хүүхнийг шилж сонгосон. Насны ханьтайгаа толгой холбох гэж байгаа болохоор маш сайн үзэж шалгаж авах хэрэгтэй шүү дээ. Төв аймгийн харьяат Бундмаа гэдэг хүүхэн л сэтгэлд буугаад болж өгөхгүй байв. Нэг гэм нь тэр дагавар хүүхэдтэй. Над шиг амьтан эцэг болно гэхэд хэцүү л дээ. Тэгээд аргагүй л сэтгэл татагдаад түүнтэй суучихаж билээ. Энэ үед би бас архи

зооглосон хэвээр байв. Бундмаа архийг нэг нүдээрээ ч үзэхгүй. Харин би архийг хоёр нүдээрээ үзээд зогсохгүй зүрхээрээ харж байлаа. Үүний хажуугаар Бундмаа миний булхайг хэн нэгнээс олоод сонсчихож. Хүчингийн хэргээр шоронд ял эдэлж байснаас эхлээд хэд хэдэн хүүхэнтэй нэр холбогдож байсныг хүртэл олоод сонсчихсон байгаа юм даа. Ямар хөгийн амьтан нь ингэж хов зөөдөг байна аа. Тэгээд бид хоёр яалт ч үгүй салсан. 1972-76 он хүртэл би дөрвөн жил ял эдэлсэн. Бас л нөгөө хүчингийн хэрэг. Харин 1977 онд хойноос сургууль төгсөөд ирсэн Эрдэнэтуяа гэдэг тун аятайхан хүүхэнд би нугасгүй дурладаг юм байна. Тэр хүүхэн нэг их гоё урт сормуустай. Бөгс, мээм нь жигдэрсэн, өөх мах нь яг тохирсон, дугираг цагаан царайтай, тэвхгэр цээжтэй хүүхэн байлаа. Энэ хүүхэнтэй би хоёр жил гаруй хамт амьдарсан байх. Нэг өдөр гэртээ иртэл Эрдэнэтуяа маань нэг залуутай сууж байна. Хоорондоо шивэр авир ярилцаад донжтой нь аргагүй байхаар нь би шууд гараад явчихсан. Тэгээд дэлгүүрт орж ганц шил архи аваад подвальд орж шилээр нь хөнтөрч орхитол толгой тархи дайвалзаад, нүд бүрэлзээд ирсэн. Яг энэ үед би дотогшоо орсоньг санаж байна. Гэрийнхээ хаалгыг тогшгол Эрдэнэтуяа онгойлгож өгсөн. Нөгөө хар юм нь цаана нь хэвтэж байсан. Би чухам тэр үед яаснаа сайн санадаггүй юм. Нэг мэдэхэд л сэргийлэх дээр хүргэгдэж ирсэн байсан. Уусан архи маань гэнэт толгойд гарч тэрхэн хугацаанд тас үсэрсэн байгаа юм. Би яагаад энд байж байгаа юм бэ? гэж сэргийлэгч залуугаас асуутал тэр над руу ихэмсэг байдалтай харснаа “Өө, за за. Хүн хутгалчихаад юу ч мэдээгүй царайлж байх чинь. Та эрүүгийн гэмт хэрэгтэн болсон. Таньд хутгалуулсан хүн Гэмтлийн эмнэлэгт үхлүүт байна” гэдэг байгаа. Би энэ үгэнд нь итгэсэнгүй. Эрдэнэтуяа намайг гэмт хэрэгт гүтгэсэн биш байгаа ч гэж бодлоо. Гэтэл яах аргагүй би хутгалчихсан байгаа юм даа. Тэр залуу нь гай болж үхсэн. Хэрвээ амьд гарсан бол би үсрээд л жил зургаан сарын ял авах байсан. Энэ хэрэгт арван жилийн ял авсан. Эрдэнэтуяа намайг цааз ялнаас хэлтрүүлэхийн тулд нэлээд хөөцөлдсөн. Сүүлдээ бүр өөртөө хүртэл буруу өгөөд, тэр нь ял болж хувирсан. Гэхдээ шоронд суугаагүй. Хоёр жилийн тэнсэн авч билээ. Харин би Мааньтын шоронд очоод ёстой “од” болсон доо. 1960-аад оны үед надтай цуг ял эдэлж байсан “Муухай” Дашгалсан, Гилхүүгийн Данхар, Сэлэнгэ аймгийн харьяат “Хутга” Сампил, Доржийн Лханоров, “Шулга” Сандаг нар 1980-аад оны үед халхын шоронд ид мандаж байсан үе. Эд нар намайг “од” болгосон. Хэрвээ би жараад оны үед шоронд орж байгаагүй бол наяд оны үед “од” биш “мод” болох байлаа шүү дээ. Тухайн үед Халхын шоронд шүлэг бичих авьяастай нэг нөхөр гарч ирж нэр алдарт гарсан ялтануудаар шүлэг зохиосон байдаг. Тэр нь нөгөө “Зүүнбаян зүгээр нутаг, зүлэг ногоо ургадаггүй нутаг” гэдэг шиг их урт шүлэг байлаа. Энэ шүлгэнд миний нэр хүртэл орсон.

“Муу усны гэгдэх “Лаг”-ын хэрэгт холбогдсон

“Муухай” Дашгалсан таван жилийн ялтай

Мунагийн хэрэгт удаа дараа холбогдсон

“Муужгай” Цэрэндорж арван жилийн ялтай” гэж ирээд л шүлэглэдэг байсан. Бусдыг нь мартчихаж. Аргагүй л “Муужгай” Цэрэндорж гэж өөрийнхөө нэр орсон болохоор зөвхөн энэ хэсгийг цээжилчихсэн хэрэг. Би 1990-ээд оны үед шоронгоос суллагаад ёстой л нэг хонь болсон доо. Нас сүүдэр ч нэлээд явж өгсөн. Энэ үед архинд хэт орсон маань амьдрал хувь заяа болоод эрүүл мэндэд их муугаар нөлөөлсөн. Гурван ч удаа шоронд орсон болохоор

элдвийн хууч өвчтэй болж сав л хийвэл эмнэлэгт хэвтдэг болсон. Юун нөгөө хүүхэн эргүүлэх. Тавь, жар, дал, наяд оны тэр сайхан хүүхнүүд одоо зөвхөн дурсамж төдий л үлдэж дээ.

*“Муужгай” Цэрэндорж ийм дурсамж бичээд дэрнийхээ дор нэг хэсэг хадгалжээ. Амьдралынхаа сүүлчийн хэд хоног байнгын хэвтэрт байсан бөгөөд харж хандах үр хүүхэдгүй, хань ижилгүй ганцаардмал байдалтай нүд аньсан аж. Харин түүний дурсамжийг дүү Цэрэнпүрэв нь олж “өөд нь татаж” байгаа нь энэ.*

## “Шорноон” Хуягаа шоронгийн тогооч болж тарчилсан нь

Шоронгийн хамгийн сайхан ажил гэвэл тогооч ажээ. Нээрээ ч “Буянтын гуанзанд гэдэс цаггалан санаа амар” гэдэг шиг Халхын шоронд тогооч болно гэдэг нь хэн хүний хийчихдэг ажил биш ажээ. Ёстой л ар өврийн хаалгатай, ах дүү, танил талтай, авилга энэ тэрийг атгуулчих бэл бэнчинтэй, азтай аавын хүү л шоронд очоод тогооч болдог юмсанж. Харин энд өгүүлэх “Шорноон” Хуягаа гэгч эр шоронд очоод хэдийгээр тогооч болсон ч ялтан хүний жаргалыг амсч чадсангүй. Уг нь тэр тогооч болохын тулд зохих хэмжээний арын хаалга хэрэглэжээ. Аавынх нь төрсөн дүү томоохон хуульч бөгөөд түүнийг зургаан жилийн ял аваад шоронд явахад хуульч ах нь “Би чамайг шоронгийн тогооч болгохоор ярьчихсан байгаа. Гэдэс цаггалан санаа амар. Харин чи бусдын итгэлийг алдаж болохгүй шүү” гэж захисан байна. Ингээд тэр шоронд очоод шууд л туслах тогооч болчих нь тэр. Харин ахлах тогооч нь “Элдүүр” Батаа гэгч олон жил шоронгоор явчихсан нэлээд егзэр эр байжээ. Хуягааг нэгэнт дээрээс томилогдсон тогооч болохоор “Элдүүр” Батаа эхэндээ нэг их дарамталж чадсангүй. Хорихын 300 гаруй хулгараас хоншоортой аавын хүүд олддог энэ мест эхэндээ Хуягаад тун аятайхан санагджээ. Гэвч нэг л өдөр бүх юм орвонгоороо эргэх нь тэр. Яасан бэ гэхээр шоронгийн нэг овгор нөгөө овгороо чадах гээд “Шорноон” Хуягаагаар шургуу хийлгэсэн байгаа юм. Тэр нь юу гэвэл овгор ялтан Галжавын тавагтай хоолонд гурван ширхэг жоом хийх байлаа. Үүнийг Хуягаа тун ядах юмгүй гүйцэлдүүлжээ. Тэгтэл Галжав гэгч мөнөөх ялтан хоолоо идэж сууснаа гэнэт жоом харуутаа муухай бархираад явчихаж. Тэгээд Хуягааг дуудаж ирүүлээд “Чамд энэ захиалгыг хэн өгсөн бэ” гэж шалгааж гарчээ. Хуягаа “Би таны тавагтай хоолонд жоом орсонг ёстой мэдсэнгүй. Хэн нэг нь таныг хорлох гээд л хоолонд чинь жоом хийчихлээ” гэж гүрийсэн байна. Энэ үед ахлах тогооч “Элдүүр” Батаа давхиж ирээд Хуягааг заамдан авч “Чи муу хэний даалгаварыг биелүүлсэн бэ. Хэлэхгүй бол ална шүү” гээд ширээн дээр байсан тавагтай хоолыг шүүрч аваад нүүр лүү нь цацаж орхиход Хуягаа “Зөвлөлийн дарга Чулуунсүхийн даалгаврыг биелүүлсэн” гэж үнэнийг өчсөн байна. Үүнээс болж хоёр овгор ялтан хоорондоо зодолдож бөөн юм болжээ. Эцэст нь Чулуунсүх тархиа хагалуулж хүнд бэртэл аваад шоронгийн эмнэлэг рүү, нөгөөдөх нь ял нэмүүлж чанга дэглэмтэй хорих анги руу шилжсэнээр энэ хэрэг дуусгавар болжээ. Харин энэ цагаас хойш тогооч Хуягаа “Жоом” хоч аваад өөд нар харсангүй. Учир нь ялтанууд Зөвлөлийн дарга Чулуунсүхэд их муу, Галжавг их сайн байж л дээ. Нэгэнт муу хүний үүрэг даалгаварыг биелүүлж, сайн хүнийг дэглэм дээшлүүлсэн болохоор “Шорноон” Хуягаа жинхэнэ “диграмм”-нд орсон байна. Тэр удах тусам хорих ангийн харгис ялтануудын гарын шүүс болж буйгаа ухаарчээ. Зарим ялтан “Чи миний хоолонд өөх, мах бага хийлээ. Намайг ялгалаа, дугаарлалаа” хэмээн сав л хийвэл гарынхаа чилээг гаргадаг болж. Зарим нь “Хөөе, жоом гуай. Миний хоолонд хэдэн ширхэг жоом хийсэн бэ. Би их өлсч байна. Жоом идмээр байна. Арван ширхэг жоом хийгээгүй байвал ална шүү” гэх зэргээр даапаалдаг болжээ. Үүнээс гадна хянагч нар түүнийг бууны нохой болгохоор шийдсэн нь бүр ч нэрмээс болсон байна. Ер нь хаа газрын шоронгийн тогооч нар ихэвчлэн бууны нохойны үүрэг гүйцэтгэдэг юмсанж. Энэ нь тогооч хэмээх ховорхон месттэй нь ч дүйдэг бололтой. Хянагч нар түүнийг байсхийгээд л дуудаж “Чи яагаад олигтойхон бууны нохой хийхгүй байна аа. Уяаг чинь уртхан тавьж, угаадасыг чинь ахиухан өгөхийн тулд тогооч хүртэл болголоо. Үүнээс илүү яаж харж үзүүлэх гэсэн юм бэ” гэж ирээд л элдвээр эрүүдэн шүүнэ. Жишээ нь хорих ангийн дэд дарга түүнтэй нууцаар уулзаад “Намайг байхгүй хооронд ямар хянагч, ямар ээлжийн дарга



хоригдолуудад архи зөөсөн бэ. Албан хаагч хүүхнүүдээс хэн нь хулгаруудтай дотно харьцаа үүсгээд байна” гэх мэтээр түүнээс элдвийн зүйл асууж, ямар нэгэн шинэ мэдээ хэлэхгүй бол бороохойдно. Хоригдол залуу түүнд бороохойдуулахгүйн тулд “Тэр хянагч тэгсэн” гээд матвал эргээд нөгөө хэддээ жанчуулах тун хэцүү ангалд хавчуулагджээ. Түүний энэ зовлонг хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага гэхээс өөр яалтай. Цаг хугацаа өнгөрөх тусам “Жоом” Хуягаа сайн хоол хийж сурахын хажуугаар бас сайн ташуур даадаг ган төмрөөр цутгасан биетэй юмуу гэмээр нэгэн болж хувирсан байна. Тэгээд цаадуул нь ч зодож л байдаг, мань эр ч юу ч бодсон шинжгүй зодуулж л байдаг болж. Сүүлдээ бүр “Жоом” Хуягаа хэн нэгэн ялтаныг дуудах болгонд дэргэд нь гүйж очоод цохиулах гээд шанаагаа найр тавьж өгдөг болсон байна. Ингэснээр “Жоом” Хуягаа биш “Шанаа” Хуягаа болж хувирчээ. Гэхдээ тэр хүн харахад хэн бүхэнд зодуулаад л гүйж яваа юм шиг мөртлөө цаагуураа муусайн дээрэлхүү ялтануудыг хөөрхөн чадчихдаг байсан байгаа юм. Яадаг гээч. Ялтануудад хоол аягалахаас өмнө наранцэцэгийн тосны саванд нус, цэр, шүлс, зарим тохиолдолд шээсээ хүртэл хийгээд дээр нь жаахан наранцэцэгийн тос дусаачихна. Хэн ч харсан наранцэцэгийн тос байна гэж бодно. Тэгээд цуйван юмуу, будаатай хуурга аягалж өгөхдөө мөнөөх балиар тосноосоо дээр нь хийгээд хутгачих жишээтэй. Өөрийг нь зодож дээрэлхдэг аархуу ялтанууд түүний нус, цэр, шээс шингэсэн хоолыг юу ч мэдрэх сөхөөгүй амтархан зооглодог байж. Энэхүү нууцыг Хуягаагаас өөр хэн ч мэдээгүй бөгөөд тэрбээр зургаан жилийн дараа шоронгоос суллагдаад л энэхүү нууцаа бусдад дэлгэжээ. Түүнийг зодож дээрэлхдэг байсан ялтанууд энэ тухай дуулж сонсоод “Аа, муу жоом Хуягаа. Чи биднийг аймаар чаддаг байжээ. Даанч өнгөрсөн явдал юм даа. Тэрнээс биш бөөлжмөөр л байна. Чамтай хэрвээ тааралддаг л юм бол нусаа идүүлж, шээсээ уулгана даа” гэж занасан гэдэг.

## **Засаршгүй гэмт хэрэгтэн заяатын ХАЛТМАА гэнэ алдаж баригдсан нь**

Жар, далаад оны үед мөрдөн байцаах алба болон тагнуулын албанд “од” болж байсан хурандаа С.Рэнцэнхорлоо гуай олон арван цуутай гэмт хэрэгтэнийг үйлдэл дээр нь баривчилсан байдаг. Энд зөвхөн Заяатын Халтмаа гэгч ялтаны тухай өгүүлье. Энэ эр хулгай дээрмийн хэргээр олон удаа яллагдаж, нийтдээ хорь гаруй жил шоронд суужээ. Энэ ч утгаараа жараад оны халхын шоронд Заяатын Халтмаа гэж алдаршсан байна. Тэр ч байтугай “Заяа байгаад наранд гарвал заавал чамайг ална даа” гэх дууны үг Заяатын Халтмаад зориулагдаж гарсан түүхтэй аж. Гэхдээ уг дууг Налайхын шоронд ял эдэлж байсан нэг залуу анх дуулж Халхын шорон даяар түгээжээ. Харамсалтай нь мань залуу уг дууг амьдруулаад ердөө сарын дараа Налайхын уурхайд нүүрс ухаж байгаад дарагдаж үхсэн гэдэг. Тиймээс дээрхи дууг “Хөр мөртэй дуу” гэж ярих нь олонтаа. Заяатын Халтмаа хамгийн сүүлд буюу 1967 оны хавар шоронгоос оргож явахдаа Улаанхуаран хавьцаа байсан нэг дэлгүүрийн манаачийг боомилж алаад их хэмжээний мөнгө төгрөг, эд зүйлс хулгайлжээ. Тэгээд хэдэн сарын турш баригдалгүй явжээ. Сургийг нь сонсохнээ Улаанбаатар хотын хаа нэгтээ эсэн бусын хүмүүстэй архидаж наргиад л явах. Гэвч цагдаагийнхан яг очоод барих гэхээр Халтмаа ямар нэгэн аргаар бултчихдаг, хэн нэгнээс мөр буруулахдаа үнэхээр гаргууд байж. Харин 1967 оны 10-р сарын 19-ний өдрийн 13 цагийн үед Заяатын Халтмаа үйлийн үргүй баригджээ. Тэр үед хурандаа С.Рэнцэнхорлоо эргүүл ротын нэгэн салаагаар офицеруудын ордны арын дэнж дээрхи нэгэн хашааг сэмхэн бүслүүлээд, хамт яваа офицертоо “Цаад Халтмаа чинь буутай шүү. Болгоомжтой хандаарай. Хамаагүй буудаж болохгүй шүү” гэж тушаагаад хашааны зүг алхжээ. Тэгээд хашааны завсраар шагайтал гурван гэрийн дунд байгаа мотоциклийн дэргэд Халтмаа нэг хүнтэй хөөрөлдөн зогсох нь тодхон харагдсан байна. Энэ үед энгийн хувцастай Рэнцэн-хорлоо энгийн хүний дүр эсгээд хашааны хаалгаар ортол Халтмаа алга болчихсон, харин түүнтэй хөөрөлдөж байсан залуу ганцаараа зогсч байх нь тэр. Хурандаа Рэнцэнхорлоо “Чамтай сая юм яриад зогсч байсан хүн хаачив” гэж асуухад тэр залуу “Мэдэхгүй. Надтай ямар ч хүн хамт байгаагүй. Би Толгойт явах гээд эхнэрээ хүлээгээд зогсч байна” гэж мэлзжээ. Хурандаа Рэнцэнхорлоо хашаанд байсан гурван айл болон бүхий л амбаар савыг цагдаагаар нэгжүүлсэн боловч юу ч илэрсэнгүй. Гэтэл хаалга нь нээлттэй жорлон руу нэг охин бие засах гэж очсоноо гэнэт зогтусан эргэхийг хашир чекист Рэнцэнхорлоо ажиг-лажээ. Тэгээд буугаа сумлаад жорлон руу гүйж очоод хаалгыг нь онгойлготол хэн ч байсангүй. “Амьд хүн байтлаа арай жорлонгийн нүх рүү яваад орчихооргүй юм” гэж бодоод доош шагайтал шинэхэн ухсан жорлонгийн ёроолд Заяатын Халтмаа айсан болжмор адил цомцойн сууж байсан гэдэг. Тиймээс хурандаа “Халтмаа чи наанаасаа гар. Хурдлахгүй бол буудлаа шүү” гэхэд цаадах нь ус цутгуулсан зурам шиг ухасхийн гарч ирээд баригдсан байна. Хэн нэгнээс мөр буруулахдаа гаргууд, долоо буудуулсан хашир чоно Халтмаа хашааны завсраар хүн шагайхыг хармагцаа “Цагдаа нар намайг мөрдөж явна” гэж тэрхэн зуур сэтгээд жорлон руу давхин оржээ. Учир нь тэр жорлонгийн нүхний нэг буланд ороод хэвтчихсэн байхад намайг хэн ч сэжиглэхгүй, анзаар-ахгүй гэж бодож л дээ. Гэвч түүнээс хэдэн хувь илүү сэтгэдэг хашир туршлагатай хурандаа Рэнцэнхорлоо гуай Халтмаагийн арга залиг төвөггүй дийлж гарчээ.

## **“Зараа” хочит Булганжав адууны цувдайг мангас шиг цөлдөг болж**

Булган аймгийн харъяат “Зараа” хочит Булганжав гэгч нөхөр малын хулгайн хэргээр олон жил ял эдэлжээ. Түүний толгойтой үс нь өтгөн ширүүн гэж жигтэйхэн, яг л зараа шиг харагддаг байна. Тэрбээр төрөлхийн мах иддэггүй нэгэн бөгөөд шоронд орохоосоо өмнө дандаа цагаан хоолоор гол зогоодог байж. Тиймээс шоронд очоод адууны цувдай хараад бөөлжис нь цутгалгүй хаачихав. Уг нь Булганжав мэтийн хүн хорих ангийн мал дээр л байвал зохих юм. Тэр үүнийгээ мэдрээд нэг өдөр хорихын дарга дээр орж “Би төрөлхийн мах иддэггүй хүн. Сүү тараг, цагаан идээгээр л хооллодог. Тиймээс намайг хорих ангийн мал дээр гаргаж өгнө үү. Нэгэнт би мах иддэггүй юм чинь мал алж иднэ гэсэн теором байхгүй” гэжээ. Хариуд нь хорихын дарга “Манай хорих ангид ихэвчлэн эр мал байдаг. Чи эр үхрээс сүү сааж, элгэн тараг бүрэх юм биз дээ. Мал алж идэхгүй ч гэсэн чи малнаасаа хулгайлаад бусдад зараад байх юм биш биз. Эр үхэр, ухна, хуц голдуу багширсан хорих ангийн мал дээр очоод чи сүү тараг, цагаан идээгээр хооллоно гэвэл номонд хазгай” гэж ёжилжээ. Хариуд нь Булганжав “Та надад итгэж болно. Би хорих ангийн малыг бусдад зарах нь битгий хэл харин ч арвижуулж магадгүй шүү. Гэхдээ хулгайн замаар биш. Эрхбиш ганц нэг эм сүвтэй мал байдаг биз дээ. Надад ердөө ганц үнээ байхад л хангалттай. Тэр чинь л миний аминд орох гээд байна” гэж учирласан байна. Тэгтэл хорихын дарга “Ганц саалийн үнээ л чиний аминд орох хэрэг үү. Чи арай бухны үүрэг гүйцэтгэх гээд байгаа юм биш биз. Тэгээд саалийн үнээ та хоёрын дундаас сарлаг ч биш, ортоом ч биш, тугал ч биш, хүн ч биш нэг хачин юм гарч манийнхаа нэр төрийг улс даяар хөөдчих юм биш биз дээ, ха ха ха” хэмээн учиргүй шоолжээ. Гэхдээ тэр ялтануудынхаа зовлонг ойлгодог сайн дарга байсан тул төдөлгүй Булганжавыг хүсээд байсан мал дээр нь гаргаад хаячихжээ. Тэнд очоод Булганжав нэг хэсэгтээ ямар ч гэсэн өөрийгөө аргалаад байж. Нэлээд сүүтэй хүрэгч үнээ түүний аминд орсон байна. Зарим үед Булганжав үнээгээ саахаас залхуураад дөрвөн хөлийг нь тушиж байгаад яг л тугал шиг амаараа нудчин дэлэнг нь хоосолчихдог байж. Гэвч тэр сүүлдээ хэтэрхий буруу сэхсэн гэдэг. Саахалт айлынхаа гэр дээр тавьсан ааруулыг яг л элээ шиг шүүрэхээс гадна шөнө дөлөөр гэрт нь дөхөж очоод хаяагаар нь гараа шургуулж хөхүүрийг нь цоолоод хамаг айрагийг нь шланкаар соруулаад авчихдаг болжээ. Үүний зэрэгцээ айлын мал хулгайлж бусдад дамлан боов чихэр авч идэж тансагласан байгаа юм. Энэ нь сүүлдээ бүр даамжирсаар хорихын удирдлагын сонорт хүрч “Зараа” Булганжав мал хариулахаа болиод зоонд татагдан иржээ. Аманд орсон шар тосыг хэлээрээ түлхсэн хүн одоо яая гэхэв. Уг нь хусран бяруу аятай хүрэгч үнээгээ гувшаад байж байсан бол ашгай юу даа. Булганжав зоонд ирээд цагаан идээгээ санагалзаж сүүлдээ бүр цөхрөнгөө бараад адууны цувдайтай үйлийн үргүй эвлэрсэн байна. Олон жил мах идээгүй хүн маханд нэг орохоороо ёстой л мангас шиг иддэг гэлцдэг. “Зараа” Булганжав сүүлдээ адууны цувдайг яг л мангас шиг иддэг болжээ. Хувь заяаны эрхээр махчин болсон энэ эр эдүгээ шоронгоос суллагаад нутагтаа амьдарч байгаа бөгөөд бодвол адууны цувдайг ёстой нэг идэх шиг болж байгаа биз.

## Хүний халаасанд хуруугаа шургуулна гэдэг халуун төмөр атгахтай адил

Нэрээ нууцлахыг хүссэн Б гэгч залуу өөрийнхөө тухай доорхи зүйлийг бичиж ирүүлжээ. Хэдий ялтан ч гэлээ үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг нь хүндэтгэж үзэх хэрэгтэй. Гэхдээ тэр дарга даамлынхаа тухай сайн муу ганц ч үг чулуудаагүй тул эрхэм шоронгийн дарга нар эмзэглээд байх шаардлагагүй. Ингээд түүний бичиж ирүүлсэн зүйлийг бүрэн эхээр нь сийрүүлье.

Албан тушаал, авгай хүүхэн аливааг худалдан авч болдогийг өнөөгийн нийгэм яруу тод харуулж байна шүү дээ. Тийм ч учраас би бусдын халаасыг суйлж, орон байр дэлбэлээд шоронд орсон билээ. Хулгарууд олсон мөнгөө бусдаас, ялангуяа архинаас огт харамладаггүй. Яагаад гээч. Би чиний өврөөс авсан мөнгөөрөө хэн нэгнийг дайлна. Ямар миний мөнгө биш юуг нь хэнээс харамлах вэ? Тэр мөнгийг Жамц өвгөн шиг хав дарж хулганы хоол болгох хэрэг үү. Гайгүй байлгүй. Яаж мэдэхэв, үзлэг нэгжлэг болоод тэр мөнгийг олчихвол хаанаас, хэнээс авсан гээд бөөн юм болно шүү дээ. Тэгж өөрийгөө фактуулдаг тэнэг толгой биш ээ. Авгай хүүхэндээ үлдээх үү? Яах юм яршиг л байна. Намайг өнхрөөд өгөхөөр цайны хүн гээд нэг хар юм дагуулаад ирнэ. Тэгэхээр би тэдний хоол цайны мөнгийг бэлдэж зэхэх гэж үү? Үгүй шүү. Иймээс сэтгэл санаа уужруулдаг архинаас юугаа ч харамладаггүй юм. Тэгээд ч хүчээ гаргаж, хөлсөө урсгаж олоогүй мөнгө төгрөг бол үнэндээ чихрийн цаас шиг цацагддаг юм. Би гэдэг амьтан одоогоос найман жилийн өмнө Зүүнхараагийн шоронд ял эдэлж байлаа. Хотод ойрхон болохоор эхнэр хүүхдүүд маань эхний нэг, хоёр жил овоо эргэж тойрч байснаа цөөрсөөр цөөрсөөр сүүлдээ бүр сураг тасарсан. Сураг чимээ сонсвоос эхнэр маань өөр хүнтэй суусан дуулав. Түүнийг би буруутгаагүй. Би хэдий шоронд ял эдэлж байгаа ч жолооч ухааны юм болохоор гадуур жаанд их явдаг байлаа. Ингэж явахдаа нэг хүүхэнтэй жоготой болсон. Нэгэн шөнө тоонд орсоноос хойш хянагчаа хулхидаж байгаад тэднийдээ хоног тааруулсан юм. Эмэгтэй хүний гарын хоол идэж хөлс гарч, дулаан хөнжлийн халуун явдалд ядарсан би нам унтаж орхисон. Нойрон дунд нохой ус долоогоод байх шиг шал пал гээд байхаар нь шүдэнз зураад харваас нөгөө хасаг хүүхэн маань паалантай эрээн түмпэнд явган суугаад нөгөөдөхөө алгдан угааж байлаа. Казакууд их цэвэрч улс шүү. Би иймэрхүү байсан болохоор муу авгайгаа хатсанаа дэвтээж хагсаагаа гаргаг гээд тоосонгүй. Тэгээд ч Шекспирийн эмгэнэлт жүжигт “Би мэдээгүй бол хороо цэрэг ашигласан ч яадаг юм бэ” гэдэг үг байдаг шүү дээ. Харин авгай маань намайг дээрхи үгийг сонсохоос өмнө эргэсэн болж нэг удаа ирэхдээ шоронгийн ээлжийн ахлагчтай унтсан. Үүнийг би мэдмэгц ганц сайн болгож өгсөн. Тэр ч шангаа хүртсэн, би ч ялаа нэмүүлсэн. Хүүхэн болгон хүзүүнээсээ доош адилхан гэдэг. Үүнийг би салсан бөгөөд хаясан эхнэртээ зориулан хэлж байна. Түүнийг Дамдин-шаравын Гэрэлмаа гэдэг юм. Овог нэрийг чинь гаргачихлаа уучлаарай. Гэхдээ чи үүнээс илүү шийтгэл хүлээх ёстой хүн гэдгээ мартаж болохгүй. Бүү март, мартвал сөнөнө. Чамтай суусан шинэ нөхөр чинь намайг өчүүхэн жижиг хулгайч гэж доромжилсон сураг дуулдсан. Хулгай хийнэ гэдэг чинь зориг самбаа, тэвчээр, бас ур чадвар шаардсан хэцүүхэн мэргэжил шүү дээ. Үүнийг чиний наад цагаан гартай нөхөр чинь хэзээ ч ухаж ойлгохгүй. Гар нь чичирч, хөлсөө гоожуулсан аймхайнууд хулгай хийж яасан ч чаддаггүй. Ямар өөрийнхөө өвөр түрийг ухалтай нь биш дээ. Хүний халаасанд хуруугаа шургуулна гэдэг халуун төмөр атгахтай адилхан байдаг юм. Үйлдэл дээрээсээ баригдах шиг хэцүү юм хаана байна. Гарцаагүй ял авна гэсэн үг. Одоо харин лангуунаас юм шүүрэх, аль эсвэл халаас суйлаад баригдахад

амбаардах юмуу, шанаадаад хөөгөөд явуулдаг болжээ. Нэгэнт юмыг нь аваагүй, эсвэл буцаагаад өгчихсөн болохоор цагдаад барьж өгөөд ямар нэмэр байхав. Цагдаа нар сайндаа л бороохойдно. Цааш-лаад аквариумд хорино биз дээ. Бусдын юмыг хулуулсан бид байтугай улс гүрэн, ард түмний хөрөнгөнөөс улайм цайм дэлсээд байгаа дээдсээ яаж ч чадахгүй шүүх, прокурор нь тэдний өмнө мэхэлзээд, бөхөлзөөд байгаа болохоор энэ хууль чинь гууль, шүүх нь шүүрхий шанага болсоныг нотлоод өгч байгаа юм. Би ч энэ мэргэжилээрээ ходоо-доо дүүргэж хоолойгоо чийглэсээр насан өөдлөх биз. Өөр юу ч хийж үзээгүй болохоор хойд насандаа тамд очих биз дээ. Гэхдээ энэ насандаа ч гэсэн тамд унаснаас ялгаагүй амьдарлаа. Хулгайчууд хүний өөдөөс эгц хардаггүй чоно шиг гөлөгнөдөг боловч гар нь барагтай л бол чичирдэггүй юм. Засгийн зарлиг, төрийн өршөөл хүссэн, горьдсон ялтанууд зөндөө байдаг. Хэн хүнгүй л эрх чөлөөтэй, наранд дураараа алхаж, саранд нойрсон унтахыг бодолгүй яахав. Гэтэл гэм нь урдаа, гэмшил нь хойноо гэгчээр хулгай дээрэм, алаан хядаан, хүчин мүчин аливааг юу ч бодолгүй хийчихээд адаг сүүлд нь “аавынд” очихоороо “Төр засаг, түмэн олон минь утсан чинээ улаан амийг минь өршөө” гэдэг хүн дүрстэй сүгнүүд олон бий. Одоо ч миний хажуу талын нааран дээр дөрөв таваараа нойрсч байна. Эд нар зөвхөн хар амиа л боддог. Аяга цай, зүсэм талхаа хуваагаад иднэ гэж байхгүй. Ингэхээс ч өөр аргагүй. Хонь муулах хүн олдохгүй болж нэгнээ алдаг адгуус араншинтаны тоо өдрөөс өдөрт өсөх төлөвтэй байгааг миний байгаа орчин харуулж байна. Ялихгүй зүйлээс болж хүн хутгалаад алчихсан тав зургаан хүн миний хажуу талын нааран дээр бахдалтайгаар хурхирч байна. Эд нарыг би командалдаг юм. Гэвч зарим нь арай дэндүү арчаагүй, ёстой л амь нь хаана байгаа нь мэдэгдэхгүй амьтад байх юм. Халхын шорон иймэрхүү алуурчидаар дүүрч байна. Үнэхээр үнэний төлөө, зөв юмны төлөө тэмцэж байгаад хүн алчихсан ялтан ширхэг ч байхгүй гэдгийг би баттай хэлж чадна.

## Эрхтэнээсээ салах шахсан саваагүй ялтаны эвгүй дурсамж

*Хорь гаруй жил ял эдэлсэн “Хавхаг” Тэрбиш гэгч эр шоронд байх хугацаандаа эсэн бусын дуулиан дэгдээж явсан нэгэн юмсанж. Тэрбээр ялтан хүний хийх ёстой бүхий л зүйлийг өөр дээрээ туршсан гэж бардам хэлдэг ажээ. Наад захын жишээ гэхэд л бэлэг эрхтэндээ шаариг суулгадаг гэж зуршилгыг өөр дээрээ туршаад үзчихсэн байх жишээтэй. Тэгээд үүнийгээ дурсамж маягтай цаасан дээр буулгасан байх нь бүр ч сонин. Ингээд түүний дурсамжийг сонирхоно уу. Даширамд хэлэхэд мань эр бэлэг эрхтэнээ “Хэвнэгт баатар” гэж нэрлэсэн байх юм.*

Наяад оны үед намайг шоронд ял эдэлж байх үед цөөхөн жилийн ялтай хоригдолууд бэлэг эрхтэндээ шаариг суулгах нь их байсан. Яагаад чухам цөөхөн жилийн ялтай хоригдолууд ингэдэг байсан нь цаанаа бас учиртай. Олон жилийн ялтай хоригдол бол хэзээ шоронгоос суллагаад, эмэгтэй хүнтэй хэрхэн хавьтах нь бүрхэг шүү дээ. Харин цөөхөн жилийн ялтай хоригдолууд бол шоронд байх зурвасхан үедээ өөртөө ямар нэгэн ашигтай зүйл хийхийг урьтал болгодог байлаа. Үүний нэг нь “Хэвнэгт баатар”-аа том болгох асуудал байсан бөгөөд амьхандаа шоронгоос суллагдаж гараад хүүхнүүдийг умруулах гэж л тэр шүү дээ. Би ч энэ замыг тойрч гараагүй. Нэг өдөр найз Төрөөгийнхөө хамт хумсны толион чинээ дөрвөн ширхэг “Гасал” буюу шаариг, хөвөн марль, лаа шүдэнз бэлдэж аваад эр хүний ганц нандин хэрэглэлээ тоноглох ажилдаа орлоо. Бид хоёр лааны дөлөн дээр олон хоног амандаа хүлхсэн “Гасал”-аа халааж зөөлрүүлэв. Тэгээд “Хэвнэгт баатар”-уудаа гараараа оролдон байж босгоод арьсыг нь шамлаж байгаад сахлын хутгаар тээрхийнийхээ доод талыг яран зүсч арьс, мах хоёрын завсараар нөгөө олон хоног хүлхсэн шааригаа чихэж оруулаад шархыг нь чимхэн хавчиж өгөв. Гурав хоногийн дараа гэхэд мэс заслын шарх маань сайхан эдгээд ирлээ. Гэвч яг тэр үед миний “Хэвнэгт баатар” эмнэлэгийн мэс засалд орж билээ. Учир нь шоронгийн эмчийн үзлэгээр нэг сувилагч хүүхэн намайг нууц газраа шаариг суулгасныг ажиж мэдээд “Энийг хараач ээ. Бас нэг мунаг төгцөг гараад ирлээ” гэж сүр бадруулаад намайг шоронгийн ТӨК дээр дагуулж орсон. Төдөлгүй би эмнэлэгийн орон дээр хэвтэж, мөнөөх сувилагч хүүхэн шууд л миний өмдийг шувт татаад “Хэвнэгт баатар”-ыг минь ичиж зовох юмгүй барилж базалж байгаад босгоод ирдэг байгаа. Тэгээд тэр “Энэ ч уг нь давгүй хэрэглэлтэй өлгүүр байна шүү” гэж тохуурхаад нэг хүнээр миний цээжин дээр даруулж байгаад тээрхийний маань доод талыг хутгаар яран зүсч нөгөө хоёр шааригийг суга татаад гаргаад ирдэг байгаа. Би бага байхдаа хэдэн хүн нэг азарган үрээг хөнгөлж байхыг харж билээ. Сувилагч хүүхэнд хоёр шааригаа суга татуулж байх үедээ би өөрийгөө яг л тэр азарган үрээтэй зүйрлэж байлаа. Миний “Хэвнэгт баатар”-аас гаргаж авсан хос шааригийг шоронгийн ТӨК их л чамин зүйл хураан авч байгаа мэт сувилагчаас хоёр гардаж аваад тусгай жижиг саванд хийж дээр нь миний овог нэр, зүйл ангийг бичсэн цаасыг наагаад сейфиндээ хийж хадгалсан. Тэрхүү сейфинд тийм шаариг бүхий овог, нэр бичиж наасан жижиг савнуудыг ярайтал өрсөн байж билээ. Тэгээд ТӨК над руу муухай харсанаа “Чи хө, эдээрээ оролдвол эвдэхийн тэмдэг, эхнэрээрээ оролдвол салахын тэмдэг гэдэг үгийг бодвол сонсоо биз дээ. Наад салтаан дахь ганц юмаа хайрлаж гамнаж чадахгүй байгаа бол бид бүр тас огтлоод хаячихаж чадна шүү” гээд ширээнийхээ нүднээс герман гав гаргаж ирээд миний хоёр гарыг гавлаад “Алив мунаг эр гуай миний араас дагаад яв” гэлээ. Тэгээд намайг шоронгийн эмнэлэгийн хонгилоор дагуулан явав. Энэ үед миний гуян завсар ширүүн гартай сувилагч

хүүхний хайр найргүй зүсч тамласан “Хэвнэгт баатар”-аас минь цус алдан халуу дүүгүүлж байсан ч хоёр гараа ардаа гавлуулсан би түүнийгээ барих ч тэнхэлгүй ТӨК-ийн араас эв хавгүй алцагнасаар “Мэс заслын тасаг” гэсэн өрөөнд орлоо. Энэ үед миний толгойд “Нөгөө муу “Хэвнэгт баатар”-ыг минь тас огтлох гэж байгаа юм биш биз” гэсэн эвгүй бодол төрөөд явчихаж билээ. Өрөөний мухрын орон дээр хэвтэж байсан тураалдаа орсон нэг нөхрийг ТӨК өөр дээрээ дуудаж ирүүлээд “Өмдөө тайл” гэж тушаах зуураа над руу харж “Салтаан дахиа хамаагүй оролддог саваагүй хүн яадагийг чи хоёр нүдээрээ хар. Чи ч гэсэн ийм болмоор байна уу” гэлээ. Өмдөө шувталсан нөгөө хоригдол руу хартал ээ, бүү үзэгд. Тэр эрийн гуян завсар эр хүний бахархал болон гозолзож байдаг “Хэвнэгт баатар”-ын нь оронд онгорхой нүх харагддаг байгаа. Бүр онгорхой нүх шүү. Шоронгийн ТӨК нөгөө хоригдолд хандаж “Чи яагаад эр хүний бахархал болсон ганц зүйлээсээ салсанаа энэ нөхөрт ярьж өг” гэлээ. Санасаныг бодоход тэр хоригдол үг ярианы баялаг сайтай нөхөр байсан. Тураалдаа орж сэнсэрсэн тэр хоригдол “Үгүй юу л даа” гэж түгдрэн байсанаа “Би Хараагийн жаан дээр байхдаа нэг гал хамтайгаа хоёр хүүхэн авч “бардаакалсан” юм. Тэр шөнө зэргэлдээ өрөөнд “жимс” нухсан нөхөр маань өнөө “чавгаа” орилуулж чарлуулаад ёстой нэг эдлэх шиг болсон. Цаад “чавга” нь амьсгаадан гиншиж байна гэж юүхэв. Би амьдралдаа анх удаа л “жимс”-ийг тэгж гайхамшигтай нухдаг эрийг үзсэн юм. Ядахад нөгөө “лүүс”-нийх нь дуу чимээг сонсоод миний өвөрт унтаж байсан чавга хүртэл “Танай тэр нөхөртэй чинь ганц удаа ч болов нухалцаж үзье” гээд босоод алга болдог байгаа. Өглөө нь би гал хамдаа “Чи ч худаг болчихсон “лүүс”-нүүдийг өрөмдөхдөө гаргууд юмаа. Тэгтэл нь орилуулж чарлуудагийг бодоход лут том “аппарат” салтаандаа зүүсэн цус юмаа даа, чи” гэтэл мань хүн үг дуугүй өмдөө тайлаад бэлэг эрхтэнээ надад харуулсан. Гэвч түүний эрхтэн минийхээс жижигхэн гулилзсан бор юм харагдлаа. Тэгэхнээ гал хам маань эрхтэнийхээ тээрхийний үзүүрийн шамардаг хэсэг дээр нэг жижигхэн бондгор юм гүрэлзэн харагдаж байгааг заагаад “Хамаг учир энд л байгаа юм даа. Арьсан дор нь шаариг суулгаж орхисон юм. Ийм шааригтай, дээр нь бага зэрэг янаглах эрдэмд суралцсан байх юм бол чи ямар ч “жимс”-ийг дуу алдуулж эрхэндээ оруулж чадна. Чамайг ганц тавьж байхад цаад хүүхэн чинь дор хаяад гурав дөрвөн удаа тавьж орхидог юм. Хэрвээ чи хүсвэл ингэж шаариг суулгаж болно шүү дээ” гэлээ. Би ч угийн бөөн дур хулгайч юм хойно уухайн тас зөвшөөрөөд эрхтэндээ шаариг тавиулж ямар ч “жимс”-ийг байлдан дагуулж эрхэндээ оруулахаар шийдсэн. Тэгээд л...” гээд таг болчихов. Тэгтэл шоронгийн ТӨК “За за, юундаа маягласан лалар вэ. Цааш нь ярь” гэж шаардлаа. Энэ үед миний хоёр гарыг ард маань албадан холбосон герман гав намайг хөдлөх бүрийд аяндаа чангарч хоёр шууг минь тас татах шахаж, мохоо хутганы ир шиг ялтас нь гарын шууны ясанд тултал шигдэн тэсч ядаж байлаа. Ингэж зовж байхад шоронгийн ТӨК улам зовоох гэсэн аятай мөнөөх гавны никельдсэн төмөр гинжин дээрээс атгаж аваад хүчтэй дугтрахад би тэсэлгүй “Ёо ёо” гэж уянгалуулан дуу алдаж билээ. ТӨК намайг өмдөө шувталчихаад өмнө минь ангайн зогсоо хоригдол руу ойртуулж түлхээд “Алив амьсгаа минь. Чи тонгойгоод наадахынхаа салтаа руу сайн хар. Муусайн лаларууд эм хүнийг өрөвдөж хайрлахаа байг гэхэд өөрсдийнхөө эрхтэнийг хайрлахад яадаг байна аа” гэж зандрав. Нөгөө онгорхой нүхийг нь ойртоод хартал муухай гэж жигтэйхэн. Зүүн цавинд нь гуурс байхыг бодоход тэрүүгээрээ шээдэг бололтой. Шоронгийн ТӨК дахиад л захиргаадаж “Юундаа түгдэрсэн лалар вэ. Цааш нь юу болсоныг наад амьсгаадаа ярьж өг” гэж тушаалаа. Зөвхөн надад сонсох биш өөрөө ч бас сонсох дуртай байгаа бололтой. Нөгөө сэнсэрсэн хоригдол гүнзгий амьсгаа авсанаа “Шаариг тавьсан эрхтэн маань аажимдаа гурилын ганжин шиг хавдаад намайг маш их зовоосон. Тэгээд л би амьд үлдэхийн тулд эр хүний ганц бахархал, сүр сүлднээсээ хагацсан

даа. Надад мэс засал хийсэн эмч, сувилагч нар “Чи бэлэг эрхтэндээ хайртай юу, амь насандаа хайртай юу” гэсэн хоёр асуулт тулгаж байлаа. Би хоёуланд нь хайртай гэж хэлсэн. Тэгтэл тэд “Хоёуланд нь хайртай байж болохооргүй асуудал тулгараад байна. Бэлэг эрхтэндээ хайртай бол амь нас чинь үгүй болно. Амь насандаа хайртай бол бэлэг эрхтэн чинь үгүй болно. Тэгээд алийг нь сонгох юм бэ” гэж шавдуулсан. Мэдээж би амь насандаа арай илүү хайртай байх нь ойлгомжтой биз дээ. Амьгүй эрхтэнээр би яах ч юм билээ. Үүний оронд эрхтэнгүй амьд бие хэрэгтэй шүү дээ. Нууц эрхтэнийг маань угаар нь тасдаж авахаас өөр аргагүй болсон байлаа. Ингээд юуных нь нууц байх билээ, зүгээр л нэг онгорхой нүх болж хувирсан. Одоохондоо ч яахав онгорхой харагдаж л байна. Яваандаа битүүрнэ гэж эмч хэлсэн. Би эрхтэнээсээ салчихаад эхэн үедээ амиа хорломоор л бодогдож байлаа. Гэвч яг цаг дээрээ тулахаар хүн чинь аминдаа хүрч чаддаггүй юм билээ. Одоо би эрхтэнээрээ хамаагүй тоглосоны горьг амсаад эр ч биш, эм ч биш ийм л нэг сүг болчихоод байна. Саваагүй зан хүнийг ийм л болгодог юм байна даа” гээд толгойгоо сэгсрэхэд би түүний “Хэвнэгт баатар” байсан газарт онгойн харагдах дугуй улаан нүхийг алмайран ширтэж билээ. Энэ үед шоронгийн ТӨК “За чи сонсов уу. Тэнгэр бурхан хайрласан ганц эрхтэнээрээ оролдоод байвал эр хүний хийморь лундаа байхгүй болдог юм. Буруу хэрэг хийсэн чамайг долоо хоног сахилгад суулгана” гээд шоронгийн шорон гэгддэг сахилгын байр луу аваад явж билээ. Тэгээд би ёстой л мэддэг бүх үгээ хэлж ахиж хэзээ ч “Хэвнэгт баатар”-аа оролдохооргүй болтолоо хаширсан. Долоо хоногийн дараа ТӨК намайг сахилгаас гаргахдаа шоронгийн эмнэлэгт өөрийн үзсэн харсанаа хэнд ч ярихгүй байхыг анхааруулж билээ. Хэрвээ тэнд үзсэн, сонссон зүйлийнхээ нууцыг задалвал ахиж шоронд орох болно гэсэн ам өчгийг минь авч байлаа. Ингээд хүүхэн болгоныг байлдан дагуулах ид шидэт санаачилга маань талаар болж, “Хэвнэгт баатар”-аа шааригаар тоноглох гэсэн адал явдал маань төгсгөл болж билээ. Одоо харин энэ мэтийн явдлыг нууцлах хэрэггүй болж. Нэг муу бэлэг эрхтэний нууц байтугай Монгол улсын төрийн нууцыг хүртэл ил ярьдаг боллоо шүү дээ. Бэлэг эрхтэндээ шаариг суулгаад хэрхэн хөглөж явсан тухайгаа хожим би нэг сексологич эмч найздаа ярихад мань хүн толгой сэгсрэн инээгээд “Яс үндэс, арьс өнгө өөр нь хамаагүй. Хорвоогийн эрчүүд бүгд л “нандин эрдэнэ”-ээ том болгох гэж сонирхож байдаг юм. Саяхан би Барууны орнуудын эрчүүдийн дунд “Сарнай ургуулах” гэдэг нэг бусармаг арга дэлгэрч олон арван эрчүүл эрүүл мэндээрээ хохирсон тухай мэдээллийг олж уншлаа. Зарим эрчүүд үс нь унаж толгой нь халзрахыг, майга хөлтөй, муухай царайтай байгаадаа нэг их эмзэглэдэггүй хэрнээ бусдын нүднээс далд байдаг нууц эрхтэнийхээ төлөө бол туйлын эмзэг ханддаг юм даа. Өнөөдөр эр хүний нууц эрхтэнийг хөгжүүлэх асуудал анагаах ухааны бие даасан бүхэл бүтэн нэг салбар болтолоо өргөжиж, эр хүний эрхтэнийг томруулах “Хатагтай Донна Пауэлийн арга”, “Даосизмын арга”, “Доктор Роберт Чартхэмийн арга”, “Энэтхэгийн Садху омгийн хэрэглэдэг арга”, Арабуудын “Жельк” арга гэх зэрэг эр хүмүүний амьдрал дунд туршигдан шалгарсан олон арга бий болсон шүү дээ. Гэхдээ эмэгтэй хүн болгон том эрхтэнд дуртай байдаг гэвэл худлаа. Эр бэлэг эрхтэн том байлаа ч, жижиг байлаа ч ялгаагүй дур хүсэл оргилж байсан цагт эм хүний умдаг руу ухаан жолоогүй давхиад л орно. Хүсэл тачаал нь хөдөлсөн л бол ямар ч эм хүний эрхтэн хамтран загас наадуулагчийнхаа эрхтэнийг дуртайяа хүлээж авдаг. Эмэгтэй хүний дур тавилт хэрхэн янаглах, хэрхэн энхрийлэхээс бас шалтгаална. Ер нь эр бэлэг эрхтэн гэдэг чинь эм бэлэг эрхтэнд тохируулан агшиж, сунаж байдаг өвөрмөц чадвартай эрхтэн шүү дээ. Түүнээс биш хоёр хөлийнхөө дунд гуалин шиг урт юм унжуулсанаараа супер эр болчихдоггүй юм” гэж онолдож билээ.



## **Засангийн удирдлага эрх танхи хоригдолуудаараа ажил хийлгээч ээ!**

*Соц нийгмийн үед хорь орчим жил ял эдэлсэн Осоржсамаагийн Мөнхбат гэгч эр өнөөгийн шоронгийн диктатур хэтэрхий зөөлөн болчихсон, хууль тогтоомж хэтэрхий энэрэнгүй болчихсонд дотроо бас бухимдаж явдаг нэгэн ажээ. Ингээд түүний яриаг сонирхоно уу?*

**-Юуны өмнө та соц нийгмийн үеийн шорон гяндан ямархуу диктатуртай байсан талаар ярина уу?**

-Жинхэнэ социализмыг байгуулна, коммунизмыг бүтээнэ гэж уриалж байсан үеийн шорон гянданг өнөө үеийн шорон гяндантай харьцуулбал өдөр шөнө шиг ялгаатай болсон байна. Би тэр чанга хатуу социализм, коммунизмын үед төрж өсөөд, ардчилалтай амьдралаа холбоод өнөөдөр амьд яваадаа бас баяртай байдаг юм. Тэр үеийн шорон гяндан, хууль хяналтын байгууллага бол үнэндээ харгис хатуу байсан. Хууль бол хууль байсан. Шорон бол шорон байсан. Одоо бол шорон гээч нь асрамжийн газар ч юмуу, амралт сувилалын газар ч юмуу, жаахан хэтрүүлж хэлбэл ясли цэцэрлэг шиг болчихсон юм байна лээ. Өнөөгийн хоригдолууд өрөөндөө телевизортой, өрөөндөө хоол ундаа хийж иддэг ч юмуу, тэгээд унтдаг ор нь хүртэл диван кресло болчихсон, түүнийгээ хивс дрожоор бүрчихсэн байх жишээтэй. Намайг шоронд байхад “Нарсанд муу явахаар наранд сайн яв” гэж ярьдаг байсан. Одоо харин эсрэгээрээ наранд ядарч зүдэрч явахаар нарсанд ороод ард түмний татварын мөнгөөр өөрийгөө тэжээлгээд амар жимэр явж байх сэтгэлгээтэй болчихож. Ар гэр нь ядуу зүдүү гуйлгачин ямар ч байлаа гэсэн “Намайг эргэхгүй бол энэ долоон метр хашаанаас үсэрч үхлээ, боомилж үхлээ” гэж айлгаад, тэгээд сард хэдэн төгрөгийн тэтгэвэр авдаг хөгшчүүл үр хүүхдээ үхүүлэхгүйн тулд шорон луу боов боорцог, тамхи тариа аваад л очдог болж. Ер нь бол нийгэм өөрчлөгдөхөөр хүний мөс чанар бас мууддаг юм байна. Мөн энэ мөс чанараа дагаад хууль нь гууль болчихдог юм байна. Миний хувьд гэвэл тэртээ нэгэн цагт санамсаргүйгээр хүний амь хөнөөсөнийхөө төлөөсөнд 20 орчим жил ял эдэлсэн. Би шоронгоос суллагдсан цагаасаа хойш хувь, хувьсгалын бүх байгууллагад өнөөдрийг хүртэл шударга хөдөлмөрөөрөө амьдарч байна. Түүнээс биш би янз бүрийн хадгаламж зээлийн хоршоо ч юмуу, байшин барилга барина гээд амьтан хүнээс арав таван төгрөг луйвардаж явсангүй.

**-Та түрүүн өнөөгийн хоригдолууд нарсанд жаргаж байгаа тухай цухас өгүүлсэн. Нээрээ ч үнэн юм шиг. Дарга нар нь хүртэл тансаг сайхан шорон гяндан нэмж бариад л байх шиг байна. Энэ тухай та дуулж сонссон уу?**

-Сонсохоор барах уу. Энэ тухай хэд хэдэн сонин дээр бичигдсэн байхыг олж үзсэн. Сүүлийн хоёр жилд улсын эдийн засаг, санхүүгийн чадавхи сайжрахын хэрээр төвлөрсөн төсвөөс хорих байгууллагуудыг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт нэлээд нэмэгдсэн бололтой юм. Тиймээс энд тэндэхийн шоронгууд сүүлийн гурван жилийн сүүлийн гурван жилийн хугацаанд улсын төсвөөс нийтдээ гурван тэрбум төгрөг шомбодсон байх жишээтэй. Хайран мөнгө. Уг нь ялтануудаараа ажил хийлгээд улсын төсөвт мөнгө оруулах ёстой байтал татвар төлөгчдийн өгсөн хэдэн төгрөгөөр хайр найргүй гараа угааж байгаа нь даанч харамсмаар. Ялтануудын тоог улам нэмэгдүүлэх гэсэн аятай шорон гяндангаа улам нэмж бариад, хоригдох хүний тоо болон хүчин чадлыг нь улам ихэсгээд байгаа нь “Монголчууд байнга гэмт хэрэг үйлдэж, шоронгяндан улам цэцэглэн хөгжөөсэй” гэж муугаар зөгнөөд байгаатай адилхан ч

юм шиг. Ер нь засангийн зарим дарга нар “Манай байр хачин сайхан тохилог шүү, наашаа хүрээд ир” гэж дуудах нь холгүй байх юм. Нэртэйгээр нь телевизээр шинээр байгуулагдсан тэр сайхан тансаг шоронгийнхоо бүх зураг хөрөг, тохижилтыг үзүүлээд “Иргэн таныг тохилог сайхан байранд тавтай амьдрахыг урьж байна. Та нарын бүх зардлыг Монголын татвар төлөгчид даана. Манайд ирээрэй” гээд рекламдчихмаар юм. Өдөр тутмын нэг сонинд засангийн нэг том дарга ярилцлага өгөхдөө “Бид бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3500 ялтаныг олон улсын стандартад нийцсэн хоёр давхар саруулхан, тохилог байртай болголоо. Хорих өрөөнд 4-6 хүн амьдарна. Нэг хүнд гурван ам.метр талбай ногдох ёстой. Батлагдсан зураг, төсвийн дагуу халуун, хүйтэн ус, халаалт болон агааржуулалтын систем, халуун усны газар, ариун цэврийн өрөө гээд дутуу юм байхгүй” гэж ирээд л сайрхсан байхыг яана. Би бол шоронгийн тухай ярих юмуу, бодож санах дургүй. Гэхдээ сүүлийн үед барьж байгуулаад байгаа амралт сувилал маягийн 3500 хүний багтаамжтай тансаг шилтгээн шорон энэ тэрийг бодоод “Үүний оронд ганц сайхан үйлдвэр барьчихгүй яав даа” гэж харамсах сэтгэл төрөх юм. Энэ дарга нар үнэхээр даварч байна. Монголчуудад маш их хүний нөөц байна, маш их үйлдвэр уурхайн орд газрууд байна. Өнөөдөр Монголд арваад мянган хоригдол байгаа болов уу. Энэ арваад мянган хоригдол өнөөдөр зөвхөн ард түмнийг шулж байна. Татвар төлөгчдийн мөнгөөр тансаглаад л, сайхан орд харш бариулаад л, шоронгийн дарга нар нь үүнийгээ рекламдаж гүйгээд байгаа нь жинхэнэ эмгэнэл. Жишээ нь Зайсангийн дамжинг долоон метр өндөр битүү хашаагаар бүрсэн байгаа юм. Монголд одоо ямар гадны халдлага орж ирэх гээд байгаа биш. Нөгөө талаар гэвэл энэ олон шоронг барьж байгуулахад бас менежмент хэрэгтэй. Тэгтэл ямар ч менежментгүй барьсан байгаа юм даа. 1984 онд Дүүрэнгийн шорон гэж байгуулагдаж байлаа. Дүүрэнгийн шоронд Монгол улсын нөөцийн байгууламж болох том том агуулахууд барьж байлаа шүү дээ. Зөвхөн улсын нөөцийн газрыг барихын тулд тэр битүү уулын голд хоригдолуудын хүчийг ашиглаж байлаа. Дараа нь Шувуун фабрикт “Хар үнэгний фирм” барина гээд Салхитын шоронг барьж байгуулж байсан. Мөн ялгаагүй бас 200 гаруй хоригдолыг Мааньтаас ачиж авчраад зургаан метрийн гүнтэй, 1000 гаруй метрийн урттай хадан дунд резирварын нүх ухуулж байсан. Энэ бол үнэхээр хүнд ажил байсан. Тэгэхэд би яг тэнд хоригдолоор очиж байсан. Би бригадын дарга, зөвлөлийн дарга, журам гээд юм юм л хийж байсан. Мужаан, дархан ч хийж л байсан. Сангийн слесарь ч хийж байлаа. Би “Ганц худаг”-ийг анх гяндан байх үеэс нь тэнд хоригдож байлаа. Тэгээд 1986 онд гуравны хоёроор ял эдэлсэн гээд дэглэм буурч байлаа. Тэр үеийн хууль ийм хатуу байсан. Жишээ нь би гэхэд л арван жилийг ардаа хийсэний дараа чангаас жирийн дэглэмд шилжиж байгаа юм. Намайг тэр үед жирийн дэглэм рүү явууллаа л гэсэн. Тэгтэл Авдрантын шорон луу ачсан. Би тэнд очоод зөвлөлийн дарга хийсэн. Намайг очиход Авдрант гурав дөрвөн давхарын хэрээтэй сликатын цагаан тоосгоор барьсан, Италийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон их том үйлдвэртэй байсан. Жишээ нь сам хөрөө, өнгөлөгч хөрөө, таслагч хөрөө нь дандаа алмазан иртэй. Чулууны иж бүрэн үйлдвэр байлаа. Энэ үйлдвэрт би өдөр шөнөгүй 24 цагаар ээлжгүйгээр ахлах бригадын дарга хийж л байсан. Гурван жилийн өмнө би хүн эргэх гэж Авдрантад очоод бүр нүдэндээ ч итгээгүй. Авдрантын шоронг самсаа шархирмаар аймшиг болгочихсон байсан. Эндхийн шоронг Булганы Хөлдүү Мааньт руу нүүлгэсэн. Уг нь Авдрантад социализмын үед бүтээн босгосон тэрбум гаруй төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж байсан юм. Тэгтэл нэг ширхэг төмрийн хэлтэрхий ч үлдээлгүйгээр тоночихсон байлаа. Авдар уул бол боржин чулууны 400 жилийн нөөцтэй. Нөөц нь байж байдаг. Ажиллах хүчин болох ялтанууд нь байж байдаг. Тэгтэл энэ дарга нар яаж байна. Шоронгийнх нь хашаан дотор шорон барьж өгөөд байхаас биш тэр Авдар уулыг түшиглэж үйлдвэр барьж

байгуулахыг ер төсөөлөхгүй байгаа юм. Намайг тэнд ял эдэлж байхад Авдар уулын боржин чулууг зүсч өнгөлөөд чулуун хавтан хийдэг байлаа. Зуун хувь иж бүрэн ажиллаж байсан энэ үйлдвэрийг яагаад ингэж балгас болгосоныг би ерөөсөө ойлгохгүй байгаа. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нь дарга нар нь зараад идчихдэг юмуу, эсвэл улсаас наадахаа зарж хоригдолуудаа тэжээ гээд үүрэг өгчихдөг юмуу, ямар ч байсан тэр их үнэт эрдэнэс ул мөргүй болсон. Ер нь бол урьд нь ингэж шорон барьж байгуулж байгаагүй юм шүү.

## **-Соц нийгмийн үед шорон гянданг зөвхөн үйлдвэрлэлийн зориулалтаар байгуулдаг байсан хэрэг үү?**

-Ерөөсөө л тийм шүү дээ. Мөнгөн морьтын уулын модыг хяргуулахын тулд “Мөнгөн морьт”-ын шоронг, Хар-Айрагийн жоншийг ухахын тулд Хар-Айрагийн шоронг барьж байсан. Энэ чинь одоо нөгөө менежмент гэдэг нь болов уу. Тэгтэл өнөөдөр ажил хөдөлмөр өрнөөд, чулуу үйлдвэрлээд мандаж байсан шоронгоо нурааж хаяад тэс өөр газар ямар ч бодлогогүйгээр шинээр шорон барьж байх жишээтэй. Зөвхөн 2008 онд гэхэд л Амгалан дахь 421, Тоосгоны 409, Мааньт дахь 415 гэх зэрэг 10 гаруй ангид тус бүр нь 300-600 ялтаны амрах байрыг ашиглалтанд оруулсан байгаа юм. Үүн дээр мөнөөх алдар цуутай, олон улсын стандартад нийцсэн, 3500 ялтаны багтаамжтай, хоёр давхар саруулхан, тохилог байрыг нэмээд үз. За тэгээд ТЭЦ-4-ийн орчимд 1000 хүнийг цагдан хорих байр бариад ашиглалтанд оруулчихлаа. Монгол улс үнэхээр шоронжиж гүйцсэн байгаа биз. Одоо энэ олон шоронгийн том савыг Монголын залуучууд л дүүргэж таарах байх даа. Зайсангийн аманд долоон метр өндөр хэрмэн хашаа барьж бараг Ази тивдээ рекорд тогтоож байх жишээтэй. Монголын түүхэнд ийм шоронгийн хашаа байгаагүй. Одоо Зайсан майсанг гадна дотны жуулчид хараад юу гэж бодох бол. Ичмээр юм. Хүн амын бөөгнөрөл Улаанбаатарт бий болоод байна гэсэн чинь одоо бүх шоронгууд Улаанбаатараа тойроод баригдчихлаа. Арваад мянган хоригдолоор Улаанбаатарт амьдарч байгаа сая гаруй иргэнээ хамгаалуулах гээд байгаа юмуу, эсвэл энэ сая гаруй хүн лүү нэг шөнө арван мянган хоригдолыг дайран оруулж алуулах гээд байгаа юмуу, бүү мэд. Нийслэл хотоо тойруулаад шорон бариад л байдаг. Ямар ч үйлдвэрлэл явуулахгүй. Тэр олон хоригдолоор өнөөдөр ер нь юу хийлгээд байна аа. Намайг Мааньтын хориход байхад Эрдэнэт рүү өдөрт 4-6 вагон, Хөтөл рүү өдөрт 12-20 вагон жижиглэсэн цагаан чулуу ачдаг байлаа. Хоригдолуудын хоншоорыг жинхэнэ шалгадаг байсан. Эр хүний эр бяр гээч юмыг тэнд ёстой амтлуулдаг байлаа шүү дээ. Тэгвэл өнөөдөр Мааньтад юу хийж байна. Чулуу зөөж, шохой шатаах асуудал бол үндсэндээ зогссон. Тэгтэл соц нийгмийн үед Авдрант, Мааньт, Зүүнхараа зэрэгт амьдрал ид буцалж байсан юм. Би Авдрантын чулууны үйлдвэр дээр очоод ерөнхий бригад хийж байлаа. Манай бригадад 180 гаруй хоригдол байсан. Тэгээд энэ “Чингис” зочид буудал, “Улаанбаатар” зочид буудал, МАХН-ын төв байр эд нарын бүх гантигийг Авдрантын хоригдолууд хийсэн юм шүү дээ. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр өнөөдрийн энэ эрх танхи хоригдолуудаа ашиглаач ээ, ажил хийлгээч ээ, ард түмнийг ядуурлаас гаргаач ээ, бүтээн босголт руугаа хөрөнгө хаяач ээ гэж хэлэх гээд байгаа юм. Малгай шүүрсэн ч юмуу, дэлгүүр ухсан жижиг гэмт хэрэгтэнүүд нь ганц нэг бригад болж ажил хийх аядаж байгаа болохоос биш албан газар, хувь хүний өч төчнөөн сая төгрөгийг луйвардчихсан хүмүүс нь шоронд нэртэй наранд л явж байдаг болж. Тэгээд бүгд гар утастай. Их хуцвал гадаа нь дандаа жийп машин зоолттой. Ер нь бол шорон гэдэг чинь цэцэрлэг, амралт сувилалын газар болчихсон гэдэг нь тодорхой болчихоод байгаа юм. Тэгэхээр одоо энэ төр засгийн эрхэмүүд шоронд өгөөд байгаа тэр олон тэрбум төгрөгөөрөө үйлдвэр

баримаар байх юм. Хятадаас авч байгаа шохой, цементээ зогсоогоод дотооддоо үйлдвэрлэл явуулах хэдэн мянган жилийн нөөцтэй ордууд байхад тэдэн лүүгээ яагаад энэ их хөрөнгийг хаядаггүй юм бэ. Монгол улс чинь улс төрийн солиоролд орчихлоо гээд байсан, одоо бол бизнесийн бүлэглэлийн солиорол эхэлчихлээ шүү дээ.

## **Лувсанпэрэнлэй хурандаа ялтан хүнийг ямар цагт нь шийтгэж, ямар цагт нь хайрлах вэ гэдгийг сайн мэддэг хүн байсан**

“Засангийн удирдлага эрх танхи хоригдолуудаараа ажил хийлгээч ээ” гэсэн утга бүхий ярилцлага дээхэн үед орон шоронд ял эдэлж байсан олон хүний сэтгэлд хүрсэн бололтой. Тэдний нэг болох Долгорын Нямгарав доорхи яриаг өрнүүлсэн юм.

**-Дээхэн үеийн ялтануудыг манай төр засаг ажлаар үнэхээр дарж өгдөг байж дээ?**

-Тэр үнэн. Төр засаг ажлаар дарах нэг хэрэг. Харин тэр дарсан ажлыг нь ялтанууд хэрхэн хийж гүйцэтгэх нь бас нэг хэрэг шүү дээ. Миний үеийн ялтанууд ажил хийх гэж ёстой умалзуулж өгдөг байлаа. Бид тухайн үед ямар нэгэн ажил хийхийг “Ял хийх” гэдэг байлаа. Хянагч нар ч бас ингэж л хэлнэ. “Та нар улсад цалинтай ажиллаж байгаа хөдөлмөрчин ард биш, өөрсдийнхөө үйлдсэн ялыг хийж нүглээ наминчилж байгаа ялтанууд шүү” гэж зандарна. Өнөөгийн ялтануудын дийлэнх хэсэг нь төрөөр тэжээлгээд зүгээр л гэдсээ илээд хэвгэж байдаг бололтой. Өмнөх ярилцлаганд чинь Мөнхбат гэдэг нөхөр яг үнэн юм ярьсан байна лээ. Сүүлийн жилүүдэд баахан шорон нэмж барьсан, хуучин муу шоронгуудаа засварлах гэж улсын өч төчнөөн сая төгрөгийг үрэн таран хийсэн тухай би сонин хэвлэлээс олж уншсан. Мөн Дөрөвдүгээр цахилгаан станцын ойролцоо саун, халуун устай люкс шорон бариад ашиглалтанд оруулчихлаа. Нэртэйгээр нь манай төр засгийн удирдлагууд таван одтой зочид буудал гэдэг шиг таван одтой шорон барьчихмаар юм. Ер нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулаад, бусдыг сэтгэл санаа, эд материалаар хохироогоод шоронд орсон хүмүүсийг нэг их чамин тансаг байранд орогнуулаад байх хэрэг байна уу. Үйлдсэн хэргийнхээ ялыг эдэлж байгаа тэднийг дусаал гоожсон муу навсгар байшинд байрлуулсан ч ер яадгийм. Харин эрүүл мэндэд нь муугаар нөлөөлж мэдэх агаар салхигүй, чийгтэй орчинд байлгаж болохгүй байх. Төр засаг энэ тал дээр л анхаарал тавих хэрэгтэй. Тэрнээс биш амралтанд амруулж байгаа аятай чамин тансаг байранд хийх ажилгүй тарвалзуулаад байх шаардлага байна уу. Үүнд л миний дургүй хүрээд байгаа юм. Яагаад гэвэл миний үед ялтануудыг зай завсаргүй ажлаар дарж жинхэнэ шүүсэлж байсан болохоор тэр шүү дээ.

**-Нэмж барьсан энэ олон шоронгийн барилгуудын цаана хэн нэгний бизнесийн ашиг сонирхол явж л байгаа байх даа.**

-Энэ чинь ерөөсөө ганцхан утга нь л бизнес шүү дээ. Өөр юм байхгүй. Чи бод л доо. Засангийн нэг ажилтан, шоронгийн нэг дарга цалингаа аваад зүгээр л цалингаараа амьдарч байна гэж бодъё, авгай нь ч бас засанд ажилладаг. Тэгтэл энэ хүн яагаад зуун хэдэн саяын орон сууцанд сууж байна, яагаад хаммер жийп унаж байна. Шоронгийн дарга нар бүгд л дандаа жийп уначихсан, бүгд л хагартлаа баяжчихсан байгаа шүү дээ. Наяад оны үед намайг ял эдэлж байх үед Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль гэж байсан юм. Тэр хуулийг хоригдолуудаар ягшгал цээжлүүлдэг байлаа. Хэрвээ тэр засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөөгүй ялтаныг дэглэм дээшлүүлнэ, ял нэмнэ, тэр ч байтугай гяндалдаг байлаа. Өнөөдөр ийм юм байхгүй болсон. Өөр нэг асуудал гэвэл хянагч нар нь ч юмуу, нөгөө шоронгийн овгорууд нь ч юмуу ялтануудын ар гэрээс маш их татвар нэхдэг болж. Тэр байрыг засч өгвөл чамайг төдөн хоногоор шагнана, тийм тоосго, төмөр, будаг авчруул, тэгэхгүй бол

чамайг тэгнэ ингэнэ ч гэдэг юмуу. Одоо нэг ийм хэлбэрт орчихож. Ийм уур амьсгал ард түмний дунд мэдрэгдээд байна. Үүнийг шоронд хэн нэгэн хүнээ явуулсан айл өрхүүд л мэднэ үү гэхээс биш зүгээр нэг шалдан төрийн албан хаагч, шалдан сэтгүүлч мэдэхгүй. Жишээ нь хүүгээ шоронд явуулсан эцэг эхчүүд маш их дарамтан дунд амьдарч байна шүү дээ. Хянагч нараас гадна овгор ялтануудын дарамт их болсон байна. Миний үед овгор ялтанууд ядарсан хоригдолуудын ар гэр лүү хандаад байдаггүй байлаа. Харин өнөө цагт зах зээлд орсон болоод ч тэр үү, ерөөсөө л ар гэрийнхэнтэй нь харьцдаг болчихож. Шорон нэмж барьж байгаа тухайд гэвэл ганцхан би яриад байгаа юм биш, Мөнхбат яриад байгаа юм биш. Бид нар ийм гоё шорон барьчихлаа гээд дэлхий нийтэд гайхуулаад байдаг, тэгсэн мөртлөө ерөнхийлөгч, ерөнхий сайд, яамны сайд нар нь ийшээ тийшээ бадар бариад гуйлга гуйгаад байдаг. Тэгээд тэр гуйсан мөнгөөрөө шорон бариад байвал гадаадынхан бид нарт яаж зээл тусламж өгөх юм бэ. Энэ шоронгуудыг барьж байгуулах нь зөв ч юмуу, буруу ч юмуу, би бол ойлгохоо больчихоод байна. Миний ганцхан зөв гэдэг бодлого бол ерөөсөө л Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль. Одоо ийм хууль гэж байна уу, үгүй юу. Аливаа хүн гэмт хэрэг үйлдэж болно, ял эдэлж болно, гэхдээ тэр хүн хөдөлмөр хүмүүжлээрээ засарч гарах ёстой болохоос биш өнөөдөр хүмүүсийг шулж мөлжөөд эрх танхи цагаан гартан болж, ард түмнээр өөрсдийгөө хамгаалуулж, улсаар өндөр том байшин бариулаад амьдраад байж болох уу. Хүн хөдөлмөрөөр хүмүүжихээс биш цаасан дээрхи юм уншаад хүмүүжинэ гэж түүхэнд байхгүй. Хүн хөдөлмөрөөр яаж хүмүүжих вэ гэхээр тухайн хүн хөдөлмөрийг бүр яс, цус, махандаа мэдрээд, дахиж эрүүгийн гэмт хэрэг хийхгүй болдог байхгүй юу. Тэгэхээр энэ олон уурхайнуудаа түшиглээд үйлдвэр барьж байгуулаад, хуучин байгуулагдаад ажиллаж байсан үйлдвэрүүдээ сэргээх нь чухал болчихоод байна. Монголчууд өнөөдөр ажлын байр байхгүй гээд байгаа юм. Гэтэл энэ их ажлын байрыг монголчууд ерөөсөө ашиглахгүй байна шүү дээ.

**-Дээхэн үеийн шоронгийн дарга нар ялтануудаар үнэхээр ажил хийлгэж чаддаг байсан гэдэг. Та зарим нэг хүний талаар дурсахгүй юу?**

-Миний үед Мааньтын шоронгийн дарга Лувсанпэрэнлэй гэж хурандаа байлаа. Энэ хүн жинхэнэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс орондоо хувь нэмэр оруулах, хоригдолуудыг жинхэнэ хөдөлмөрөөр нь засч хүмүүжүүлэхийн төлөө ажилладаг байсан. Лувсанпэрэнлэй хурандаа хуулийг жинхэнэ сахиулж чаддаг, хөдөлмөрийн хууль гэж юу байдаг, ялтан хүнийг ямар цагт нь шийтгэж, ямар цагт нь хайрлах вэ гэдгийг сайн мэддэг хүн байсан. Мөн Дорж хурандаа байна. Хоригдолууд, албан хаагч нартайгаа ямар үед нь яаж харьцах вэ, яаж эд нарыг номхотгох вэ, хааяа бас хоригдол биш хүн гэдэг утгаар нь энэ хүнийг яаж хамгаалах вэ гэдгийг мэддэг хүн байсан. Одоо цагт сав л хийвэл хүний эрх гэж солиордог болж. Харин ч дал наяд онд жинхэнэ хүний эрхийг хамгаалдаг газар бол Засан хүмүүжүүлэх байгууллага байсан юм шүү. Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газарт Содном гэдэг генерал байлаа. Энэ хүн бол Монгол улсад маш их юм хийсэн. Миний яриад байгаа тэр үйлдвэрлэлийг Содном генерал удирдан зохион байгуулж байсан юм. Энэ хүн Засангийн удирдах газрын дарга хийж байхдаа бүх шоронгийн дарга нарыг гарынхаа арван хуруу шигээ мэддэг, захирч чаддаг, тэд нараараа юм хийлгэж чаддаг, шаардлагатай нөхцөлд өөрийн биеэр шоронгуудад очиж биеэрээ шалгадаг байсан. Тэр үеийн хуяг дарга нар ч тэр, хулгайч нар ч тэр жинхэнэ эр хүн байсан байхгүй юу. Өнөөгийн хоригдолын зарим нь хоригдол ч юмуу, энгийн хүн ч юмуу, бүү мэд. Жигтэйхэн ганган үнэтэй “Монтана” жинсээр гоёод л халимаг тавьчихсан, тэгээд 11-тэй утас өвөртөө хийчихсэн яваад байгаа шүү дээ. Том том жийп

уначихсан. Энэ хэн бэ гэвэл шоронгийн даргын жолооч. Тэр нь тэгээд ялтан байж байдаг. Авдрантын гяндангийн дарга Дашхорлоо гэж хошууч байлаа. Тэр маш их хөдөлмөрч, маш шударга хүн байсан. Дашхорлоо дарга хоригдолуудад хандаж “Та нар хамгийн хүнд гэмт хэрэг хийчихээд тэгээд бас ард түмний мөнгөөр гэдсээ цатгуулаад ингээд сууж байна гэж битгий горьдоорой” гэдэг байсан. Нэг талдаа ингэж зандардаг ч гэсэн нөгөө талдаа гяндангийнхаа хоригдолуудыг хараад өрөвддөг байсан. Турж эцсэн, өдөр шөнөгүй хоол цай бодсон, хагас өлсгөлөн байдаг хүмүүсийг хөдөлмөрт оруулаад, тэгээд жаахан хоол ундан дээр нь урамшуулал өгөөд ирэхээр сэтгэл нь сэргээд ирдэг. Тэгээд хоёр жилийн дараа гарах гэж байсан хоригдол хүртэл жил зургаан сар чулуу нүдээд гарч байлаа шүү дээ. Өнөөдөр ийм л юмыг буцаагаад сэргээмээр байгаа юм. Хуучин Засангийн дарга нарын зарим нэг нь тэтгэвэрт гарсан л байх. Энэ хүмүүс засангийнхаа удирдах газарт цугларалтанд ирдэг бол үгээ хэлэх хэрэгтэй. Одоо жишээлбэл Ганбат гэж миний шүтэж явдаг сайхан хурандаа байлаа. Жаахан эвгүй юм л даа. Их залуудаа тэр хүн нэг хочтой байсан. За тэр хочийг нь больё доо. Гэхдээ ямар ч байсан тэр Ганбат даргыг Засангийн удирдах газар байтугай шоронд ороод гарсан хүн болгон мэднэ. Жинхэнэ эр хүн. Ёстой жинхэнэ хуулийн ажилтан хүн гэвэл Ганбат хурандаа байсан юм.

**-Та хорь гаруй жил буу зэвсэгтэй харгалзагчийн хатуу ширүүн хяналт дарамтан дор амьдрахдаа юу бодож байв?**

-Юу эсийг бодох билээ дээ. Гэхдээ миний буруу л гэж сэтгэлээ чангалж байсан. Ер нь шоронд муу эр амархан зовж ядарч сэтгэлээр унаж гэр орноо, эхнэр хүүхдээ санаж байгаад үхдэгийг би олон баримтаар мэднэ. Харин өөрийн хийсэн хэрэг, гэм буруугаа мэдэж сэтгэлээ чанга байлгаж чадсан хэн ч бай хүний дор орохгүй.

**-Ажилд нухлагдах, хоол ундаар гачигдах, дарга харгалзагч нарт загнуулах үед ингэж зовж байхын оронд оргож зайлаад азаа үзье гэсэн бодол төрдөг байсан уу?**

-Иймэрхүү бодол бишгүй л төрдөг байлаа. Зарим хоригдол харж хамгаалдаг хүмүүсээ хороочихоод оргож яваад тун удалгүй баригдаж дахин ял нэмүүлэх явдал бишгүй л гардаг байсан. Энэ нь сэтгэлийн тэнхээ, тэвчээргүйн шинж байхгүй юу. Ер нь шоронд архи ууж зодолдох, хулгай дээрэм хийх, нэгийгээ егүүтгэх бол юу ч биш шүү дээ.

**-Шоронд олон жил ял эдэлж байгаа хүний сэтгэл санаа ямар байдаг бол?**

-Ихэнх нь ажил бага хийж, хоол их идэж бие амар байгаад ялынхаа хугацааг дуусгах юмсан гэж боддог. Гэр орноосоо, ах дүү танил нөхдөөсөө эргэлт олон ирээсэй гэж хүсэмжилдэг. Үүнээс өөр хүсэл зорилго тэдэнд бараг байхгүй гэж хэлж болно. Шар будаанд чанасан, үс хялгаснаас нь бүрэн салгаагүй адууны гэдэс зэрэг эхэндээ хоолой давдаггүй байсан. Сүүлдээ идээд сурчихаар бас ч дажгүй шүү. Гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа бүрэн ойлгосон цагт шоронгийн ажил, хоол нь ч зохидог байж мэдэх юм.

**-Дээхэн үед ялтануудын хооронд шинэ хуучин, хөгшин залуугийн ялгаа их байдаг байсан. Одоо энэ байдал арилсан болов уу?**

-Гүйцэд арилаагүй юм шиг байна лээ. Гэхдээ мөнгөтэй хүн бол шоронд ноёрхдог

болсон цаг шүү дээ. Мөнгөтэй хүн бол заавал бие хаа томтой, атаман байх шаардлагагүй. Гэсэн ч хэн нэгэн этгээд хүн алж хүрээ талж ирчихээд амралт сувилалд байгаа юм шиг тарвалзаад байвал захын ялтан хандыг нь дарж өгөхийг л бодно шүү дээ. Энэ бол шоронгийн бичигдээгүй хууль. Миний үед бол харуулаа алаад оргоцгооё, хулгай дээрэм хийж хэдэн өдөр ч гэсэн баригдалгүй амарцгаая гэж зарим нь ятгадаг л байлаа. Үүний хариуд “Аа яршиг. Суллагдах хугацаа дөхөж байна, би оргохгүй” гэхэд “Дарга нарын бууны нохой чамайг ална” гэж янз бүрээр дарамталж эрхшээлдээ оруулахыг боддог. Тиймээс худлаа, үнэн ч гэлээ “Оргох юмсан. Даанч боломж алга” гэх мэтийн үгээр булзааруулж байхад гэмгүй. Ер нь удаа дараа хэрэг хийж олон жилийн ял сонссон этгээд бол хүн алахыг мал төхөөрөхөөс амархан гэж санадаг. Харин би залуу насаа дуустал шоронгоор явахдаа ийм сэтгэл агуулж явсангүй.

**-Ялын хугацаагаа дуусгаад ч юмуу, төрийн өршөөлөөр суллагдсан хүмүүс яагаад хэдхэн хоноод эргээд шоронд орчихдог юм бол?**

-Арав хорин жил шоронд суугаад суллагдсан хүнийг аятайхан тосоод авчих аав ээж, ах дүү байдаггүй. Тэднийг хэн ч тоохгүй. Чөлөөт амьдралд сайн сайхан явахад нь үй зайгүй үерхэж нөхөрлөж байсан зарим нөхөд нь ч харж халамжлахгүй болчихсон байдаг. Ийм хүмүүс хэдэн өдөр хоол ундгүй явах юм бэ. Өлсөхийн эрхэнд хулгай дээрэм, зодоон цохион хийгээд л бэлэн хоол унд байртай газраа очъё гэж бодно биз дээ. Үүнийг төр засаг анхаарах л учиртай. Өөр нэг анхаарах асуудал гэвэл ялтануудад биш өвлийн хүйтэнд осгож нас бараад байгаа архичдад жаахан анхаарлаа хандуулахгүй бол болохгүй нь. Энэ өвөл гэхэд л миний хоёр ч найз шөнө согтуу явж байгаад осгоод үхчихлээ. Шинэ оны өмнөхөн Алтангэрэл гэдэг найз маань Хайлаастад осгосон бол шинэ оны дараахан Будцэрэн гэдэг найз маань Гуравдугаар хороололд хөлдөөд үхчихсэн. Осгосон хүмүүс зөвхөн энэ хоёроор тогтохгүй шүү. Найгүй архичдын жинхэнэ үүр оромж болсон газруудад хичнээн хүн осгож үхэж байгаа бол доо, бурхан минь. Ер нь нийслэл хотод хүн ам төвлөрөхийн хирээр хүний амь нас үнэ цэнээ алдаж байна. Ялангуяа гудамж траншейнийхан ийм эрсдэлд өдөр болгон шахуу өртдөг болж. Осголтоос гадна өдөр болгон нэг архичин архиндаа түлэгдээд ч юмуу, цус харвалт өгөөд цаашаа хардаг. Хамгийн харамсалтай нь тэднийг үхчихсэн хэвтэж байхад энгийн хүн байтугай цагдаа нар хүртэл төвөгшөөгөөд ойртож очдоггүй юм. Харин маргааш нь ч юмуу, хоёр гурав хоногийн дараа иргэдийн гомдол шахалтаар 5-р тасгийнхан очиж нэг юм далд оруулдаг бололтой.



## “Ялтаныг алсан ялтаныг ямар цаазаар авах биш, тагтааныхаа байранд очиж хэвтээ дээ”

Дундговь аймгийн харьяат Баатарсүрэн гэгч залуу одоогоос зургаан жилийн өмнө малын хулгайн хэргээр таван жилийн ял авчээ. Мань эр өмнө нь бас малын хулгайн хэргээр Багануурын шоронд ял эдэлж байсан юмсанж. Тиймээс давтан хэрэгтэн гэдэг утгаараа Мааньтын шорон руу илгээгдсэн байна. Чанга дэглэмтэй шоронд анх удаа очиж байгаа хүн эхэндээ нэлээд зовлон туулдаг юмсанж. Харин овгор товгор гэсэн сэтэр зүүчихсэн, ийм хэмжээнд очих чадваргүй хүмүүс бол нэг хэсэгтээ тэсээд гарна. Баатарсүрэнгийн хувьд ийм юм байхгүй тул шууд барлаг болсон байна. Эрдэнэтэд нэг хэсэг шуугиулж явсан “Шожгор” Ганболд гэгч агаман хоригдол түүнийг барлагаараа авч хөл гараа угаалгахаас эхлээд бөгсөө хүртэл арчуулсан байгаа юм. Баатарсүрэн энэ бүхнийг тэсвэрлэж чадалгүй Мааньтын чангаас оргохоор сэтгэл шулууджээ. Тэгээд нэг орой шууд л өндөр хэрмэн хашаа өөд ухаан жолоогүй авирч орой дээр нь гарсан ч дээгүүр нь гүйлгэсэн төмөр торонд өмд нь орооцолдчихсон байна. Тэгээд өөрийгөө торноос салгаж авах гэж амь наана, там цаана тэмцэж байтал буун дуу тасхийгээд явчихаж. Тухайн үед Баатарсүрэн юу ч мэдэрсэнгүй. Арай гэж торноос салаад цаад руу нь үсэрч буугаад ганц хоёр алхтал гуяыг нь дагаад ямар нэгэн шингэн юм урсах шиг болж. Тэмтрээд үзтэл цус. Түүний шоронгоос оргох гэсэн оролдлого ингээд бүтэлгүйтжээ. Баруун талынхаа хонго руугаа буудуулсан Баатарсүрэн шоронгийн эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд аз болж харин амин газар нь сум таарсангүй. Тэр шоронгийн эмнэлэгт хэвтэж байхдаа Өвөрмонголын гэмт хэрэгтэн Улаанцав гэгчтэй гал хам болжээ. Төдөлгүй мань хоёр эмнэлэгээс гараад зоон дээрээ очтол Эрдэнэтийн овгор ялтан “Шожгор” Ганболд угтаж аваад “Өө, муу гөлөг Баатарсүрэн чи хүрээд ирэв үү. Чамайг Өвөрмонголын нэг шээстэй гал хам болсон гэж дуулсан. Тэр чинь энэ үү?” гээд Улаанцавыг заамдаж аваад хайр найргүй шанаажээ. Тэгтэл Баатарсүрэн гал хамаа өмөөрч овгор ялтаны өөдөөс улаан галзуу юм дайрч орж цээж рүү нь мөргөж унасан байна. Тэгээд хажуудаа байсан сандалыг шүүрч аваад тархи толгойгүй балбаж гарчээ. Үүнээс болж “Шожгор” Ганболд эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд энэ цагаас хойш Улаанцав, Баатарсүрэн хоёр луу хэн ч зүрхэлж халдахаа байсан байна. Гэвч хүн гэдэг амьтан байнга л даварч байдаг болсон хойно Улаанцав, Баатарсүрэн хоёр сүүлдээ хэн нэгнийхээ дээр гарах гээд хоорондоо тэрсэлддэг болжээ. Овгор ялтанууд ингээд ирэхээрээ л өөрсөддөө гай дагуулдаг бөгөөд уг нь мань хоёр шоронд тогтоосон эрх мэдлээ бататгахын тулд зовхи өөдөө хэд гурван ялтаныг өөртөө татаж улам хүчирхэгжих ёстой байлаа. Гэвч Баатарсүрэнд ийм бодол байсангүй. Нөгөө л монголчуудад хамааралтай тамын тогооны үлгэр гээч нь нөлөөлсөн хэрэг. Баатарсүрэн нэгэн цагт шоронгийн дарамтыг тэсвэрлэж чадалгүй оргож босох гээд цустайгаа холилдож байсанаа ор тас мартчихаад ядарсан хоригдолуудыг дарамтлахын зэрэгцээ гал хам Улаанцавыгаа хүртэл ад шоо үзэж “Хятадын нэг муу бөөс халхын шоронд томроод байх ёсгүй шүү. Миний үгэнд ороод аятайхан байж чадахгүй бол чамайг амьтан болгоно шүү” гэж заналхийлэх болжээ. Гэвч Улаанцав аль хэдийн өөрийн гэсэн тойрон хүрээлэгчидтэй болчихсон болохоор түүнд тийм ч амархан буугаад өгчихсөнгүй. Харин ч бүр Баатарсүрэнгийн өөдөөс “Энэ шоронд чи бид хоёрын хэн нь эрх мэдэлтэй болохыг цаг хугацаа харуулна. Би чамд бууж өгнө гэж байхгүй. Харин чи л миний өмнө сөгдөх цаг ирнэ дээ” гэх зэргээр томорчээ. Харь нутгийн нэг муу гэмт хэрэгтэнд ингэж басуулсандаа Баатарсүрэн ихэд шаралхаж “За яах вэ. Чи амь насаа мэдэж яваарай. Би шууд л хутга шаадаг хүн шүү” гэж сүрдүүлэх аядтал Улаанцав “Би ч гэсэн шууд л дүрдэг хүн.

Зөвхөн халх эрчүүд л хутга шаадаг гэж бодоо юу. Муу ч гэсэн би хятадуудын ямаан омгийг өөртөө шингээсэн хүн шүү. Хэн нь хэнийгээ өрсөж хутгалахыг цаг хугацаа харуулна” гээд цааш эргэжээ. Тэгтэл Баатарсүрэн “Яасан их цаг хугацаа ярьдаг хулгайч вэ” гэж хэлүүтээ ар нуруу руу нь шууд хутга шаачихаж. Тэгээд “За тэр цаг хугацаа чинь хүрээд ирлээ. Би өрсчихлөө. Одоо тэр цаг хугацаагаа харав уу” гэж ёжлоод Улаанцавын нуруунаас хутгаа сугалж авмагцаа “Найдвартай нь дээр” гээд цээж рүү нь хоёр ч удаа дүрж орхисон байгаа юм. Гурван удаа хутгалуулсан Улаан-цавыг үхэтхийн унахад Баатарсүрэн сэтгэл нь ханасан байдалтай “Ялтаныг алсан ялтаныг ямар цаазаар авах биш дээ. Тагтааныхаа байранд очиж хэвгээ дээ” гэсэн гэдэг. Тагтааны байр гэдэг нь гянданг хэлж байгаа хэрэг.

## **Гэмгүй иргэнийг онц хүнд гэмт хэрэгт холбогдуулсан мөрдөн байцаагч 5-10 жил хоригдох ялтай**

Ямар ч гэмт хэрэг үйлдээгүй хүнийг гэм буруутайд тоо-цон яллагдагчаар татах явдал манайд олон гардаг. Гэвч олон гардаг энэхүү хэлмэг-дүүлэлтийн хариуцлагыг сүүлд нь хэн хүлээж, хохиролыг нь хэрхэн төлж барагдуулсан талаархи мэдээлэл төдий л сонсогдоод байдаггүй. Мөрөөрөө явсан хүмүүсийг мэргэжлийн маш ноцтой алдаа гарган эрх чөлөөнд нь халдаад зогсохгүй, баривчлан хорьж, улмаар эрүүл мэнд болон сэтгэл санаа, ахуй амьдралд нь хохирол учруулсан тохиолдолд тухайн мөрдөн байцаагч ямар шийтгэл хүлээх ёстойг эхлээд сонирхоё. Манай цагдаагийнхан гэмт хэргийг мөрдөн шалгах асаа өмнө эрүүдэн байцаах арга барилыг л гол болгодог тул эдүгээ яг энэ агшинд ч хаа нэгтээ гэм зэмгүй хүнийг хилс сэжигээр саатуулан хуулиа зөрчиж суугаа гэхэд буруудахгүй. Иймээс иргэд дор дурдсан хуулиудыг цээжлэн амны уншлага болгож явахад буруудахгүй санагдана. Монгол улсын Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлгийн 248-р зүйлийн 1-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт гэм буруугүй хүнийг сэжигтэнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”. 248-ын 2-т “Илт гэм буруугүй хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулсан, сэжигтэнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн эсвэл энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”. 249-ийн 1-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахайн болон хувийн сэдэлтээр илт хууль бусаар хүнийг баривчилсан бол албан тушаал үйл ажиллагаа явуулах эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, гурваас дээш зургаан сар эсвэл таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ. Эдүгээ цагдаа нарын мэдлэг чадвар илт дутагдсанаас ажилдаа хөнгөн хуумгай хандаж, зөвхөн гэмт хэргийн сэжигтэнийг барих, хорих, хэрэг тулган хүлээлгэх ноцтой үйлдэлүүд газар авч байгаа тул дээрхи хуулийн заалтууд зөрчигдөж буй эсэхийг хүн бүр нягтлан шалгаж байвал зохистой. Ингээд дээрхи хуулийн заалтуудыг зөрчсөн нэгэн хэргийг толилуулъя. Иргэн Т.Энхболд, Т.Энхтуяа нарыг машинтай явж байхад нь энгийн хувцастай гурван залуу ирж бичиг баримтыг нь шалгасны дараа өөрсдийнхөө машинд суулгаад нэг нь машиныг нь жолоодон авч явсан байна. Тэгсэнээ “Байцаагч Баярцогт” гэж өөрийгөө танилцуулсан залуу “Чи ер нь үхэх ялтай. Чи хаанаа буудуулмаар байна” гэж хэлэхэд нь гайхсан Т.Энхболд “Та нар хүн андуураад байна. Намайг явуулаач” гээд инээхэд урдаас нь “Энэ угаасаа алчихсан юм байна л даа” гэж хэлсэн аж. Төдөлгүй Энхболд, Энхтуяа хоёрыг цагдаагийн хэсэг дээр авчраад Энхболдыг ганцаарчлан байцааж “Чи хэргээ хүлээ. Танай хамтрагч Баянмөнх чинь үхчихсэн. Үхэхдээ чамтай энэ хэргийг хийсэн гэж гэрээслэл биччихсэн байна. Одоо чамтай аятайхан ярьж байгаа дээр хэргээ бушуухан хүлээ. Хэлтэс рүү очвол ингэж ярихгүй шүү. Чиний дүү Энхтуяа хэргээ хүлээчихсэн” гэсэнээ түрүүхэн үхчихсэн гээд байсан Баянмөнхийг сэхээнд байгаа мэтээр ярьжээ. Сүүлдээ бүр цагаандаа гарч “Сэхээнд байгаа Баянмөнх одоо бараг үхэж байгаа байх. Чамд бид туслах гээд байна. Чи ямар тэнэг юм бэ. Баянмөнх чамайг дарамтлаад энэ хэргийг хийлгэсэн биз дээ. Баянмөнх намайг сүрдүүлж хийлгэсэн гэж хэлээд чи ялаа багасгаач” хэмээн цохилдуулан ятгаж гарсан аж. “Чиний хамсаатан хэргээ хүлээчихсэн. Одоо чи үнэнээ хэл” гэх мэтээр соц нийгмийн үеийн

цагдаа нар л сэжигтэнүүдийг ингэж хооронд нь цохилдуулдаг байлаа. Одоо энэ арга хоцрогдсон байлтай. Т.Энхболд үүний хариуд “Юу яриад байгаа юм бэ. Надад хийсэн хэрэг байхгүй” гэхэд мөрдөн байцаагч түүнийг зодож эхэлсэн байна. Энэ үед Энхболдын ухаан санаа орж гаран бие нь илт муудаад иржээ. Ийнхүү түүнийг өглөөний 04 цаг хүртэл зодож дарамталж байгаад хүлээлгэнд аваачаад хийчихэж. Энхболдыг хүлээлгэнд 15 цаг болсоны дараа ямар ч хууль зүйн үндэслэлгүйгээр мөрдөнд 46 хоног саатуулан хорьжээ. Монгол улсын Эрүүгийн хуулинд онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа тохиолдолд баривчилна гэсэн заалт байдаг. Гэтэл Баянмөнх гэгч алуурчин эр хохирогч Баярмаагийн амь насыг хөнөөмөгцөө талийгаачийн халаа-санд Энхболд, Энхтуяа гэсэн бичиг хийж үлдээсэн нь тогтоогджээ. Хохирогчийн халаас-наас ийм бичиг гарч ирсэн тохиолдолд ямар ч мөрдөн байцаагч нэр бүхий улсыг сэжиглэн байцаах нь зүй ёсны хэрэг. Гэхдээ нотлох баримтанд бодитой дүгнэлт хийлгүй шууд л тулган хүлээлгэх, эрүүдэн байцаах аргаар хандаж улмаар хүч хэрэглэсэн нь гарцаагүй тэднийг буруутай болгож байгаа юм. Ганц энэ хэрэг дээр ч биш өөр олон хэрэг дээр иймэрхүү өрөөсгөл, харгис арга барил гарч байгааг үгүйсгэх аргагүй. Ухаан муутай, мэдлэг боловсролоор дулимаг, бусдыг хайрлах нинжин сэтгэлгүй зарим нэг мөрдөн байцаагч нар ямар ч гэмт хэрэг хийгээгүй хүнийг иймэрхүү маягаар дарамталж зодож, элдвээр эрүүдэж байгаад онц хүнд гэмт хэрэг хүлээлгэсэн тохиолдол зөндөө бий. Наад захын жишээ гэхэд л “Фүүд лэнд”-ийн хэрэг байна. Мөн Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэсийн нэг мөрдөн байцаагч гэмгүй иргэнийг “Ганц худаг”-т хүн амины гэмт хэргийн сэжигтэнээр аваачиж хориод овгор ялтануудаар бүхий л биеийг нь эрээн цоохор болтол зодуулаад амь насыг нь хөнөөж байсан удаатай. Хамгийн сүүлийн үеийн жишээ гэвэл Хэнтий аймгийн цагдаагийн газрын мөрдөн байцаагч Баттогтох гэгч иргэн Н.Баатархүүг хувийн өс хонзонгийн улмаас найман настай охиныг зэрлэгээр хүчиндсэн гэх онц ноцтой хэрэгт хилсээр холбогдуулж Хэнтий аймгийн мөрдөнд хоёр жил шахам тарчлаасан байх жишээтэй. Энэ тухай саяхан Н.Баатархүү ярихдаа “Би урьд өмнө нь ямар нэгэн хэрэгт холбогдож байсангүй. Хошууч Баттогтохтой би авто машины асуудлаас болж нэг удаа хэрэлдэж байлаа. Тэгээд намайг хүчингийн хэрэгт гүтгэгдээд мөрдөнд очиход Баттогтох хошууч “Өө, нөгөө хулгайч чинь өөрөө хүрээд ирлээ. Ёстой ясыг чинь цайлгаж өгнө өө” гээд л камерт хийсэн. “Би хэрэг хийгээгүй шүү дээ” гэсэн чинь “Чиний хэрэг хийсэн, хийгээгүй хамаа байхгүй. Надтай аятайхан яриад 25 жилийн ял ав. Эсвэл буудан ав” гэж хэлж байсан. Харин би өлсгөлөн зарлаж тэмцсэний ачаар энэ айхгар хүчингийн хэргээс мултарсан. Энэ хэргээс болж би хорин жил ханилсан эхнэр хүүхдээсээ хагацаад гудамжинд гарсан. Юу ч үгүй болсон. Энэ бол шинэ цагийн хэлмэгдүүлэлт” гэсэн юм. За яахав, нэг гэмгүй иргэн ингээд хэлмэгдчихдэг байж. Харин түүнийг хилс хэргээр хоёр жил шахам шоронд хатаасан мөрдөн байцаагч Баттогтоход ямар хариуцлага тооцов оо. Эрүүгийн хуулийн 248-ын 2-т “Илт гэм буруугүй хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогд-уулсан, сэжигтэнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн эсвэл энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн энэ заалт харамсалтай нь гэм буруугүй хүнийг онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан сэжиг-тэнээр тооцсон мөрдөн байцаагч Бат-тогтоход үйлчилсэнгүй. Түүнийг Өмнөговь аймгийн нэгэн суманд хэсгийн төлөөлөгчөөр явуулаад л болчих нь тэр. Таваас арван жил шоронд хорихоо байг гэхэд албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасч болно оо доо. Гэмгүй иргэнийг хувийн өш хонзонгоор хохироох маягаар илэрхий алдаа гаргасан цагдаа нарынхаа толгойг ингэж илээд байх юм бол Монгол улсад эрүүдэн шүүлт, шинэ цагийн хэлмэгдүүлэлт

ГЭЭЧ ЮМ ХЭЗЭЭ Ч ТАСРАХГҮЙ НЬ ОЙЛГОМЖТОЙ.

## Өс хонзонтой хоёр эр өвөрлөгч нөхдөөс болж төө зайгүй найзууд болцгоов

Энд өгүүлэх “Оцог” Нямаа, “Дэгнээн” Баттөмөр хоёр нарсанд байхдаа ёстой л хонь чоно хоёр шиг өш хонзонтой байжээ. “Оцог” Нямаа нь Эрдэнэтийнх, Баттөмөр нь Улаанбаатарын унаган хүүхэд. Нямаа Эрдэнэтэд байхдаа нэлээд агаман байсан бөгөөд Баттөмөр ч Улаанхуаран хавьдаа агамануудын тоонд ордог байж. 1990-ээд оны сүүл үед Баттөмөрийг Багануурын шоронд очиход Нямаа аль хэдийн агаман болчихсон байсан бөгөөд энэ ч утгаараа Баттөмөрийг дарамтлах гэж оролджээ. Гэтэл Баттөмөр “Чи муу намайг дарамталдаг хэн юм бэ. Би чамайг бодвол хотын хүүхэд шүү” гэж томорсон байна. Энэ үгийг сонсоод “Оцог” Нямаагийн шар гозолзож Баттөмөрийг нэвширтэл нь зодож орхижээ. Гэтэл гурав хоногийн дараа Мааньтын шоронгоос Баттөмөрийн хоёр хам дэглэм буураад Багануурын шоронд иржээ. Баттөмөр хоёр найздаа бүхий л зовлонгоо тайлагнаад “Энд “Оцог” Нямаа гэдэг сүрхий хулгайч байгаа. Хөгшин чинь тэрэнд навсайтлаа зодуулдаг байна ш дээ. Та хоёр юун төлөө Мааньтын чангаас ирсэн билээ. Нямаагийн хандыг хага дарах хэрэгтэй” гэж үүрэгджээ. Тиймээс цаад хоёр нь нэг л их мундаг хүн болох гээд “Оцог” Нямааг өдөж хоргоосон байна. Тэгтэл Нямаа “Мааньтын муусайн бөөснүүд минь аятайхан байгаарай. Энэ шоронд би найман жил болж байна. Та нарыг бодвол би дошин дээрээ байгаа хулгайч шүү. Мааньтын шоронгоос ирсэн гэхээр л та хоёроос би айх болж байна уу. Тэр Авдрант, Мааньт чинь эцсийн эцэст юу юм бэ. Тэнд чинь хүн алахын дон шүглэсэн хөгийн новшнууд л цуглардаг юм шүү дээ” гэх зэргээр ам нээх чөлөө өгөлгүй хандыг нь хага даржээ. Энэ цагаас хойш Баттөмөр Нямааг яаж ч чадсангүй. Нямаа ч Баттөмөрийг яаж ч чадаагүй бөгөөд хоёр агаманы хооронд бие биенээ үзэн ядсан цусгүй дайн үргэлжлэх болжээ. Уг нь агаман улс шоронд эвдрэлцэж байхын оронд гал хам болвол илүү амжилтанд хүрдэг гэдэг. 1980-аад оны үед Сангирагчаа, Дамдинсүрэн гэгч хоёр агаман хоорондоо чоно хонь шиг байж. Тийм ч учраас хоригдолууд хоёр тал болж хуваагдан Дамдинсүрэнгийнх, Сангирагчаагийнх гэсэн тодотголтой болсон гэдэг. Тэгээд хоёр тал болоод хоорондоо байнга зодолдоно. Сүүлдээ бүр аль аль нь туйлдаа хүрсэн байгаа юм. Уг нь шоронд нэг нь хэт хүчтэй, нөгөө нь сул дорой тэнцвэргүй тулаан байх ёстой юмсанж. Ингэж байж л улсын төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэдэг байж. Хүч тэнцүүхэн хоёр бүлэг бие биенийхээ дээр гарах гээд зүтгэчихдэг бөгөөд дунд нь улсын ажил хохирдог юмсанж. Сүүлдээ бүр захирах, захирагдах ёс хүртэл алдагдаад ирдэг аж. Тиймээс хорихын удирдлага Дамдинсүрэн, Сангирагчаа хоёрыг эвлэрүүлэх талын юм хийхээс өөр аргагүйд хүрч байсан гэдэг. Төдөлгүй мань хоёр гал хам болсоноор дураараа дургисан хоригдолууд жаахан эмх замбараатай болж иржээ. Ер нь шоронд агаманууд нэгдэж байж амжилтанд хүрдэг бөгөөд ганц ганцаараа зүтгээд хол явдаггүй бололтой. Харин Нямаа, Баттөмөр хоёр бие биедээ өш хонзон өвөрлөж ганц ганцаараа зүтгээд байсан нь хачирхалтай. Сүүлдээ хоригдолууд “Оцог” Нямаагийн бүлэг, “Дэгнээн” Баттөмөрийн бүлэг гэж хуваагдан дээр доороо орох гээд үзчихдэг болжээ. Нямаагийн бүлгийнхэн Баттөмөрийг элдэв дээдээр хараан зүхэж, Баттөмөрийн бүлгийнхэн Нямааг “Энэ муу хулгайчийг болдогсон бол алчих юмсан” гэж зандаг болжээ. Гэвч тэр занаж зүхээд байгаа хүмүүс нь амиа яая гэж байгаа ядарсан хоригдолууд байдаг нь хачирхалтай. Ер нь амиа яая гэж байгаа ядарсан хоригдолуудыг зарим агаман өөрийнхөө талд элсүүлээд өрсөлдөгчийнхөө эсрэг турхирдаг бичигдээгүй хууль байдаг юмсанж. Нямаа, Баттөмөр хоёр иймэрхүү байдлаар зургаан жилийн турш тэмцэлджээ. Гэвч хэн нь ч хэнийгээ дийлэхгүй байсаар шоронгоос сулагдсан байна. Гэтэл гурван жилийн дараа их сонин юм

болох нь тэр. Урд хөршөөс Монголд наймаа хийхээр ирсэн хоёр өвөрлөгч эр нэгдүгээр хорооллын гурван залууд арав гаруй сая төгрөгөө улаан цагаан сэгсрүүлчихжээ. Гэхдээ энэ гурван залууг танихын дээдээр таньдаг, бүр хамтарч бизнес хийдэг гээд бодчих. Өвөрлөгч эрчүүд шүүхэд хандах гэсэн боловч цаадуул нь “Та нар биднийг яагаад ч дийлэхгүй. Шүүх, цагдаад бидний хамаатан садан, найз нөхөд зөндөө байна. Та хоёр ёстой явдлын гарз болно. Нэгэнт л биднийг зодох чадал чинь хүрэхгүйгээс хойш та нарын хохь. Хүчтэний өмнө хүчгүй нь буруутай байдаг юм” гэх зэргээр даапаалжээ. Хоёр өвөрлөгч эр үнэндээ яах ч арга байсангүй. Харин тэднийг анх Монголд ирж наймаа хийхэд нь зуучилж өгсөн Эрдэнэбат хэмээх эр нэгдүгээр хорооллын гурван залуугаас хэрхэн мөнгөө салгаж авах талаар бяцхан зөвлөгөө хайрлажээ. Тэрбээр хоёр өвөрлөгч эрд хандаж “Та нар хүчирхийллээс хүчирхийлэл бий болдогийг мэднэ биз дээ. Тэр гурван хулгайчтай шүүхдэлцээд ямар ч нэмэр байхгүй. Харин тэднийг хүч чадал, зориг зүрхтэй эрүүгийн нөхдөөр дарамтлуулах хэрэгтэй. Тэгсэн цагт цаадуул чинь та нарын өмнө ёстой гөлөг болно. Өөрсдөө буруутай болохоор цагдаад хандаж чадахгүй. Би нэг үе шоронд байсан хүн шүү. Надтай хамт шоронд ял эдэлж байсан “Оцог” Нямаа, “Дэгнээн” Баттөмөр нарын хоёр гурван ч нөхөр өнөөдөр дажгүй явж байна. Тэднийг би цуглуулж чадна. Харин та нар нөгөө гурван хулгайчаас авах гээд байгаа арван сая төгрөгнийхөө таван саяыг бидэнд өгөх хэрэгтэй” хэмээжээ. Цаад хоёр нь ч мөнгөнийхөө хагас хугасыг ч болохнээ олж авья гэж бодоод дуртайяа зөвшөөрсөн байна. Ер нь олон жил ял эдэлсэн эрүүгийнхэн иймэрхүү хэрэг дээр “ажиллах” нь цөөнгүй байдаг ажээ. Эрдэнэбат хоёр өвөрлөгчийн дээрэмдүүлсэн мөнгийг олж авахын тулд тэгэхээс тэгэх гэсэн юм шиг өмнө нь хоорондоо өс хонзонтой байсан “Оцог” Нямаа, “Дэгнээн” Баттөмөр хоёрыг зориуд сонгож авсан байгаа юм. Тиймээс урьдын өс хонзонт хоёр эр таван сая төгрөг хувааж хүртэхийн тулд юу юугүй л төө зайгүй найзууд болж хувирчээ. Мөнөөх нэгдүгээр хорооллын гурван залуу өмнө нь орон шоронд орж яваагүй “цагаан захтанууд” болохоор “Оцог” Нямаа, “Дэгнээн” Баттөмөр нарын эвгүй царайг харж, аймаар үгийг сонсоод л шууд гөлөг болж хувирсан байгаа юм. За энэ ч яахав, байдаг л нэг хэрэг. Харин Нямаа, Баттөмөр хоёртой нэгэн цагт хамт ял эдэлж байсан “Одон” Хорлоо хэмээх залуу саяхан мань хоёрыг төө зайгүй найзууд болчихсон явахыг хараад эвэртэй туулай үзсэн мэт гайхжээ. “Одон” Хорлоо мань хоёрт хандаж “Та хоёр чинь хэдийдээ ийм сүрхий болчихов оо. Ер нь та хоёр наранд гарсан хойноо гар зөрүүлсэн үү” гэж асуухад Баттөмөр “Юу боллоо гэж зөрүүлэх юм бэ. Шорон гэдэг чинь новшийн газар шүү дээ. Бид хоёр наранд гарсан хойноо ганц шил юм хувааж уугаад гал хам болчихсон. Одоо архины найзууд болчихоод цохиж явна. Бид хоёрын дунд одоо хэн ч яс хаяад нэмэргүй. Төрсөн ах дүү нар шиг болцгоосон. Чи Эрдэнэбатыг мэднэ шүү дээ. Тэр л бид хоёрыг төрсөн ах дүү болгочихлоо. Биднийг сүхээр цохьсон ч салахгүй. Та нар чаддаг юм бол бид хоёрыг салгах гээд сүх бариад хүрээд ирээч дээ” гэх зэргээр марзагнажээ.

## Хянагч дэмбэрэлийг айлгаж явсан Цэвээний Бунданхүү гэгч хэн бэ?

Монголын шоронд хорь гаруй жил ял эдэлсэн Цэвээний Бунданхүү эдүгээ Тавантолгойн уурхайд хүнд даацын тэрэг жолоодоод ид мандаж байгаа юмсанж. Мань эр 1990-ээд оны эхэн үед Зүүнхараагийн шоронд ял эдэлж байхдаа Далхаагийн Дэмбэрэл гэгч хянагчтай тэрсэлдэж нэг үе Халхын шоронд нэр алдараа дуурсгаж байсан хүн. Эхэндээ тэр хянагч Дэмбэрэлийн хамсаатан болж муу муухай юм нэлээдийг хийж байсан гэдэг. Харин сүүлдээ гэнэтхэн л гэгээрээд Дэмбэрэлийн эсрэг тэрсэлж эхэлсэн байгаа юм. Гэхдээ тэр муу муухай юм хийж байсанаа хэнээс ч нууж байсангүй. Наяад оны сүүл үед Зүүнхараагийн чанга дэглэмтэй шоронгийн гал зууханд хоригдолуудын ходоодоор бохир бизнес хийх нь тоймоо алдсан бөгөөд үүнийг хянагч Дэмбэрэл зохион байгуулдаг байж. Тэр шоронгийн ахлах тогоочоор өөрийн дотны анд болох “Хуумгай” Тайван гэгчийг томилж, Цэвээний Бунданхүүг түүний туслах болгож л дээ. Тухайн үед Зүүнхараагийн шоронд мянга гаруй ялтан байж. Тайван, Бунданхүү хоёр Дэмбэрэлээс зааварчилгаа авч мянга гаруй хоригдолын нормын хүнсний ихэнхийг гадагш нь гаргадаг байсан гэдэг. Гэвч Дэмбэрэл сүүлдээ Тайван, Бунданхүү хоёрт итгэхээ байж хорих ангийн журам болох Дандар гэгч атаман хоригдолыг татан оролцуулаад зогсохгүй, хоригдолуудын зөвлөлийн дарга Намсрай гэгчийг бас оролцуулжээ. Тиймээс Дэмбэрэлийн хамаг булхайг мэддэг Тайван, Бунданхүү хоёр бараг л жийгдэхэд хүрсэн байна. Гэхдээ Дэмбэрэл мань хоёрыг арай ч хөрөө раман дээр өгчихсөнгүй. Хамаг нууцыг нь мэддэг байсан болохоор мань хоёрыг өөр хорих руу шилжүүлэх талаар хөөцөлдөж эхэлсэн байгаа юм. Тухайн үед хоригдолуудаас эргэлт ирэхэд таван кг-аас дээш юм оруулдаггүй байж. Харин Дэмбэрэл энэ журмыг өөрчилж эргэлтээр оруулж байгаа идэж уух юм, тамхи тарианд тодорхой хэмжээ заалтгүй чөлөөтэй оруулдаг болжээ. Тиймээс Зүүнхараагийн шоронд гаднаас их хэмжээний хоол хүнс, тамхи тариа, мөнгө төгрөг хуримтлагдах эх үүсвэр нээгдсэн гэдэг. Үүгээрээ Дэмбэрэл хоригдолуудын өмнө гавьяа байгуулсан хүн. Өөрөө нормт хоолноос нь хумсалж байсан болохоор арга байж уу. Тухайн үед гаднаас эргэлт чөлөөтэй оруулдаг болсоноор улаан тамхи, сахар, боов боорцог өөрийн гэсэн үнэ ханштай болжээ. Гэвч Дэмбэрэл сүүлдээ арай дэндсэн гэдэг. Мал хуйтай хоригдолын ар гэрээс хонь, үхрийн мах хүртэл шаарддаг болсон бөгөөд тэр махаар нь цуйван хийж хоригдолуудад зарж өөртөө ашиг унагадаг байж. Мань эр хоригдолуудын нормт хүнснээс шомбодохын зэрэгцээ зарим нэг бийлэгжүү хоригдолд амт чанартай тусгай хоол зардаг байсан гэдэг. Үүнийг нь Тайван, Бунданхүү хоёр гардан гүйцэтгэдэг байж. Гэвч хянагч Дэмбэрэл сүүлдээ мань хоёрыг өөрөөсөө зайлуулах маягаар шоронгийн гал тогооноос холдуулсан биш өөртөө Бунданхүү хэмээх сүрхий заргач дайсантай болж, улмаар хоригдолуудын ходоодоор бизнес хийдэг байсан бүх хэрэг нь илэрч шоронгийн тав болсон гэдэг.



## “Гяндан хүлээс”-ний эргэн тойронд

Сүүлийн үед манай хүчний байгууллагынхан “Гяндан хүлээс” гээч юмыг их хэрэглэх болжээ. Зөвхөн хүчний байгууллагынхан ч гэлтгүй энгийн иргэд ч гяндан хүлээсээр бусдыг хүлж орхидог болсон бөгөөд үүнийг урьд өмнө нь засан хүмүүжүүлэх байгууллагад хянагч хийж байсан хүмүүс нарны амьдралд нэвтрүүлсэн байхаас зайлахгүй. Өвөрхангай аймгийн харъяат Сангидорж хэмээх өвгөн энэ тухай ярихдаа “Манай аймагт малын хулгай ер тасрахаа байлаа. Зарим хулгайч өөрөө хэрэг үйлдэхийн хажуугаар өрөөлийг хэрэгт татчихдаг боллоо. Саяхан манай саахалт айлын Гунгаа гэдэг сайхан залуу гэв гэнэт л хүн амины хэрэгтэн болж хувирсан. Энэ залуу өглөө үхрээ бэлчээчихээд өдөр тийшээ үхрээ эргэхээр очтол нэг хулгайч хэдэн сайхан шарыг нь тусад нь ялгаад туугаад явж байж. “Наад үхэрнүүдээ яах гэж байгаа юм бэ?” гэж асуутал хулгайч “Замд хэдэн үхэр тааралдахаар нь чоно нохойд бариулчих болов уу гэж бодлоо. Ойрхон айл байвал дөхүүлээд хаячих санаатай явна” гэж хэлж. Тэгэхээр нь Гунгаа “Чи ч мөн айл руу дөхүүлэх байх даа. Миний хэдэн шарыг ялгаад тууж яваагаа мэдэж байна уу. Чамайг ерөөсөө цагдаад барьж өгнө” гээд барьж аваад ноцолдож гарч. Тэгээд тэр нөгөө хулгайчийг арай ядан дороо оруулаад мориных нь ногтыг мулт татаж аваад гяндан хүлээгээр хүлчихэж. Тэр гяндан хүлээ гэдэг нь толгойг нь салтаа руу нь шургуулж хүлэхийг хэлдэг юмсанж. Гунгаа түүнийг хөдөлгөөнгүй болтол хүлж орхиод манайд ирж хэлсэн. Тэгээд манай том хүүтэй цуг нөгөө хулгайчийг сумын цагдаад хүргэж өгөхөөр болсон юм. Гэвч нөгөө хулгайч дээр эргээд иртэл үхчихсэн байж. Тэр гяндан хүлээ гэдэг чинь хүний биеийн хамаг цусыг түр хугацаагаар хаачихдаг бололтой. Жаахан л удах юм бол цус нь хаагдаад үхчихдэг юм гэнэ. Гунгаа малын хулгайчийг үхсэнийг мэдэнгүүтээ над дээр яаран сандран давхиж ирээд “Нөгөө үхэр хулгайлсан хүн чинь үхчихсэн байна. Одоо яах вэ. Тэр чигт нь орхичих уу, цагдаад мэдэгдэх үү” гэж асуулаа. Тэгэхээр нь би “Хүн амины хэрэг хэзээ нэгэн цагт илэрдэг юм. Чи нууж хаасаны хэрэггүй. Хийсэн хэргээ үнэн зөвөөр нь мэдүүл. Чи ямар санаатай алчихсан биш. Цаад хүн чинь өөрөө буруутай байсан болохоор чамд бас хүндэтгэх шалтгаан бий. Одоохон явж цагдаад мэдэгд” гэж зөвлөсөн. Ингээд нэг малын хулгайч амь насаа алдаж, нэг сайхан залуу хүн амины хэрэгтэн болж хувирсан даа. Ерөөсөө тэр гяндан хүлээс гээчээс л болсон хэрэг. Энэ гайтай хүлээсийг Гунгаа өмнө нь Хархорины шоронд хянагч хийж байсан “Хорхой” Сандаг гэдэг нөхрөөр заалгасан болохоо мөрдөн байцаалтанд мэдүүлсэн байна лээ. Гяндан хүлээс гээч энэ муухай юмны оронд Гунгаа өвөг дээдсээсээ уламжлагдаж ирсэн “Тооно туших” уяагаа хэрэглэсэн бол тэр малын хулгайч амьд гарах байлаа” гэсэн юм. За яахав, өмнө нь орон шоронд хянагч хийж байсан хүмүүс гяндан хүлээс гээчийг бусдад зааж өгдөг л юм байж. Харин зарим нэг мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагч нарыг “Гяндан хүлээс”-ээр хүлж байгаад эрүүдэн шүүдэг болсон нь сонин байсан юм. Эрүүгийн хуулийг ноорог болтол нь ар өвөргүй эргүүлж тойруулж хичнээн үзсэн ч “Гяндан хүлээс” гээчийг хэрэглэх тухай ямар ч заалт олдсонгүй. Монгол улс эрүүдэн шүүлтээс татгалзах олон улсын конвенцид нэгдсэн улс юм чинь яалаа гэж хуулиндаа тийм зүйл тусгах билээ гэж зарим нэг хүн зэмлэж байна. Нээрээ ч тийм юмуу гэтэл цагдаа, хүчнийхэн тодорхой заасан орчинд, шаардлагатай үед “Гяндан хүлээс” гээчийг хэрэглэх зөвшөөрөл байдаг гэж төрийн форм өмссөн зарим хүн ЦЕГ-ын даргын зэвсэг бороохой, номхотгох цамц хэрэглэх журмыг дурдаж байх юм. Энэ журам нь эрүүгийн хуулинд тусгагдаагүй байх бөгөөд тухайн албаны дарга ажлынхаа онцлогт тохируулан гаргасан дотоод дүрэм бололтой. Номхотгох цамц, гяндан хүлээс мэт нь социализмын үед ч байж л байсан

эрүүдэлт. Хуучин ЗХУ-д төрийн машины гол мотор болж байсан КГБ болон комиссар Вышинский “Гяндан хүлээс” гээчийг хэрэглэж байсан баримт байдаг. Бүр 13-р зууны үеийн католик шашны харгис шүүх “инквизинз”-ийн үед ч номхотгох цамц, гяндан хүлгийг хэрэглэж байсан байгаа юм. Яг л хуучны ховор үнэт зүйлстэй адил зүйл бөгөөд шорон гээч зүйл анх бий болсон цагаас эхлээд өнөөг хүртэл харгалзагч хуягуудын гарт зэвсэг болсоор яваа үнэнч “туслах” нь гэхэд болно. Соц нийгмийн үед гяндан хүлгийг зөвхөн алах ял заагдсан хүмүүст л аргагүй тохиолдолд хэрэглэж байсан гэдэг. Яахаас ч буцахгүй шийдсэн гэмт хэрэгтэнүүдийг л ийм аргаар буулгаж авдаг байж. Харин жирийн нэг сэжигтэнийг “Гяндан хүлээс” гээчээр залхаан цээрлүүлээд байх нь утгагүй юм. Ингээд гяндан хүлээстэй холбоотой нэгэн хэргийн тухай өгүүлье. Хөдөөний нэгэн суманд боловсролгүй малчин эр архи уугаад агсам согтуу тавьж нэлээд дүвчигнэсэн ажээ. Хэсгийн төлөөлөгч нь түүнийг барьж авчраад паарнаас гавлаад хаячихаж. Согтуу л хүн болсон хойно мөнөөх эр хуурай агсам тавьж гарч дээ. Тэгтэл өөрийн ухаангүй хүний үгэнд учиргүй эмзэглэсэн цагдаа нөгөө эрийг “Яасан овоо муу новш вэ. Хулхийг чинь нам буулгаад өгье л дөө” гэж занасаар гяндан хүлгэнд оруулж “амьтан” болгоод орхисон байна. Зүгээр ч хүлээд орхисонгүй. Дээр нь гишгэн чангалж орилуулаад л бах таваа хангасан байгаа юм. Энд нөгөө тусгай журмаа хэрэглэх ямар гээч айхтар зөрчил гаргасныг хэлэхэд хэцүү. Агсам тавьсан согтуу хүн бүхнийг гяндан хүлгэнд оруулж байх ёстой гэсэн маш хатуу журам батлагдаагүй л баймаар юм. Гэтэл ганц энэ ч биш өнөөдөр манай захын нэг эрүүлжүүлэх байранд л шөнө болгон үгэнд ороогүй ганц хоёр согтуу хүнийг заавал гяндан хүлээсэнд оруулж эрүүдэн шүүлтийн маягаар залхаан шийтгэдэг нь “мода” болсон гэхэд хилсдэхгүй. Тэд архи хэтрүүлсэн жирийн л иргэд болохоос биш хүн алж хүрээ талчихсан эрүүгийн гэмт хэрэгтэнүүд биш шүү дээ. Манай цагдаа нар “гяндан хүлээс” хэтрүүлэн хэрэглэснээс болж хүний амь насанд хүрч байсан гашуун тохиолдолоосоо сургамж аваагүй л байгаа бололтой. Хүний цусан хангамжийг бүрэн боож багладаг уг хүлэг нь даралт ихтэй, бие муутай хүнийг бол ядах юмгүй нөгөө ертөнцөд аваачаад хаячихна. Төрийн гянданд хүртэл үймээн дэгдээсэн хоригдолыг ийм хүлээсэнд оруулахдаа таван минутаас хэтрүүлэлгүй буцааж сулладаг юмсанж. Эс тэгвэл аяндаа цусны эргэлт нь хаагдаад хичнээн залуу чийрэг биетэй хүн байсан ч амьсгал хураадаг ажээ. 1990-ээд оны үед Авдрантын гянданд нэг харгалзагч өс хонзонтой хоригдолоо гяндан хүлээсэнд оруулж хэтэрхий удааснаас амийг нь бүрэлгэсэн хэрэг гарч бөөн хэрэг дэгдэж байлаа. Гэвч түүнийг эмчийн магадлагаагаар уушигны өвчнөөс болж үхсэн гэдэг онош гаргаад л хав дарчихсан тухай учрыг мэдэх хүмүүс ярилцдаг юм билээ. Харин үүнээс хойш нэг хэсэг гяндан хүлээсийг хориглох тухай яриа гарч байсан ч ажил хэрэг болж чадаагүй гэдэг. 2000 оны үед Налайх дүүрэгт гяндан хүлээстэй холбоотой нэг том хэрэг дэгдэж байлаа. Ганбат, Амгаланбаяр хэмээх хоёр залуу нэг өдөр бааранд орж ганц ганц аяга пиво уучихаад гарч яваад гурван цагдаатай тааралджээ. Тэдний дотор Амгаланбаярын танил Түвшин гэдэг цагдаа явж байсан бөгөөд хоёр залууг халамцуу явсан болохоор цагдаа нар барьж хорино гэх мэтээр жаахан сүрдүүлсэн юм байх. Тиймээс хоёр залуу тэдэнд дэлгүүрээс нэг шил архи авч өгөөд салахын түүс болжээ. Гэвч Түвшинтэй хамт явж байсан Буян, Энхболд хоёр “Бид ганцхан шил архинд хууртагдах улс биш шүү” гээд хоёр залууг баар луу дагуулж орсон байна. Энэ үед Амгаланбаяр “Та нар төрийн формтой явж байгаа болохоор хамаагүй архидаж болох юмуу” гэхэд цагдаа Энхболд “Чи муу одоо юу яриад байна аа. Налайхын довон дээр би л дуугарна” гэж агсамнаад Амгаланбаярыг зодож эхэлжээ. Ганбат найздаа туслан тэднийг болиулах гэтэл цагдаа Буян /нохой сургагч/ дагуулж явсан нохойгоороо Ганбатыг уруулаад зогсохгүй гяндан хүлээсээр хүлээд төмөр сандалаар нүүр нүдгүй балбасан байгаа юм. Ганбатыг “Нохойгоо

аваач ээ” гэхэд гурван цагдаа шоолж инээлдэж байсан гэдэг. Тухайн үед хохирогч Ганбатын ээж ярихдаа “Нохой нь хүүг минь юу ч үгүй сэглэж, өөрсдөө тахтай гутлаар нүүрнийх нь ясыг цөм өшиглөж, Амгаланбаярын хоёр хөлийг тениэр түлж тамласан байсан. Ямар ч гэмгүй хоёр хүүхдээс өөрсдөө архи нэхээд, зөв шаардлага тавьсных нь төлөө ингэж тамлаж зугаацна гэдэг эрүүл хүний хийх ажил биш. Төрийн хувцас өмссөн цагдаа нар ийм дорой ухамсартай байна гэдэг дэндүү харамсалтай. Эдний балгаар хоёр сайхан залуу тахир дутуу болоод хоцорлоо. Хүү маань ухаан орохгүй хоёр, гурав хоносон. Эмнэлэгт ирэхэд хэвлийн хөндийн хагалгаа хийлгэж, сэмжээ тайруулсан. Мөн цусан хавдар авахуулсан. Венийн гурван судас тасарсаныг нь залгуулсан. Эдгээр гэмтэл сэтгэцэд нь нөлөөлж одоо хүү маань орон гаран ухаантай, зүрх нь байн байн зогсдог, эрэмдэг хүн болсон доо. Амгаланбаяр нь доголлон, хоёр суга таягтай үлдсэн. Миний хүү “Ай Кей Эйч” ХХК-д худалдааны менежер хийдэг байсан. Одоо ямар ч ажлын чадваргүй хүн болсон. Хэрвээ хүүг минь сайхан эмчлүүлээд өгчихсөн бол би тэр гурван цагдааг шоронд хатаагаад өгөөч гэж хаанаас гуйж, уйлж суух билээ. Даанч миний хүүг хүн гэж үзэхгүй зодож тамлан адгууснаас дор авирласанд нь гомдоод байгаа юм. Миний хүү надад “Ээж ээ төрийн форм гэдэг чинь далайсан гарыг өөрийн эрхгүй буулгадаг юм билээ” гээд уйлаад ярьж байсан” гэж хэлээд нулимс дуслуулж билээ. “Тоон дотор үсэг цохиж явна” гэгчээр энд тэндхийн цагдаагийн газар, хэлтэсүүдэд Түвшин, Буян, Энхболд нар шиг “хүн сүгнүүд” мэр сэр байж л байгаа. Гяндан хүлээстэй холбоотой хэрэг зөвхөн үүгээр дуусахгүй. Хөдөөгийн нэгэн суманд хэдэн цагдаа архи ууж агсам тавьсан залууг айлгаж номхруулах гэж гяндан хүлэг хийчихээд захиргааны байшингийн мухрын өрөөнд оруулаад хаячихаж. Гэтэл яг тэр үеэр өөр нэг газар хэсэг танхай залуус хутга барьчихсан дэвж байна гэсэн мэдээлэл ирмэгц бүгд яаравчлан хөдөлжээ. Нөгөө мухрын өрөөнд хүлээтэй орхисон залууг хэн ч санасангүй. Танхайрсан согтуучуудыг номхруулж авчрах гэсээр байтал бараг бүтэн цаг өнгөрчээ. Захиргаан дээр авчирч бүгдийг нь холбож гавласны дараа гэнэтхэн нөгөө хүлээстэй нөхрийг санаж мухрын өрөө рүү яаран харайлгасан боловч цаадах нь аль хэдийнэ мод шиг хөшчихсөн байж. Тэр үед л юугаар тоглосноо гэнэтхэн сэхээрч “Чи хүлсэн, үгүй чи” гэх мэтээр бие бие рүүгээ чихэж эхэлсэн ч хэн нь ч энэ хэргээс мултралгүй бүгдээрээ “аавын” хаалга татаж байсан гашуун түүх бий. Өнөөдөр манай цагдаа нар болж л өгвөл ялихгүй зөрчил гаргасан хүмүүсийг гяндан хүлээсэнд оруулж хашраах гээд байгаа нь мэргэжлийн гаж дон мэт санагдах боллоо. Гав, бороохой хоёр байхад л агсам согтуу хүмүүст хангалттай юм биш үү? Аягүй бол хэн нэг ондоо цагдаа согтуу хүнийг гяндан хүлээсэнд оруулан тарчлааж буйг хараад өөрөө ч бас ийм зүйл хийж үзмээр сэтгэгдэл төрдөг байж болно шүү дээ. Фрейдийн онолд мэргэжлийн онцлогоос шалтгаалсан иймэрхүү гаж дон хүнд аяндаа бий болж эцэст нь гэмт хэрэг хүртэл хийлгэдгийг тодорхой баримтаар дурдсан байдаг. Ялангуяа хүчний байгууллагад, тэр дундаа шоронд хянагч хийж байсан хүмүүс насны эцэс гэхэд ямар нэгэн садист маягийн шинжтэй сэтгэцийн өвчнөөр өвчилдөг юм гэсэн. Иймээс хууль хяналтын байгууллагад ажилладаг хүмүүсээ тушаал биелүүлдэг робот талаас нь биш хүн гэдэг талаас нь үзэж өдөр бүр сэтгэл зүйн хичээл зааж баймаар санагдах юм. Гэтэл ийм ч зодуур хэрэглэж болно, тийм ч хүлээс, бороохой хэрэглэх ёстой гэсэн хатуу албадлагын хуулиар тархийг нь тэсэртэл угаагаад, гарт нь зөвшөөрөгдсөн зэвсэг атгуулаад л гудамжинд гаргаж байна. Тэд цагдаагийн даргын зөвшөөрөлтэй тусгай журмыг “Монгол цагдаа” шүлэгнээс ч илүү бүтнээр нь цээжилчихээд биеэ авч явах чадваргүй болтолоо согтсон иргэдээр гарынхаа шүүсийг тарааж байгааг хэн хүнгүй мэднэ. Гэвч ийнхүү зөвшөөрлийн дагуу хүмүүсийг залхаан цээрлүүлж, гяндан хүлээс мүлээс хэрэглэж байгаад гэнэ алдан хүний аминд хүрчихвэл тусгай журам баталсан цагдаагийн дарга хариуцах уу, эсвэл тушаал

журмаа биелүүлсэн цагдаа нь хариуцах уу? Энэ асуултанд жирийн нэг эргүүлийн цагдаа “Бид яг хариуцаж харагдаач” гэж хариулсан юм. 2008 оны 7-р сарын нэгний орой цагдаа нар таван хүн буудаж алчихаад өнөө хэр ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байгаа нь ч үүнтэй холбоотой. Эрүүл саруул ард иргэд рүүгээ хүйтэн зэвсэг чиглүүлээд хэнэг ч үгүй гал нээж байгаа цагдаа нар согтуу хөлчүү архичид болон зэрлэг танхай гэмт этгээдүүдэд “Тяндан хүлээс” гээчийг хэрэглээд амийг нь хөнөөх наад захын хэрэг шүү дээ.

## Янхан хүүхнийг бүтэн шөнөжин эдэлж хэрэглээд гурван жилийн ялаар “шагнуулсан” эр

*Шоронгоос оргосон ялтан бүрийн оргосон учир шалтгаан янз бүр байдаг. Тэдний ихэнх нь “Зүгээр л оргооор санагдаад оргочихсон юм” гэж өчдөг аж. Харин энд өгүүлэх Равдангийн Мөнгөнхөлөг гэгч ялтны хувьд арай өөр байх шиг. Ингээд түүний оргосон шалтгааныг өгүүлье.*

Хорих ангийн жижүүрийн ээлжийнхэн өглөө тоо авахад мужааны цехэд ажилладаг хоригдол Р.Мөнгөнхөлөг алга болсон байж. Унтчихсан байж магад гээд мужааны цехийн нэг талаас нөгөө тал хүртэл нэгжсэн боловч байсангүй. Харин ойролцоох ширээнээс гурван хуудас дүүрэн юм бичсэн цаас олджээ. Уг захианд “Энд ял эдлэхэд үнэхээр хүнд байна. Яагаад гэвэл зөрчил гаргасан хэн нэгэн хоригдолын өмнөөс бусад нь дэглүүлж шийтгүүлдэг. Хориг-долын хамт олны зөвлөлийн хэдэн овгор хоригдол энэ байдлыг далимдуулан өөрсдийн ноёрхолоо тогтоох гэж бусдыг дарамталж байна. Ийм байдлаар ямар нэгэн зөрчил гаргасан хоригдол албаны зүгээс шийтгэгдэхээс гадна хамт олны зөвлөлийнхөнд аймшиг-тайгаар дэглүүлдэг. Эцэст нь “Чамаас болж бид дэглүүллээ” гээд бусад хоригдолууд ад үзэж элдвээр дарамталдаг. Зоонд байгаа хоригдол сэтгэл тайван байх арга байхгүй. Одоо хэн нь зөрчил гаргаж биднийг дэглүүлдэг бол гэсэн байнгын түгшүүртэй байдаг. Тиймээс би энд байхыг хүссэнгүй. Миний араас эрэл болж битгий шуугиан дэгдээгээрэй. Би тайван явж байгаад баригдмаар байна. Араас ирвэл эвгүй юм болно шүү. Баригдвал би эргээд очихгүй, өөр шоронд очно. Чанга юмуу, онцгойд очсон ч яадаг юм бэ. Ер нь манай зооноос хэд хэдэн новшийн ялтаныг зайлуулж чанга дэглэмд шилжүүлэх хэрэгтэй. Тухайлбал Зүүн-хараагийн Бадрал, “Хоовон” Галбадрах, Идэрийн Ганболд, Жанчивын Өсөхбаяр, “Могой” Түмэнцогт зэрэг ялтаныг зайлуулахгүй бол хүн амины хэрэг ч гарч мэднэ. Эд нар хянагч нартай хуйвалдаж эсэн бусын юм хийдэг. Өөрсдөө хоригдол мөртлөө бусад хоригдлуудын эрх ашгийг хэтэрхий боогдуулж “Та нар эрх чөлөөгүй ялтанууд” гэж заналхийлдэг. Эд нар ядарсан хоригдлуудыг шөнө унтуулдаггүй. Ийм хэцүү газар би удаан тэвчиж чадахгүй болоод л оргосон юм” гэсэн байж. Мөнгөнхөлөг ажлаа хийж байснаа эргүүл манааны эгзэгийг тааруулан ажлаа орхин голын бургас чиглэн шөнийн түнэр харанхуйд уусах мэт алга болжээ. Тэгээд тэр шөнөдөө бургасанд хонож, өглөө нь голоо дагаж явсаар төмөр замын 53-р зогсоол хүрч бургасанд өдөржин нуугджээ. Ингээд бүрий болмогц өртөөний нэгэн жорлонд орон сууж байгаад шөнийн суудал ирүүт хамгийн арын вагоноос зүүгдэн авирч гараад Эмээлт дээр бууж хотыг зүглэн алхжээ. Ингэж явсаар 22-ын товчооны орчимд аргал түүж явсан нэг эмгэнтэй тааралдаж үнэнээ хэлж тэднийд очиж цай хоол хийлгэж идээд Улаанбаатар луу зүглэжээ. Оройхон нь хотод ирж Таван шарын нэг байрны орцонд хонож маргааш нь хотын төвөөр баахан тэнэсэн боловч таньдаг хүн тааралдаагүй байна. Эмэгтэй хүнтэй удаан хугацаагаар хавьтаагүй тэрбээр хэн нэгэн эмэгтэйг хүчирхийлэхээр шийдсэн байна. Тэгээд “Улаанбаатар” зочид буудлын өмнө ирж нэг янхантай хоногийн арван мянгаар тохиролцжээ. Гэвч түүнд мөнгө байхгүй тул ямар нэгэн арга хэрэглэхээр шийдэж “Манай ахынх Зурагтын дэнжид байдаг юм. Одоо эзгүй байгаа. Хоёулаа тийшээ очиж хоноё. Тэнд очоод мөнгийг чинь өгье” гээд нэг түлхүүр үзүүлтэл цаадах нь түүнд итгээд зөвшөөрсөн байна. Ингээд түүнийг Зурагтын дэнж рүү дагуулаад явжээ. Тэгтэл Мөнгөнхөлөг Зурагтын дэнжийн айлуудын хамгийн арын гудманд очоод мөнөөх янханд хутга тулгаж “Би шоронгоос оргож яваа ялтан

байна. Олон юм ярилгүй дагаад яваарай” гэж зандраад түүнийг дагуулан Далан-давхарын оршуулгын газар луу зүглэжээ. Тэгээд хойд талынх нь уулан дээр очоод мөнөөх янханы хамаг хувцсыг тайлж байгаад эдэлж гарсан байна. Янхан бүсгүй түүнд хууртагдсанаа мэдэнгүүт түүний гараас амьд гарахыг л эрмэлзэж хэлсэн болгоныг нь гүйцэлдүүлжээ. Мөнгөн-хөлөг түүнийг бүтэн шөнөжин эдэлж хоноод өглөө нь хөөж явуулсан байна. Тэгээд тэр Зурагтын дэнжид байх ахындаа ороод “Ёох, арай гэж нэг юм шоронгоос суллагдлаа. Дахиж л тийшээ зүглэх юм биш. Ёстой хэцүү газар байна” гэж хэлээд л нам унтаад өгчээ. Гэвч ердөө гуравхан цагийн дараа түүнийг хоёр хянагч халуун хэвтрээс нь гавлаад авчээ. Учир нь Мөнгөнхөлөг ахынхаа гэрийн хаягийг ялтануудын дэлгэрэнгүй бүртгэл дээр үнэн зөвөөр тэмдэглүүлсэн байж. Шоронгоос оргосон энэ хэрэгтээ тэрбээр гурван жилийн ял нэмүүлжээ. Нэг ёсондоо мань эр янхан хүүхнийг бүтэн шөнөжин эдэлж хэрэглээд, гуравхан цаг бөх гээч унтаж нойрсоод л гурван жилийн ялаар “шагнуулсан” байгаа юм.

## Ялтан Бундаагийн хараалаар ахмад

### Дашхорлоо өөд болсон байж болзошгүй

*Халхын шоронд зарим хянагч, дарга нар ялтануудад сайнаар үнэлэгдэж байсан бол зарим нь ихэд муугаар үнэлэгдсээр өнөөг хүрчээ. Тухайлбал нэгэн цагт Авдрантын онцгойд алба хашиж байсан Дашхорлоо хэмээх ахмад олон ялтаны хараалыг идсэн байдаг. Ингээд мань ахмадын талаар Чойрогийн Дүгэрээгийн ярьсаныг сийрүүлье.*

“1980-аад оны дунд үед намайг Авдрантын гянданд ял эдэлж байхад манай камерт Баянхонгор аймгийн Богд сумын харъяат Логоогийн Жаргал гэж хүн амины хэрэгтэй, 15 жилийн ялтай залуу хамт хоригдож байлаа. Мөн Төв аймгийн харъяат Гэрлийн Цэрэндорж, Дорнод аймгийн харъяат Сүхбаатарын Галсүх нар хамт байсан. Тэр үед Авдрантын шоронд шимтгэл гэж юм анх нэвтэрч байсан. Тэр нь юу гэвэл ялтануудын ар гэрийнхэн эргэж ирэхэд нэрийн дансанд нь мөнгө хийлгэдэг, улирал болгон арван төгрөгний юм авч өгдөг байлаа. Нөгөөдүүл маань эргэлт тойролттой, арван төгрөгтэйгөө, харин цааз ялнаас мултарсан би юу ч байдаггүй. Садан төрөл муутай, эргэлт тойролт харьцангуй байхгүй шахуу хүн чинь ямар юмных нь нэрийн дансны мөнгөтэй байх билээ. Надтай хамт байсан гурван хүний нэг нь гарч шимтгэл авахдаа гурван хүний гучин төгрөгөнд арваад кг боорцог авчраад хуваагаад идчихнэ. Надад тэрнээсээ өгөх ч үгүй, харуулж байгаад л идчихдэг байлаа. Дарга нар орж ирээд тэдний авсан юмыг харчихаад “Дүгэрээд өгсөн үү” гэж асуухад нэгэн дуугаар баясгалантай нь аргагүй “Өгөөгүй” гэж чангаар хэлнэ. Яагаад гэвэл тэд засангийн дарга нар Дүгэрээд муу гээд ойлгочихсон. Ер нь тэд “Бид нар Дүгэрээд сайн байгаад байвал эд нар биднийг шийтгэнэ. Тэгэхээр Дүгэрээд муу л байгаад байвал энэ дарга нар биднийг яах ч үгүй” гэсэн ойлгоцтой байсан. Нэг өдөр тэднийг шимтгэл авч байх үед Жаргалсайхан гэгч ахмад орж ирээд “Шимтгэлээ бүгд авсан уу. Дүгэрээд өгсөн үү?” гэхэд нөгөөдүүл урьдын адилаар “Өгөөгүй” гэж нэгэн дуугаар өчсөн. Тэгтэл Жаргалсайхан ахмад учиргүй уурлаж “Та нар ч ёстой хүн юм даа. Манай бусад дарга нар Дүгэрээг гадуурхдаг бол би харин үгүй шүү. Та гурав наад хүндээ ядаж ганц ганц боорцог өгчихөж болсонгүй юу. Адилхан ядарч зүдэрч байж нэгэндээ харуулж байгаад идэж яаж чадаж байна аа. Би гурван өдөр та нарыг ажиглалаа. Засаг бас хүнээ харж үздэг юм шүү. Алив Дүгэрээ аягаа аваад гараад ир” гэдэг байгаа. Тэгээд намайг дагуулж яваад бүр наймын хувинтай хоол өгч “За идээд бай” гэсэн. Гэвч гянданд олон сар суугаад ходоодоо агшаачихсан хүн чинь нормынхоо засаг цагаан тавгаар хоёр идээд л болчихож байгаа юм. “Би үүнийг идэж дийлэхгүй нь ээ, өрөөндөө аваачаад нөгөөдүүлдээ өгчихье” гэсэн чинь “Тэд нарт өгч яах юм. Гэхдээ чи энэ хоолыг өрөөндөө аваад ор. Гэдэс гүзээ чинь эвгүйтэх шинжтэй болбол жорлонд хийгээд усыг нь тагчихаарай. Цаадулдаа битгий өгөөрэй” гэлээ. Би нөгөө хоолыг өрөөндөө авч ороод “За, хамуудаа, надад хувин хоол өглөө. Би үүнийг барах ч үгүй юм байна. Та гурав хөрөхөөс нь өмнө ид” гэж хэлж дуусав уу, үгүй юу л нөгөө гурав чинь гялс дайраад бүгдийг нь хоосолж орхисон. Тэгсэн орой тийшээ Логоогийн Жаргал “Гэдэс эвгүй болчихлоо” гээд л жорлон руу гүйлгэж эхэлсэн. Ер нь Логоогийн Жаргал их өөдгүй эр л дээ. Олон арван ялтаны зүрхэнд шар ус хуруулдаг байсан Дашхорлоо гэгч ахмадын бууны нохой байсан юм. Энэ Дашхорлоо намайг нэг нүдээрээ ч үздэггүй байлаа. Намайг өчүүхэн төдий хэрэгт холбогдох л юм бол шууд л сахилгад хийчихдэг байсан. Өвлийн нэг өдөр биднийг гадаа нарлаж байтал уулнаас

хүүхдүүд гулгаад, орилолдоод чарлалдаад ирсэн чинь Логоогийн Жаргал “Пөөх. Хүүхдүүд байна шүү дээ” гээд л учиргүй гайхдаг байгаа. Тэгэхээр нь би “Чи одоо тэнэг юмуу хаашаа юм бэ. Аятайхан бай л даа. Хүн амьдардаг газар хүүхэд байдаг л биз дээ. Юунд нь ингэж хашгичаад байгаа юм бэ. Хүүхэд харах сайхан л даа, харин хашгичих ямар хэрэг байна” гээд хэлчихгүй юу. Тэгтэл Логоогийн Жаргал энэ үгийг дараа нь мушгиж матаад сүйд хийх шахсан. Нэг өдөр Дашхорлоо ахмад манай камерт орж ирээд хоол өгөхдөө Логоогийн Жаргалыг ямар нэгэн юм мэдэгдэх болов уу гэсэн янзтай түүн рүү их л нухацтай харлаа. Тэгтэл Жаргал нээрээ л нууц юм хэлэх гэж байгаа аятай нүүр амаа нууцаар хөдөлгөөл явчихсан. Дашхорлоо ахмад ч ойлгов бололтой “Жаргал чи тавагаа аваад гараад ир” гэлээ. Жаргалыг тавагаа аваад гарсан байхад цаадах нь ходоодыг нь ёстой бондойлгоно шүү дээ. Тэгээд л “Дүгэрээ юу ярьж байна” гээд янз бүрийн юм асуудаг байсан байгаа юм. Маргааш нь намайг харуул хамгаалалт эрхэлсэн орлогч дарга Доржсүрэн дэд хурандаа өрөөндөө дуудууллаа. Яваад ортол нярав, нягтлан, мастер, техник энэ тэр гээд 20-иод хүн цуглачихсан, сандлууд дээрээ багтахгүй чихээд сууцгаачихсан байлаа. Дашхорлоо ахмад түрүүлж ам нээгээд “Энэ Дүгэрээ гэдэг ялтан байнга зөрчил дутагдал гаргаж байдаг. “Ганц худаг”-ийн гянданд байхдаа ч олон зөрчил гаргасан. Энд ирээд засарч хүмүүжсэн юм ер алга. Ялтануудад чи бидний тухай юу гэж ярина гэнэ ээ. Шударгаар ярь” гэлээ. Тэгэхээр нь би “Юун зөрчил вэ. Би ямар ч зөрчил гаргаагүй. Номын дагуу л байж байгаа шүү дээ” гэсэн чинь Дашхорлоо ахмад “Ингээд хэргээ хүлээдэггүй хүн байгаа юм. Юу гэж ярьсаныг нь уншаад өг” гэхэд нэг сурган хүмүүжүүлэгч босоод зөрчлийг маань уншлаа даа. “Ялтан Дүгэрээ өчигдөрийн нарлагааны үеэр ялтан Логоогийн Жаргалд их хачин юм ярьсан байна. Уулан дээр хүүхдүүд чаргаар гулгаад тоглож байсан чинь тэднийг харсанаа “Засангийн яргачдын хүүхдүүд тоглож байна. Эд нар бол ирээдүйн яргачид” гэж ярьсан байна” гэдэг байгаа. Тэгтэл тэнд байсан нярав нягтлан, мастер бүгд л “Өө ямар зэвүүн амьтан бэ. Наадах чинь ёстой зэвүү хүрмээр новш юмаа. Гуч хоног сахилгад хийчих” гэж бүгд хашгиралдаад намайг сахилгад 30 хоног хийчихэж байгаа юм. “Жаргал намайг гүтгэж байна. Би ингэж хэлээгүй” гэж хичнээн хэлээд миний үгийг тэд өчүүхэн ч авч хэлэлцээгүй. Дашхорлоо ахмад сахилгад байгаа намайг эргэх тоолондоо арав хорин удаа ташуурддаг байсан. Миний нуруу бүр сүүлдээ мэдээгүй болсон. Нэг удаа өвдөхийн эрхэнд түүн рүү эргэж хараад “Одоо болох юм биш үү” гэсэн чинь гар бөмбөг тоглоход сеткэн дээгүүр үсрээд цохидог шиг үсрээд л ташуураа далайж билээ. Тэр дүр зураг миний санаанаас ер гардаггүй юм. Тэгээд миний нүүрэн дундуур ороолгож байгаа юм. Сүүлдээ би цементэн шалан дээр түрүүлгээ харж хэвгээд босох тэнхэлгүй болсон. Тэгсээр байгаад сүүлдээ ядраад нам унтчихаж. Нэг сэрсэн чинь төмөр хаалга дуугараад хүн ороод ирлээ. Толгойгоо өндийлгөөд харсан чинь түрүүгүй гутал харагддаг юм байна. Тэгэхээр нь би гаднаас л ирсэн хүн байна, прокурор ирж байгаа юм болов уу гээд дээшлүүлээд харсан чинь монгол дээлийн хормой харагдлаа. Ямар сонин юм бэ гээд дээшлүүлээд харсан чинь Дашхорлоо ахмад зогсч байлаа. Тэр шөнө Цэмбэл гэдэг ахлагч ээлжтэй байсан юм. Хүн чанар сайтай, их сайхан сэтгэлтэй ахлагч л даа. Энэ хүн миний аминд олон ч удаа орж тус болсон. Ер нь албаны хүмүүс бүгдээрээ надад муу байгаагүй л дээ. Тэдний зарим нь “Аятайхан байгаарай Дүгэрээ. Амьд байхыг бодно шүү. Чамайг хөлөөр чинь биш нуруугаар чинь гаргана гэж ам тангараг тавьсан хүн удирдлага дотор байгаа шүү. Тэгэхээр хор байна, шар байна, амьд гарна шүү, хичээгээрэй” гэж захидаг байлаа. Дашхорлоо ахмад тэр шөнө Цэмбэл ахлагчид хандаж “Энэ муу Дүгэрээ новшийг би сая үхчихэж гэж зүүдэллээ. Тэгээд нээрээ үхчихсэн юм болов уу гэж бодоод очиж үзмээр санагдаад яваад ортол муу новш чинь толгой нь хөдлөөд амьд байна шүү” гэж ярьсан байгаа



юм. Нэг өдөр миний хажуу талын өрөөнд Батсүмбэрийн гаралтай Бундаа буюу Буяндэлгэр гэдэг ялтаныг авчраад хийчихсэн. Үүний дараахан Дашхорлоо ахмад орж ирэнгүүтээ намайг ташуураар баахан ороолгоод, дараа Буяндэлгэрийн камерт орж түүнийг ороолгож эхэлтэл “Яргачин Дашхорлоо намайг аллаа. Новшийн муу яргачин чи тун удахгүй үхнэ. Би чамд хараал хийнэ” энэ тэр гээд бөөн юм болсон. Дашхорлоо түүнийг баахан нүдэж аваад гарч одсон. Тэгсэн чинь яасан гээч. Кино үйлдвэрт жолооч хийж байгаад хүн амины хэрэгтэй орсон Батмэнд гэдэг ялтан маргааш орой нь сахилгын байрны ялтануудад хоол өгч явахдаа “Дүгэрээ би чамд их сонин юм дуулгая. Чи энэ мэдээг сонсоод баярлана даа. Дашхорлоо ахмад өнөө өглөө үхчихсэн шүү дээ” гэдэг байгаа. Тэгэхээр нь би “За чи зүгээр байгаарай. Ингэж хэлвэл Дүгэрээ баярлах нь уу, яах нь вэ гэж зориуд цаанаасаа даалгавартай ярьж байгаа юм биш үү. Наадах чинь тоглоом биш шүү” гэсэн чинь “Үгүй, үгүй. Яг үнэн. Цаадахын чинь бие өчигдөр оройноос хойш муудаж байсаар өнөө өглөө үхчихсэн. Гэв гэнэт харвачихсан. Өчигдөр орой эмч нар ирж үзээд хааш нь ч хөдөлгөж болохгүй гэсэн боловч өглөө нас барчихсан” гэдэг байгаа. Гэсэн ч би итгээгүй. Тэр үед “Морин толгой” Баяржав надтай хамт хоригдож байсан юм. Яагаав нөгөө ченж Баасансүрэнг алсан хэрэгт холбогддог Баяржав шүү дээ. Баяржав тухайн үед Дашхорлоо ахмадын бууны нохой байсан юм. Тэгсэн Баяржав “Дашхорлоо ахмадыг үхсэнийг сонсоод таны бах чинь ханаж байна уу” гэж үг өдлөө. Би бодлоо. “Дашхорлоо ахмад үхээгүй байвал яана. Эд нар намайг туршиж байгаа ч юм билүү хэн мэдлээ. Бах маань ханалаа гээд хэлчихвэл энэ сахилгаас энэ насандаа гарч чадахааргүй юм болно” гэж бодоод “Юунд нь бах ханах вэ дээ. Хэрэв үхчихсэн байлаа гэхэд дөч орчим насны эр хайран л байна. Бид хоёрын муудалцах бол нэгнийгээ үхүүлэхийн дайны муудалцаан биш шүү дээ. Эр хүнд байдаг л нэг юм. Яахав намайг ядарч байх үед дээрэлхээд байдагт нь жаахан гоморхдог л юм. Өөр юу байхав. Дөнгөж дөч шүргэж байгаа эрүүл саруул сайхан ахмад арай нас бараагүй байлгүй дээ” гэж манжиллаа. Тэгтэл “Морин толгой” Баяржавын ааш зан аль хэдийн эргэчихсэн аятай “Цаадах чинь үхсэн нь үнэн байх аа. Өчнөөн олон аавын хүүгийн мууг үзсэн юм чинь үхсэн байлгүй” гэж хэлж байгаа юм. Дашхорлоо ахмад үнэхээр нас барчихсан байсан л даа. Тэрнээс хойш яагаад ч юм бэ, миний хувь заяанд эргэлт гарсан. Намайг хавчиж шургаад, дарлаж дээрэлхээд, зовж зүдэрч байхад минь дарамтлаад, үхүүлэх гэж оролдоод байсан хүн гэв гэнэт байхгүй болчихсонд сэтгэл маань нэг л хөнгөрөөд явчихаж билээ.

## Шоронгоос суллагдсан этгээдүүд Азийн гэмт хэргийн ертөнцөд хөл тавих нь их боллоо

Манай улсын зарим нэг дээрэмчин нутаг орондоо байж суух газаргүй болоод харь нутагт очиж элэг нэгтнээ дээрэмддэг болсоор удаж байна. Хилийн чанадад ажиллаж амьдарч байх үедээ гэмт хэрэгт холбогдон харь орны шоронгийн хаалга татах явдал сүүлийн хэдэн жилд эрс өсчээ. Харь нутагт дээрэм тонуул хийж танхайрсан, хулгай зэлгийг сэрдэгдсэн, хүний амь нас бүрэлгэсэн, хориотой наймаанд хутгалдсан зэрэг онц ноцтой хэрэгт холбогдсон таван зуу гаруй хүн тухайн улсын хуулиар шийтгүүлэн шоронд хоригдож байгаа юмсанж. Тэр дундаа ОХУ, Герман, Польш, Бельги, Солонгос, Хятад, Сингапур зэрэг улсад байгаа монголчууд янз бүрийн гэмт хэрэгт холбогдох нь ихэсчээ. Ер нь Монголын шоронд ял эдэлж байсан этгээдүүд суллагдаад харь орон руу гарах нь их болсон бөгөөд тэд аль нэг улсад очоод ажиллаж амьдрахыг урьтал болгожгүй дээрэм тонуул, хүн амь, хүчин, хулгай зэлгийг хийхийг л эрхэм болгодог аж. Тухайлбал Солонгост ажиллаж байсан Л гэдэг эмэгтэй хамтран амьдрагч Т.Баярхүү /Энэ этгээд Монголын шоронгоос суллагдаад Солонгос руу бараг л дүрвэсэн бололтой/ гэдэг залуугийн гарт амиа алджээ. Л-ийг амиа алдсаны дараа Т.Баярхүү цагдаа-гийнханыг дуудаад “Найз бүсгүй маань угаартчихлаа” гэж мэдүүлсэн боловч Солонгосын цагдаа-гийнхан гадны нөлөөтэй болохыг тогтоосон байна. Бүсгүйг амиа алдсан орой хамт байсан Т.Баярхүүг баривчлан шалгахад тэрбээр түүний амийг хөнөөсөн болохоо хүлээжээ. Тэр Солонгосын цагдаа нарт мэдүүлэхдээ “Бид хамтран амьдраад багагүй хугацаа өнгөрсөн. Гэвч талийгаач надаас өөр хүмүүстэй уулзаж намайг их зовоодог байсан. Би сүүлдээ аргаа бараад хашраая гэж шийдээд айлгах гэсэн юм. Гэтэл угаартаад үхчихлээ” гэж хэнэг ч үгүй өчсөн байна. Тэрбээр талийгаач эмэгтэйн гар хөлийг хүлээд хөхөвч, оймс, дотуур өмд зэргийг нь шатаажээ. Энэ үед хөөрхий эмэгтэй байж суух аргагүй болоод байдаг чадлаараа орилж чарласан байна. Тэгтэл Баярхүү түүнийг өдөн хөнжлөөр битүү хучиж амийг нь бүрэлгэжээ. Гэвч тэр дараа нь юу ч болоогүй царай гаргаж цагдаагийнханд дуудлага өгчээ. Эдүгээ Баярхүү Солонгосын шоронд ял эдэлж байгаа бөгөөд иймэрхүү хэргээр ял эдэлж буй этгээдүүд Герман, Польш, ОХУ зэрэг оронд нэлээд байгаа аж. Үүнээс гадна шунахайн сэдэлтээр хэд хэдэн хятад иргэний амь насыг бүрэлгэж дээрмийн хэрэг өдөөсөн хоёр монгол иргэнд тухайн улсын хуулийн дагуу 15 жилийн хорих ял оноожээ. Монголчуудын хувьд их нүүдлийн орон болоод буй Солонгос улсад эдүгээ 40 орчим монгол хүн хоригдож байгаа аж. Шоронгоос суллагдсан улс тийш очиж хялбар аргаар мөнгө олохын тулд ихэвчлэн нутаг нэгтнүүдээ рэкетлэдэг бөгөөд одоогоос хэдэн сарын өмнө манай цагдаагийнхан нутаг нэгтнүүдээ дээрэмдэн зодож танхайрсан дөрвөн монгол залууг Солонгосоос баривчилж иржээ. Тэдний өдүүлсэн хэргийн улмаас таван монгол иргэн хүндээр гэмтэж эмнэлэгт хүргэгдсэн байна. ОХУ-д манай зуу гаруй хүн элдэв хэрэг төвөгт холбогдон шалгуулахын зэрэгцээ хийсэн хэрэгтээ шийтгэл хүлээн шорон гянданд өдөр шөнийг элээж сууна. Амьдралын төвшин ядуу хэмээн эх орноосоо дайжин харийг зорьсон монголчууд бие биеэ дарамтлан, нэгийгээ тахир дутуу болгоод зогсохгүй амьдралаас нь салгаж байгаа нь дэндүү хар амиа хичээсэн явдал юм. Германд л гэхэд тухайн улсын хуулийн заалтыг зөрчсөн, хулгай дээрэм, залилан, хүчин танхайн хэрэгт холбогдсон 300-гаад хүн бүртгэгдээд байгаа аж. Польшид 80 орчим монгол мөн л гэмт хэрэгт сэжиглэгдэн зарим нь зохих ял шийтгэлээ хүлээн хоригдож байгаа юмсанж. Бельги улсын хуулийн байгууллагад шалгагдаж байсан долоон монгол Брюселийн төв талбайгаас гэгээн цагаан өдөр нутагт нэгт эмэгтэйд сүрдүүлэн авч явж бүлэглэн хүчирхийлээд тэндхийн цагдаа нарт баривчлагджээ. Эд нар бүгд

л Монголын шоронд ял эдэлж байсан этгээдүүд ажээ. Азийн гэмт хэргийн ертөнцөд манайхан аль эрт хөл тавьсан бөгөөд одоогоор Хятадад гуч гаруй, Сингапурт 20-иод биеэ үнэлэгч ял эдэлж байгаа юмсанж. Гэхдээ тэдний ихэнх нь хахууль өгөөд шоронгоос гарах юмуу, эсвэл гэмт хэргийн бүрэлдэхүүн нь тогтоогдохгүй байна гэсэн үндэслэлээр шоронгоос мултарч дөнгөдөг аж. Манай урд хөршид янхандалт, биеэ үнэлэх явдал хатуу хууль цаазтай байдгийг хэн хүнгүй мэднэ. Гэвч энэ төрлийн гэмт үйлдлийн 50-иад хувь нь нэлээд нарийсч зохион байгуулалтын шинж чанартай болжээ. Биеэ үнэлэгчдийг өндөр үнээр хилийн чанад руу гаргахад Монголын нэр нөлөө бүхий хүмүүс, компаний эзэд ч холбогдох болсоныг Хятадын тал манайд албан бусаар мэдээлсэн байна. Ер нь Монголын шоронд ял эдэлж байсан этгээдүүд харь улсад очиж гэмт хэрэг үйлдэх нь их болсон бөгөөд тэд бусдыг дээрэмдэхдээ “Монголын харгис жандармууд биднийг олон жил хилсдүүлж дарамталсан. Одоо бид тэднээс өш хонзонгоо авч байна. Та нарыг дээрэмдэх явдал бол цагдаа нараас өш хонзонгоо авах хамгийн шилдэг арга” гэх ухааны юм яриад элэг нэгтнээ хайр найргүй дээрэмддэг ажээ.

## Таксигаар хүн зөөж явахдаа шорон аргаар олон хүнийг дээрэмджээ

Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн ажилтанууд таксиндаа суусан эмэгтэй зорчигчдыг дээрэмдэж, хүчирхийлдэг нэгэн аюултай этгээдийг баривчилжээ. Тэрхүү дээрэмчнийг Цогтын Наранбат гэх бөгөөд өмнө нь шорон гянданд толгой хоргодож байсан мань эр бусдыг дээрэмдэхдээ жинхэнэ шорон арга хэрэглэдэг байж. Тэрбээр сүүлийн нэг жилийн дотор таксиндаа суулгасан гурван ч бүсгүйг хүчиндэж, арваад зорчигчийг дээрэмдсэн байна. Таксинд нь сууж түүнд хүчиндүүлсэн иргэн Д, А, М нарын мэдүүлэгээс үзэхэд гэмт этгээд шөнө оройн цагаар ганц нэгээрээ такси хүлээсэн эмэгтэйчүүдийг машиндаа суулган бензин авах нэрийдлээр хөл хөдөлгөөн багатай захын түгээгүүрээс бензин аваад хүнгүй газар луу давхидаг байж. Тэгээд хээр очоод хутга гаргаж ирээд “За машинаас буу. Би дээрэмчин байна. Эсэргүүцвэл ална шүү” гэж сүрдүүлээд үйлчлүүлэгчийнхээ авч явсан цүнх торыг нэгжиж мөнгө төгрөг, гар утсыг нь дээрэмдээд, ээмэг бөгжийг нь мулталж авсанаа “Чи ингээд зүгээр явчихна гэж бодож байна уу. Үгүй шүү. Хувцасаа тайл” гэж зандраад шууд хүчирхийлдэг байж. Тэрбээр машиндаа суусан хүмүүсийг цөлмөн дээрэмдэх үедээ нүүрээ харуулахгүй явж байгаад хүнгүй газар очмогцоо маск зүүж, малгайгаа дарж өмсдөг байсан тул түүнийг хохирогч нар таних боломжгүй. Заримдаа тэр хохирогч нарыг айлгахдаа “Би цагаандаа гарсан алуурчин байна. Арын багаажинд энэ машины жолоочийг алаад хийчихсэн байгаа” гэж дөвчигнөдөг байсан бөгөөд хохирогч Даваацэцэг Сүхбаатар дүүргийн прокурорт өгсөн мэдүүлэгтээ “Жолооч бензин авна гээд Тасганы овооны колонк руу эргэж 1000 төгрөгөнд бензин авсан. Тэгээд зайдуу очоод надад хар иштэй урт хутга тулгаад “Мөнгөө өгөхгүй бол чамайг Даландавхарт аваачиж ална шүү” гэсэн. Би түрүүвчээ гаргаж 3000 төгрөг өгтөл “Бүх мөнгөө өг” гэсэн Тэгээд би өөрт явсан 50 мянган төгрөгөө бүгдийг нь өгсөн. Тэгтэл нөгөө жолооч миний хуруунаас бөгжийг минь мулталж авсан. 40 мянган төгрөгийн үнэтэй бөгж байсан юм. Дараа нь тэр өөрийнхөө суудлыг арагш хэвгүүлээд “Наашаа ирээд хэвт” гэж хутга тулгасан. Би айхдаа сандал дээр нь суухад тэр халааснаасаа бэлгэвч гаргаж ирээд надтай бэлгийн ажил хийсэн. Тэгээд буухдаа арынхаа багаажийг онгойлгоод “Чи үүнийг харах уу” гэхэд нь түрүүн хүн алаад хийчихсэн гэж байсан болохоор нь би айгаад зугтчихсан” хэмээжээ. Цогтын Наранбат иймэрхүү байдлаар олон хүнийг дээрэмдэж, бас хүчинджээ. Тэрбээр мөрдөн байцаалтанд мэдүүлэхдээ “Зарим хүүхнийг зүгээр дээрэмдээд явуулчихмаар байсан ч эр эмийн ажил хийх дур хүрээд байдаг байсан. Тэгээд яаж зүгээр явуулах вэ гэж бодоод гурван ч хүүхнийг хүчиндсэн нь үнэн. Зарим хүн ингэж хүчиндсэн хүнээ ихэвчлэн цааш нь харуулдаг. Харин надад тэднийг алах сонирхол төрж байгаагүй. Тиймээс зарим нь надад “Баярлалаа” гэж хэлээд явдаг байсан” хэмээжээ. Мань эр Дорноговь аймгийн харъяат бөгөөд нутаг орондоо хийх ажилгүй дэмий гиюүрч байхаар Улаанбаатарт очиж дээрэм хийе гэж шийдсэн юм байх. Тэгээд л нэг машины сэг олж аваад бузар ажилдаа шуударсан нь энэ. Ер нь сүүлийн үед хөдөөний ажилгүй залуус хотод ирж дээрэм тонуул хийх нь ихэсчээ. Тухайлбал саяхан Говь-Алтай аймгийн харъяат, эрхэлсэн тодорхой ажилгүй Ж.Ганбат гэгч этгээд цагдаагийнханд чихдүүлжээ. Гэхдээ тэр дээр өгүүлсэн Наранбат шиг үйлчлүүлэгчдээ дээрэмддэг таксины жолооч биш харин таксины жолооч нарыг дээрэмдэж, луйварддаг цагаандаа гарсан этгээд аж. Мань эр гар өргөж суусан машиныхаа жолоочоос дөнгөж оруугаа “Та утсаа өгөөч. “Сим”-ээ хийгээд ярьчихаад өгье” гэж аваад тэр чигээрээ хаалгыг нь онгойлгоод зугтчихдаг байжээ. Зорчигч гэнэт хаалгыг нь онгойлгоод үсрэхийг завдахад ямар ч жолооч яаж ч чадалгүй зогсдог бөгөөд харин энэ үед

гэмт этгээд яах ийхийн зуургүй зугтаж алга болдог байж. Ж.Ганбат одоогийн байдлаар 10 гаруй таксины жолоочоос гар утсыг нь салгачихаад байгаа юмсанж. Саяхан түүнийг Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн ажилтанууд баривчилжээ. Тэрбээр өөрийн хийсэн үйлдлээ зөвтгөн “Угаасаа жолооч нар анхаарал болгоомжгүй байдаг. Танихгүй хүнд яах гэж гар утсаа өгсөн юм бэ, хохь нь. Би бол шийдсэн хүн” хэмээн цагдаагийн ажилтнуудыг сүрдүүлж байгаа аж. Гэмт этгээд нь шөнө орой гэлтгүй гэгээн цагаан өдрөөр хүртэл дээрхи аргаар бусдын гар утсыг аваад зугтчихдаг байжээ. Нэг үеэ бодвол учиргүй буу шийдэм тулгаж дээрэмдэх явдал нь багассан боловч арай боловсон аргаар дээрмийн хэрэг үйлдэх болсоны нэг жишээ энэ. Машиндаа суусан огт танихгүй хүнд гар утсаа өгөх, санамсаргүйгээр гэнэ алдаж машинаасаа буух зэрэгт болгоомжтой хандахгүй бол энэ мэтийн хэрэг зөрчил гарсаар байхыг үгүйсгэхгүй.

## Хэнчбишийн Мандуул шоронд сайхан байсан үеэ нэг дурсаад нүд аньсан байна

1986 онд “Мандухай цэцэн” хатан анх дэлгэцнээ гарч манай зарим эцэг эхчүүд дөнгөж төрсөн хүүхэддээ Мандухай, Мандуул, Өнөболд гэх мэтийн өвөрмөц нэр өгч байлаа. Тэдгээр хүүхдүүд эдүгээ 22 насыг зооглоод байна. Эдний тоонд Хэнчбишийн Мандуул орох бөгөөд тэрбээр хар багаасаа траншейгаар гэр хийж, орон нутгийн галт тэргэнд гуйлга гуйж, дуулж, бүжиглэж явсаар эрийн цээнд хүрчээ. Түүний төрсөн эцэг, эх нь хаана ч явдаг юм бүү мэд. Хогийн гаруудын дунд “нохойн” амьдралаар хүн болсон Мандуулд сурсан зүйл их. Халаас суйлна, хүн боож унагана, тагтнаас тагт руу сармагчин аятай дамжина гэх мэт. Муугаа мэдэхгүй, насанд хүрээгүй байж бас хятад спирт нэлээд сайн гудардаг байж. Ингэж явсаар 18 насандаа ЭБШХ-ийн 123-ын 3-аар буюу айлын амбаар “дэлбэлж” түлээ, нүүрс хулгайлсан хэргээр гурван жилийн хорих ял авчээ. Анх “Ганц худаг”-т орсон өдрөө мөрдөнгийн тоо бүртгэгчийн “Аавын чинь нэр хэн бэ?” гэсэн ширүүн асуултанд тэрээр “Хэн ч биш” гээд хариулчихсан юмсанж. Түүний “Надад аав байхгүй” гэж хэлсэн үгийг тоо бүртгэгч ойлгохгүй аавынх нь нэр “Хэнч биш” гээд бүртгэчихжээ. Энэ цаг мөчөөс эхлэн хоёр жил ялтан Хэнчбишийн Мандуул гэж дуудуулах болжээ. Мандуул хар нялхаасаа траншейгаар гэр хийсэн тул мөрдөнд ормогцоо л өөрийнхөө амийг хоохойлоод явчихаж. Төдөлгүй тэр Амгалангийн хорих ангид хуваарилагдсан бөгөөд анх мөрдөнд орохдоо 62 кг жинтэй байсан бол Амлагангийн шоронд очоод 88 кг жинтэй болжээ. Наранд хортой спирт ууж, заримдаа нүүр угаах ус олдохгүй явсан түүний хувьд шорон гэдэг нь Сөгнөгөрийн амралт шиг санагдсанаас тэр. Тэрбээр гурван жилийг хорихын зоонд өнгөрөөгөөд 2007 оны 7-р сард Шүүхийн магадлангаар суллагджээ. Мандуул шоронгоос гарсан өдрөө “нохойн” амьдралаар амьдарч явсан вокзалын хүнд гаруудаа хайгаад олсонгүй. Зарим нэг хогийнхноос асуувал шоронд орсон, зарим нэг нь үхсэн байх аж. Тиймээс Мандуул бараг л дайнд оролцоод ирсэн баатар лугаа найруулсан архи ууж, үеийнхэндээ агсам согтуу тавьсаар нэг сарыг ардаа хийжээ. Түүний цагаан царай тас харлаж, хачин их турсанаас болж өмд нь хүртэл томдоод сүйд болжээ. Дөнгөж 22 настай гэхэд архи, шорон гэх зэрэг аймшигтай зүйлийг аль хэдийн “амталж” орхисон мань эр голоо зогоохын тулд ундааны сав, шар айрагны лааз олж тушаах боловч хуушуур аваад идье гэхээр хоёрын хооронд цадахгүй тул 200 төгрөгөөр хятад спирт уугаад галзуу солиотой юм шиг манарч явдаг болжээ. Тэгээд ч урьд нь хаа сайгүй хөглөрч байдаг ундааны сав, шар айрагны лааз олдохоо байсан, түүж яваа гуйлгачин нь бараг ундааны савнаасаа их болсон өнөөгийн хэцүү цаг үед дөнгөж шоронгоос суллагдсан Мандуул мэт нь хөл алдан салбарч унах нь зүйн хэрэг шүү дээ. Түүний бие махбодь шоронгийн хар гурилтай хоолонд дасал болсон болоод ч тэр үү хог ухаж идсэн зүйл ходоод гэдсэнд нь шингэхээ байжээ. Тиймээс жаахан юм идээд л шууд “сур харвах” жишээтэй. Мандуул сүүлдээ траншейнаасаа гарч чадахаа байж ам нь хатаж, гэдэс нь өлсч, ангаж цангахын ирмэг дээр иржээ. Нэг өдөр тэрбээр хамаг хүчээ шавхан босч шатаар өгссөөр нүхнээсээ цухуйсан байна. Ашгүй борооны ус траншейны нүхний хажууд тунасан байсан тул шалбаагны усыг алганыхаа хонхорт хийгээд уужээ. Гэвч гурав хоног юу ч идээгүй Мандуул гэдсээ цэрийтэл шалбаагны ус уугаад бие нь улам муудсан байна. Харин түүнийг үхлүүт байх үед нь хар нялхаасаа траншейнд хамт өссөн Цэрэвийн Төмөрхуяг гэгч найз нь ирж асарч тойлох аяджээ. Гэвч өөрөө мөн л траншейны этгээд болохоор Төмөрхуяг Мандуулыг тэгтлээ сайн асарч чадсангүй. “Чи бараг хэвтэрт орчихсон байна. Эмнэлэгт хэвтвэл яасан юм бэ” гэхэд Мандуул “Над шиг биеийн байцаалт, мөнгө төгрөг байхгүй шоронгийн хулгайчийг ямар ч эмнэлэг тоохгүй. Одоо

надад ганцхан зам л байна. Бие маань жаахан тэнхэрдэг л юм бол ямар нэгэн гэмт хэрэг үйлдээд шоронд очих хэрэгтэй байна. Тэнд миний бие таргалж тэнхэрдэг юм. Харин наранд гарч ирээд ингэж тураалд орчихно гэж ёстой зүүдэлсэн ч үгүй. Би ерөөсөө л шоронд байх ёстой хүн байна” гэж өөрийнхөө ирээдүйн хувь заяаг оношилжээ. Гэвч түүний бие огтхон ч тэнхэрсэнгүй. Тэрбээр тамир тэнхээ тасарч нөгөө ертөнц рүү одохынхоо өмнө найз Төмөрхуягтаа шоронд байсан сайхан үеэ нэг дурсаад нүд аньжээ.

## Орон байрны “Бүлтүүш” Болдхүү угаалгын машин “Акира” болж хувирчээ

Баянгол дүүргийн харьяат “Бүлтүүш” Болдхүү Гандан-гийн хүр дэнж дээр өсчээ. Тийм учраас өөрийгөө хотын унаган хүүхэд гэж нэрлэх дуртай. Эдүгээ Болдхүү орон байрны хулгайн хэргээр шоронд ял эдэлж байгаа бөгөөд мань эрийн нэг онцлог нь халдсан ч хар халзандаа гэгчээр дандаа ах дүү, төрөл садныхаа гэрийг тонодогт оршино. Нэг орой Болдхүү бусдаас хумсалсан мөнгөөрөө хоёр найзтайгаа навсайтлаа архидаад өглөө хар үүрээр сэржээ. Сайндаа ч бус толгой тархи нь өвдөж, ам нь хатаж байсан учир ус уухаар үүрийн таван жингээр хар нүд хуу татжээ. Болдхүү хий дэмий л баахан огиулж суутал өчигдөр орой хамт архидсан Нарангэрэл нь орж иржээ. Түүний царай харлаж, бээвийн зогсохыг харваас бас л шартсан бололтой. Хоёр найз шөнө хэдий үед салцгааснаа бие биенээсээ гайхан асуухыг бодоход тасартлаа ууна гэгч нь болжээ. Болдхүү “За хоёулаа эхний ээлжинд дотроо засах хэрэгтэй байна. Дараа нь орон гэрээ болон төр засгаа засчихна. Одоо чи бид хоёрт ганцхан л арга байна” гэхэд цаадах нь “Ямар арга вэ” гэжээ. Тэгтэл Болдхүү “Айл ухах. Үүнээс өөр арга үнэндээ байхгүй. Айл айлдаа бас л манай хамаатных. Хэрвээ цагдаад баригдлаа гэхэд гомдол нь арай гайгүй байж мэднэ. Ийм учраас л би ах дүү нараа тонодог юм шүү дээ. 3-р хороололд манай аавын дүү Гантөмөрийнх байдаг юм. Тэднийхэн өчигдөр өглөө Дархан явчихсан. Хоёулаа очоод ухчихъя” гэжээ. Ингээд мань хоёр тийш явж хашааных нь завсраар шагайтал үнэхээр хүн байсангүй. Болдхүү хашааг нь даван орж гэрийнх нь хаалгыг ганцхан хүчтэй угзраад онгойлгожээ. Тэд юуны түрүүнд хөргөгчийг нь онгойлгож үзвэл тал шил архи байж. Болдхүү тэр дор нь хоёр стаканд хувааж хийгээд эгээтэй л огиулчихалгүй өөрийнхөө хувийг цааш нь харуулжээ. Тэгээд шууд л хананд нь өлгөөтэй байсан Чингис хааны зурагтай хивсийг хуу татаж аваад гарах гэтэл найз Нарангэрэл нь “Нэгэнт л гэрт нь орсон юм чинь өөр юм авахгүй юмуу” гэж шуналтжээ. Тэгтэл Болдхүү “Чи битгий хуцаад бай. Энэ чинь муу ч гэсэн манай хамаатан. Танай хамаатныд ороод хамаг юмыг нь тоноод байвал чамд ямар санагдах вэ” гэж ирээд л өгөөмөр хулгайчийн дүрд хувирчээ. Ингээд мань хоёр хулгайлсан хивсээ хямдхан зараад өдөржин архидаад арай гэж гэр гэртээ харьсан байна. Гэвч маргааш өглөө нь Болдхүүгийн мөнөөх өгөөмөр зан ор мөргүй алга болж “Нарангэрэл ээ. Хоёулаа Гантөмөрийнд дахиад очъё. Тэднийхийг эцсийн удаа ухаад больё” гэхэд найз нь “Өө, яасан ядаргаатай юм бэ. Би чамд хэлээгүй юу. Өчигдөр л бөөндчих байсан юм. Ингэж нэг айл руу дахин дахин явах осолтой. Бусдын хараанд өртөх аюултай. Өөр айл ухъя. Хайлаастан танай нэг эгчийнх байдаг биз дээ. Тэднийхийг дэлбэлье” хэмээн бүр цагаандаа гарчээ. Гэвч Болдхүү түүний саналыг зөвшөөрсөнгүй. Тэрбээр “Нарантуяа эгчийнхийг одоо больё. Өмнө нь би гурван удаа ухчихсан юм шүү дээ. Харин Гантөмөр ахынх надад ердөө ганцхан удаа ухуулж байгаа. Эднийх онгоноороо байгаа айл байхгүй юу. Дахиад нэг ухчихсан байхад гэмгүй. Ах дүү нараасаа хэнийхийг ухахаа өнөөхөндөө би мэдэж байна” гээд Нарангэрэлийг дагуулаад гарсан байна. Төдөлгүй мань хоёр гуравдугаар хороололд байх Гантөмөрийнд очоод ёстой л гэрийн эзэн шиг загнажээ. Тэд нэгмөсөн тоймтой юм хулгайлахаар шийдэж түрдэг тэргэн дээр хөргөгчийг нь ачаалаад арилж өгсөн байна. Тэгээд орой нь Гантөмөрийнд шал согтуу ирээд унтаад өгчээ. Нэг ёсондоо өглөө шараа тайлахын тулд эд хогшлоос нь дахин зарах гэж тэр. Гэвч гурав дөрөв хоног ухаангүй архидсан мань хоёр өглөө эрт сэрж чадалгүй үд болтол унтжээ. Энэ үед гэрийн эзэн Гантөмөр эхнэр хүүхдийнхээ хамт Дарханаас ирсэн бөгөөд хаалга нь онгорхой, хивс, хөргөгч нь үгүй болчихсон, хоёр согтуу нөхөр гэрт нь унтаж байхыг хараад шууд л цагдаа дуудсан байна. Гантөмөр цагдаагийнханыг ирэхээс өмнө сониуч



зандаа хөтлөгдөөд байдгаараа хурхирч буй хоёр хулгайчийн хөнжлийг сөхөж үзтэл төрсөн ахынх нь хүү Болдхүү унтаж байх нь тэр. Тиймээс мань эр ихэд уурлаж Болдхүүг татаж босгоод дэмийртэл нь хэд шанаадаад цагдаа руу утасдаж “Манайд хулгайч ороогүй байна. Буруу мэдээлэл өгсөнд уучлаарай” гээд утсаа тасалжээ. Ингэж Болдхүү, Нарангэрэл хоёр шоронд орохоос аврагдсан байна. Гэвч төрөлхийн хулгайч Болдхүү дээрхи явдлаас өчүүхэн ч засал авсангүй. Тэр ердөө ганцхан сарын дараа Хайлаастанд байх эгчийнхээ гэрийг тоноод баригджээ. Гэвч энэ удаад түүний толгойг зүгээр илээд орхилгүй цагдаад мэдэгдэж, 111-д баривчлуулжээ. Эндээс гарч ирснээсээ хойш бүр ч цагаандаа гарч хамаатан садныхаа гэр орныг гэгээн цагаан өдрөөр ухчихдаг болсон байна. Олон хавар нэгэндээ гэгчээр Болдхүүгийн нэг эгч нь үнэхээр тэсгэл алдарч түүнийг шууд цагдаад барьж өгсөн байна. Учир нь мань эр эгчийнхээ гэрийг удаа дараа ухаад зогсохгүй, хамгийн сүүлд байшинг нь зарчихсан байгаа юм. Болдхүү ах дүү, хамаатан садныхаа нийт 11 айлыг ухсан бөгөөд өөрийн гэр орноо хүртэл хэд хэдэн удаа ухсанаа цагдаагийнханд мэдүүл-жээ. Эдүгээ тэр жирийн дэглэмтэй шоронд ял эдэлж байгаа бөгөөд “Бүлтүүш” хоч нь ор мөргүй мартагдаж “Акира” хэмээх хочтой болжээ. Учир нь тэрбээр хорих ангид очсон өдрөөсөө эхлээд л овгор хулгайчуудын хиртэй хувцасыг угаадаг болж. Тэгээд л орон байрны “Бүлтүүш” Болдхүү угаалгын машин “Акира” болж хувирсан байна. Заримдаа тэр зөвхөн овгор хулгайчийн биш жирийн хулгайчийн хувцасыг угааж өгөөд хөлсөнд нь таваг гурил, үмх мах олоод авчихдаг аж. Тэгээд түүгээрээ хоол хийж идээд, дээр нь засгийн хоол өдөртөө гурван удаа цохих жишээтэй. Өнөөдөр хаана хонох вэ, өдрийнхөө хоолны мөнгийг яаж олох вэ гэдэгт санаа зовохгүй нэгэн бодлын санаа амар, гэдэс цатгалан. Усанд орчихно, өдөржин зоондоо зурагт үзээд, зав чөлөөгөөрөө хулгайч нарын хувцасыг угаагаад амьжиргаагаа залгуул-чихна. Хорих ангиас хоригдолуудад сар бүр гарын болон барааны саван хангалттай тавьж өгдөг бөгөөд “Акира” Болдхүү хулгаруудын хувцасыг угаахдаа тэдний өгсөн савангаас илүү гаргаад сожчихдог ажээ. Тэгээд тэр сожсон савангуудаа нэгэн цагт гомдоож цөхрөөж байсан ах дүү, хамаатан садан руугаа илгээдэг байна.

## Соц нийгмийн шоронд банди байсан эрийн очил

Хүний удам судрыг үргэлжлүүлдэг ёс журмаар үйлдээгүй секс бол гаж буруу үзэгдэл гэж би үздэг. Хүйтэн өвчин авч “Хоргой өмд” өмсөөд “Ээжийнд” (Соц нийгмийн үед хүйтэн өвчнийг хоргой өмд, эмнэлэгт хэвтэхийг “Ээжийнд зочлох” гэдэг байлаа) хүргэгдэн эмчилгээ хийлгэж гарч ирсэнээс хойш хагас жилийн дараа би хэсэг нөхдийн хамт танхай дээрмийн хэрэгт сэжиглэгдэн “Аавынд” хүргэгдэн Эрүүгийн хуулийн 168-ын “б” гэсэн зүйл ангиар ял сонсох дөхөж Монгол улсын төв шорон “Ганц худаг” гэгчид олон сар сууж билээ. Бүлэглэн хэрэг үйлдсэн биднийг нэг нэгээр нь салгаж тус тусад нь камерт хорив. Намайг хүлээн авсан хуяг бичиг баримтаа цэгцлээд шоронгийн “камер”-т хийхээр шээс шивтэр, чийг өмхий ханхалсан бүдэг гэрэлтэй нарийхан хонгилоор туун явах үед хажуу талаар минь “Зэрэгц” команд авсан цэргүүд шиг ярайн орших зузаан төмөр хаалгануудын цаанаас “Хөөе хамаа чи хэн бэ? Нар ямар байна. Амь байна уу? Наадахаа манай өрөөнд хийчих” гэлцэн орилолдох нь харанхуй шөнө энд тэндээс золбин ноход боргох шиг санагдаж, миний сэтгэлийг тийм гэхийн аргагүй айдас жихүүцэл нөмрөн авч билээ. Хуяг гартаа буй олон түлхүүрээ шажигнуулсаар цүүнд нь сул дүүжилсэн цоож санжиганах В-104, В-105 гэсэн номерын өрөөнүүдийн жижиг нүхээр шагайн явсаар В-107-д хүрч хаалгыг нь онгойлгов. Дотор нь сүр сархийх чимээ гарч таван хүн гараа ардаа аван хана руу харан алцайж зогслоо. Бүдэгхэн гэрэлтэй, өргөн нь хоёр метр, урт нь долоон метр орчим хавчиг өрөө харагдав. Хаалганы эсрэг талын хананы дөрвөлжин нүхний чанх дор дээл нөмөрсөн, хууз сахалтай гуч эргэм насны эр хэвтэнэ. Хуяг намайг дуугүйхэн дотогш түлхээд, төмөр хаалгыг тар няр хийтэл хүчтэй саван хааж, ёстой л жинхэнээсээ цоожилж байгаа янзтай түжигнүүлэв. Энэ үед турж эцэн нүд нь гархилж, чих нь дэлдийсэн, хөсрий дааж хувхай цайсан царайтай, хир дайр болсон хар хувцастай хэдэн хүн эргэн харж өлсгөлөн нохой хурга барих гэж буй аятай гөлөлзөн нөгөө хэвгэж буй хүн рүү нэг, над руу нэг харж байлаа. Тэднийг ажиглахад ёстой л нөгөө “Биеэрээ ноён хийж, сүүдрээрээ түшиг хийж явдаг хүмүүс байна даа” гэж бодогдож билээ. “Халиу булга нөмөрсөнийг нь ноён гэж тань, халцгай сармай өмссөнийг нь боол гэж бод” гэгчээр дээл нөмөрсөн хууз сахалтай эрийг би овгор нь буюу ноён нь болов уу гэж бодлоо. Өрөөний доторхийг тойруулан харвал хаалганы дээхэн талд ухаж суулгасан сараалжин төмрийн цаана бүдэг гэрэл ёлтойно. Толигор цементэн хана нь нэг метр гаруй зузаантай бололтой. Уг ханан дээр элдэв зураас, тоо, янз бүрийн үг, үсэг сараачсан байлаа. Цементэн шалны талыг бүрэн зассан намхан модон шалан дээр шатрын хөлөг, “Та битгий уурлаарай” тоглоомын хөлөг зурсан байв. Нэлээд онгиороо байрын шаравгар царайтай, туранхай өндөр залуу над руу дөхөж ирээд хаалган дээрээс түлхэн холдуулж, хаалганы шагайварт амаа наагаад “Улаан цэргээс ирсэн бололтой их цэвэрхэн цэцэг байна” гэж хашгирлаа. Тэгээд надаас анкет авч нөгөөдүүлдээ дамжуулж байснаа миний өмссөн орос хромыг ихэд сонирхон “Алив наад гутлаа тайл” гэхэд нь би хариу дуугаралгүй, гутлаа ч тайлах янзгүй өөдөөс нь ширтэхэд “Өө муу лалар чинь. Чи муу яасан зэвүүн харцтай банди вэ. Чам шиг ийм лаларууд энэ газар бөөс, хир хоёртоо л эзэн байдаг юм. Бусдыг нь хулгарууд мэддэг юм. Ойлгов уу” гэнгүүтээ миний улаан нүүрэн дундуур цохиод авах нь тэр. Ингээд өрөөнд бага зэргийн зодоон болсон бөгөөд аз болж уг тулалдаан миний ялалтаар дуусч билээ. Нударга чанга, зориг зүрхтэй, гардан зодоонд сайн эр хүн хаана ч ядардаггүй ёсоор би тэр дорхноо л сайх өрөөнд өөрийн байр сууриа найдвартай олж суусан юм. Найман метр урт, хоёр метр өргөн уг өрөөнд таван хүн байсан бөгөөд надтай зургаан хүн боллоо. Монгол улсын зартай ганц шоронгийн умгар өрөөнд хоригдох бидний

зургаан мулзан толгойт чадалтай чадалгүйгээсээ шалтгаалан дотроо “овгор”, “барлагууд” гэж ангилагддаг байлаа. Бидэн дунд бас нууцлаг хоёр хүн байсан нь мөнөөх шоронгийн банди, шуумар хоёр болой. Банди, шуумар гэдэг нь тухайн үед Халхын шоронд маш нууц тогтсон, тэр дундаа гадны хүн, харуул, хянагч нар яаж ч оролдоод мэдэх боломжгүй, зөвхөн тэр өрөөндөө л дархлагдсан зүйл байлаа. Хэрвээ банди, шуумарын харилцааны нууц задрах юм бол банди байсан эр ч, шуумар байсан эр ч тав таван жилийн хорих ял өчиггүй сонсч дэглэм дээшилдэг байлаа. Одоо харин хамаа намаагаа алдсан юм билээ. Нарсанд гадны ямар ч хүн үл нэвтэрч чадах тэрхүү олон нууцыг мэдэж авна гэдэг нь ширэнгэн ойг луужингүй туулахтай адил юм. Нарсны хэн нэгэн этгээд тэрхүү нууцуудын тухай гэнэ алдаж ам нээж гэмээнэ “аав”-ынхаас амьд гарна гэдэг тун хэцүү. Тиймээс банди, шуумарын явдлын үнэн түүх барагтай бол задрахгүй. Хэрвээ хэн нэгэн энэ нууцыг задалбал нарсан доторхи бичигдээгүй хуулийг шоронд буй захын эр хүн л хэрэгжүүлж орхино. Учир нь “Эр хүн, эр хүндээ хайртай” гэдэг зарчмыг тэнд байгаа хүн болгон мөрддөг, тэгээд ч хоригдол хүмүүс элдэв бууны нохойнд дургүй. Манай өрөөний овгор “Махан толгой” хочтой нэгэн хүдэр эр байх. Би тэнд хоригдсон өдрөөсөө нэлээд олон хоногийн хойно түүнийг шуумар болохыг мэдсэн. “Махан толгойн” өвөрт эр гэхээсээ эм гэхээр төрхтэй ганган дэгжин хувцасладаг, жорлонд морь харахдаа хүртэл эм хүн шиг явган суудаг, цаг үргэлж л гяндан хатгамал хийж гоё, гоё хээ хуар оёж хатган суудаг нэг эр байх. Яагаад гэвэл би тэдний итгэлийг олж, тэд надтай нөхөрсөг харьцаа тогтсон хойно л тэр хоёрын нууцыг олж мэдсэн минь тэр. Нэг удаа “Махан толгой” хэд хоног “Ганц худаг”-ийн эмнэлэгт хэвтэж, тэр хооронд би түүний банди Сэргэлэн гэгч залуутай ихэд дотносон чин сэтгэлээсээ элдвийг ярилцаж билээ. Түүний эмэгтэй хүнийх шиг махлагдуу гуя, шингэн дуу хоолой, цэвэрхэн царай, нимгэн уруулыг би их соинрхдог байлаа. Сэргэлэн үүнийг мэдчихээд над руу нэг л сонин харцаар талимааран харсанаа “Чи намайг гайхахын сацуу надаас айж цэрвэж байгааг чинь би ойлгож байна” гэлээ. Би учиргүй сандарч “Үгүй, үгүй би юу боллоо гэж чамаас айж, цэрвэх билээ” гэхэд Сэргэлэн инээмсэглээд “Шоронгийн бид хэнд юу ярихаа, хэний өмнө уурлаж, хэний өмнө уйлахаа ч мэддэг улс шүү. Ер нь сүүлийн үед би хэн нэгэнд өөрийн дотоод сэтгэлээ уудлан чин үнэнээ ярихсан гэж бодож явсан юм. Энэ шоронд намайг хэн гэдгийг чи мэдэх үү” гээд миний гараас атгаад авлаа. Тэгэхээр нь би гарыг нь өөрөөсөө зайлуулаад “Үгүй, мэдэхгүй” хэмээн толгой сэгсэрвэл Сэргэлэн “Намайг нарсанд банди гэдэг юм. Шоронд бол энэ мэргэжил хамгийн ховор, хамгийн үнэтэй мэргэжил дээ. Жишээ нь наранд байхдаа би яаж ийгээд авч өмсөхсөн гэж хүсэвч чаддаггүй байсан бүх хувцас, амталж үзэхсэн гэж бодож явсан бүх зүйлээ энэ шоронгоос л олж чаддаг болсон. Энэ бол банди болсоны маань л хүч. Одоо надад урьд нь олж эдлэхсэн гэж хүсээд ч барааг нь харж чаддаггүй явсан тэр бүх юмс хангалттай байдаг болсон. Ер нь би нарсанд банди болсондоо харамсдаг ч үгүй, гутардаг ч үгүй. Харин ч баярлаж явдаг” гээд чимээгүй болж, хүүхэн хүн шиг хуруу хумсаа засч янзалж билээ. Би түүнээс “Банди гэж яг юу гэсэн үг вэ” гэж асуувал Сэргэлэн гүнзгий санаа алдсанаа “Эмэгтэй хүнгүй газар эр хүн эм хүний явдлаар явахыг шоронгийн хэлээр банди гэдэг юм. Энэ нарсанд “жимс”-ний бараа харна гэдэг бол диваажинд очихтой адил. Тиймээс олон жилийн ялтай шоронгийн хоригдолууд дотроосоо хамгийн царайлаг, бие хаа сайтайг нь шилж банди болгодог юм” гэж билээ. Би энэ бүгдийг мэдэж байгаа хирнээ янзыг нь үзэх санаатай “Уучлаарай. Би нэг сайн ойлгож өгөхгүй байна” гэвэл тэрбээр “За даа. Та нарын нарны боловсон хэллэгээр бол эрийг эмлэх үйлдлийг хэлж байгаа юм. Эр хүн байж эм хүн болж аашилж аяглан бусад эр хүний хүслийг хангаж өгдөг хүнийг л банди гэдэг юм” хэмээгээд намайг сонжих мэт хэсэг харж суусанаа “Би ер нь чамд юу ч нуулгүй бүгдийг ярьж өгье.

Сэтгэлийн зовлонг ярьж арилгадаг гэдэг биз дээ. Хожим би ахиж энэ тухай хэнд ч ам ангайхгүй” гээд над руу шахаж суугаад “Би анх дөрвөн жилийн өмнө 18 настай хөвгүүн олон нийтийн газар чанга хашгирсан хэргээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 169-ын б гэсэн зүйл ангиар ял шийтгүүлж таван жилийн ял аваад шоронгийн хаалга татсан юм. Намайг шоронгийн хаалгаар орж ирэхэд угтсан хүмүүс шууд л “Ёстой цэвэрхэн банди байна” гэж уулга алдацгааж билээ. Тухайн үед би тэр үгний учрыг ойлгоогүй. Тэр орой шоронгийн овгорууд дунд зодоон болсон. Хожим мэдэхнээ тэд намайг булаацалдсан юм билээ. Нэг нэгнээ алахаас наагуур нүдэлдсэн тэр зодооны дараа манай энэ ялагчаар тодорсон юм” гээд “Махан толгой”-н хөнжил гудас руу зааж дохиод тэр надад “Одоо бол чи минийх болсон. Энэ мөчөөс эхлээд хоёулаа халхын шоронгийн хатуу замыг зад цохин туулна шүү” гэж билээ. Би эхлээд түүний юу хэлсэнийг ойлголгүй зүгээр л түүнийг дагаад дээд нааран дээр гарсан юм. Тэгээд тэр надад хандаж “Шоронгийн овгор өөрөө надад цай хоол, чихэр жимс зөөж бусад цуг очсон нөхөд маань “адислуулж, “нидрүүлж” өлсч, зовж байхад би дээд нааран дээр тарвалзаж, надад хэн ч халдахгүй байсанд анхандаа туйлын их гайхаж билээ. Гэвч төд удалгүй нэг шөнө өвөрт минь хэн нэгэн орж ирээд намайг учиргүй үнсч үлгэн, илж таалахад би “Банди” гэж юу болохыг ухаарч түүнийг түлхэн зайлуулсан. Манай хүн ч барайж “Чи ингэж байгаа бол би чамайг шууд ёодоно шүү” гээд миний хоёр гарыг ард гаргаж хүлээд, тонгойлгон дарж байгаад “хас”-ын минь нүх рүү өөрийнхөө зантайтал боссон эрхтэнээ вазлиндаж байгаад чихэж оруулахад би ч ёстой л “ёо-ёо”-гоо уянгалуулан дуулж, өвдсөн доромжлуулсандаа өөрийн эрхгүй чарлан уйлж билээ. Хүн гээч амьтан шударга бус явдалтай нэг бол тэмцдэг, эсвэл эвлэрдэг бололтой юм билээ. Дээрхи явдлаас хэд хоногийн дараа хорлохож шарлахсан би шуумараа эсэргүүцээд хурцалж үзүүрлэсэн 200-гийн хадаасаар цээж рүү нь дүрж орхисон. Шуумар маань золтой л нөгөө ертөнц рүү заларчихаагүй. Халхын шоронд арга эвийг нь олвол яаж ч амьдарч болно. Би сүүлдээ шоронгийн бузар булай бүхэнтэй эвлэрсэн. Энэ “тамын саванд” хэн ч биднийг хайрлахгүй. Тиймээс энэ савнаас амьд гарахын тулд би шоронгийн бичигдээгүй хуулиар нэг залуутай гэрлэж, би “Банди”, тэр маань “Шуумар” болж өргөмжлөгдсөн. Ямар ч хүн амьдран байгаа газартаа л зохицон аз жаргалтай байж сурах ёстой гэж миний шуумар надад байнга зөвлөдөг. Түүнийг маань амьд байсан цагт халхын шоронд хэн ч надад гар хүрэхгүй” гэж хэлээд хэсэг зуур хуруу хумсаа оролдон сууснаа “Шоронд жинхэнэ мэргэжлийн “банди” болно гэдэг асар их зориг тэвчээр, ур ухаан шаарддаг ажил шүү. Нэг ёсондоо би эр хүн биш, эм хүн болж хувираад цаг үргэлж эм хүн шиг байх учиртай. Чи одоо намайг хар даа. Би үс гээггүй л болохоос биш бие сэтгэл, ааш аялга гээд бүх юмаараа эмэгтэй хүн болчихсон. Тэр ч бүү хэл надад сардаа нэг удаа сарын юм ирж бэлэг эрхтэнээс минь шингэн юм гоождог гээд л бод доо” гэхэд ихэд гайхсан би “Та хоёрын банди, шуумар гэдгийг хянагч нар мэдвэл яах вэ?” гэж асуухад Сэргэлэн “Яах ч үгүй. Шоронгийн “төк”-үүд банди, шуумар бололцлоо гээд бид хоёрт ял нэмэх гэж хэд хэдэн удаа оролдсон ч чадаагүй. Яагаад гэвэл тэдэнд эд мөрийн баримт, гэрчлэх гэрч болох хүн олддоггүй юм” гэж билээ. Би түрүүнээс хойш асуухсан гэж хорхойсоод байгаа зүйлээ асуухаар зориглон “Та хоёр нөгөө ажлаа яаж хийдэг вэ” гэвэл Сэргэлэн “Аа тэр үү. Би нэгэнт банди буюу эм хүн юм чинь эр нөхрөө тэр тал дээр нь бүрэн жаргаана шүү дээ. Шуумар, банди хоёр эр эмийн ажлыг “цавьдах”, “ёодох”, “гачаадах”, “соосгодох” гэсэн гол дөрвөн аргаар үйлддэг юм. За тэгээд нарсан дахь банди хүний дагаж мөрддөг маш олон дүрэм журам бий. Жишээ нь банди хүний эрхтэн шуумараа нөгөө чухал ажил хийж байх үед босох ёсгүй. Ер нь нөгөө ажлын үед банди хүн эр хүний шинж тэмдэг гаргах эрхгүй. Сайхан эм хүн шиг янаглан гийнаж амьсгаадах ёстой. Тэр бүү хэл банди хүн босоогоороо шээх, бусад руу

сээтэгнэх, харц чулууудах ёсгүй. Хардах гэдэг наранд ч, нарсанд ч хамгийн муухай, хамгийн аюултай эд” гээд толгой сэгсрэн дургүйцлээ илэрхийлээд “Нэгнээ хардах гэдэг үхэл хагацал, зовлон шаналал л авчирдаг хог доо” гээд санаа алдаж билээ. Тэгээд тэр надтай шууд л хурьцал үйлдсэн. Тэр надад банди, шуумарын талаар уртын урт оршил ярьсан болохоор би ч түүнийг эсэргүүцээгүй. Эхэндээ би түүнийг шуумарддаг байлаа. Харин сүүлдээ түүнийг дуурайгаад шууд л банди болсон. Ингэж л 1976 оны хавар манай камерт хоёр хөөрхөн банди бий болж билээ. Тэр цагаас хойш миний сэтгэлд “Хүн гээч амьтан шударга бус явдалтай нэг бол тэмцдэг, эсвэл эвлэрдэг. Ямар ч хүн амьдран байгаа газартаа л зохицон аз жаргалтай байж сурах ёстой” гэдэг үг үүрд хадагдаж үлдсэн юм.

## Хэрцгий зандалчин Ядамсүрэнгийн амийг ерөнхийлөгч өршөөсөн ч сүрьеэ өвчнөөр өөд болжээ

Монгол улс шилжилтийн нийгэм рүү дөнгөж орсоны дараахан буюу 1991-1995 оны хооронд онц, ноцтой хүн амины хэргүүдийн “оргил үе” байсан гэхэд болно. Тухайлбал 1994 онд ээж, охин хоёрын амь насыг хэрцгийгээр бүрэлгэсэн хэрэг гарч байлаа. Хоёр хүний амь насыг бүрэлгэсэн хэргийн эзэн нь рецедив этгээд бус жирийн нэг хар ажилчин эр. Автозасварын баазад гагнуурчин хийдэг асан, урьд өмнө нь ял шийтгэл эдэлж яваагүй Ядамсүрэн гэгч хоёр удаагийн үйлдлээр бусдын амь насыг зэрлэг, балмадаар хөнөөсөн гэж бодохоор гайхал төрмөөр. Гагнуурчны хөнөөсөн талийгаачдын биен дээрхи зөвхөн хутганы сорви гэхэд л 46 удаагийнх байх жишээтэй. Харин гараараа цохиж, хөлөөрөө өшиглөсөн гэмтлүүдийг тогтооход хүний санаанд багтамгүй хэрцгий болох нь ажиглагджээ. Гал тогоондоо үдийн цайгаа бэлдэж байсан Нарантуяа хаалганы хонх дуугарахад “эрлэгийн элч” ирж буйг мэдсэнгүй. Тэрбээр хаалганы дурангаар ажиглавал эмэгтэй хүн харагдсан тул муу зүйл бодолгүйгээр үүдээ нээжээ. Гэтэл эмэгтэйн хажууд намхан нуруутай жартгар нүдтэй 30 орчим насны Ядамсүрэн гэгч байсан нь түүний сайн таньдаг хөрш нь байв. Нарантуяагийн нөхөр Батмөнх хувьдаа барилгын жижиг компанитай, боломжийн бизнесмен байж. Ядамсүрэн гагнуурын тал дээр мэргэжсэн “уран гартай” нэгэн байсан болохоор тэдэнтэй ажил хэргийн холбоо тогтоож үе үе ирнэ. Харин сүүлийн үед Ядамсүрэнгийн гэр бүл бөөн бужигнаанд орж эхнэр Отгонтуул нь нөхрөөсөө салахын түүс болж байгааг Нарантуяа сайн мэдэж байв. Гэр бүл салах болсон шалтгаан нь Ядамсүрэн тамтаггүй их архи ууж, архидсан газар болгондоо хэрэг төвөгт орооцолдох болсоноос үүдэлтэй. Түүнээс гадна Ядамсүрэн архины мөнгө олж чадахгүй үедээ гэрээсээ дэл сул юм гулгуулж шил архиар өгөөд уучихдаг байжээ. Тэр ч бүү хэл архинд толгойгоо мэдүүлсэн Ядамсүрэн Нарантуяагийн гэртээ хадгалж байсан 250 ам.долларыг хулгайлж, Нарантуяагийн нөхөр Батмөнх гагнуурчин Ядамсүрэнг хулгай хийснийг мэдүүт “Мөнгө өгөхгүй бол цагдаад барьж өгнө шүү” гэж айлгаад хулгайлсан мөнгийг нь арав хоногийн хугацаатай төлүүлэхээр болсон учраас тэр эхнэртэйгээ ирсэн нь энэ байж. Нэг ёсондоо хулгайчийг хуулийн байгууллагад мэдэгдсэн бол энэ гэр бүл элэг бүтэн амьдарч явах байсан биз. Ядамсүрэн эхнэртэйгээ Батмөнхийнд хүрч ирээд уйлж хайлахаас наагуур юм болж “Битгий намайг цагдаад хэлээрэй. Би хэд хоногоос танайхаас хулгайлсан мөнгөө буцаагаад олж өгье” хэмээн баахан гуйж байгаад явжээ. Тэгтэл хоёр хоногийн дараа Ядамсүрэн тэднийд ахин ирэхдээ халамцуухан, нүд нь тогтохгүй гөлөгнөж байхыг Нарантуяа хараад айх шиг болсон байна. Тэгтэл Ядамсүрэн Батмөнхийг гэртээ байгаа эсэхийг асуугаад гутлаа ч тайлалгүй зочны өрөө рүү шагайн харжээ. Энэ үед Нарантуяа “Батмөнх одоогоор алга. Харин чи манайхаас хулгайлсан мөнгөө буцааж авчрав уу” гэж хүйтэн өнгөөр асуухад гагнуурчин “Би Эрээн явах талаар танай нөхөртэй ярилцах гэсэн юм. Тэгвэл танайхаас авсан мөнгөө дор нь төлчихнө” гэж хэлээд зочны өрөөний буйдан сандал дээр тухалсан байна. Тэгтэл гэрийн эзэгтэй уурлаж “Одоо чамтай зууралдах хүсэл надад алга. Чи дараа манайд ирэхдээ заавал эрүүл ирээрэй” гэж хэлээд түүнийг буйдан дээрээс татаж босгоод хаалга руу түлхжээ. Гэвч гагнуурчин эр гэрээс тийм ч амар гарсангүй. Тэрбээр “Чи муу гичий намайг хөөдөг хэн юм бэ” гэж хашгираад Нарантуяагийн нүүр лүү хэд хэдэн удаа нударга буулгаад авчээ. Бүсгүй балмад эрээс зугтааж унтлагын өрөөндөө явж ороод хаалгаа дараад суучихаж. Гэвч улангассан эр хаалгыг эвдэж ороод бүсгүйг газар унаган дээрээс нь хайр найргүй балбаж гарчээ. Нарантуяа “Амь авар” хэмээн хоёр удаа байдаг

чадлаараа хашгирсан ч гурав дахь удаагаа хэн нэгнээс тусламж гуйж чадсангүй. Түүний тархинд сандлын хөл буусны дараа бүсгүй ухаан алдан унажээ. Ядамсүрэн энэ хооронд гал тогоонд орж хоолны хутга, байцаа хэрчдэг жижиг сүх зэргээр зэвсэглэж амжсан байна. Хэдэн хормын дараа гэрийн эзэгтэй ухаан ороод хартал гагнуурчны гарт хутга гялалзаж харагджээ. Ядамсүрэн шүдээ хавиран хүйтэн харцаар бүсгүйг цоргиод “Муу өлөгчин минь, одоо чи мөнгө хаана байгааг надад хэлнэ дээ” гэж тулгажээ. Нарантуяа “Би мөнгө хаана байгааг мэдэхгүй. Батмөнх аваад явсан” гэж хэлтэл Ядамсүрэнгийн гар дахь хутга гялсхийж, бүсгүйн чихний омог, ээмэгтэй нь хамт хивсэн дээр унасан байна. Баруун шанаанаасаа урсах цусыг хараад бүсгүй шоконд орж хэн нэгнээс тусламж гуйх гэтэл ам нь эвлэсэнгүй. Ядамсүрэн бүсгүйн чихийг тас огтолсондоо өчүүхэн ч эмзэглэлгүй, ороолтоор хоолойг нь боож гарчээ. Нарантуяа байдаг чадлаараа тэмцэж, тийм ч амар бууж өгсөнгүй. Боолт амжилтгүй болсны дараа Ядамсүрэн байцааны алхаар бүсгүйн толгой, хүзүү, мөр лүү чөлөө өгөлгүй цохиж гарсан байна. Энэ үед гагнуурчин эрийн ард хөлийн чимээ сонсогдож, хаалга чихран дуугарчээ. Тиймээс тэр хаалганы ард ороод нуугдчихсан байна. Тэгээд зандалчин эр Нарантуяагийн 15 настай охиныг өрөөнд орж ирмэгц хаалганы араас гарч ирээд түүний хоолойг цустай гараараа дарсан байна. Гэнэтийн халдлагад өртөж, эхийгээ амьгүй болтлоо сийчүүлэн хэвгэхийг харсан хөөрхий охин тэр дороо муужран унажээ. Гэсэн ч тэр төдөлгүй сэргэж зандалчинаас амь гуйж “Ах аа би таныг хэнд ч хэлэхгүй. Та манайхаас авах юм байвал ав. Би мөнгө хаана байгаа зааж өгье” хэмээн цурхиран уйлжээ. Гэвч Ядамсүрэн охины хэлсэнээр мөнгө төгрөг, эд зүйлийг аваад гарахдаа түүний хоолойг маслын хутгаар огтолж орхисон байна. Зандалчин эр хоёр хүний амь хөнөөчихөөд ер сандарч тэвдсэн шинжгүй үнэртэй ус, будаг арилгагч бодис цацаж ул мөрөө арилгаад зугтжээ. Шүүх эмнэлэгийн задлан шинжилгээгээр Нарантуяа нь цус алдалт болон гэмтлийн шокоор нас барсан нь тогтоогдсон бөгөөд харин 15 настай охины хувьд тархи нугасны нээлттэй гэмтэл, тархины суурь ясны хугарал, цус алдалтаас үүдэн нас барсан нь тогтоогдсон байна. Цагдаагийнхан шуурхай хөдөлсний хүчинд Ядамсүрэнг энэхүү хэрцгий хэргийг үйлдсэн болохыг тогтоож, хоёр хоногийн дараа Замын-Үүдээс баривчилжээ. Тэр үйлдсэн хэргээсээ бултахын тулд Хятад руу гарахаар төлөвлөж байсан гэдэг. Зандалчин Ядамсүрэнд шүүхээс цаазын ял оноосон ч мань эр тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбатаас өршөөл хүсч бүх насаараа хорих ялаар шийтгүүлсэн байна. Гэвч бурхан тэнгэр хилэгнэсэн ч юмуу, эх охин хоёрыг онц хэрцгийгээр тамлаж алсан Ядамсүрэн гурван жил гянданд суугаад дөрөв дэх жилийнхээ хавар нь сүрьеэ өвчнөөр өөд болжээ.

## **Ах дүү нараа луйвардаад шоронд орох шиг булай юм байхгүй**

*Луусангийн шоронгоос суллагдсан зарим хүүхнүүд Монголд амьдрах ямар ч нэр нүүргүй, боломжгүй болчихдог нь зүй ёсных ажээ. Учир нь тэд таньдаг мэддэг хүмүүсээ луйвардаад, зарим нь бүр төрсөн ах дүү, хамаатан саднаа хүртэл сүнсгүй луйвардаад шоронд орсон болохоор арга ч үгүй юм. Тиймээс шоронгоос суллагдаад гадаадын аль нэг орон руу дүрвэхийг л бүхнээс илүүд үздэг байна. Яагаад гэвэл гадаад оронд түүний өмнөх бузар булайг хэн ч мэдэхгүй. Улаанхүүгийн Занданхүү хэмээх бүсгүй 1998 онд төрсөн ахыгаа сүнсгүй луйвардаад гурван жилийн ял авч Луусангийн шоронд очжээ. Гэвч түүнийг 2001 онд шоронгоос суллагдахад хэн ч тоож авч хэлэлцсэнгүй. Ах дүү, хамаатан садныхнаас нь гадна найз нөхөд нь ч нэг нүдээрээ харсангүй. Тиймээс Занданхүү гадаад руу гарахаар шийджээ. Тэгээд Хятадаар дамжаад Гонконг руу гарсан байна. Тэнд таван жил болохдоо бааранд тайчих бүжиг хийдэг байж. Ингээд түүний яриаг сонирхуулья.*

### **-Чи хэдэн настайгаасаа тайчих бүжиг бүжиглэж эхэлсэн бэ?**

-Өвөө, эмээ хоёр маань уртын дуу их сайхан дуулдаг байлаа. Би жаахан охин байхдаа өвөөгөө уртын дуу дуулахад хамаг хувцасаа тайлж шидчихээд өргөн тал, тэр их гоё зэрэглээ рүү гүймээр санагддаг байж билээ. Тэрнээсээ болоод ч юмуу, урлагийн хүн болохыг мөрөөдөж эхэлсэн. Удалгүй сургуульд ороод Хүүхдийн ордны бүжгийн дугуйланд орж бүжиглэж, 18 наснаасаа эхлэн тайчих урлагаар хичээллэсэн. Гэвч сургалтын зардал, энэ тэрээс болоод залилангийн хэрэг рүү хальгарч орсон доо. Тэгэхдээ бүр төрсөн ахынхаа байрыг зараад түүнийг орон гэргүй болгочихсон. Үүнээс болж манай хамаатан саднууд намайг үзэж чадахаа байсан. Луусангийн шоронд гурван жил болоход намайг хэн ч эргэж тойроогүй. 2001 онд суллагдаад гарч ирэхэд ах дүү, хамаатан саднууд маань “За чи одоо хэний байрыг луйвардаж голомтыг нь самрах вэ. Биднээс холхон яв” гээд шууд л хөөж туусан. Ах дүү нараа луйвардаад шоронд орох шиг булай юм байдаггүй юм билээ. Хар элэгтэй хүн луйвардчихсан бол тэгсхийгээд мартагдаад өнгөрнө шүү дээ.

### **-Гонконгт бүжиглэх ямар байв?**

-Би тэнд очоод дөрвөн монгол бүжигчин хүүхэнтэй хамт амьдарч байлаа. Тэд маань надаас түрүүлээд Гонконгт оччихсон байсан болохоор надад нэг их бэрхшээл гараагүй. Би бааранд хүний өмнө гараад нүцгэн бүжиглэхэд хөгжим, тайзтайгаа хослоод сэтгэл их гоё мэдрэмж төрөөд явчихдаг байлаа. Анхнаасаа л Гонконгт бүжиглэхэд их амар байсан. “Намайг ямар хүн таних юм биш” гэж бодохоор их чөлөөтэй, сэтгэл хангалуун болчихдог. Харин яг миний мэдрэмжийг заавал секстэй нарийн холбох шаардлагагүй. Зүгээр л урлаг гээд ойлгоход болно. Бидний таван бүсгүй лесби маягийн бүжиг бүжиглэхэд гонконг залуус алга ташаад сүйд болдог байсан. Үүнийхээ хэрээр мөнгө ч их олсон. Ямар сайндаа л өөртөө нэг байрны мөнгө, ахдаа нэг байрны мөнгөтэй ирэх билээ дээ.

### **-Нөгөө луйвардсан байрныхаа үнийг төлсөн хэрэг үү?**

-Тэгэлгүй яахав. Ингэсний хүчинд би өнөөдөр ах дүү, хамаатан садныхаа өдөөс эгцэлж харахтайгаа болоод байна. Хүн алдаж болно. Хамгийн гол нь алдаагаа ухаараад, нэг



ёсондоо гомдоосон хүнийхээ сэтгэлийн шархыг нөхөх сэтгэлийн тэнхээтэй байх хэрэгтэй. Энэ ч утгаараа би Гонконгт байх таван жилийн хугацаанд ахынхаа хохирлыг барагдуулна гэж цаг ямагт боддог байсан. Ингэж хүчилсэний ачаар 2006 он гэхэд ахынхаа байрны мөнгийг хийсэн. Тэгээд наашаа явах гэсэн боловч өөртөө бас нэг байрны мөнгө хиймээр санагдаад бааранд өдөр шөнөгүй бүжиглэсэн дээ. Нуулгүй хэлэхэд зарим хүнд биеэ үнэлдэг байлаа. Үүнийг нуугаад яахав. Тэртэй тэргүй ойлгомжтой шүү дээ. Биднийг тайзан дээр гараад бүжиглэж байхад заримдаа үнэ хаялцах худалдаа явдаг. Тэгээд хамгийн өндөр үнэ хэлсэн хүнтэй сексдэх шаардлага гардаг. Гэхдээ гонконг эрчүүд надад огтхон ч таалагддаггүй байсан. Дээд зэрэглэлд орох биеэ үнэлэгчид сэтгүүл дээр өөрийгөө сурталчилдаг. Дунд зэрэглэлд орох биеэ үнэлэгчид нь гудамжинд өөрийнхөө утас, хаяг гэх мэт танилцуулгыг тараа-гаад зогсч байдаг. Биеэ үнэлэгчдийн ихэнх нь түр оршин суугч оюутан охид байдаг. Тэр бүү хэл мазохист маягийн биеэ үнэлэгч хүүхнүүд хүртэл бий. Би дунд зэрэглэлийнх байсан болохоор хааяа гудамжинд зогсдог байсан. Ахиухан мөнгө олохын тулд л энэ шүү дээ. Хэрвээ би өөртөө байрны мөнгө хийлгүйгээр Монголд ирлээ гэж бодоход амьдрахын эрхэнд дахиад л луйвар хийж магадгүй гэж бодсон л доо. Ер нь аливаа хүн төрөлхийн луйварчин байдаггүй, харин амьдарч буй орчин нь луйвар луу яах ч аргагүй түлхчихдэг болохыг би Гонконгт байсан хэдэн жилд л ухаарлаа.

**-Тэгэхээр Монгол улс маань луйвар луу түлхдэг орон болж таарч байна уу?**

-Миний хувьд гэвэл тийм. Гэхдээ улс төрчдөөс эхлээд том жижиггүй л луйвар хийж байгааг хэн хүнгүй л харж байна шүү дээ. Улс төрчид бол луйвар хийсэн ч эндээ байж болоод байдаг. Харин ч бусдад ад үзэгдэхгүй баян тансагаараа гайхуулаад сайхан амьдрахыг яана.

**-Монголд ирээд найз залуутай болж амжсан уу?**

-Одоохондоо үгүй. Надад боловсролтой, царайлаг гэдэг ч юм уу тийм эр хүн онц санагддаггүй. Хамгийн гол нь ухаантай, эмэгтэй хүнийг хүндэлж чаддаг эр хүн л таалагддаг. Заримдаа хайртай болсон хүнийхээ төлөө амьдралаа зориулна гэж бодохоор амьдрал дэндүү утгагүй юм шиг санагддаг.

**-Чи тэгэхээр нууц амраг байх ёстой гэдгийг зөвшөөрч явдаг байх нь ээ?**

-Эр ч бай, эм ч бай хань нь сэтгэлд хүрэхээргүй болсон үед нууц амрагтай болж хайр нь дэндээд хагацаж чадахгүйдээ хүрч, бүр амьдралаа холбосон явдлууд зөндөө л дуулддаг шүү дээ. Нууц амраг бол хүний амьдралд сүүдэр шиг дагаж ирсэн хэзээ ч хаяж болдоггүй зүйл.

**-Таны нөхөр чинь сексдээ муу байвал яах вэ?**

-Секс бол хүний амьдралын нэг томоохон хэсэг. Хэрвээ нөхөр маань сексийн тал дээр муу мэдрэмж төрүүлээд байвал би шууд сална. Хүн секс хийхгүйгээр амьдарч чадахгүй. Зарим эрчүүд сексийн тал дээр хэт мундаг хүн болох гээд эмэгтэй хүнтэй мал, адгуустай харьцаж байгаа юм шиг аймаар авир гаргаад байвал утгагүй.

## Шоронд сэтгэлээр унах л юм бол шууд нөгөө ертөнц рүү очно

Шоронд байдаг элдэв дэглэлт, тоглоом шоглоом, тэнд ноёрхсон гаж ёс суртахууны талаар хүмүүс янз бүрээр л ярьдаг. Саяхан нарснаас суллагдсан “Бажуухай” Нямдорж гэгч эр доорхи зүйлийг хүүрнэсэн юм.

**-Та ямар хэргээр шоронд орсон юм бэ?**

-Би Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127-р зүйл буюу залилангийн хэргээр шоронд орсон. “Ганц худаг”, Мааньт, Багануур, Амгалангийн шоронд сууж байлаа. Шоронгийн амьдрал ямар л олиг байв гэж дээ. Гэхдээ хүн зовлон даадаг, жаргалыг даадаггүй гэдэг үнэн юм билээ. 60-70 кг-ын хооронд хэлбэлздэг миний бие тураалд орж 47 кг хүрч байлаа. Бие ихэд муудаж бараг нөгөө ертөнц рүү явах шахсан даа. “Ганц худаг”-ийн агаар, салхигүй орчинд олон тамхичдын дунд байснаас уушиг их муудсан. Би тамхи татдаггүй л дээ. “Ганц худаг” гэдэг чинь жаргалын орон биш үхлийн орон шүү дээ. Одоо харин их өөр болсон сурагтай.

**-Анх “Ганц худаг”-т ороход ямар байв?**

-”Ганц худаг”-ийн камерт анх ороход хүйтэн гэж жигтэйхэн байсан. Тэгээд балиар заваан, тэр жижигхэн өрөөн дотроо наймын хувинд өтгөн шингэнээ гаргадаг. Өмхий гэж жигтэйхэн. Ийм л орчин угтсан даа. Одоогоос хэдэн жилийн өмнө “Ганц худаг”-ийн нэг камерт 12-оос 20 хүн байдаг байлаа. Уг нь нэг камерт дээд тал нь арван хүн байх ёстой юм билээ. Нэг камерт хэт олон хүн болоод ирэхээр заримыг нь мал шиг тууж, цонх нь онгорхой хүйтэн камерт хөөж оруулдаг. Ингэснээс болж би хүртэл хатгаа авч байлаа. Камерт нь ор гэж байхгүй. Ташуу ширдгэн дээр унтах жишээтэй. Атаман нь хамгийн дээр заларна. Доожоогүй ялтан наймын хувингийн хавьцаа унтана. Наймын хувинтай ялгадасаа өдөр нэг удаа асгана. Асгахдаа камерын өнөөх доожоогүй хоригдол асгана. Манай камерын атаман нь Хэнтийгээс ирсэн “Цэнхэр” Эрхэмээ гэдэг нөхөр байсан. Мөн мөрдөн байцаагчаа алах гээд гар буугаар айлгаж байгаад гавлуулсан “Орсгой” Мягмарсүрэн гэгч эр атаман болох гэж их тэмцэлддэг байлаа. Даанч тэр гаднаас хэн нэгний зананд орсоноор бусдад хорлогдсон. Бодвол мөрдөн байцаагч нь захиалга өгөө биз. Намайг “Ганц худаг”-т хоригдож байхад бакалан гутлаар бух алах буюу бакалын өсгийгөөр цохих, нэг хөл дээр нь удаан хугацаагаар зогсоох гэх мэтийн дэглэлт явагддаг байлаа. Харин зооны шоронд бол хүнийг сэтгэл санаагаар шууд унагааж хоолыг нь өгөхгүй байх зэргээр дэглэдэг. Хянагч нар “Чи яагаад контакт авдаггүй юм бэ” гэж ирээд л бороохойддог. Би эхэндээ ойлгохгүй байсан. Сүүлд нь ойлговол “Би хоригдол Нямдорж” гэж хариулах ёстой байсан юм билээ. Ер нь хянагч нарын зананд орсон ялтан хэзээ ч өөдөлдөггүй. Ар гэрийнхэн нь эргэж ирээд хоол унд өглөө гэхэд тэрийг нь өгөхгүй нүдэн дээр нь асгаад хаячихдаг. Бичиг цаас, захиа зануул бол бүр ч оруулахгүй. Одоогоос хэдэн жилийн өмнө “Ганц худаг”-ийн урьдчилан хорих төв үнэхээр хэцүү байсан. Шинэ хоригдолыг камерт орж ирэнгүүт шууд зодно. Хичнээн шийртэй аавын хүү байлаа ч бүгдээрээ нийлж байгаад нүдчихдэг байсан. Тэгээд хамаг л өнгөтэй өөдтэй хувцас хунарыг нь дээрэмддэг байлаа. Одоо харин арай өөр болсон сурагтай. Дансандаа мөнгөтэй сэжигтэн “Ганц худаг”-т бол үнэхээр жаалдаг гэсэн. Дуртай хоолоо захиалж идээд л хэвтэж байдаг юм байх.

## **-Шоронд сэтгэлээр унаж болохгүй гэлцдэг?**

-Сэтгэлээр хэзээ ч унаж болохгүй. Хэрвээ унах л юм бол шууд нөгөө ертөнц рүү очно гэсэн үг. Олон ч хоригдол сэтгэл санаагаар унаснаас болж амь насаа алдаж байсан. Хоригдолуудад эргэлт ирэхэд хуягууд тэр болгон дундаас нь аваад байдаггүй. Харин камерын овгор хажууд хүрч ирээд хамаг хоолыг нь идчихээд яваад өгдөг. Тэр үедээ гал хам гэж сайхан манж үг хэлдэг. Тэгээд хоол дууссаны дараа танихаа больдог. Ер нь эргэлтийн хоолыг атаманууд түрүүлж амсах гэж дайраад байдаг нь утгагүй. Атаманууд засангийн хоолыг нэг их идээд байдаггүй. Шоронд өглөө цай, 500 грамм хар талх, өдөр шар будаатай шөл, орой бас л шар будаатай шөл өгдөг. Янз бүрийн махтай байдаг. Заримдаа бүр үнэр орчихсон махаар хүртэл хоол хийчихсэн байдаг. Өлсөхгүйн эрхэнд идэхээс өөр аргагүй. Тэр жил Ерөнхий сайд асан М.Энхсайханыг Амгалангийн шоронд очиход телевизээр “Хоригдолуудад 1, 2-р хоол өгч байна” гэж ирээд л рекламдаад байсан. Үнэн хэрэгтээ тэр бол шоу байсан. М.Энхсайханыг явсаны дараа хуучин хэвэндээ орсон. Тэр ч байтугай Ерөнхий сайд ирнэ гээд туранхай, хувцас муутай хоригдолуудыг өөр газарт аваачаад, оронд нь тарган, өнгөтэй өөдтэй хувцастай хоригдолуудыг авчирч суулгаж байсан юм. Үүнийг би нүдээрээ харсан.

## **-Таны байсан шоронгуудын аль нэгэнд хоригдол үхсэн тохиолдол байдаг уу?**

-Лав л миний мэдэхээр 19 настай залуу гэнэт үхсэн. Сүүлд нь сонсохнээ өлсөхгүйн эрхэнд адууны түүхий тархи идсэн гэсэн. Мөн хүчингийн хэргээр орсон 81 настай нэг өвгөн яг миний гар дээр нас барж билээ. Зайлуул амьдрах гэж их үзсэн дээ. Гэвч ах дүү, хамаатан садныхан нь ерөөсөө эргэж ирдэггүй байсан. Хүчингийн хэргээр орсон болохоор жигшиж зэвүүцээ байлгүй. Тэр ч байтугай гаднаас “Наад өвгөнийхөө амьсгалыг боогдуулаад алчих” гэсэн мессеж ирж байлаа. Мөн яруу найрагч Урианхай гуайн хүү шоронд ял эдэлж байгаад уушигны сүрьеэгээр нас барсан.

## **-Зодоон цохион байнга гарах уу?**

-”Ганц худаг”-т хоригдож байгаа хүмүүс бие биенийхээ дээр гарах гэж ёстой үзэж тардаг байлаа. Овгор болохын тулд тэгж байгаа юм. Хоол унднаас болж хоорондоо их зодолдоно. Миний хувьд гэвэл хүнд нэг их дээрэлхүүлж байгаагүй ч зодуулах үедээ зодуулдаг байсан. Шоронд уравгар царайтай харагдсан хүнийг улам доош нь оруулдаг юм шүү дээ. “Пальдаг” Нямдаваа гэгч ялтан нэг залууг зодож нүдсээр байгаад мэдрэл муутай болгочихсон. Тэр нь мэдрэл муутай болсон учраас шоронгоос суллагдсан. “Ганц худаг”-ийн камерт овгор мэдээж хамгийн дээр залардаг. Харин Багануур, Хонхор, Амгалангийн шоронд давхар наар байдаг учраас атаманууд нь дээд талын нааран дээр унтана. Доод талын нааран дээр унтаж байгаа хоригдолуудыг овгорууд нохой шиг шилбүүрдэнэ. Шаланд суулгана. Шоронд эмэгтэй хүнийг алсан, настай хүнийг алсан хэрэгтэнүүдийг их доош нь хийдэг. Ийм хэрэг үйлдсэн хүмүүс нохой шиг шилбүүрдүүлж, байнга л шаланд суудаг.

## **-Шоронд бэлгийн дур хүслээ хэрхэн хангадаг вэ?**

-Шоронд олон жил суусан хоригдолууд дээр эргэлт ирдэг. Эргэлт ирэхдээ найз бүсгүй нь ч юмуу, авгай нь ирээд 24-48 цагийн хугацаатай тусгай өрөө авна. 2500 төгрөг төлнө. Тэгээд л нөгөө бэлгийнхээ дур хүслийг хангадаг байлгүй дээ. Шоронд бандидана гэж байдаг.

Гэхдээ би энэ тухай сонсч л байсан болохоос биш нүдээрээ үзээгүй.

-Олон жил шоронд суусан хүмүүс шоронгоос суллагд-аад эм хүнийг хэр хүсэх вэ? Эмэгтэй хүнд дургүй болчихдог гэсэн үнэн болов уу?

-Шоронгоос гарч ирээд эм хүний мөрөөсөл болох эсэх нь хувь хүмүүст янз янз байдаг байх. Тухайлбал тасралтгүй найман жил суусан би шоронгоос сууллагдсанаас хойш нэг ч эмэгтэй хүнтэй унтаагүй явж л байна. Хамгийн гол нь тэсвэр тэвчээр хэрэгтэй л дээ. Тэрнээс биш би эмэгтэй хүнд дургүй болчихсон юм огт биш.

**-Шоронд юу хориотой вэ?**

-Шоронд чанга ярихыг хориглодог. Мөн овгоруудын дэргэд шивнэж ярихыг хориглоно. Мөн хүйтэн зэвсэг хориотой. Гэсэн ч шоронд нууж далдалсан хүйтэн зэвсэг байдаг. Овгорын авдар гэж камерын хойморт газар ухаад хийчихсэн байдаг юм. Тэнд идэж уух юм, зэвсэг зэрэг нь байдаг. Тэндээс нь ихэвчлэн зүү гарч ирдэг. Хэн нэгнээс зүү гуйхад хүрвэл “Эхнэрээ өгөөч” гэж хэлнэ. Тэвнэ хэрэгтэй болбол “Ааваа өгөөч” гэж хэлдэг. Мөн жижигхэн хөрөөний ишээр хутга хийчихсэн байдаг. Цаашилбал салхилах үедээ хадаас нуугаад аваад явдаг. Камер болгоны доод буланд цаад талын камер луу ухсан нүх байдаг. Бүгд тийм нүхтэй. Уртаашаа 10 камер байлаа гэж бодоход тэр нүхээрээ хамгийн сүүлийн камер руу үг хэлэхэд дуу дуугаа авалцаад дамжуулж хэлнэ. Камеруудын хоорондох нүхийг хуягууд үе үе шалгаж үзээд битүүлдэг боловч дахиад л ухчихдаг. Эцсийн эцэст шорон бол хүмүүжигчээ элдэв арга хэлбэрээр дарамтлах, хүнд хэцүү хөдөлмөрөөр залхаан цээрлүүлэх хөгийн газар байх ёсгүй. Манай зарим дарга, хянагч нарт ийм хандлага байдаг. Ямар ч аавын хүү шоронд орж болно. Тэднийг хүн гэдэг талаас нь харж хандаж байхыг нийт шоронгийн удирдлагад уриалмаар санагддаг шүү.

## Дуулиан шуугиантайхан хоригдсон хүмүүсийг “Ялны ченжүүд” ээрч хоргоогоод амар заяаг нь үзүүлдэггүй

Норолхоогийн Аюурзана, Сэнгээгийн Сэд, Галсангийн Болдбаатар, Ерэнтэйн Батсүх нар сүүлийн хоёр жил зогсоо зайгүй архиджээ. Тэд архи уух мөнгөө яаж олдог нь сонин. Тэд бусдын малыг хулгайлж зардаг байж. Аюурзана, Сэд хоёр нь малын хулгайн гэмт хэргээр 2-3 удаа ял эдэлсэн хашир хандгайнууд бөгөөд мань хоёр 2006 онд шоронгоос суллагдаад нэгэн цагт шоронд хамт байсан Болдбаатар, Батсүх хоёрыг эгнээндээ нэгтгэжээ. Тэд цагдаагийнханд өөрс-дийнхөө байгаа газрыг мэдэгдэхгүйн тулд энд тэнд айлын шавар байшин хөлсөлж зам мөрөө буруулж байсан байна. Эдний толгойлогч Аюурзана бусаддаа хандаж “Хэдүүлээ ерөөсөө мал л хулгайлж амьдарна. Хүн дээрэмдэхгүй. Яагаад гэвэл дээрмийн хэрэг үйлдэхэд доод тал нь найман жилийн ял авна. Мөн хүчин хийхгүй. Харин мал хулгайлсан байхад дээд тал нь таван жилийн ял авна. Тэгэхээр одоо хэдүүлээ үхэр, хонины эрлэгийн элч болцгооё” гэж уриалдаг байжээ. Нээрээ ч малын хулгайн гэмт хэрэг дээд тал нь таван жилийн ялтай болохоор гэмт этгээдүүд ихээхэн оодорч байгаа бололтой. Дээрхи этгээдүүд ихэвчлэн ганц бие хөгшчүүлийн малыг хулгайлдаг байж. Ямар сайндаа л нэг хөгшин цагдаагийнханд мэдүүл-эхдээ “Хулгайчууд үнэхээр хэцүү болж. Хэдэн үхрээ хариулах гэхээр гэр ухчих гээд байх юм. Гэрээ хараад үхрээ бэлчээхээр үхэр хулгайлчих гээд байх юм. Заримдаа бүр шөнийн цагаар хашаанаас үхэр хулгайлаад аваад явчих юм. Над шиг настай хүн шөнө гадаа хулгайч ирсэнийг мэдсэн ч гэрээс гарах аргагүй. Чимээгүйхэн байж байгаад л тэднийг явуулахаас өөр арга байхгүй” гэсэн байх жишээтэй. Буянт малын эсрэг дайн зарласан дээрхи дөрвөн хулгайч саяхан баривчлагдсан бөгөөд бүх хэргийг Аюурзана нь ганцаараа үүрэх гэж зүтгэж байгаа юмсанж. Хэрэв тэр ганцаараа үүрчихвэл бусад нь ялнаас мултарч дахиад л мал хулгайлна. Тэгээд шоронд байгаа Аюурзаныгаа эргэж тойрно. Бүлэг хулгайчдын дунд нэг иймэрхүү бичигдээгүй хууль хууль үйлчилдэг болсон тул бусдын хэргийг өөртөө авч өмнөөс нь шоронд ял эдэлдэг этгээдүүд ч бий болжээ. Ийм хүнийг хоригдлууд “Ялны ченж” гэж нэрлэдэг аж. Монголд ер нь ченжгүй юм гэж байхгүй боллоо. Хүний өмнөөс ял эдэлдэг “ченж” хүртэл бий болсоныг бодоход Монгол улс зах зээлд арай л хэтэрхий ороод байх шиг. Тэр ч байтугай “Гэмт хэргийн ченж”-үүд үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө мөнгөний бололцоо, гэмт хэргийн хүнд хөнгөн нөхцөл байдлаас шалтгаалж тодорхой хэмжээний үнэ ханш тогтоожээ. Тухайлбал 1-3 жилийн ялтай хүний хэргийг өөртөө авсан тохиолдолд 2-3 сая төгрөг, 3-5 жилийн ялтай хүний хэргийг 3-6 сая төгрөг байх жишээтэй. Харин залилан, хүн амины гэмт хэргүүд тусгай ханштай болжээ. Залилангийн хэрэг гэхэд л хохирлын хэмжээний дөчин хувийг аваад зогсохгүй өмнөөс нь ял эдлэх хөлсөө нэмж авдаг байна. Гэхдээ мөнгөнийхөө тавин хувийг урьдчилж аваад ар гэр лүүгээ гуйвуулаад шоронгийн эргэлтээ зохион байгуулдаг юм байх. Харин үлдсэн мөнгийг суллагдсаныхаа дараа авдаг бөгөөд дахин ченжийн ажил олтолоо уг мөнгөөрөө тансагладаг юмсанж. Ченжүүдийн авах дургүй бараа буюу хэргүүд гэвэл хүн амь, хүчингийн хэргүүд байдаг аж. “Ганц худаг” дахь өнөөгийн зах зээл дээр ялны ченжүүдэд хамгийн их эрэлт хэрэгцээтэй байгаа гэмт хэрэг бол залилангийн, мөн 7-р сарын нэгний үймээн самууны хэрэг болчихоод байгаа юмсанж. Гэвч 7-р сарын нэгний үйл явдалд холбогдсон хүмүүсийн царай төрх телевизийн камерт нэгэнт үлдчихсэн байгаа болохоор “Ялны ченжүүд”-эд ихээхэн бэрхшээл тулгарч байгаа юм байх. Ялны ченжүүд цагдаагийнханд “Би долдугаар сарын нэгэнд МАХН-ын байрыг шатаахад оролцсон. Энэ хүн ямар ч буруугүй. Зүгээр л намайг дагаад явж байсан

юм” гэх зэргээр мэдүүлээд бас амжсан байна. Гэвч цагдаагийнхан “Ялны ченжүүд”-ийн арга залийг бас жаахан гадарладаг болохоор хэн нэгний хэргийг даахаар улайрсан этгээдийн дээрхи маягийн мэдүүлгийг нэг их тоож авч хэлэлцээгүй ажээ. Мөн нэг ченж “Хадгаламж” банкнаас 14 тэрбум төгрөг шомбодсон Чимэд-цэрэнд хандаж “Хөгшин чинь чиний хэргээс үүрэлцэе. Яагаад гэвэл би чамайг “Хадгаламж” банкны мөнгөөр Солонгост казинодож байх үед чинь наранд жинхэнэ бужигнуулж явсан байхгүй юу. Тэгэхээр зарим мөнгөнийхөө эх үүсвэрийг над руу бухаж болно шүү. Би тэр мөнгийг чинь тансаглан жаргаад л дуусгачихсан байгаа биз. Үүний хариуд чи надад ерөөсөө ганцхан зуун мянган төгрөг өгчих” гэсэн санал тавьсан байх жишээтэй. Мөн Гаалийн Баатарыг хэд хэдэн хүн дээрхи маягаар хоргоосон сураг байдаг. Энэ мэтээр томоохон хэргээр дуулиан шуугиантайхан хоригд-сон хүмүүсийг “Ялны ченжүүд” ээрч хоргоогоод амар заяаг нь үзүүлдэггүй ажээ. Магадгүй сая Ж.Батзандан, О.Магнай, “Буян”-гийн Жагаа нарын зандалчилсан гэх хэргийг хамт үүрэлцэхээр тэдэнд эсэн бусын санал тавьсан ч байж мэдэх юм. Дашрамд хэлэхэд “Ялны ченж” буюу “Гэмт хэргийн ченж”-ийн ажил нь эрсдэл ихтэй байдаг болохоор шоронд үхчихгүй, бие сайтай, амиа аваад явчих арга зальтай, орчиндоо дасч зохицсон овгор хулгайчууд голдуу хийдэг байна. Магадгүй тэд хэдэн жилийн дараа шоронгоос суллагдаад үйлчлүүлэгчдээсээ “Хүнд хортой нөхцөлд ажилласны нөхөн төлбөр” гээчийг нэхэж болзошгүй юм.

## Шоронжсон этгээд Баярсүрэнг мөрдөх үеийн адал явдал

Эрүүгийн онц ноцтой гэмт хэрэгтэнүүд сэтгэж тэнэгтдэг бол цагдаа нар сэтгэж ухаардаг. Энэ хоёрын тэмцэл цагдаагийн өнөөгийн амжилт юм. Эрүүгийн цагдаагийн ажилтнууд сэтгэлд бууж, санаанд багтамгүй элдэв янзын адал явдалтай учирч гайхаж эргэлзмээр сонирхолтой учрал тохиолдолтой байнга таарч байдаг билээ. Эрүүгийн төлөөлөгч В.Отгонбаяр дүрээ хувиргаж, нэрээ өөрчилдөг жижигхэн адал явдалтай нэгэн учралыг шалгажээ. Цэцэрлэгийн нэг өрөө түрээслэн “Сега” тоглоом ажиллуулдаг Пүрэв гэгч нэг шөнө өрөөндөө алагдсаныг цэцэрлэгийн ажилчид хүүхдээ авах үед мэдээд цагдаагийн жижүүрт мэдээлсэн байна. Жижүүрийн бүрэлдэхүүн хэргийн газарт ирж үзлэг явуулахад цэцэрлэгийн байшингийн гаднаас тусгай хаалгатай нэг танхимд “Сега” тоглоом явуулдаг зургаан ширээн дээр нэг нэг зурагт, тоглоом тоглуулах автомат удирдлагын аппарат байрлуулсан байж. Хавьд цэвэрлэгээ хийгээгүй бололтой хогтой шалан дээр ул мөр мэдэгдэхгүй байлаа. Танхимын хойд буланд диспа фанераар хаалт хийж тусгаарласан жижиг өрөөний хиймэл модон орон дээр ямар ч хувцасгүй чармай нүцгэн дээш харсан эрэгтэй хүний цогцос байжээ. Эр чадалтай залуу бусдад хүчирхийлүүлж алагдана гэдэг хачирхалтай ховор явдал байлаа. Цэцэрлэгийн хүүхнүүд сая л учрыг мэдээд хэрэгт дурлан шагайцгаагаад “Пөөх яана аа” гээд ум хумгүй зугтацгаажээ. Цогцостой орны урьд хажуугийн шалан дээр гудас дэвсээд хэвтэхээр бэлдсэн бололтой хөнжил, хувцас зэрэг байв. Мөн плитка, данх, сав суулганы байрлалд ямар нэгэн хөдөлгөөн ороогүй бололтой байжээ. Цогцосны гадна үзлэгээр улаан хүрэн өнгийн нарийвтар торгомсог галстукаар хоолойг нь боож зангидсан, салтаа, хэвлий, цээж орчмоор үрийн шингэн илэрснээс өөр ямар нэгэн гэмтэл шарх, сорви байхгүй нь тогтоогджээ. Тоглоомын танхимын баруун талд байсан цаасан хайрцаганд 50 гаруй мянган төгрөг байв. Алуурчин үүнийг үзээгүй ч байж болно. Эсвэл эд мөнгөний шуналгүй зөвхөн өс хонзонгоор хийсэн ч байж мэдэхээр байж. Гэхдээ л ижил хүйстэн гомочуудын үйлдсэн хэрэг болох нь бүүр түүрхэн мэдрэгдээд байлаа. Үзлэгийн протокол хөтөлж шинжээч томилох тогтоол бичиж цогцосыг шүүх эмнэлэгийн моргт шилжүүлжээ. Отгонбаяр хэд хэдэн таамаг (верси) дэвшүүлж, төлөвлөгөө гарган шуурхай зөвлөлд оруулсан байна. Ингээд цэцэрлэгийн манаач Тулгааг байцаахад “Сега тоглоомын өрөөнд шөнийн 01-02 цагийн үед хүмүүс дуулж шуугилдаж байгаад чимээгүй болсон. Намайг өглөө зургаан цагийн үед өрөөнөөсөө гарч байшингаа тойрч, хашаан доторхи хог цаас түүж явах үед “Сега” тоглоомын өрөөний хаалгаар нэг залуу гарч есөн давхар байшингийн чигт зүүн урагш явахдаа “Өө та яасан эрт цэвэрлэгээ хийдэг юм бэ” гэж хэлээд л явчихсан. Хаанахын хэн болохыг нь мэдээгүй. Тэнд тоглож хоноод явж байгаа хүн л байна гэж бодсон” гэж мэдүүлжээ. Тэр бас залуугийн нүүр царай, дүр төрхийг тодорхой хэлж өгсөн байна. Ингээд хавь ойрынх нь хүмүүсээс асууж эрэн сурвалжлага явуулахад уг цэцэрлэгийн зэргэлдээ өрөөг түрээсээр ашиглан ундаа үйлдвэрлэдэг эмэгтэйн төрсөн дүү Хуягаа, хохирогч Тулгаа хоёр дотно үерхдэг болох нь тогтоогджээ. Төдөлгүй Хуягааг дуудаж байцаахад “Өчигдөр орой талийгаач бид хоёр “Вест” бааранд 19 цагт орж суугаад 22 цагийн үед гарч явсан. Тэгээд би цех дээрээ ирж машин хөлслөн ТҮЦ-нд нэг авдар ундаа өгч, мөнгийг нь авсан. Энэ хугацаанд талийгаач Тулгаа Өлгийн гудамжинд байх ахындаа очиж хоол идээд гарч ирсэн. Бид хоёр дахин нийлж “Вест” бааранд суух гэхэд 23 цаг болчихсон гээд хаалгаа бариад оруулаагүй учир шөнийн дэлгүүрээс нэг шил архи, дөрвөн лааз пиво аваад 72-р хотхон дундуур байр луугаа явж байхад “Вест” бааранд хүүхэн залуу хоёртой сууж байсан нэг залуу таарч бид хоёрыг танимхайрч

өөрийгөө савхи хийдэг “Алтан-Оч” компаний ахлах менежер ажилтай Баяраа гэж танилцуулсан. Энэ хавьд хонуулах буудал байна уу гэж асуусан санагдана. Бид ярилцаж явсаар цэцэрлэгийн байрны “Сегга” тоглоомын байранд 01 цагийн үед ирсэн. Тэнд нэг шил архиа хувааж уучихаад би явсан. Баяраа тэр хоёр үлдсэн. Түүнээс хойш юу болсоныг мэдэхгүй, уг залууг үзвэл танина” гэж мэдүүлжээ. Мөрдөгч Отгонбаяр сэжигтэний мөрөөр амархан орчихлоо гэж бодоод Баянзүрх дүүргийн үйлдвэр худалдаа, үйлчилгээний хэлтсийн бүртгэлээс аялал жуулчлал эрхэлдэг “Алтан-Оч” компаний хаягийг авч очвол тэнд Баяраа гэдэг менежер ажилладаггүй болох нь тогтоогдож мухардалд оржээ. Нэрээ буруу хэлсэн байж болно гэж үзээд цөөн хэдэн залуучуудыг ажиглавал ойролцоо төрхтэй хүн байсангүй. Ингээд хаана амьдардаг, хэн болох нь үл мэдэгдэх зальт алуурчныг өрөөндөө урьж дайлаад эд хөрөнгө байтугай өөрийнхөө амь насаар дэнчин тавьсан хүн амины эзэнгүй хэргийн тоо нэгээр нэмэгдэх нь тэр. Энэ нь өөртөө үхэл дуудсан эмгэнэлтэй, болгоомж-илвол зохих тохиолдол байлаа. Уг хэргийг илрүүлэх үүрэг хүлээсэн залуу төлөөлөгч Отгонбаяр сэтгэл зовнин нойр хоол дутуухан эрэн сурвалжлах үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсаар бүтэн сарыг өнгөрөөсөн ч няцаж шантралгүй магадлах, лавлах, шалгах үйл ажиллагаагаа уйгагүй үргэлжлүүлсээр байлаа. Төдөлгүй Баянзүрх дүүргийн 5-р хорооны нутагт оршин суух Оюун гэгч бусдад 300 мянган төгрөг залилуулсан тухай өргөдөл гаргаж, уг өргөдлийг Отгонбаяр шалгах болжээ. Энэ бол байдаг л нэг залилан байв. Уг залилан юунаас үүдэлтэй вэ гэвэл Оюуны шоронд ял эдэлж байсан хүүтэй холбоотой байлаа. Нэг орой Оюун руу Баяраа гэдэг хүн утасдаж “Би Зайсан дахь хорихын эмч Баяраа гэдэг хүн байна. Танай хүү Батхуягийн уушиг устсан, бие нь тааруухан байна. Энэ талаар би тантай уулзаж ярилцах гэсэн юм” гэхэд Оюун сандарч тэвдэн үгээ олж ядан уулзаж ярилцъя гэж гуйжээ. Баяраа эмч уриалгахнаар “Би зав муутай байна. Та маргааш өглөө Техникийн их сургуулийн үүдэнд яг 10 цагт хүрээд ир” гэжээ. Оюун тэнд машинтай давхиж очиход Баяраа гэгч залуухан эмч Оюунтай уулзаж мэндлээд “Танай хүү манай эмнэлэгт эмчлүүлж байлаа. Хүү чинь чихэртэй цай их уудаг. Гарын алга үргэлж хөлөрдөг юм билээ” гэхэд Оюун хүүгийнхээ үнэн байдлыг сонсоод үнэхээр баярлажээ. Ингээд Баяраа Оюуныг авч Зайсангийн хорих анги руу явах болжээ. Тэнд очоод эмч Баяраа ангийн шалган нэвтрүүлэх үүдний өрөө орчмоор явж хоёр гурван ч хүнтэй уулзсан байна. Энэ үед машинд суугаад үлдсэн Оюун “Ашгүй дээ, хүүгийн минь тухай ярилцаж байна, учир нь олдох нь” гэж боджээ. Гэтэл Баяраа хүрч ирээд “Танд 30 мянган төгрөг байна уу. Эндхийн хүмүүст өгч хүүг чинь чөлөөлүүлэх хүмүүстэй найрах хэрэгтэй байна” гэхэд Оюун хорин мянган төгрөг уухайн тас гаргаад өгчээ. Баяраа эмч цааш ороод төдөлгүй гарч ирээд “300 мянган төгрөг байвал бүх юм бүтэх гээд байна. Хүүг чинь эмчийн актаар шууд чөлөөлүүлэхээр болчих-лоо” гэсэн сайхан үг хэлжээ. Оюун мөн л түүнд итгээд “Яг одоо надад мөнгө алга. Маргааш өглөө таньд гурван зуун мянган төгрөг өгье” гэжээ. Тэгээд маргааш өглөө нь офицеруудын ордны үүдэнд Баяраатай уулзаад түүний гарт гурван зуун мянган төгрөг атгуулсан байна. Энэ үед Баяраа “Би дээд газар луу нь ярьчихсан. Одоо Зайсан руу явцгаая” гэжээ. Төдөлгүй Зайсанд очоод Баяраа эмч “Хүүхэд дээр чинь зүгээр оролтой биш. Гуанзангаас жаахан идэж уух юм авъя. Хот руу буцъя” гэхэд гэнэн итгэмтгий Оюун бас л зөвшөөрч орхисон байна. Тэгээд буцаад хот руу орж такси Төв шуудангийн ард талд зогсоход Баяраа эмч барьж явсан цагаан тортой юмаа машинд үлдээгээд “Би эндээс жаахан юм аваад ирье. Манай авгай энд ахлах тогооч хийдэг юм” гээд машинаас буужээ. Гэвч тэр эргэж ирсэнгүй. Хаагуур ороод хаашаа явсаныг нь Оюун, жолооч хоёр мэдсэнгүй. Ингэж Оюун унаж тусталаа залилуулсанаа сая л ойлгоод цагдаад хандсан байна. Залуу төлөөлөгч Отгонбаяр үл мэдэгдэх алуурчин, залилагч нь Баяраа гэдэг нэг хүн болохыг ойлгож ээдрээтэй



эрлийн мөрөөр мөшгиж гарчээ. Оюун ч дүр зургийг нь маш сайн хэлж өгсөн байна. Отгонбаяр ам зураг гарган мөшгин хөөцөлдсөөр байлаа. Тэр “Вест” баарны үйлчлэгч нартай ярилцаж, уг бааранд байнга суудаг эмэгтэйг сурвалжлан “Бэр” дэлгүүрийн худалдагч гэдгийг тогтоожээ. Уг эмэгтэй алуурчины ам зургийг хараад “Энэ хүн “Вест” бааранд байсхийгээд л орж ирдэг үл бүтэх зальтай нөхөр байгаа юм. Мөнгө байхгүй гээд надаар төлүүлсэн. Би тооцоогоо хийгээд нэг шил архи авч гарахад араас ирж миний архийг булааж зугтсан. Одоо би үзвэл танина” гэжээ. Бас нэг залилан юу хийхээс ч буцахгүй араатны араас мөрдөж яваагаа улам ойлгов. Оюуны ял эдэлж байгаа хүүтэй цуг хоригдож байсан хүмүүсийг судлахад Баяр гэсэн нэр орсон гурван хүн байжээ. Налайхын цагдаагийн хэлтэст хулгай, залилангийн хэргээр мөрдөгдөж байсан Баярсүрэн гэгч тун сэжигтэй санагдсан байна. Төдөлгүй Отгонбаяр Налайхын цагдаагийн төлөөлөгч ахлах дэслэгч Ганхүүтэй уулзаж “Урьд нь хоёр удаа шийтгэгдсэн. Баярсүрэн 2000 оны хавар айлын үхэр хулгайлж амралтын аж ахуйд худалдаж мөнгөөрөө наргисан хэрэгт нь баривчлах үед гэртээ байгаагүй. Эмгэн хүний дүрд хувиран хувцаслаж араг үүрээд аргал түүж явсан ихээхэн зальтай, ямар ч хүнийг аргалж чаддаг хүн дээ. Энэ Баярсүрэн “Ганц худаг”-т хоригдож байгаад даалтанд гарч мөрдөн байцаалтаас оргосон. Энэ шоронжсон этгээдийг бид хайж байгаа” хэмээжээ. Техникийн их сургуулийн үүднээс Оюунаагийн машинд суусан худалдагч мэдүүлэхдээ “Нэг хүн дэлгүүрт орж ирээд дүү хүү ахтайгаа хамт явж нэг шил юм хуваагаад уучих” гэсэнд би дотроо зөвшөөрч утсаар яриулсан. Тэгээд машинд нь найз охинтойгоо хамт сууж Багшийн дээд сургуулийн тэнд буусан. Тэр залуу намхан нуруутай, шовх хамартай, шар царайтай, содон шингэн дуутай хүн байсан” гэсэн нь өмнөх хүмүүсийн мэдүүлэг төдийгүй оргодол Баярсүрэнтэй яг таарч байв. Одоо хий үзэгдэл биш жинхэнэ Баярсүрэнгийн араас хөөж эхлэв. Нэг л содон шингэн дуу хоолой гэсэн ижил үг төлөөлөгчийн сэтгэлийг эзэмдэж хүн алсан, Оюунааг залилсан хэргийг нэг хүн л үйлдсэн гэсэн дүгнэлтэнд аргагүй хүргэжээ. Тэгээд Баярсүрэнгийн гэр, очиж болох хамаатан садан, найз нөхдийнх нь хаягийг сурвалжлан тогтоож, далдхан отолт хийжээ. Төдөлгүй алуурчин Баярсүрэнг Өлгийн гудамжинд амьдардаг төрсөн дүүгийнхээ гэрт байна гэдгийг тогтоогоод өглөө эрт баривчлахаар ортол алга байлаа. Хашаа хороог нь шалгатал байсангүй. Хашаан дээгүүр өнгийж хартал араг үүрсэн чавганц цаашаа явж байсан байна. Мөрдөгч Отгонбаяр “Нөхөр Баярсүрэн та зогс” гэж хашгираад хойноос нь хөөтөл мөнөөх чавганц чинь аргаа хаяад цааш зугтаажээ. Гэвч тэр хичнээн зугтаагаад нэмэр болсонгүй. Тэрбээр нэг муу уранхай торгон дээл өмсөөд, толгойдоо алчуур зангидсан байсан бөгөөд хэн ч харсан аргал түүж яваа чавганц гэж харагдахаар байлаа. Энэ хэрэгтээ Баярсүрэн дээд хэмжээ авчээ.

## **Мянгат малчин Балжид хүн хутгалчихаад шоронд оролгүй өнгөрсөн нь гайхалтай**

Өнгөрсөн сар шинийн баяраар буюу 2-р сарын 19-нд Хэнтий аймгийн Биндэр суманд нэгэн хачирхалтай хэрэг гарчээ. Нутаг усандаа олон малаараа баярхаж явдаг “Хоёр мянгат малчин” Балжид гэгч нь өөрийн малчин Ганбямбыг шинийн нэгний өглөө цээжин тус газар нь нэг удаа хутгалжээ. Хохирогч Ганбямба нь цус их алдсанаас “шок”-онд орж аймгийн эмнэлэгийн сэхээн амьдруулах тасагт хүргэгдсэн байна. Тэгээд ачит эмч нарын буянаар амь аврагдаж тус эмнэлэгт арав гаруй хоног эмчлүүлээд гарчээ. Хүйтэн зэвсэг хэрэглэж, хүний аминд хүрэх шахсан Балжидыг Хэнтий аймгийн Эрүүгийн Цагдаагийн газар шалгаж эрүү үүсгэн, аймгийн прокурорын газарт шилжүүлжээ. Гэвч хүний аминд санаатай халдахыг завдаж хүйтэн зэвсэг хэрэглэсэн мань эрийн хэргийг прокурор хэрэгсэхгүй болгожээ. Ингэснээр “Хоёр мянгат малчин” Балжид мөрдөнгийн хашаанаас юу ч болоогүй аятай инээгээд гарч одсон байна. Хүний аминд хүрэх шахсан энэхүү ноцтой хэргийг хэрэгсэхгүй болгосон шалтгааныг “Хутга хэвлийн хэсэгт нэвтрээгүй, хөнгөн гэмтэл” гэж онцолсон байх жишээтэй. Заавал хэвлийн хэсэгт нэвгэрч байж л эрүүгийн хэрэг болдог юм байх даа. Уг нь хуулиндаа хүний биед мэс дүрж, сийчих нь бүү хэл бага зэрэг эсгэсэн л бол эрүүгийн хуулийн дагуу ял шийтгэл оногдуулдаг гэдгийг прокурор байтугай энгийн иргэд ч мэднэ. МАХН-ын байр луу хоёр ширхэг чулуу шидсэн залуу таван жилийн ял авч байхад малчиныхаа цээжинд улайм цайм хутгалж танхайрсан мянгат малчин ял зэмгүй өнгөрсөн нь үнэхээр гайхалтай. Үүний цаана нөгөө авилгал, хээл хахууль чинь “цохиж” яваа юм биш биз. “Хоёр мянгат малчин” хүн энэ зэргийн хэргийг аргалж дөнгөх нь ойлгомжтой. Хохирогч тал нь хүртэл гомдол гаргалгүй өнгөрчээ. Учир нь Балжид баян өөрийн малчин байсан хохирогч Ганбямбад цөөн тооны мал тасдан өгч амыг нь үдээд тусад нь гаргасан байх жишээтэй. Мянган малчин хүн сайхан юмаа. Хүн хутгалж таашаал аваад л...

## Түмэндалайн Ожилдайг Монголын бүх шоронгоор дамжуулжээ

Түмэндалайн Ожилдай хэмээх хятадын эрлийз эрийг 1980-аад оны шоронгийн хулгарууд андахгүй. Мааньтын шоронд ялан дийлж явсан тэрбээр анх 15 настай байхдаа найзынхаа чихийг сэт хазаж гэмтээгээд хүүхдийн колонид очсон байна. Тэнд байхдаа гэмт хэрэг үйлдэж насанд хүрүүт томчуудын шоронд очжээ. Тэгээд шоронгоос суллагдалгүй байсаар нийтдээ 33 жил ял эдэлжээ. Ожилдай яагаад ингэж олон жил ял эдлэх болов гэвэл атаман гэсэн тодотголтой хүмүүстэй сав л хийвэл зодолддог, тэднийг заавал дийлж байж салдаг байж. Тийм ч учраас хэд хэдэн хүнийг хутгалж гэмтээсэн байна. Тэрбээр нэг газар удаан байх юм бол ихээхэн нэр нөлөөтэй болчихдог тул засангийн удирдлага түүнийг Монголын бүх шоронгоор дамжуулжээ. Гэвч Ожилдай шинэ газар дөнгөж очуугаа л зодоон нүдээн хийж будлиан тарьдаг байж. Мань эр 1978 онд Бат-Өлзийн шоронд байхдаа тэндэхийн хянагч Төмөртогоо гэгчийн эхнэртэй жиг ургуулж улмаар жирэмсэн болгоод нэг гэр бүлийн хооронд бөөн будлиан хутгасан байна. Тэгээд дэглэм дээшилж Мааньтын чангад иржээ. Энд ирээд мөн л зодоон нүдээн хийж тухайн үеийн шоронгийн атаман Дашийн Мундаа, Дорноговийн Ваанчиг-жамбаа нартай ана мана үзэлцдэг байж. Ожилдай 1984 онд шоронгоос суллагдах тун дөхжээ. Гэвч түүнийг суллагдахаас хоёр хоногийн өмнө Ваанчигжамбаа “Ожилдай гэдэг энэ Хятадын эрлийзийг шоронгоос гаргаж ёстой болохгүй. Ямар нэгэн зодоон үүсгэж ялыг нь нэмүүлэх хэрэгтэй байна” гэж гал хамууддаа хэлсэн байна. Ер нь шоронд зодоон үүсгэж хэн нэгэнд ял нэмүүлдэг бичигдээгүй хууль байдаг бөгөөд суллагдах гэж байгаа хоригдолд зодуулсан хүн дараа нь зодоон үүсгэгчээс мөнгө авдаг байж. Ваанчигжамбаа Ожилдайн ялыг нэмүүлэхийн тулд Говь-Алтайн “Хэлтгий” Базар гэгч этгээдийг хөлсөлжээ. Энэ этгээд хүн өдөж зодуулахдаа гаргууд нэгэн байсан бөгөөд үдийн хоолны үеэр Ожилдайн хөл дээр санамсаргүй маягаар гишгэчихжээ. Гэтэл угийн ямаан омогтой Ожилдай “Чи муу бөөс доодохоо харж явахад яадаг юм бэ. Ер нь чи миний хажуугаар зөвшөөрөлгүй өнгөрдөг хэн юм бэ” гээд босоод ирж. Энэ үед “Хэлтгий” Базар “Чи намайг бөөс гэнэ ээ. Түрүүний бөөс толгойд гарахыг чи харах уу” гээд Ожилдайн нүүр лүү тавагтай бантангаа цацаж орхижээ. Ожилдай үнэхээр тэссэнгүй. Уг нь тэсээд өнгөрсөн бол тэр хоёр хоногийн дараа шоронгоос суллагдах байлаа. Хор шар нь дээд цэгтээ тулсан мань эр “Хэлтгий” Базарын үүдэн шүдийг цөм цохиод зогсохгүй чихийг нь сэт хазаж цустай нь хутгаж орхисон байна. Ингээд юун нөгөө шоронгоос суллагдах байх билээ. Бусдын эрх чөлөөнд халдсан, хүний гоо сайханд сэв суулгасан гэх зүйл ангиар таван жилийн ял нэмүүлэх нь тэр. Харин 1989 онд Ваанчигжамбаа гяндлуул-чихсан байсан бөгөөд энэ үед Ожилдай шоронгоос суллагдахдаа “Одоо намайг хэн ч хорьж чадахгүй. Харин Ваанчигжамбаа байсан бол намайг нэг удаа тогтоох байсан биз. Ваанчигжамбаа ер нь гяндандаа үхэх тавилантай хүн. Би наранд гарч байгаад Ваанчигжамбааг гянданд нь үхүүлэх талаар төлөвлөгөө боловсруулна” гэж хэлж байжээ. Гэвч Ваанчигжамбаа гянданд үхэх нь байтугай 1990 оны үед шоронгоос суллагдаад төрөлх Дорноговь аймагтаа очиж амьдрал цогцлоож байгаад 1993 онд өвчнөөр өөд болжээ.

## **Ялтануудыг шоронгоос суллагдмагц хүүхэн олж өгдөг эмсийн хүрээлэн маягийн тусгай байгууллага баймаар ч юм шиг**

Энэ оны эхний есөн сарын байдлаар анхан шатны шүүх улсын хэмжээнд гарсан 35246 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ. Үүнээс хүнийг санаатай алсан 195, бусдын бие махбодьд хүнд гэмтэл санаатай учруулсан 199, бусдын эд хөрөнгийг хулгайлсан 1280, танхайрсан 550, хүчингийн 140, эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлсэн 23, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн 464, бусдын эд хөрөнгийг тонон дээрэмдсэн 149 гэмт хэргийг хянан шийдвэрлэжээ. Эдгээр-ээс эрүүгийн хэргийн 68,8 хувийг таслан шийдвэрлэж, яллагдагч нарт хуулийн дагуу хариуцлага ноогдуулсан байна. Дээрхи гэмт хэргийн улмаас хувь хүн, албан байгууллагад 23.9 тэрбум гаруй төгрөгийн эд зүйлийн хохирол учирч, 393 хүний амь нас хохирчээ. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийг төрлөөр нь авч үзвэл өмнөх оны мөн үеийнхээс хүчингийн хэрэг 8.5 хувиар өссөн байхад хүнийг санаатай амь насыг нь хохироосон гэмт хэрэг 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ер нь манай улсад хүчингийн гэмт хэргийн тоо ер буурахгүй байгаа бөгөөд урин дулаан цаг болоход бүр ч ихэсдэг. Учир нь энэ үед охид бүсгүйчүүд нимгэн хувцсанд орж бие галбир нь жинхэнэ төрхөөрөө нүдэнд тусдаг тул зарим нэг мунаг эрчүүдийн сэрлийг хөдөлгөдөг байна. Тиймээс тэд эхлээд гуйж нэг үзээд болохгүй болохоор нь хүчирхийлдэг тал бий. Ийм хэрэг найз нөхөд, ах дүүс, хамаатан садны хүрээнд ихэвчлэн гардаг бөгөөд олонд мэдэгдсэн, огт мэдэгдээгүй хичнээн хэрэг гардагийг бүү мэд. Гарах гарахдаа онц аюултай хэрцгий түрэмгий гараад байгаа нь харамсалтай. Хүчингийн хэрэг хөдөө хээр, хонь малын бэлчээрт, орц хонгилд, эзгүй орон байранд гардаг байсан бол эдүгээ гудамж талбайд гарахаас гадна машинаар хүч түрэн авч яваад хүчиндэх явдал олширчээ. Саяхан нэг шөнө Д гэгч эмэгтэйд орой ажлаасаа тараад ганцаараа явж байтал нэг машинтай залуу хажууд нь ирж зогсоод “Хөөе бүсгүй. Би чамайг гэрт чинь хүргээд өгье” гэхэд Д бүсгүй машинд суужээ. Тэгтэл арын суудалд хэвтэж байсан нэг залуу нь өндийж ирээд Д-гийн араас барьж аваад нүдийг нь даавуугаар боочихсон байна. Тэгээд хаашаа ч явсан юм бүү мэд, нэлээд явж байгаад нэг газар ирж Д-г машинаас буулгаад мань хоёр залуу шууд хүчирхийлсэн байна. Дараа нь Д-гийн хөл гарыг хүлж “Чи өнөө шөнөдөө энд хонох болж дээ. Амьд гарсандаа баярла. Маргааш өглөө гэхэд сайн санаат хүмүүс чиний хүлээсийг тайлж нүдний чинь боолтыг авах болно” гээд машинаа асаагаад явчихаж. Д бүсгүй машинд анх суухдаа номерыг нь харж амжаагүй, жолооч залуу хар нүдний шил зүүсэн байсан тул түүнийг дараа нь таних боломжгүй байж л дээ. Мунаг эрчүүд чухам үүнийг л ашигласан байгаа юм. Хүчингийн хэргийн дийлэнх хувийг шоронгоос суллагдсан, нэг ёсондоо эмэгтэй хүнтэй хэдэн сар жилээр хавьтаагүй хагсарсан этгээдүүд үйлддэг болох нь тогтоогджээ. Тэгэхээр одоо яалтай ч билээ. Ялтануудыг шоронгоос суллагдмагц нь хүүхэн олж өгдөг, нэг ёсондоо эмсийн хүрээлэн маягийн тусгай байгууллага баймаар ч юм шиг. Ядахнаа сүүлийн үед янханууд нь ховордчихсон ч юмуу, шоронгоос суллагдсан этгээдүүд хагсаагаа гаргахын тулд шөнө орой ганц нэгээрээ яваа охид бүсгүйчүүдийг зүгээр явуулахаа байсан байна. Ядахад яр гэгчээр сүүлийн үед ялтануудыг хорих хугацаанаас нь өмнө тэнсэн харгалзан суллах явдал эрс ихэсчээ. Сүүлийн зургаан сарын байдлаар хуулийн дагуу зохих ялаа эдлэн хүмүүжиж байсан 1290 хоригдолыг тэнсэнгээр суллаж, 71 хоригдолыг хорих ялаас чөлөөлсөн бөгөөд 228 хоригдолын эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 1200 хоригдолын ял эдлэх дэглэмийг бууруулж өгсөн байх жишээтэй. Тэнсэнгээр суллагдсан 1290

хоригдолын чухам хэд нь хүчингийн хэрэг үйлдээ бол. Найз нөхөд, ах дүүс, хамаатан садны хүрээнд хүчингийн хэрэг үйлдсэн бол цагдаа-гийнхан огт мэдэлгүй өнгөрсөн байж таараа. Яагаад гэвэл ах дүүс, хамаатан садны хүрээнд хүчингийн хэрэг үйлдлээ гэхэд ихэвчлэн зохицоод өнгөрдөг, эсвэл цагдаад мэдэгдвэл ална тална гэж айлган сүрдүүлдэг бөгөөд эдүгээ хичнээн охид бүсгүй дээрхи маягийн дарамтанд бусдад хүчиндүүлээд дуугүй явж байгааг тооцоолох арга алга. Үүнд ядуу зүдүү амьдрал бас зохих хэмжээгээр нөлөөлдөг бөгөөд хүчирхийлэгч этгээд хүслээ гүйцээсний дараа гэмт үйлдлээ мөнгө төгрөгөөр цайруулах нь олонтаа. Хүчиндүүлсэн эмэгтэй-чүүд ч шүүх сэргийлэхээр явж цаг заваа алдахгүйн тулд, мөн нэр нүүрээ бодоод хүчирхий-лэгчээс хэдэн төгрөг аваад хал балгүй салдаг бололтой. Хүчингийн хэргээр хоёр ч удаа ял эдэлсэн Дансрангийн Сүхжаргал гэгч этгээд саяханы нэг шөнө ганцаараа явсан нэг эмэгтэйг гэнэдүүлэн барьж аваад эзгүй байшинд авчраад хүчиндэхийг завджээ. Энэ үед бүсгүй самбаачлан нэг давхарын цонхоор гарч зугтах санаатай үсрээд гэмтэхэд Сүхжаргал эмнэлэг дуудахын оронд биеэ хамгаалах чадваргүй болсныг нь далимдуулж хүчиндсэн байгаа юм. Харин түүнийг азаар амьд үлдээсэн бөгөөд бүсгүй түүнд тунирхаж гоморхолгүй “аятайхан” үйлчилж амиа авч гарч чадсан байна. Үүнд бүсгүйг буруутгах үндэс байхгүй бөгөөд хэрвээ туниа муутай, аймхай, бүрэг ноомой нэгэн байсан бол Сүхжаргалыг элдвээр аргалж чадалгүй амиа алдах байсан биз.

## Цуутай гэмт хэрэгтэн Гилхүүгийн Данхарын үнэнч шавь “Хялар” Дэмчиг гэгч хэн бэ?

1950-иад оны сүүлч, жараад оны эхэн үед Оросын ИЖ-49, М-72, Чехийн Ява-250 мотоциклиуд Улаан-баатарын хөрөнгө чинээтэй хүмүүсийн гол гангараа болдог байж. Гэвч тэд гоё ганган мотоциклиэ хулгайд алдах, тонуулах явдал мэр сэр гардаг байсан бөгөөд харамсалтай нь хулгайч нар баригдахгүй цагдаагийнханд ихээхэн чирэгдэл учруулдаг байжээ. Тиймээс цагдан сэргийлэх газрын дарга нар мотоциклийн хулгайч нарын үйлдлийг эцэс болгохоор туршлагатай мөрдөгч Баасандоржийг мөрдөн байцаагчдын ахлагчаар томилжээ. Баасандорж ажил хүлээж авмагцаа мотоцикль хулгайлдаг бүлэг хүмүүсийн тухай мэдээ, мэдээллийг нарийвчлан шалгаж эхэлсэн байна. Ингээд сарын дараа гэхэд Дэмчиг, Ваша, Жүгдэр, Дондов нарын бүлэг этгээдүүд удаа дараа гэмт хэрэг үйлдэж байгаа нь үйл ажиллагаа, нэр хаягаараа бүрэн тогтоогдож, тэдний толгойлогч нь “Хялар” Дэмчиг гэгч болох нь тодорхой болжээ. “Хялар” Дэмчиг нь 1960-аад оны үед халхын шоронд нэг хэсэгтээ л мандуулж явсан нэгэн бөгөөд тэрбээр тухайн үеийн цуутай гэмт хэрэгтэн Гилхүүгийн Данхарын өсгөж бойжуулсан үнэнч шавь нь байж. 1960-аад оны үед Гилхүүгийн Данхар, “Чийчаан” Лувсандорж, “Зэрлэг” Дамдинсүрэн, “Лойдий” Төмөр нарын хүмүүс халхын шоронд цууд гарч байсан гэдэг. 1953 оны намар Улсын цагдан сэргийлэхийн ажилтанууд Гилхүүгийн Данхар нарын бүлэг 13 хүний хэргийг таслан шийдвэрлэсэн бөгөөд Хэнтий аймагт адууны хулгайч байсан Данхар Улаанбаатар хотод орж ирмэгцээ насанд хүрээгүй хүүхдүүдийг удирдан зохион байгуулж орон байрны хулгайн гэмт хэрэгт уруу татаж эхэлсэн байна. Энэхүү бүлэгт мотоциклийн хулгайч “Хялар” Дэмчиг багтжээ. Дэмчиг нь 1959 онд шоронгоос суллагдан гарч ирээд эх Дулмаа, дүү охин Оюун, Жимсээ нарынхаа хамт одоогийн Ногоон нуурын урд талд айл амьтангүй зэлүүд газарт хашаа хороогүй ганц гэрээр байдаг байж. Ингээд 1960 онд эндээс нүүж хуучин 500 айлын орон сууц гэж байсны баруун талын хогийн жалгын зүүн эрэг дээр мөн л ямар ч хашаа хороогүй, хавьдаа айл амьтангүй ганц гэрээрээ буусан байна. “Хялар” Дэмчиг нь гэр орондоо өдрөөр бараг байдаггүй, ажил хөдөлмөр хийдэггүй атлаа ИЖ-79 маркийн мотоциклийнхээ араар хүүхнүүд суулгаад өдөржин сэлгүүцдэг байж. Төдөлгүй тэр хэвлэх үйлдвэрт ажилтай Жүгдэр, цагдаа Дондов, Чехийн элчин сайдын яаманд ажиллаж байсан Доржийн хүү Ваша нарыг өөрийн гэмт үйлдэлдээ элсүүлэн авчээ. Нэгэнт энэ бүлэг хүмүүс олон тооны мотоцикль хулгайлж тонож байгаа нь нотлогдсон тул мөрдөгч Баасандорж юуны өмнө толгойлогч Дэмчигийг барихаар төлөвлөсөн байна. Ингээд Баасандорж нь Бадарч хэмээх цагдаагийн хамт одоогийн шар дэлгүүрийн орчимд Дэмчигийг мотоциклийнхээ араар нэг хүүхэн суулгачихсан давхиж явахад нь баривчлахаар “Зогс” гэж хашгиртал гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр Дэмчиг зогсолгүйгээр хурд нэмэн зугтжээ. Гэсэн ч тэднийг баривчлахаар эртнээс төлөвлөсөн Баасандорж хойноос нь явган хараад зогссонгүй. Дэмчигийг зугтана гэдгийг зөнгөөрөө мэдэрсэн тэрбээр тухайн үеийн “Шаахай-72” хэмээх мотоциклийг шар дэлгүүрийн гадаа сойчихсон байж. Тэгээд л цагдаа Бадарчийг хажуудаа суулгаад “Хялар” Дэмчигийн хойноос хөөж гарчээ. Гэвч Дэмчиг мотоцикль барихдаа гаргууд нэгэн тул хотын мурий тахир гудамжаар маш овжин зугатааж мөрдөгч Баасандоржийн хараа-наас амархан мултарч чадсан байна. Гэсэн ч Баасандорж бууж өгсөнгүй. Тэрбээр нийслэл хотын төв бүхлээрээ харагддаг Тасганы овоон дээр гарч ийш тийш дурандаж байтал Дэмчиг гэрийнхээ ойролцоо буюу 500 айлын орон сууц гэж байсны баруун талын хогийн жалгын ойролцоо мотоциклиэсээ буугаад тухалж суугаа харагджээ. Тиймээс Баасандорж шууд давхиж очоод Дэмчигийн хоёр гарыг

гавлчихсан байна. Гэвч орон шоронд орж багагүй догширсон Дэмчиг тийм амархан буугаад өгчихсөнгүй. Түүнийг цагдаагийн газарт авчраад мэдүүлэг авах гэтэл “Та нар гэмгүй хүнийг яагаад баривчилж байгаа юм бэ. Би ямар ч мэдүүлэг өгөхгүй. Нотлох баримт чинь хаана байна. Би та нарыг зөрүүлээд шүүхэд өгч чадна шүү” гэх зэргээр хэгжүүрхжээ. Түүнийг нэгэнт мэдүүлэг өгөхгүй гэсэн учир протокол хөтлөөд 72 цагаар албадан саатуулсан байна. Тэгээд дараагийнх нь этгээд болох Вашаг айлд нуугдсан байхад нь нэн даруй баривчлаад Усны гудамж хавьцаа байх гэрт нь үзлэг хийхэд цоо шинэ Ява-250 мотоцикль дамкрадаад тавьчихсан, орон дороос нь төрөл бүрийн мотоциклийн сэлбэг, задалсан эд ангиуд гарч иржээ. Энэ бүхнийг фото зургаар баримтжуулаад эд мөрийн баримт болгон хурааж авсан байна. Тэгээд анх удаа л цагдаад баригдаж байгаа айж хулчийсан Вашаг байцаахад далан таваар бууж өгөөд бүх үнэнээ мэдүүлжээ. Тэрбээр “Хамгийн сүүлд Дэмчиг бид хоёр хамт явж байгаад нэг Ява-250 мотоцикль хулгайлж, Дондов, Жүгдэр нартай хамтран тонож мотоциклийн рам, шаврын хаалтыг шуудайнд хийж, Дамбадаржаагийн наана Сэлбийн голын тохойн усанд хийгээд замын хашлаганы хугархай чулуугаар дарсан” гэж өчжээ. Вашаг авч газар дээр нь очиж үзэхэд дарсан гэх хугархай чулуу нь байсан ч мотоциклийн рам, шаврын хаалт зэрэг нь байсангүй. Тиймээс Вашаг худлаа ярьж чулуу хөөлгөж байна гэж үзээд дахин байцаахад тэрбээр “Би худлаа хэлээгүй. Хүн аваад явсанаас зайлахгүй. Та нар энэ хавийн хүмүүсээс асууж сураглаач дээ. Би тэгж хоёр алхаад баригдах юман дээр худлаа хэлэх хүн биш” хэмээжээ. Нээрээ ч үүнийг нь хүн аваад явчихсан байсан бөгөөд мөрдөгч Баасандорж “Сэлбийн голоос мотоциклийн сэг олсон хүн байвал авчирч өгнө үү” гэсэн зар бичиж Дамбадаржаагийн дэлгүүрийн гадаа наасанаар төдөлгүй нэг хүн мөнөөх мотоциклийн сэгийг нь авчирч өгсөн байна. Энэхүү мотоцикль нь автын цагдаа Чулуун гэгчийн Өндөр хоршооны үүднээс алдсан мотоцикль байж. Ингээд “Хялар” Дэмчигийн хам хэрэгтэн Жүгдэр, Дондов нарыг баривчлах болтол тэд хам нөхдөө дараалан баригдаад сураггүй болсонд сандарч тэвдээд хадгалж байсан мотоциклийн сэлбэгээ хээр аваачин булж хаяад өөрсдөө гэр орныхондоо ч хэлэлгүй хөдөө тийш гараад арилж өгсөн болох нь тогтоогджээ. Жүгдэрийн танил бүсгүй Сурмаа мэдүүлэхдээ “Тэр өчигдөр ээжийгээ асарна гээд Хэнтий аймгийн Биндэр сум руу явсан. Тэндээ өвөлжих юм ярьж байна лээ. Харин Дондов өчигдөр Дундговь явсан” хэмээжээ. Төдөлгүй Баасандорж шуудангийн машинаар Хэнтийн Биндэр суманд ирж Жүгдэрийн ээжийнхийг сурагласаар яваад очтол жар гаруй насны хөгшин “Манай хүү Жүгдэр ууланд мод хийж байгаа. Чи найз нь уу. Найз ирвэл зааж өгөөрэй гэсэн” хэмээжээ. Ингээд Баасандорж сумын хэсгийн төлөөлөгчийг дагуулаад Биндэрийн хойд талын модонд очиж Жүгдэрийг баривчилсан байна. Жүгдэр шалдаа бууж “Энд байгаа хүмүүст намайг баривчилж байна гэж битгий хэлээч. Би таныг миний найз гээ. Та ч тэгж хэлээч. Би настай ээжийнхээ нэрийг бодъё” гэх зэргээр царайчилжээ. Баасандорж үүнээс татгалзсангүй. Шууд л Жүгдэрийн найз болж мөрөн дээр нь алгадаад “Хөгшөөн, хоёулаа хот руу явъя. Цэргийн найзууд маань чамтай уулзаж учиръя гэж дуудаад байна” гэж жүжиглэжээ. Жүгдэр ч дүрдээ итгэчихсэн “Найз нар маань уулзъя гэж дуудуулсан бол би явалгүй яахав” гээд машинд суужээ. Төдөлгүй тэр хотод ирээд мөн л далан таваар бууж өгсөн байна. Энэ үед Дундговь явсан гэх Дондов ч хөдөөнөөс баригдаад ирчихсэн “Би буруу хүмүүсийн ятгалганд орж муухай том алдаа гаргалаа” гэх зэргээр гонгинож суусан байна. Зохион байгуулалттайгаар мото-цикль тонодог байсан дөрвөн этгээд нийтдээ есөн мотоцикль худгайлснаас гадна “Хялар” Дэмчиг нь НААҮ-ний үсчний газрын хувцасны өлгүүрээс үсчин Мэндбаярын бор хурган дотортой үйтэнхуар дээлийг хулгайлсан болох нь эд мөрийн баримтаар нотлогджээ. Толгойлогч Дэмчиг бүхий л хэргээ хүлээн мэдүүлж улмаар хулгайлсан мотоцик-лиудын запас

эд ангийг хаана нууж далдалсанаа хүртэл зааж өгчээ. Тэрбээр гэрээсээ арагш гурав алхамын зайд Ява-250 мотоциклийн хоёр дугуйг шуудайнд хийж булсанаа, түүнээс зүүн тийш гурван алхамын зайд ИЖ-49 мотоциклийн аккумулятор, карбюратор зэрэг жижиг запасыг шуудайнд хийж булсанаа, гэрийнхээ дээвэр, цаваг хоёрын завсраар гар тормоз, консны трос мэтийн овор багатай жижиг зүйлийг нууснаа тус тус гаргаж өгсөн байна. Энэ бүхний гэрэл зургийг бэхжүүлж аваад Дэмчигийг цагдан хорихоор прокурорын газарт авчирчээ. Тэгтэл Дэмчиг прокурорын гаднах модон жорлонд бие засч байгаад гэв гэнэт оргочихсон байна. Цагдаагийн байгууллага тэр дороо түргэн авч Дэмчигийг эрэн сурвалжилсан бөгөөд маргааш өглөө нь төмөр зам хавиас М-72 мотоцикль алдагдсан тухай дуудлага ирж, оргодол Дэмчиг түүнийг хулгайлаад хөдөө гарсан нь тогтоогдов. Ингээд тэр хоёр сарын турш Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутгаар чөлөөтэй сэлгүүцэж, тэр ч байтугай айлд хүргэн орж, баруун аймгуудын тууварчдын хоол хүнс, эд зүйлийг хулгайлах зэргээр баахан мундар хутгаж орхижээ. Энэ тухай сураг сонссон мөрдөгч Баасандорж төдөлгүй Сэлэнгэ аймгийн Орхон суманд очиж тэндхийн хэсгийн төлөөлөгч нартай хамт Дэмчигийг баривчлахаар өдөр шөнөгүй хөөцөлдсөн боловч баривчилж чадсангүй. Учир нь Дэмчиг мөрдөгч Баасандоржийг ирсэн сургаар зөрөөд Улаанбаатар явчихсан байна. Мань эр хотод ирмэгцээ сурсан зангаараа мөн л мотоцикль хулгайлж ардаа эсэн бусын хүүхэн суулгаад нэг хэсэг жаргалаа эдэлжээ. Хамгийн сүүлд тэрбээр Ява-250 мотоцикль хулгайлан унаж яваад цагдаа нарын хараанд өртмөгцөө шууд зугтсан байна. Цагдаа нар түүний хойноос М-72 мотоциклиор хөөж явсаар 22-ын товчоо хавиас баривчилжээ. Дэмчиг яг баригдах үедээ гутлынхаа түрийнээс хутга гаргаж ирээд “Би амиа хорлоно. Ойртовол ална шүү” гэж сүржигнэж байжээ. Мөрдөгч Баасандорж түүнд дахин хэрэг бүртгэлт хийж хотын прокурорын мөрдөн байцаалтанд шилжүүлсэн ба “Хялар” Дэмчиг удаа дараа мотоцикль хулгайлсан уг хэрэгтээ 12 жилийн ял сонсчээ. Тэгээд 1972 онд шоронгоос суллагдсан байна. Гэвч тэр үнэндээ засрал авсангүй. Төрөлхийн хулгайч, гэмт хэрэгтэн гэж байдаг бөгөөд “Хялар” Дэмчиг наранд гараад ердөө долоо ч хонолгүй хэсэг нөхдийн хамт Мэргэжилтэний 20-р дэлгүүрийг тоножээ. Үүний дараа шөнийн цагаар Улсын их дэлгүүрийг ухаж байгаад газар дээрээ баригдсан байна. Ингээд тэр насаараа ял эдэлжээ. 1994 оны үед Мааньтын шоронд жар гаруй настай “Хялар” Дэмчиг гэгч хөгшин хулгайч байдаг гэж сонсогдож байлаа. Түүнээс хойш энэ хүний тухай сураг тасарсан. 1960-аад оны үед гурван нөхрийн хамт арав гаруй мотоциклийн бодийг хөтөлсөн мань эр 1970-аад оны үед 37 мотоциклийг гав ганцаараа хулгайлсан алдарт Чойрогийн Дүгэрээг ихэд шүтэн биширдэг байж. Тэрбээр 1980-аад оны үед Мааньтын чангад байхдаа Чойрогийн Дүгэрээтэй тааралдаад “Ээ, бурхан минь. Чамтай ингэж уулзана гэж байх уу. Чи бол бидний хажууд бурхан хулгайч. Хожмын үеийн гэгээнтэн. Ер нь чи яаж яваад 37 мотоцикль хулгайлж рекорд эвддэг байна аа. Чиний рекордыг эвдэх хүн Монголд байтугай дэлхийд төрөхгүй” гэж хөөргөдсөн гэдэг.



## 26 жил ял эдэлсэн Орломжавын

### Дөшийн өчил

Орломжавын Дөш хэмээх жар орчим насны өвгөн 26 жил шоронд суугаад өнгөрөгч зун нарны амьдралд хөл тавьжээ. Тэрбээр түмнийг ивээдэг Гандан хийд, төр засаг хоёртоо хандаж доорхи зүйлийг өчиж байна.

“Орломжавын Дөш миний бие Монголын газар шороон дээр төрж өсөөд 59 жилийн нас сүүдэр зооглосон ч 26 жилийг нь шоронд өнгөрөөлөө. Энэ 26 жил миний амьдралд арилашгүй хар толбо үлдээсэн. Өнөөдөр би нарны амьдралтай золгосон хэдий ч өөрийн гэсэн орон гэргүй, хань ижил, үр хүүхэдгүй, мэргэжил мэдлэггүй, ажил төрөлгүй, ёстой л үнсэнд хаягдсан шалз шиг болчихоод байна. Уг нь миний төрсөн дүү Орломжавын Даш гэдэг хүн амьд сэрүүн байх учиртай. Эх Орломжав маань Дөш, Даш гэдэг хоёр бутач хүү төрүүлсэн ч тэднийхээ ач буяныг үзэлгүй хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн. Дүү Даш маань бас л над шиг орон шоронгоор явж арчаагаа алдаж байлаа. Одоо үхсэн ч байж магадгүй. Би шоронгоос гараад юуны түрүүнд Гандантэгчинлэн хийдээр орлоо. Энэ хийдээр орсон бүх хүн өөрийн бололцоогоор их шүтээндээ мөнгө төгрөг тавьж байлаа. Харин надад энд тавих сохор зоос ч байсангүй. Тиймээс эндхийн тагтаануудад хий дэмий л хэдэн будаа хаяж өглөө. Уг нь энэ Гандан хийд чинь над шиг ядарсан амьтанд л буян болох байтал надаас тав арван төгрөг салгах бодлого явуулдаг юм байна. Олон түмний хандивласан тэр их мөнгө чухам юунд зарцуулагддагийг хэн мэдлээ. Эрхбиш тэдэнд зориулж хэд гурван маани уншиж өгдөг л байх. Тэглээ гээд амьдрал нь сайжирсан юм харагдахгүй л байна. Миний бодлоор бол өнөөгийн айл бүхэн л мөнгөний хэрүүлтэй, ямар нэгэн юмаар дутагдаж гачигдсан байх юм. 26 жил шоронд суусан болохоор энэ бүх хэрүүлээс би үнэхээр төсөөрсөн байна. Гандан хийдэд очиж мөргөснийхөө дараа би энд тэндхийн захуудаар баахан тэнэлээ. Миний нэр мэдэх 20 гаруй, мэдэхгүй 100 гаруй найгүй архичин хаа сайгүй хөлхөлдөж байх юм. Харин би эдний хажууд архинд нэвшрээгүй, бие эрүүл, ухаан саруул, цаашид амьдрах өчүүхэн зорилготой байгаа нь яамай. Тэднээс би ганцхан үүгээрээ л давуу юм. Тэд бүгд л амьдралдаа гутарч 500 төгрөгийн үнэтэй найруулсан спиртээр голоо зогоох юм. Өдөр шөнөгүй хулхи спирт уусан мөртлөө яагаад амьд яваагийн учрыг тэднээс асуутал “Христийн шашныхан л бидэнд хааяа тусалдаг. Харин Гандан хийд бол бидэнд хэзээ ч буян үйлдэж байгаагүй” гэж хэллээ. Мөн шоронгоос суллагдсан зарим хүмүүст Шинэ Зеландын иргэн Маргарита гэгч эмэгтэй, Солонгос гаралтай Германы иргэн Ким мэтийн хүмүүс их тус болдог бололтой. Шоронгоос суллагаад нутаг буцах замын зардалгүй олон арван хүнд Маргарита хувиасаа мөнгө өгч нутагт нь явуулсан гэнэ. Мөн зарим хүнд орон гэр хүртэл олгожээ. Хэдийгээр би энэ хүнд хандах сонирхол байвч эхлээд Гандан хийдээсээ тусламж авмаар байна. Учир нь миний эх Орломжав дээхэн үед энэ хийдэд мал хуйгаараа хүртэл өргөл барьц өгч байсан юм гэдэг. Гэсэн хэдий ч манайд зовлон нүүрлэснээс жаргал нүүрлээгүй. Хамгийн сүүлчийн зовлон нь надаар дуусч байх шиг. Энэ хийд одоо надад л тус болвол болохоор. Мөн энэ ядарсан архичид, орон гэргүй тэнэмэл хүмүүс чадалтай сайхан амьдарч явах үедээ Гандан хийдэд их л мөнгө төгрөг тавиа болов уу. Гэтэл Монголын шашин хийд ард түмнийхээ зам мөрийг ганц удаа ч болов үнэгүй засаад өгч чадахгүй, тэдний өглөг буянаар сайхан амттай хэвийн боовоор хооллож байна. Тэд үнэндээ гадаадын сайхан сэтгэлтэй хүмүүсээс долоон дор юм. Бурхан номын хүчгүй, зөвхөн мөнгө

төгрөг хураагч байгууллага гэж бодогдож байна. Мөн би төр засагтаа их гомдож байна. Би 26 жил ял эдлэхдээ энэ төр засгийн хамаг л хүнд хүчир ажлыг үнэ төлбөргүй хийсэн хүн. Би улс орноо хэзээ ч хохироогоогүй. Харин хувь хүнийг хохироосон нь үнэн. Үүний хариуд төр засаг надаар 26 жил ажил хийлгэсэн. Тэр бүх ажлын хөлсийг тооцох юм бол өнөөдөр би саятан болчихсон байх учиртай. Тиймээс төр засаг 26 жил ажил хийлгэсэн намайг шоронгоос суллахдаа дөрвөн ханатай гэр өгчихөж болох асуудал. Улс нийгэмд хорь гучин жил ажилласан хүн тэтгэвэрт гараад сайхан л байх юм. Надад юуных нь тэтгэвэр байхав. Харин үүний оронд ажил олоод өгчихвөл буян болох нь тэр. Шоронгоос суллагдсан хүмүүст ажил олддоггүй нийгэм байна. Тэгээд биднийг чухам яаж шуухан амь зуу гэж шоронгоос сулласан юм бол. Уг нь хэдэн жилийн өмнөөс “Суллагдсан хоригдлуудын эрх ашгийг хамгаалах холбоо” гэж байгуулагдах сураг дуулдсан боловч ийм холбоо улсын хэмжээнд байдаггүйг мэдрээд өөрөө өөртөө гутарлаа. Би улсаар зүгээр тэжээлгэх гээгүй. Хамгийн гол нь ажил төрөлтэй, цаашид өлбөрөөд үхчихээргүй амьдралын баталгаатай болох юмсан гэсэндээ л энэ бүхнийг тэрэллээ” хэмээжээ.

### **“Цоохор” Янжив, “Ноорхой” Чулуун хоёрын хэн нь аймаар хулгайч вэ?**

Өвөл хичнээн өнтэй ч цас, жавар хоёроор хайр найргүй хайрна. Гэвч Монголын тал нутаг өвөлд өчүүхэн ч жиндсэн янзгүй байх ажээ. Айлууд өвөлжөөндөө тухалж, адуу мал оторт налайж, ан амьтан ичээ нүхэндээ жаргана. Гэтэл өвлийн гурван есийн хүйтнээс ховдог сувдаг хүний сэтгэл бүр хүйтэн ажээ. Мөрдөн байцаагч Бадамсүрэнг өглөө ажилдаа иртэл цагдан сэргийлэх хэлтэсийн жижүүр шөнө гурван айлыг ухсан тухай илтгэсэн байна. Байдлыг тэр дор нь судалж шуурхай хэсэг авч өөрөө давхиж очив. Ийм хулгай ойрын үед хэд хэдэн удаа гарсан учир одоо л хэргийн халуун мөрөөр орчих шиг санагджээ. Ихэд чинээлэг, бэл бэнчинтэй айлуудыг ухсаныг харахад сайтар судалсан, эсвэл урьдын сайн танил хүний урт гар хамаад гарсан нь илт байлаа. Байцаагч хэргийн газарт үзлэг хийж, олон арван хүнээс мэдүүлэг авсанаар орон гэрээ тонуулсан айлуудаар орж гардаг хүмүүсийг нарийн судалж эхэлжээ. Харамсалтай нь амжилт гарсангүй. Маш хашир туршлагатай урт гар дайраад гарсан нь ойлгомжтой болжээ. Эрэл сурал болох бүрт цасан дээр хавтгай хөнгөн зүйл унасан, хэн нэгний гутлын мөр шинэхэн цасан дээрээс олдох бөгөөд тэр чиглэлд нь мөрдөөд үзэхээр тохьтой томоотой гэгддэг айлын хашаа гэр, амбаар руу орсон байх жишээтэй. Хашир хулгайч нэг ёсондоо чулуу хөөлгөх арга хэрэглэж, огт гэмгүй нэгнийг хулгайн хэрэгт сэрдүүлэх гэж энэ бүхнийг санаачилсан болох нь тогтоогджээ. Гэвч уйгагүй шалгаж мөрдсөний эцэст мөрөө баллаж өөр зүгт чиглүүлдэг мөнөөх урт гартай хулгайч баригдах нь тэр. Хашир туршлагатай тэр хулгайч нь өмнө нь хулгайн хэргээр гурван ч удаа орон шоронд орж байсан “Цоохор” Янжив гэгч байлаа. Мөрдөн байцаагч Бадамсүрэн тэдний гэрт ороод шууд үзлэг хийхэд гэрийн эзэн Янжив нэг л хулчигнаад “Та нар бодвол муу нэртэй луу данстай намайг л хардаж сэрдэж байгаа биз дээ” гээд амбаараа дуртай дургүй онгойлгон өгчээ. Гэтэл амбаарт нь булигаар, шар шир, шинэхэн эгнээгүй хурган дотор, дээлийн өнгө, мах, сүү зэрэг хураалттай байх нь тэр. Ингээд л “Цоохор” Янжив тун ядах юмгүй баривчлагджээ. Тэр мөрдөнд ердөө хоёр хоноод л хамаг хэргээ тоочиж улайсан байна. Янжив мэдүүлэхдээ “Би дөрөв дэх удаагаа хулгайн хэрэгт холбогдож байна. Хүндэрлээ гэхэд таван жил л авна биз. Давган хэрэг болохоор Мааньтын чангад л очно биз. Нас 60 дөхлөө, үр хүүхэд, гэр бүл, удам угсаа, төр засаг, хууль ёсыг дээдлээд ерөөсөө би зодог тайлахаар бүрмөсөн шийдлээ. Одоо дахиж хулгай хийхгүй. Хулгай хийнэ гэдэг чинь нэг ёсондоо мэргэжил юм шүү дээ. Би өчүүхэн жижиг

хулгайч биш, мэргэжлийн сайн хулгайч. Хулгай хийхдээ бэлтгэл сайн хийдэг хүн дээ. Хулгайн авд гарахаас хэд хоногийн өмнөөс архи огт амсахгүй. Цадталаа хоол идэж, сайн нойр авч бэлтгэнэ. Бурхан шүтээний зүйлс, архи, хүний хиртэй хуучин хувцас хулгайлахыг би цээрлэдэг хүн. Ер нь би нүнжигтэй хулгайч шүү. Үүнийгээ л мэргэжил гээд байгаа юм. Манай Дорноговь аймгаас халхын шоронд хоёр том хулгайч тодорсоны нэг нь би. Нөгөө нь Цэвэлийн Ваанчигжамбаа. Дорнодын “Цоохор” Янжив гэхээр халхын шоронгийнхон намайг андахгүй. Би аймгийнхаа нэрийг зохих ёсоор дуурсгаж л явдаг хүн. Таньд би хулгайлж авсан зүйлээ нууж хаалгүй бүгдийг нь ярина. Гэхдээ ямар эд зүйлийг хаанаас авсаныг би нарийн мэдэхгүй учир жаахан хольж солих л байх. Ер нь хулгайч хүн өнгөтэй өөдтэй эдийг ихэд яаруу сандруу савладаг юм шүү дээ. Энэ удаад би хулгайлсан бүх зүйлээ тоо ёсоор нь гаргаж өгнө. Тэгэхээр хөгшин ахыгаа яланд унагаад хэрэггүй. Эр хүний ёсоор зүгээр өнгөрөөчих. Тэгээд би ерөөсөө дахиж хулгай хийхгүйгээр зодог тайллаа” гэх зэргээр солиорчээ. Гэвч түүний санасанаар хуулиас гадуур ийм үйлдэл хийж яаж болох билээ дээ. Хулгай хийсэн л бол зохих ёсны ялаа үүрэх нь дамжиггүй. Амьхандаа “Цоохор” Янжив мөрдөн байцаагчийг панаалдах гэж оролдсон нь энэ. Тэрбээр мөрдөнд арав гаруй хонохдоо урьд өмнө нь эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хоёр ч үйлдлийг хүлээжээ. Тэгээд тэр долоон удаагийн үйлдлээр 10 айлын гэрээс авдар, амбаар ухсан тухай мэдүүлэгээ үнэн зөвөөр өгчээ. Тэгсэн хирнээ өөрийн шавь болох хам хэрэгтэн “Ноорхой” Чулуун гэгчийг ор тас нуусан байна. Бүх хэргийг ганцаараа үүрээд шоронд очиход нь “Ноорхой” Чулуун нь эргэж тойрох ёстой байж л дээ. Энэ бол архаг хулгайчийн чоно санаа байлаа. Төдөлгүй “Цоохор” Янжив яг л өөрийнхээ хэлж байснаар таван жилийн ял аваад Мааньтын шоронд очсон байна. Ёстой л зөн билгийн тулаанд орчихмоор сүрхий этгээд байсан бололтой. Гэхдээ зөн билэг ч юу байх вэ, олон удаа орон шоронд орсон архаг хулгайч болохоор эрүүгийн хуулийг арван хуруу шигээ мэддэг байсных биз. Гэвч түүнийг шоронд явсаны дараа Дорноговийн Сайншанд хотод дахиад хэд хэдэн том хулгай гарах нь тэр. Гэхдээ хулгайч яг “Цоохор” Янживын арга барилаар ажилласан нь тогтоогджээ. Энэ нь түүний шавь “Ноорхой” Чулууны үйлдэл байсан бөгөөд хариугүй нунж дорой мань эрийг цагдаа нар ч тоож шиншилдэггүй байсан нь хулгайн хэргийг нь улам өөгшүүлэхэд хүрсэн байна. Мөрдөн байцаагч Бадамсүрэн хулгайчийг илрүүлж чадахгүй арга ядахдаа Мааньтын шоронд ял эдэлж буй “Цоохор” Янживаас мэдээлэл авахаар тийш зүглэжээ. Тэгээд түүнтэй уулзаад “Нутаг орноор чинь сонин хачин зүйл их л болж байна. Тухайлбал яг таны үйлдлийг хэрэгжүүлдэг нэг сүрхий хулгайч тодроод байна. Тэр хулгайч мөрөө баллахдаа яг таны аргыг хэрэглэсэн байх юм. Өөрийн чинь хүмүүжүүлсэн шавь арай Дорноговь аймагт байдаг юм биш биз дээ. Та нуулгүй хэлээч” гэхэд “Цоохор” Янжив “Би юугаа хэлж, хуйхаа маажих билээ дээ. Үнэнийг хэлэхэд надад ганц ч шавь байхгүй. Тэгээд ч над шиг архаг хулгайч нар ихэвчлэн шавьгүй байдаг юм. Муу шавь бол эзнээ цусгүй ална шүү. Цагдаагийнханд үг алдана. Баригдаад ирэхээрээ багшийгаа илчилнэ. Тийм учраас би хам хэрэгтэн, шавь энэ тэрд ёстой дургүй. Аливаа хулгайг ганцаараа хийх шиг сайхан юм байхгүй. Баригдсан ч бусдад биш зөвхөн өөртөө гомдоод л өнгөрнө. Мөрөө балладаг миний аргыг маш олон хулгайч мэддэг л байлгүй. Ганцхан би мэддэг юм биш. Яс юман дээрээ би тийм сүрхий зүйл сэдээд олчихсон сод ухаантан ч биш” гээд “Ноорхой” Чулууны тухай ганц ч үг ганхийсэнгүй. Энэ нь бас л архаг хулгайчийн чоно санаа байлаа. Байцаагч Бадамсүрэн “Та нэг л хүнийг нуугаад байна даа. Хэрвээ тэр хүний тухай хэлбэл таны ялыг бас хөнгөлж чадна шүү” гэхэд Янжив “Та нар хэзээ хэлсэн амандаа хүрч байлаа даа. Ахыгаа ялгүй үлдээчих, хулгайлсан бүх зүйлээ өгье гээд хамаг үнэнээ тоочиж байсан хүн шүү, би. Тэгтэл чи миний хамаг хэргийг яриулчихаад, хулгайлсан бүх зүйлийг маань хурааж

авчихаад намайг ялгүй өнгөрөөсөн бил үү. Үгүй шүү дээ, дүү минь. Аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ гэдэг юм. Надад шавь, хам хэрэгтэн энэ тэр байх ч үгүй. Байсан ч би чамд юу ч хэлэхгүй” гэж адарчээ. Ингээд байцаагч Бадамсүрэн Мааньтын шоронгоос ямар ч мэдээлэлгүй буцсан байна. Гэсэн ч энэ явдлаас хойш хоёр сарын дараа “Ноорхой” Чулуун нь нооройтол баривчлагджээ. Тухайн үед Сайншанд хотын төвд хулгайгүй хонох шөнө цөөхөн байсан бөгөөд орос, монгол цэрэг, явуулын тэнүүлчин хэдэн хүүхэд байсхийгээд л хулгай хийнэ. Аймгийн үйлдвэрчний зөвлөлийн ажилтан Долгор зуныхаа байшингаас хурган дотортой дээл, хромон гутал, дурдан бүс, жижиг сажиг эд зүйл хулгайд алдсан байна. Бас л ул мөргүй, сэжиглэл ч байсангүй. Бадамсүрэнг өглөө ажилдаа ирж явтал хажуугаар нь хурган дотортой минчүү дээл өмсч, шар дурдан бүс ороосон, орос хромон гуталтай ганган эр мотоцикльтой давхиж өнгөрчээ. Хойноос нь сайтар ажиглан хартал таньдаг хүн нь байж. Тэр нь Ар шандын төмөр замын өртөөнд ажилладаг Ухнаа гэгч байсан бөгөөд өмнө нь тэр хэзээ ч ингэж ганган тансаг хувцаслаж явдаггүй байж. Тиймээс Бадамсүрэн Ухнааг байцаахаар шийджээ. Төдөлгүй түүний ажил дээр явж очоод “Наад гоё дээлийг чинь хэн хийсэн юм бэ. Энэ гоё гутал, дурдан бүсийг хаанаас худалдаж авсан бэ” гэж асуухад гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр учиргүй түгдэрч гацаад тун авцалдаа муутай хариулт өгчээ. Бадамсүрэн тэр даруйдаа аймгийн прокуророос зөвшөөрөл авч Ухнааг дагуулан ар төмөр замд байх түүний байшинд үзлэг хийсэн байна. Үзлэгээр хэрэгцээнээс илүү нэг төрлийн аяга халбага, сав суулга, хөнжил гудас, элдэв янзын хүүхдийн тоглоом зэрэг сэжигтэй зүйлс илэрсэн бөгөөд Бадамсүрэн тэр бүгдийг данслан жагсааж нэг том цаасан хайрцаганд хийж битүүмжилжээ. Тэгээд Ухнааг цагдаагийн хэлтэс дээр авчраад “Чамтай хамт нэг хүн амьдардаг юм байна. Тэр хүн чинь хэн бэ” гэж асуухад “Манай хамаатны Чулуун гэдэг хүн надтай хамт амьдардаг юм. Энэ дээл, гутлыг Чулуун надад өгсөн. Хаанахын хэнээс авсаныг би мэдэхгүй” хэмээжээ. Ингээд “Ноорхой” Чулуун баригдсан байна. Гэхдээ тэр хэргээ хүлээхгүй мөрдөнд арав гаруй хоножээ. Эцэст нь тэр аргагүй л буулт хийж “Тэртэй тэргүй л илэрсэнээс хойш би хэргээ хүлээе. Би ч яахав ингээд ял аваад шоронд явдаг байж. Харин миний багш Янжив ах л эргэж тойрох хүнгүй их хэцүүдэх байх даа” гэж үг алджээ. Хариуд нь Бадамсүрэн “Тэгнээ тэр. Янжив гэдэг хүний шавь байж магадгүй гэж би эртнээс мэдээд байсан юм. Чи яахав ингээд баривчлагддаг байж. Харин чиний шавь гээд бас нэг нөхөр хулгайн хэргийг чинь үргэлжлүүлэх юм биш биз” гэхэд Чулуун “Надад ёстой шавь энэ тэр байхгүй. Уг нь Ухнааг хам хэрэгтэнээ болгодог юм билүү гэж бодож байсан юм. Даанч түүнд хулгай хийх ямар ч авьяас, сонирхол байхгүй. Харин надад бол хулгай хийх авьяас, сонирхол бий. Янжив ах ч үүнийг мэдэрдэг байсан. Үнэнийг хэлэхэд би хулгайн дон туссан хүн. 10 гаруй айлаас элдэв янзын л юм хулгайлсан. Ямар сайндаа л шөнө кино үзээд гэр лүүгээ явах замдаа хулгай хиймээр бодогдоод зам дээр хэвтсэн нэг муу гөлмөн төмрийн тасархайг хүний нүд хариулан авч нуусаар хашаандаа авчрах билээ дээ. Шөнө орондоо ороод нойр хүрэхгүй, тэгээд босч айлын гэрээс буюу хашаанаас ямар нэгэн юм хулгайлан авчирч байж л унтдаг болсон. Ийм донтой болсон тухайгаа танд мэдэгдэж зөвлөгөө авахаар хоёр ч удаа ирсэн боловч өрөөнд чинь орж зүрхлэхгүй буцсан. Одоо л харин нэг сайхан зөвлөгөө аваатахъя” хэмээжээ. Түүний багш “Цоохор” Янживыг архаг хулгайч хэмээн дээр цоллосон. Тэгтэл энэ “Ноорхой” Чулуун гэгч нь түүнээс бүр аюултай, хулгайн дон гэгч сүрхий өвчин тусчихсан аймаар амьтан байжээ.

# Table of Contents

<a href="#">Өршөөлийн зарлигаар өөдөлж дэвжсэн хулгайч</a>	
<a href="#">Нарны сайхан амьдралыг нарсны амьдралаар солиод насаараа хохирох нь олонтаа</a>	
<a href="#">Орос, Монгол хоёр улсын хоригдол солилцооны шугамаар Улаан-Үдийн чанга дэглэмтэй шоронгоос мултарчээ</a>	
<a href="#">Үүдэн шүднүүдээ бахиар суга татуулаад хохирох байтал харин ч бүр завшсан байна</a>	
<a href="#">“Онгоон” Хасчулууны өдүүлсэн олхиогүй хэрэг</a>	
<a href="#">Нэгэн цагт харгис хянагч байсан бумтогоо ялтануудын авран хамгаалагч болохоор шийджээ</a>	
<a href="#">Хурандаа Л.Санжаасүрэнгийн гэгээн дүрийг Мааньтын хоригдол чулуугаар сийлжээ</a>	
<a href="#">Нарны амьдралд дасан зохицоогүй учраас үхэн үхтэлээ тортой хашаанд суухаар шийджээ</a>	
<a href="#">Шоронд ороод сүрхий гэгээрч хүмүүжсэн Тожоогийн Буяннэмэх ярьж байна</a>	
<a href="#">Луйварчин хүүхэнд хамаг байдагаа зальдуулахад “Зуун хувь” гэдэг дуу нөлөөлжээ</a>	
<a href="#">Халаас хоосон ялтан хүн шоронгоос суллагдаад гэртээ харих замдаа л гэмт хэрэг үйлдчихдэг болж</a>	
<a href="#">Жинхэнэ новширдог хулгайч</a>	
<a href="#">Шоронгоос оргоод Богд ууланд хоёр жил бүгжээ</a>	
<a href="#">Шорон санаатай Т.Оюунбатын үйлдсэн нүгэл хоёр нүдээр нь бүлт үсэрчээ</a>	
<a href="#">Шорон дотроос өшөө авагч Жүгдэрийн Мягмараас болж хэлмэгдсэн хүмүүс</a>	
<a href="#">“Дахиад пээдийхгүй болтол чинь алаад өгье” гэдэг үг Д.Сүхдоржийг насаар нь “алж” орхижээ</a>	
<a href="#">“Ойлон” Санжаа гэгч эр багшийгаа шоронгоос оргуулаад “Улаан арав”-аар яллагджээ</a>	
<a href="#">Мунагийн хэрэгт удаа дараа холбогдсон “Муужгай” Цэрэндорж арван жилийн ялтай</a>	
<a href="#">“Шорноон” Хуягаа шоронгийн тогооч болж тарчилсан нь</a>	
<a href="#">Засаршгүй гэмт хэрэгтэн заяатын ХАЛТМАА гэнэ алдаж баригдсан нь</a>	
<a href="#">“Зараа” хочит Булганжав адууны цувдайг мангас шиг цөлдөг болж</a>	
<a href="#">Хүний халаасанд хуруугаа шургуулна гэдэг халуун төмөр атгахтай адил</a>	
<a href="#">Эрхтэнээсээ салах шахсан саваагүй ялтаны эвгүй дурсамж</a>	
<a href="#">Лувсанпэрэнлэй хурандаа ялтан хүнийг ямар цагт нь шийтгэж, ямар цагт нь хайрлах вэ гэдгийг сайн мэддэг хүн байсан</a>	
<a href="#">“Ялтаныг алсан ялтаныг ямар цаазаар авах биш, тагтааныхаа байранд очиж хэвтгээ дээ”</a>	
<a href="#">Гэмгүй иргэнийг онц хүнд гэмт хэрэгт холбогдуулсан мөрдөн байцаагч 5-10 жил хоригдох ялтай</a>	
<a href="#">Өс хонзонтой хоёр эр өвөрлөгч нөхдөөс болж төө зайгүй найзууд болцгоов</a>	
<a href="#">Хянагч дэмбэрэлийг айлгаж явсан Цэвээний Бунданхүү гэгч хэн бэ?</a>	
<a href="#">“Гяндан хүлээс”-ний эргэн тойронд</a>	
<a href="#">Янхан хүүхнийг бүтэн шөнөжин эдэлж хэрэглээд гурван жилийн ялаар “шагнуулсан” эр</a>	
<a href="#">Ялтан Бундаагийн хараалаар ахмад</a>	
<a href="#">Шоронгоос суллагдсан этгээдүүд Азийн гэмт хэргийн ертөнцөд хөл тавих нь их боллоо</a>	
<a href="#">Таксигаар хүн зөөж явахдаа шорон аргаар олон хүнийг дээрэмджээ</a>	
<a href="#">Хэнчбишийн Мандуул шоронд сайхан байсан үеэ нэг дурсаад нүд аньсан байна</a>	
<a href="#">Орон байрны “Бүлтүүш” Болдхүү угаалгын машин “Акира” болж хувирчээ</a>	
<a href="#">Соц нийгмийн шоронд банди байсан эрийн өчил</a>	

Хэрцгий зандалчин Ядамсүрэнгийн амийг ерөнхийлөгч өршөөсөн ч сүрьеэ өвчнөөр өөд болжээ

Ах дүү нараа луйвардаад шоронд орох шиг булай юм байхгүй

Шоронд сэтгэлээр унах л юм бол шууд нөгөө ертөнц рүү очно

Дуулиан шуугиантайхан хоригдсон хүмүүсийг “Ялны ченжүүд” ээрч хоргоогоод амар заяаг нь үзүүлдэггүй

Шоронжсон этгээд Баярсүрэнг мөрдөх үеийн адал явдал

Мянгат малчин Балжид хүн хутгалчихаад шоронд оролгүй өнгөрсөн нь гайхалтай

Түмэндалайн Ожилдайг Монголын бүх шоронгоор дамжуулжээ

Ялтануудыг шоронгоос суллагдмагц хүүхэн олж өгдөг эмсийн хүрээлэн маягийн тусгай байгууллага баймаар ч юм шиг

Цуутай гэмт хэрэгтэн Гилхүүгийн Данхарын үнэнч шавь “Хялар” Дэмчиг гэгч хэн бэ?

26 жил ял эдэлсэн Орломжавын Дөшийн өчил